

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, Баасан гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1-2
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	3-14
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	15 -126
<hr/>	
<b>1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</b>	15-17
<b>2.Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/</b>	17-19
<b>3.Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/</b>	19-20
<b>4.Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/</b>	20
<b>5.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах</b>	20-21
<b>6.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөл</b>	21-45
<b>7. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай</b>	45-60

---

**хуулийн төслүүд болон “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

- 8.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах** 60-63  
**Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах**
- 9.“Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл** 63-73
- 10.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаар/** 73-126

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
11 дүгээр сарын 29-ний өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 85 гишүүн хүрэлцэн ирж, 67.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Т.Аубакир, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Бейсен, Ш.Бямбасүрэн, С.Бямбацогт, Ж.Галбадрах, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, М.Ганхүлэг, Г.Дамдинням, С.Замира, М.Мандхай, П.Наранбаяр, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Пүрэвдорж, Д.Рэгдэл, П.Сайнзориг, М.Сарнай, Р.Сэддорж, Ч.Ундрэм, Б.Уянга, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Ө.Шижир, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, Л.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, Б.Жаргалан, Н.Номтойбаяр,

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Х.Баттулга;

Хоцорсон: М.Бадамсүрэн-18 минут, Б.Батцэцэг-1 цаг 34 минут, Х.Булгантуяа-25 минут, А.Ганбаатар-10 минут, Б.Дэлгэрсайхан-30 минут, Б.Жавхлан-04 минут, Д.Жаргалсайхан-07 минут, Б.Заяабал-05 минут, С.Лүндэг-1 цаг 40 минут, З.Мэндсайхан-05 минут, Б.Түвшин-23 минут, А.Ундраа-07 минут, Д.Цогтбаатар-07 минут, Б.Чойжилсүрэн-03 минут, М.Энхцэцэг-01 минут, Р.Эрдэнэбүрэн-13 минут.

**Нэг.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 28

Бүгд: 68

58.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Ц.Баатархүү, Б.Жавхлан, Ж.Бат-Эрдэнэ, Б.Хэрлэн, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат, Д.Үүрийнтуяа, Б.Мөнхсоёл, нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, мөн Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын бичгээр гаргасан саналыг үндэслэн дэмжсэнээр тооцов.

Нийт 68 гишүүнээс 50 гишүүн дэмжиж, 73.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 16

Бүгд: 72

77.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59  
 Татгалзсан: 16  
 Бүгд: 75  
 78.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 64  
 Татгалзсан: 11  
 Бүгд: 75  
 85.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Б.Мөнхсоёл, Б.Хэрлэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 75 гишүүнээс 67 гишүүн дэмжиж, 89.3 хувийн саналаар хууль батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
 Татгалзсан: 11  
 Бүгд: 76  
 85.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ж.Батжаргал, П.Батчимэг, Д.Батбаяр нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 76 гишүүнээс 70 гишүүн дэмжиж, 92.1 хувийн саналаар хууль батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 7

Бүгд: 76

90.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:24/

*Дагалдан гарсан:*

2.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:25/

3.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн

найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:25/

4.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:25/

5.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:25/

*Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийг хэлэлцсэн талаарх Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Н.Наранбаатар, Л.Мөнхбаясгалан, С.Эрдэнэбат, Ц.Идэрбат, Х.Ганхуяг, Д.Энхтүвшин, Ж.Батжаргал, Д.Ганбат, Ц.Даваасүрэн, Д.Батлут, З.Мэндсайхан нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ч.Лодойсамбуу, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хороодын саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55  
Татгалзсан: 26



Бүгд: 81  
67.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Уг асуудлыг 11 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Төсвийн болон Хууль зүйн байнгын хороодын хамтарсан хуралдаан хуралдах тухай мэдэгдэж, чуулганы нэгдсэн хуралдаан 11 цаг 46 минутаас 14 цаг 33 минутад завсарлав.*

***Долоо.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн талаарх Төсвийн болон Хууль зүйн байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, Х.Булгантуяа, Б.Баярбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ж.Баярмаа, Л.Мөнхбаясгалан нар үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69  
Татгалзсан: 16  
Бүгд: 85

81.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хороодын саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 68  
Татгалзсан: 17  
Бүгд: 85

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Найм.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг гар өргөж явуулав.

**Д.Амарбаясгалан:** 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 29

Бүгд: 85

80.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 19

Бүгд: 85

77.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 17

Бүгд: 85

80.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 17

Бүгд: 85

80.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 21

Бүгд: 85

75.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 19

Бүгд: 85

77.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 19

Бүгд: 85

77.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

### **Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:32/

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:32/

5.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:32/

6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:32/

7.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:32/

*Уг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.*

***Ес. “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

“Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн болон Хууль зүйн байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Ж.Баярмаа, С.Амарсайхан, М.Бадамсүрэн, Б.Жавхлан нар үг хэлж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж тайлбар хийв.

**Д.Амарбаясгалан:** “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 18

Бүгд: 85

78.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ж.Батжаргал, М.Бадамсүрэн, М.Нарантуяа-Нара нар санал хэлж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж *тайлбар хийв*. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:02/

*Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэв.*

***Арав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаар/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга Ц.Ганзориг, Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны ажлын албаны дарга Ё.Азжаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын дарга О.Мөнхбаяр, Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын дарга М.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Малын генетик нөөцийн хэлтсийн дарга Ж.Цогтбаатар, Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, мөн яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Лувсанцэрэн, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Улаанбаатар хотын Захирагчийн албаны Хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга М.Балдандорж, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн дарга Ч.Буянжаргал, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Ерөнхий инженер Т.Мөнхболд, “Тавантолгой түлш” ХХК-ийн Санхүү, эдийн засгийн газрын дарга А.Батзориг нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах, мөн газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

*Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 16 цаг 03 минутаас хуралдааныг удирдав.*

Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн, А.Ундраа, М.Нарантуяа-Нара үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, П.Батчимэг, Г.Ганбаатар, С.Цэнгүүн, С.Эрдэнэболд, О.Цогтгэрэл, М.Нарантуяа-Нара, Да.Цогтбаатар, Ж.Золжаргал, Д.Жаргалсайхан нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, “Тавантолгой түлш” ХХК-ийн Санхүү, эдийн засгийн газрын дарга А.Батзориг, “Улаанбаатар цахилгаан түгээх

сүлжээ” ТӨХК-ийн Ерөнхий инженер Т.Мөнхболд, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга Т.Баярхүү нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Улаанбаатар хотын Захирагчийн албаны Хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга М.Балдандорж, Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны ажлын албаны дарга Ё.Азжаргал нар хариулж, тайлбар хийв.

*Уг асуудлыг 18 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 10 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 6 цаг 06 минут үргэлжилж, 126 гишүүнээс 86 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр 18 цаг 59 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРАЛ**

2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай”  
танхим  
10 цаг 06 минут

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Д.Амарбаясгалан:** Гишүүд ирцдээ оръё. Учрал сайд, Тэмүүлэн гишүүн ирцдээ оръё. Улсын Их Хурлын гишүүдийн ирц 52.4 хувь хүрсэн байна. Нийт 66 гишүүн ирж, ингээд 2024 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёрдугаарт, Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, Бага хэмжээний цөмийн материалыг шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Тавдугаарт, Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

Зургаадугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Их Хуралд хүлээж авсантай холбогдуулан хууль тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар долоодугаар асуудал 2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаарх Монгол Улсын ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Наймдугаарт, Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. **Улс төрийн намын тухай хууль хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.**



Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг явуулна аа. Санал хураалт явуулахаар байна. Гишүүд анхаарлаа хандуулъя. Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Дэмжье гэсэн саналын томьёоллоор.

Санал хураалт.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Доржханд микрофон өгье.

**Т.Доржханд:** Баярлалаа. Энэ төхөөрөмж маань бас ажилласангүй. Дэмжсэнээр бүртгэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Баатархүү сайдын микрофоныг өгье.

**Ц.Баатархүү:** Төхөөрөмж хоцорч дарсантай холбоотойгоор бас санал сөрөг гарсан байна.

**Д.Амарбаясгалан:** Дэмжих юм уу? Баатархүү сайдын микрофоныг өгье.

**Ц.Баатархүү:** Дэмжиж санал өгөхөөр протоколд бүртгүүлье.

**Д.Амарбаясгалан:** Баатархүү сайдыг дэмжсэнд бүртгэе.

Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Бүгдэд нь өглөөний мэнд. Энэ төхөөрөмж үнэхээр болсонгүй. Тэгээд дэмжсэнээр протоколд оруулж өгнө үү, тэгээд баярлалаа. Учрал сайд гэрчилнэ.

**Д.Амарбаясгалан:** Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Бат-Эрдэнэ даргын микрофоныг өгье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Төхөөрөмж ажилласангүй. Дэмжсэнээр тооцож өгнө үү гэж хүсэж байна. Хоцорсон гэдгээ өөрсдөө хүлээн зөвшөөрч байя.

Учрал сайд.

Хэрлэн гишүүн, Энхцэцэг гишүүн, Эрдэнэбат гишүүн 3-ын микрофоныг өгье дараалалаад.

**Б.Хэрлэн:** Төхөөрөмж ажиллаагүй учраас. Дэмжиж санал өгөх гэсэн боловч төхөөрөмж ажилласангүй ээ.

**Д.Амарбаясгалан:** Энхцэцэг гишүүн.

**М.Энхцэцэг:** Адилхан. Энэ одоо хүртэл улаан байгаад байна. Дэмжсэн гэж өгөөрэй.

**Д.Амарбаясгалан:** С.Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Дэмжсэн микрофоноос хоцорлоо.

**Д.Амарбаясгалан:** Үүрийнтуяа гишүүн.

**Д.Үүрийнтуяа:** Саналыг дэмжсэнээр авч өгөхийг хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Яг горим нь бол дэмжсэн санал өгсөн. Протоколд тэмдэглэж өгнө үү гэдэг хүсэлт байх ёстой Улсын Их Хурлын гишүүн. Мөнхсоёл гишүүн. Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье.

**Б.Мөнхсоёл:** Өглөөний мэнд. Дэмжсэн саналаар протоколд бүртгэж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Ингээд гишүүдийг дэмжсэнээр протоколд нэмж тэмдэглэе.

Улс төрийн намын тухай хууль хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

*10.12 цаг*

Дараагийн асуудал. **Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураана аа.

Тайлбар байгаа. Нийт энэ дэгийн тухай хуулийн 79.7-д Монгол Улсын Их Хурлын нийт гишүүний олонх олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжих ёстой буюу 64 гишүүнээр хуулийн төсөл дэмжигдэхээр байгаа гэдгийг бас гишүүддээ анхааруулж хэлье ээ.

Ингээд санал хураалт явуулахаар байна. Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Нийт гишүүдийн олонх дэмжсэнгүй.

Тэгэхээр Агваанлуvsангийн Ундраа гишүүний микрофоныг өгье.

**А.Ундраа:** Дарга энэ төхөөрөмж маань ажиллахгүй байна. Тэгээд энэ санал хураалтыг хүчингүй болгоод дахиад санал хураая гэж горимын санал гаргаж байна аа.

**Д.Амарбаясгалан:** Сая санал хураалтад хэдэн гишүүн орж чадсангүй вэ? Гараа өргөөд өгөөч. 9 гишүүн орж чадаагүй юм байна тиймээ.

Агваанлуvsангийн Ундраа гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэдэг санал хураалтыг явуулъя аа.

Санал хураалт.

Санал хүчингүй боллоо. Танхимд байгаа гишүүдийн бүртгэлийн санал хураалтыг нэг явуулаадахъя. Яг хэдэн гишүүн байна вэ? Бүртгэлийн санал хураалт.

Амгаланбаатар гишүүнийг дуудъя ирцэд сая бүртгүүлчхээд гараад явчихсан байна.

Санал хураалтад оруулъя. Далайн Батбаяр гишүүн. Дахиад нэг ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя. Гишүүд санал хураалтдаа анхааралтай идэвхтэй оролцохыг хүсье. Санал хураалт.

Сая санал хураалтад орж чадаагүй гишүүд Бадрахын Найдалаа, Жигжидийн Батжаргал. Харин тийм бүртгэлийнх 2 гишүүн орж чадаагүй байна. Болдын Жавхлан гишүүд анхааралтай, Гомбын Ганбаатар гишүүн бас орж чадаагүй байна. Одоо энэ соёрхон батлах, эцэслэн баталж байгаа. Нийт гишүүдийн олонх учраас бас энэ санал хураалт дээр бас дахиад горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгосон байгаа.

Саналын томъёоллыг дахиж уншъя. Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц. Загджавын Мэндсайхан гишүүний микрофоныг өгье.

**3.Мэндсайхан:** Энэ миний төхөөрөмж ажилласангүй. Уг нь дэмжиж санал өгсөн юм дарга аа. Тэгэхээр дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

**Д.Амарбаясгалан:** Баатаржавын Мөнхсоёл гишүүн яагаад өнөөдөр будилаад унав. Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье.

**Б.Мөнхсоёл:** Би зүгээр энэ төхөөрөмж гэдэг шиг. Протоколд дэмжсэнээр бүртгүүлье. Баярлалаа.

Хэрлэн гишүүн. Хэрлэн гишүүний микрофоныг өгье.

**Б.Хэрлэн:** Дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

**Д.Амарбаясгалан:** Нийт 67 гишүүн дэмжсэн гэсэн үг. 3 гишүүн протоколд нэмэлтээр. Ингээд Монгол Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Цөмийн аюулгүй ажиллагааны конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Дараагийн асуудалд оръё.

*10.20 цаг*

**Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

65 гишүүнээр дэмжигдлээ. Миний төхөөрөмж ажиллаагүй миний саналыг дэмжсэнд протоколд тэмдэглэхийг хүсье. Чинбатын Анар гишүүн.

**Ч.Анар:** Дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. Энэ төхөөрөмж огт ажиллахгүй байна.

**Д.Амарбаясгалан:** Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Миний төхөөрөмж өнөөдөр ер нь ажиллахгүй байна. Дэмжиж санал өгөөд дандаа эсрэг гараад байна. Тийм учраас дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх хүсэлтэй байна.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвийн Батчимэг гишүүн, Далайн Батбаяр гишүүн дараад нь.

**П.Батчимэг:** Төхөөрөмж ажилласангүй. Дэмжсэнээр протоколд оруулж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Далайн Батбаяр гишүүн.

**Д.Батбаяр:** Миний төхөөрөмж бас ажилласангүй дэмжсэнээр протоколд тэмдэглэж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Ингээд нийт 70 гишүүн дэмжсэн байна. Би бол саналаа бас өгч чадаагүй. Тэгэхдээ би бол хурууныхаа хээг уншуулж чадаагүй миний алдаа гэж байгаа. Шударга байсан нь дээр байх гэж бодож байна.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье ээ.

Дараагийн асуудалд оръё.

*10.23 цаг*

**Бага хэмжээний цөмийн материалыг шинэ шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Нийт 69 гишүүн дэмжсэн байна.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

*10.24 цаг*

**Дараагийн асуудал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороонд бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.**

1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан.

2.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна? Сонссонд тооцлоо.

3.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.25 цаг

**Дараагийн асуудалдаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх Дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.**

Уучлаарай нэг зүйл орхисон байна.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд дараагийн асуудал дээр явж байгаа.

Төслийн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Ч.Лодойсамбуу:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр бүхэлд нь хориг тавьсныг Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авсан Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хамтарсан хуралдаанаас Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоол бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан хууль тогтоолыг хэрхэн хэлэлцэх талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу ахлан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Ганмаа, Нарантуяа-Нара, Сайнзориг, Сандаг-Очир, Тэмүүжин, Уянгахишиг, Б.Хэрлэн нарын бүрэлдэхүүнтэй байгуулж саналаа нэн яаралтай боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дотор тус байнгын хороодод танилцуулах үүргийг Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 7, 6 дугаар хамтарсан тогтоолоор өгсөн.

Энэ хугацаанд ажлын хэсэг 2 удаа хуралдаж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх журмыг баримтлан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд Монгол Улсын

Ерөнхийлөгчөөс бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх Дэгийн тухай хуулийн төслийг боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанд танилцуулсан.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан нэг удаагийн харилцааг зохицуулсан хууль биш Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломж байсан эсэх, төслийг хэлэлцэхдээ орон нутгийн төсвийг батлах хугацаа тулсан тул холбогдох хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хамтад нь хэлэлцэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд хуулийн төслийн 3.5 дахь хэсэгт заасан зарчмын зөрүүтэй саналыг шинээр гаргахыг хязгаарлах боломж байгаа эсэх, 3.11 дэх хэсэгт заасан илээр санал хураах нь системээр санал хураах асуудал мөн эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно оо.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан орон нутгийн төсвийн хугацаа тулсан байгаа учир орон нутгийн төсвийг батлах хуулийн хугацааг зохицуулах шийдвэрийг Улсын Их Хурал заавал гаргах, Улсын Их Хурлын гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар Ерөнхийлөгчөөс хориг тавих болгонд нэг удаагийн дэгийн хууль гаргаад байх боломжгүй тул цаашид ажлын хэсэг байгуулан нэг мөр шийдэх зохицуулалтыг боловсруулах, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг анхаарах, Хууль эрх зүйн орчныг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд эрх зүйн шийдлийг гаргах боломж өнөөдрийн Монгол Улсын хууль тогтоомжид байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг нэгэнт цаг хугацааны хувьд яаралтай шийдвэрлэх шаардлагатай тул нэг удаагийн харилцааг зохицуулсан хуулийн төслийг дэмжиж байгаа, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригт дурдсан нөхцөлийг ханган зардал нэмэгдүүлэхгүй алдагдлыг бууруулах зарчмыг хангаж ажиллах талаар тус тус үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг төслийн 2.8 дахь хэсгийг хасах, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд төслийн 3.4, 3.5 дахь хэсэгт Засгийн газраас оруулж ирсэн санал дээр шинээр төсөв нэмэхийг хязгаарлах, 3.7.3 дахь заалт төсөлд зардлын зүйл шинээр нэмэхгүй байх гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасан боловч гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх Дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцсэн эсэх талаарх Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Лодойсамбуу гишүүнд баярлалаа.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Далайн Батбаяр гишүүн асуулт асууна.

**Д.Батбаяр:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд энэ дэгийн тухай энэ орж ирж байгаа төсөл дээр 2.7 дээр шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын дарга эсвэл Төсвийн байнгын хороо төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж болно гэсэн байна. Тэгээд энийг яг тодорхой болгоод нэг бол Улсын Их Хурлын дарга нь юм уу эсвэл Төсвийн байнгын хороо гэдэг байдлаар нь илүү тодорхой болгож тусгавал яасан юм бэ гэсэн. Ингээд тусгачхаж болдоггүй юм уу гэсэн асуулт байна.

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Далайн Батбаяр гишүүн асуулт биш санал хэлэх шиг боллоо. Ер нь тэгвэл яасан юм бэ гэж. Тэгж болно, болно. Тэр саналаа одоо гаргаж болно шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

**Н.Наранбаатар:** Өглөөний мэнд хүргэе. Сангийн сайдаас асууя.

Энэ орон нутгийнхаа төсвийн харилцааг яаж зохицуулахаар болсон бэ? Сая хуулийн хугацаанд Засаг дарга нар бол иргэдийн хуралдаанд төсвөө өргөн барьсан тэгээд тэр өргөн барьсан төсөв бол хүчин төгөлдөр болоогүй л юм өргөн барьчихна лээ. Өргөн барихгүй гээд өнөө хугацаатай учраас бас хугацаа хэтэрчих гээд байгаа. Тэгээд яаж зохицуулахаар болсон бэ? 12 сарын 5, 12 сарын 15 гэсэн хугацаанууд байгаа. Тэгээд үүнийгээ ямар чиглэл өгч байгаа вэ гэсэн асуулт байна.

Дараа нь энэ ажлын хэсгээс асууя. Тэгээд энэ нэг удаагийнх юм байна. Ер нь Дэгийн хуульдаа оруулаад цаашаа явчхаж болоогүй юм уу юу харшлаад байгаа юм болоо гэж. Хэрвээ дахиад Ерөнхийлөгч хориг тавих юм бол дахиад нэг удаагийн ийм дэгийн хууль батлах юм уу гэсэн ийм асуулт байна.

Дараа нь гишүүд зарчмын зөрүүтэй саналаа хаана гаргах вэ? Одоогийн дэгийн хуулиараа өнөө 2 өдрийн өмнө 16 цагаас өмнө гаргана гэдгээрээ гаргаж байна уу? Тэгээд төсөв нэмэх зарчмын зөрүүтэй санал гаргаж болж байна уу, үгүй юу? Энэ дээр нэг тодруулга авчихъя.

3 удаагийн хэлэлцүүлэг хийгдэх юм байна. Тэгээд танилцуулгыг нь хасчихсан юм байна. Шууд санал, дүгнэлт гаргах гээд явах юм байна. Тэгээд танилцуулгыг нь хаана бид танилцах юм. Юуг нь хасчихсан юм. Хэдэн хэмжээний төсөв хасчихсан юм гэдгийг нь хаана бид танилцах юм. Ер нь тэр хас гээд байгаа урсгал зардал бусад хөрөнгө оруулалтыг чинь яг аль шатад нь хэн нь хасах юм? Засгийн газар нь хасаж оруулж ирэх юм уу? Ажлын хэсэг нь хасах юм уу? Гишүүд өөрсдөө зарчмын зөрүүтэй санал гаргаад хасаад явчих юм уу гэсэн ийм асуултууд байна. Тэгээд тодруулъя.



**Д.Амарбаясгалан:** Эхлээд Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Яах вэ саяын асуулт бол бас л тийм нэг эцсийн төгс байдлаар бас нэг ойлгогдохгүй л байгаад байгаа юм. Гэхдээ гарцыг бол ингэж харж байгаа. Хориг тавьснаар хоригийг хүлээж авснаар хууль хүчингүй болно гэдэг ойлголт бас төгс байхгүй юм байна. Засвар хийхээр буцааж байгаа гэсэн ийм түвшинд ийм статустайгаар цаашаага энэ батлагдах дэгийн хуулиар хэлэлцээд явах нь гэсэн ийм ойлголттой байгаа.

Тийм учраас 12 сарын 5-нд орон нутгууд бол төсвөө баталдгаараа батална. Хоригийн хүрээнд хийгдсэн засварын дараа шаардлагатай аймгууд дээр дагасан тодотгол хийгдэж таарах байх. Ийм л зарчмаар явах байх. Тэгэхээр 12 сарын тавныхаа төсөв хэлэлцэх асуудлыг орон нутгууд эргэлзэх хэрэггүй хэлэлцээд явах хэрэгтэй. Ийм чиглэлийг орон нутгуудад хүргүүлсэн байгаа.

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн ажлын хэсгийн дарга хариулт өгье.

**Ч.Лодойсамбуу:** Дэгийн хуульдаа өөрчлөлт оруулаад явж болохгүй юу гэж. Одоо байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Дэгийн хуулийнхаа тэр 16 дугаар зүйл дээр хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх журам гээд байгаа. Энэ 16.1 дээр тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг энэ хуулиар зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэх дэгийг Ёс зүй, дэгийн байнгын хороо хэлэлцэж саналаа нэгдсэн хуралдаанд оруулна гээд энэ хуулийн дагуу буюу энэ дэгийнхээ хуулиар процесс нь явж байгаа.

Хоёрдугаарт нөгөө нэг одоо нэмэлт, өөрчлөлт оруулъя гэхээр хууль тогтоомжийнхоо хуулийн дагуу нөгөө бүрдүүлбэр гээд цаг хугацааны хувьд бид нар шахагдчихсан байгаа учраас одоо байгаа энэ дэгийнхээ хуулийг мөрдөөд явахаас өөр аргагүй нөхцөл байдалд байгаа. Ер нь бол Дэгийн хуульдаа цаашдаа энэ Ерөнхийлөгчийн хориг бол дараа дараа жилдээ ч гэсэн тавигдах нөхцөл байх юм байна.

Тэгээд тэрийг нь бас Их Хурал нь хүлээж авсан тохиолдолд ингээд тогтмол шийдээд явах энэ өөрчлөлтийг цаашдаа оруулъя гэдэг дээр санал нэг байгаа. Энийг бол тусдаа ажлын хэсэг байгуулагдаад ярина.

Зарчмын зөрүүтэй саналыг оруулах тухай. Энэ өдөр хоногийг бол ашиглахгүй шаардахгүй гэдгээр энэ нэг удаагийн хууль дээр оруулж өгсөн байгаа. Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналуудаа гишүүд 1 дүгээр хэлэлцүүлгийн үеэр оруулж.

**Д.Амарбаясгалан:** Лодойсамбуу гишүүн гүйцээж хариулах уу? Болох уу? Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя.

**Н.Наранбаатар:** Тэр төсвийг хасах ч юм уу, өөрчлөх ч юм уу өөрчлөлт оруулах ажлыг нь хаана хийх юм? Ажлын хэсэг нь хийх юм уу? Засгийн газар нь татаж аваад хийж бидэнд оруулж ирж Их Хуралд танилцуулах юм уу? Яаж явах

юм? Тэгвэл зарчмын зөрүүтэй саналыг би ойлголоо шүү дээ. Шууд 2 өдрийн өмнө заавал өгөх шаардлага байхгүй юм байна. Тэгээд шууд Байнгын хороон дээрээ орж очоод л бичиж өгөөд байж болох юм байна гэж ойлголоо шүү дээ. Эхнийх дээр нь.

**Д.Амарбаясгалан:** Энэ миний ойлгосноор Наранбаатар гишүүн ингэж байгаа юм байна лээ. Одоо төсөв хэлэлцдэг үндсэн дэг байгаа. Үндсэндээ 2 дугаар хэлэлцүүлгээс энэ процесс эхэлж явахаар зохицуулалт хийж байгаа. Харин тэр дундаа мэргэжлийн яам буюу Сангийн яамны саналыг авч төсөвт нөгөө урсгал зардлыг багасгах зарим төрлийн хөрөнгө оруулалтуудыг хасах зэрэг ажлыг хийх болж байгаа учраас Сангийн яамнаас санал авах процессыг энэ нэг удаагийн хуулиар нэмж оруулж ирж байгаа юм байна гэж би ингэж ойлгосон. Лодойсамбуу гишүүн тодруулаад нэмээд хариулчихъя.

**Ч.Лодойсамбуу:** Энэ хуулийн 2 дугаар зүйл дээр төслийг хэлэлцэх үе шат гээд.

2.1 дээр Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Засгийн газрын боловсруулсан санал тооцооллын үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд зохих нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдаанд оруулна гэхэж байгаа. Тэгээд 2.2 дээр Засгийн газар энэ хуулийн 2.1-д заасан санал тооцооллыг Төсвийн байнгын хорооноос тогтоосон хугацаанд ирүүлнэ гэхээр Төсвийн байнгын хороо хугацаа тогтоож өгөөд Засгийн газар саналаа өгөөд тэгээд тэр дээр нь үндэслээд Их Хурал нь хэлэлцээд явах нь гэж ойлгож болно. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар дарга аа? Цогтбаатар гишүүн байна уу? Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярбаатар дарга нэмж хариулъя. 2 Байнгын хорооны дарга бас нэмээд байр сууриа илэрхийлчихье. Олон гишүүд энэ асуудлаар асуух учраас.

**Б.Баярбаатар:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Энэ удаагийн Төсвийн хуульд бүхэлд нь хориг тавьсантай холбогдуулаад өнөөдрийн мөрдөгдөж байгаа дэгийн хуулиараа асуудалд хандаж ажлын хэсэг ажилласан байж байгаа. Лодойсамбуу гишүүн сая бас тодорхой хариулах шиг болно лээ. Ер нь бид нар нэг ч хуулиар олгогдсон эрхийг бол энэ оруулж ирж байгаа дэгд бол хаагаагүй байгаа. Харин өмнө нь тавигддаг байсан хугацаатай асуудлуудыг бол энэ дэгээсээ бид нар хасаад Төсвийн байнгын хороон дээр Засгийн газар саналаа боловсруулж ирнэ. Бусад Байнгын хороод хуралдаад саналаа нэгтгээд ирнэ. Ингээд нөгөө нэг дэх хэлэлцүүлэг буюу энэ дээрээ бид нар нөгөө зарчмын зөрүүтэй саналуудаа гаргана. Нөгөө зарчмын зөрүүтэй санал гаргах дээр бид нар нэг их айхтар тийм, ингэж болохгүй, тэгж болохгүй гэсэн хоригуудыг нэг их айхтар оруулж өгөөгүй байгаа.

**Д.Амарбаясгалан:** Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар гишүүн хариулъя.

**Д.Цогтбаатар:** Тийм энэ дээр нөгөө урьд өмнө нь ингэж төсвийг тавьсан хоригийг бүхэлд нь тавьсан хоригийг хүлээж авч байсан жишиг байхгүй учраас бид нар бол тусгайлан хууль гаргаж хийж байна шүү дээ. Тэгэхлээр Улсын Их Хурлын бүрэн эрхтэй хамаарч байгаа энийгээ яг яаж зохицуулж хэн нь хаанаа хасах вэ гэдгийг яг энэ хуулиар нэг удаа хэрэглээд л дуусна шүү дээ. Тэгэхээр ердийн төсөв

хэлэлцэх зарчмаар бол энэ Их Хурлын гишүүдийн төсвийг оруулж технократуудын боловсруулчихсан төсвийг оруулж ирээд улс төрийн механизмаар дураараа танаж хянаад байдаг юмыг чинь уг нь хязгаарлаад өгчихсөн. Бид нар тэр төсвийн хууль чинь хүчинтэй байгаагаа анхаараад тэрийг хэн ч хориг тавьж өөрчлөөгүй байж байгаа. Тэр дээр улс төржих маягаар орохгүй байх тэр хуулийн үзэл баримтлалаа бол барьж ажиллах нь зөв. Гэхдээ энэ дээр бол нэгэнт нөгөө Засгаар орохгүйгээр тэгэхдээ бүрэн тавигдчихсан хоригтой төсөв орж ирж байгаа учраас ердийн хэлэлцүүлдгээсээ.

**Д.Амарбаясгалан:** Цогтбаатар гишүүний микрофоныг өгье. Нэмж хариулъя.

**Д.Цогтбаатар:** Тийм. Тэгэхлээр энэ дээр бол ердийн нөгөө хэлэлцүүлдэг журмаасаа гишүүд бол энэ дээр илүү бүтээлч бас хандаж оролцох боломжтой. Тэгэхээр энд хаана юугаа хасахаар байна? Угаасаа Их хурлын гишүүд бол хасах эрх байдаг шүү дээ. Зүгээр өөр эх сурвалжаа өөрөө тодорхойлох л ёстой байдаг болохоос биш. Тэгэхээр тэрийгээ ашиглаад л ажиллах хэрэгтэй.

**Д.Амарбаясгалан:** Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Асуулт давхацсан учраас санал хэлээд, үг хэлчихье гэж бодож байна. Нэг удаагийн хууль биш ер нь хуульдаа оруулаад өгчихсөн нь дээр байж дээ. Яагаад гэхээр энэ бол төсвийг хориг тавьсныг бүхэлд нь хүлээж авч байгаа анхны тохиолдол гэж байна. Цаашдаа ийм тохиолдол бас гарахыг үгүйсгэхгүй шүү дээ. Тэгэхээр бид нар нэг удаагийн дэгээр биш хуульдаа өөрчлөлт оруулаад шигтгэж өгөөд явуулчих байж дээ гэж бодож байна. Ёс зүй, дэгийн ажлын хэсэг Байнгын хорооноос гарсан ажлын хэсэгтэй холбогдуулаад нэг үг хэлчихмээр байна. Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсгийн хуралдаанд ерөөсөө ирэхгүй байна. Хэд хэдэн ажлын хэсэг хуралдаж чадахгүй хойшилж байна. Бүтэн цаг 30 минут ирц нь ирэхгүй хүлээгээд сууж байна.

Хэдий Их Хурлын гишүүн хүлээгээд яадаг юм гэж бодож байгаа байх. Гэтэл тэр ажлын хэсэгт зориулж маш олон судалгаа хийсэн ажилласан төрийн албан хаагчид ирж байгаа байхгүй юу гишүүд ээ. Тэд нар ажлаа хаяад ирж байгаа. Нийт байгуулагдсан 55 ажлын хэсэгт чинь энэ төрийн албан хаагчид ажил хийх боломжгүйгээр ажиллаж байгаа. Тэгээд та бидний дуудсан цагт хурал зарласан цагт бүгдээрээ ирж байгаа. Тэгээд өдөржингөө хүлээж байгаад явж байгаа. Яамнууд ажил хийж чадахгүй байгаа шүү. Тэгэхээр төсвийн мөнгөнөөс цалин авч байгаа юм чинь та бүхэн энэ асуудлыг бас жоохон хүндэтгээд цагтаа ирээд хурлаа хийж байвал яадаг юм.

Хэрвээ ажлын хэсэгт ирдэггүй, хуралд ирдэггүй, дандаа хоцордог, тасалдаг ийм гишүүдэд ер нь ямар хариуцлага тооцдог юм болоо. Татвар төлөгчдийн мөнгөнөөс цалин авч байгаа гэдгээ бас бодож баймаар байна. Цаана нь төрийн албан хаагчид та бидний энэ хүнд сурталд чирэгдээд ажлаа хийхгүй байгаа гэдгийг бас анхаармаар байна шүү дээ. Өөрсдөө ёс зүйгүй ийм авираа жоохон татмаар байна, нэлээн удаан харж байгаа. Үүнээс цаашаа энэ байдал үргэлжлэх юм яах ёстой юм оо Амарбаясгалан дарга аа?

**Д.Амарбаясгалан:** Цалин хасна даа. Ер нь яах вэ Улсын Их Хурлын Тамгын газраас бас энэ систем үйл ажиллагаатай холбоотой Улсын Их Хурлын гишүүдийн

дан ганц ирцээс гадна Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцож байгаа байдал, өдрийн хуралдааны нийт цагийн хэдэн хувьд нь суусан талаарх асуудлыг гаргадаг болох энэ системийн хөгжүүлэлт хийгдэж байгаа. Ер нь гишүүд бол бас 2 өдрийн чуулганы хуралдаанд бүрэн сууж байх ёстой. Зайлшгүй шалтгаантай бол эмнэлгийн чөлөө мөн бусад төрлийн чөлөө авах нөхцөл бол нээлттэй байгаа.

Ер нь Дэгийн тухай хуулиараа чуулганы хуралдаанд сууж байгаа гишүүн ганц чуулган биш Байнгын хорооны хуралдаанд сууж байгаа гишүүн түр болон тухайн өдрийн хурлаас гарахаар бол хурал даргалагчаас заавал зөвшөөрөл авдаг дэгтэй. Манайхан бол одоо ингээд орж ирээд өнөөдөртөө яах вэ би нэг их айхтар нэр усыг нь дурдаад яах вэ? Орж ирж бүртгүүлчхээд гараад явчихдаг гишүүд нэлээдгүй байгаа шүү дээ. Маш олон гишүүдийн ирц харагдаад байгаа мөртөө яг санал хураалтад ордог нь нэг 70 гаруй гишүүн л ороод байгаа шүү дээ. Байнгын жижүүрлэж байдаг маягтай. Тэгээд харин энэ жижүүрлэж байгаа гишүүдээ бас урамшуулдаг тэр тогтолцоог бас гаргах нь ч бас зөв байх гэж бодож байгаа. Бүлгийн дарга нар бол яг энэ чиглэл дээрээ бас нөгөө үг хэлж оролцоог нь хангах зохицуулалт нь бүлгийн дарга нарт эрх нь байгаа шүү дээ.

Жишээлбэл, чуулганы хуралдаан дээр аливаа асуудлаар үг хэлэх дарааллыг бүлгийн дарга нар гаргаж өгч байгаа юм. Тэр бүлгийн дарга нар ч гэсэн бүлэг доторх хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс үг хэлэх гишүүдийн оролцоог нь хангаж хийдэг байх ёстой. Мөнхбаатар дарга бол бүлэг дээрээ бүүр тийм систем программ нэвтрүүлээд эхэлчихсэн байна лээ. Байнгын хороо болон бусад хуралд оролцож байгаа байдлаар нь асуудалд хандаж байгаа юм. Тэгэхээр Мөнхбаясгалан гишүүний хэлж байгаа саналыг шүүмжлэлийг бас хүлээж авч хэрэгжүүлэх нь зөв юм гэж ингэж үзэж байна аа.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэбат:** Төслийн хууль, тогтоомжид зайлшгүй тусчихсан байгаа маш их зардлууд энэ танах зардал дотор байгаа юм байна лээ. Тийм учраас энийг ангилж ямар эрэмбээр эрэмбэлэх вэ гэдгээ юмаа тодорхой тусгаж өгвөл. Хууль тогтоомжоор зайлшгүй гаргах эс үгүй бол тэр хууль тогтоомжоо өөрчлөх хэрэгтэй болно. Эс үгүй бол хасах хэрэгтэй болно. Тэрний дараа зардлыг нь тусгах тусгахгүй гэдэг асуудал яригдах ёстой болов уу гэж бодож байна.

Тийм учраас энэ хуулийн төсөл дээр энэ дээр 2.7 дээр шаардлагатай гэж үзвэл Их Хурлын дарга, Төсвийн байнгын хороо, төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж болно гэж. Энэ дээр Хууль зүйн байнгын хорооноос би бас асуумаар байна. Хууль тогтоомжид зайлшгүй гарах ёстой зардлуудыг нь Хууль зүйн байнгын хорооноос бас тусгай ажлын хэсэг гаргаад нэг авч үзвэл яасан юм бэ гэдэг ийм саналыг асуулт саналыг хэлмээр байна.

**Д.Амарбаясгалан:** Ер нь Эрдэнэбат гишүүн их зөв зүйл хөндөж байгаа юм. Жавхлан сайд энэ хуулиар зайлшгүй тавих шаардлагатай төсвүүд гээд бас л хэл ам дагуулаад л улс төр болоод л байсан. Жишээлбэл энэ Соёлын яамны ваучерын асуудал. Хуулийн заалттай төсөвт суух шаардлагатай нөхцөл хангагдчихаад л орж ирээд л бас тодорхой хэмжээний улс төрийн нөхцөл байдал үүсгээд л явчихсан л даа. Тэгэхээр яг ийм хуулиар төсөвт тусгах зайлшгүй шаардлага үүсгэгчихсэн хэдэн хууль байна гэлээ 26 хууль байна уу? Жавхлан сайд энэ дээр эхлээд хариулт өгөөдөхье.

**Б.Жавхлан:** Энэ талаар гишүүдэд нэлээн дэлгэрэнгүй мэдээлэл өнөө маргаашгүй хүргүүлнэ. Ганц тэр ваучер биш ер нь 2024-2025 оны төсвийн тэр өсөлт 3.5 их наяд төгрөг. Тэр дотор одоо сайд нар салбар салбар өөрсдөө зохиогоод тавьчихсан зардал гэж нэг мөнгө ч байхгүй. Бүгд хууль, Их Хурлын тогтоол, төсөл хөтөлбөр үүний дагуу тавигдаж байгаа ийм урсгал зардлууд байдаг юм. Энийг нэг бүрчлэн мэдээллүүдийг гишүүдэд хүргүүлнэ. Ер нь бол бид цаашдаа төсвөө хэмнэлттэй байя төсвийнхөө зардлын өсөлтийг хязгаарлая гэж байгаа бол энэ шийдвэрүүдээ бид эргэж харах цаг нь болчихсон байгаа. Тийм учраас энийг нэг бүрчлэн дэлгэрэнгүй мэдээллийг та бүхэнд хүргүүлнэ.

Тэр Соёлын яамны ваучер дээр 18.5 тэрбум тэрбум бол 3.5 их наяд төгрөг дотор багтаж байгаа. Нийтдээ 46 хууль тогтоомжийн ийм шийдвэрүүдийн дагуу өсөж байгаа ийм зардлууд байгаа. Тэрний нэг л хэсэг нь байгаа. Тийм учраас энэ дээр бас гишүүд цаашдаа бид ер нь яах вэ гэдгийг нэг сайн хармаар ийм цаг нь болчихсон байгаа шүү гэдгийг хэлье.

**Д.Амарбаясгалан:** Тэгээд ер нь Ерөнхий сайд бас Засгийн газрын түвшинд бол энэ тусдаа хуулиар нэгдүгээрт төсөв, төсвийн хуулиас гадуур хийчихдэг энэ байдлыг нэгдүгээрт таслан зогсоолгох тал дээр анхаарал хандуулж ажиллая гээд бас Хууль зүйн сайдад чиглэл өгсөн байна лээ.

Хоёрдугаарт бас хуулиар албан байгууллага шинээр байгуулах орон тоо нэмэх асуудал бол бас өнгөрсөн парламентын үед бол бас нэлээдгүй, ганц парламент ч биш өнгөрсөн парламентуудын үед бол бас нэлээдгүй хийгджээ гэдэг ийм дүгнэлттэй зүгээр нэг жишээ гэхэд л 10 жилийн дотор 20 агентлаг хуулиараа байгуулчихдаг энэ байдлыг таслан цогцлоох ёстой гэсэн ийм байр сууриуд явж байгаа юм. Одоо энэ Булгантуяа гишүүнээр ахлуулчихсан төсвийн хууль болон төсөв хэлэлцэхтэй холбоотой бусад хуулиудын хоорондын цаглаврыг жигдлэх ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж байгаа.

Тэгээд энэ хүрээнд бас энэ хуулиудын асуудлыг хөндөж сөхөх нь зүйтэй гэсэн ийм байр суурийг бол хэлж байгаа. Ирэх долоо хоногт энэ ажлын хэсэг хуралдаж ирэх долоо хоногийн Баасан гарагт бас энэ ажлын хэсгийн хуралдсан талаарх мэдээллийг бас аваад тэрний дараагийн долоо хоногоос эхлээд намын бүлгүүд дээр энэ асуудлыг хэлэлцээд эхэлнэ. Тэгэхээр Сангийн яам энэ мэдээллээ өгөөд Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө бас энэ дээр ажлын хэсгүүдийг байгуулж ахалж ажиллах ийм шаардлага бол байгаа гэж бодож байгаа.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя. Алга байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

**Ц.Идэрбат:** Өглөөний мэнд хүргэе. Энэ нэг шинэ нөхцөл байдал үүсээд Монгол Улсын Ерөнхийлөгч бүх төсөвт бүхэлд нь хориг тавьсан үед яах вэ гэдэг зохицуулалт бидэнд байхгүйгээс болоод өнөөдөр энийг хэлэлцээд дэгээ батлах гэж байна. Тэгэхээр би энэ дээр нэг л зүйлийг бас хэлмээр байгаа юм. Ер нь энэ парламентад энэ олон намын систем орж ирсэн, 126 гишүүнтэй болсон гээд зохицуулалтуудын хувьд бол зайлшгүй хийх ёстой олон зүйлүүд бас бидэнд байгаа байх гэж ингэж бодож байгаа.

Ялангуяа энэ онцгой бүрэн эрхтэй холбоотой энэ төсөвтэй холбоотой асуудал дээр энэ өнгөрсөн төсвийн хэлэлцүүлгүүдийг харж байхад тэр нийгэмд гаргаж ирж тавьж байгаа тэр гишүүдийн гаргасан асуудлуудыг ч гэсэн хараад байхад энэ төсөвтэй холбоотой энэ асуудлууд дээр бид Дэгийн тухай хууль дээрээ ер нь нэлээн том өөрчлөлтүүдийг хийх зайлшгүй шаардлага бидэнд бас байгаа юм биш үү гэж ингэж харж байгаа юм. Төсөв хэлэлцүүлэх явцад ихэнх гишүүд зөвхөн нэг удаагийн юм яриагүй. Ер нь Монгол Улсын төсвийг ингэж хэлэлцэх чинь ер нь ямар юм бэ? Төсвөө бид хэмнэлттэй байх тал дээр ямархуу санаачилгатай ажиллах ёстой юм бэ гээд ингээд олон гишүүд ярьсан шүү дээ.

Тэгэхээр би бол энэ удаагийн энэ нэг удаагийн дэгийг бол дэмжинэ. Ер нь цаашлаад энэ дэгийн хууль дээр төсөв хэлэлцэх энэ процессыг өшөө нэлээн тийм дэлгэрэнгүй болгохгүй бол яг энэ байдлаар одоо байгаа хуулиараа бид дараа дараагийн төсвөө батлаад явна гэхэд бол эргэлзээ төрөхөөр олон зүйлүүд байгаа.

Төсөв дээр бид нар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн саналыг хүлээж авсан билүү. Аудит танилцуулаад л байдаг аудитын дүгнэлтийг бид нар хүлээж авсан билүү. Хэрвээ авахгүй юм бол энэ 2 байгууллагаар ингэж дүгнэлт гаргуулах ямар шаардлагатай байгаа юм. Авдаг байлаа гэхэд ямархуу цар хүрээнд бид нар авдаг байх ёстой юм гээд ингээд энэ мэтээсээ авхуулаад зохицуулалтуудаа нэлээн сайн хиймээр юм шиг санагдаад байгаа юм.

Хоёрдугаарт, Засгийн газраас өргөн барьсан энэ хууль дээр зөвхөн Төсвийн байнгын хороо юм уу төсвийн ажлын хэсгийнхэн давуу эрхтэй юм шиг ингэж оролцоод байх юм бол яаж цаашаа явах юм. Эсвэл бүгдээрээ Төсвийн байнгын хорооны хурал дээр 126 гишүүн очиж үг хэлж байж ингэх юм уу, эсвэл бүгдээрээ ажлын хэсэгт орох юм уу. Тэгээд хэдхэн хүний ингээд нэг Төсвийн байнгын хороонд орсон давуу эрх гэх юм уу, төсвийн ажлын хэсэгт орсон давуу эрх гэдэг юм уу түрүүгээрээ ингээд асуудлуудыг шийдээд өнөөдрийн төсвийн асуудал энэнээс ч үүдэлтэй байж магадгүй гэж би бол харж байгаа. Тэгээд Засгийн газрын өргөн барьсан хууль дээр Засгийн газрын гишүүд нь дундуур нь үймүүлдэг, ил болон далдаар.

Тэгэхээр Засгийн газрын гишүүд ер нь Засгийн газрын өргөн барьсан хууль дээр Төсвийн байнгын хороон дээр ажлын хэсэг дээр тэгж хөндлөнгийн санал оруулж ирэх эрх байх ёстой юм уу үгүй юм уу гэдгийг хүртэл би бол бүүр угаар нь яримаар байгаа юм. Одоо энэ төсвийн задаргааны асуудал байгаа. 3.5 их наяд төгрөг хэмнэмээр байна л гэж хэлж байгаа. Сонсоход их тоо. Гэтэл тэр дотор хасаж болохгүй тоонууд бас нэлээн байгаа, зардлууд байгаа. Хэрвээ бид нар ингээд энэ давлагаанд ороод хасчихвал нөгөө төрийн үйл ажиллагаа гацвал яах юм.

Гэхдээ бас хасахгүйгээр явна гэвэл хэтэрхий үрэлгэн төсөв болчихвол яах юм. Тэгэхээр энэ сайд нар төсвөө оруулж ирээд Засгийн газрын өргөн барьсан энэ юун дээр тухайн сайдад ямар зардлууд нь нэмэгдээд байгаа юм ангилал нь юу байгаа юм гэдгийг гишүүдэд тараагаад өгчихөд юу нь болохгүй байгаа юм. Том дүнгээрээ энэ чинь том дүн болж харагдаад нийгэмд замбараагүй төсөв батлаад байгаа юм шиг харагдавч салбар болгоны цаана ажил байгаа, төрийн албан хаагч нар байгаа. Тэр төрийн үйлчилгээ авч байгаа иргэн байгаа. Түүгээр дамжуулж хувийн хэвшлийнхэн тэр үүргийг гүйцэтгэж байгаа. Тэгэхээр бид нар нэлээн ялгаж салгахын тулд энэ зардлын ангиллын зүгээр базаад бид нарын дунд ингээд

тавьчих биш зардал зардлын ангиллаар нь сайд болгон энийг ингэж оруулж ирдэг ийм дэгийн хууль руугаа.

**Д.Амарбаясгалан:** Тийм. Одоо Идэрбат гишүүн чинь нөгөө Булгантуяа даргын ахалж байгаа ажлын хэсэгт байгаа тиймээ. Энэ ажлын хэсэг нэг дэх өдрөөс эхлээд эрчимтэй бас хуралдаж эхлэх ёстой. Яг л энэ төсөв хэлэлцэхтэй холбоотой асуудлыг бид халуун дээр нь энэ ондоо багтаж шийдье л гэсэн шүү дээ. Тэгэхгүй бол одоо ингээд төсөв хэлэлцэх процесстэй холбоотой асуудал үүсдэг. Улсын Их Хурлын гишүүд бас өөрсдийн санаа бодлыг бүрэн тусгаж чаддаггүй. Санаа бодол гэхээс илүүтэйгээр энэ төсвийн үр ашигтай байх нөхцөл дээр нь бодитой дүгнэлт гаргаж тэрийгээ хэрэгжүүлж чаддаггүй асуудлууд хүртэл энд хөндөгдөж байгаа.

Тэгээд энэ жил бол 126 гишүүнтэй парламент маань маш ажил хэрэгчээр асуудалд хандах нөхцөл боломжууд бол өргөн хүрээгээр тавигдчихсан байгаа. Зүгээр энэ жил анхны төсөв учраас аль аль талдаа дэг нь шинэ байгаад, гишүүд нь шинэ байгаад бүрэн хэрэгжүүлж чадаагүйгээс өнөөдрийн нөхцөл байдал бол үүсчихсэн байгаа. Энийг бид тал талаасаа бас ойлгож хүлээн зөвшөөрөх ёстой байгаа юм. Харин дараа жилийн төсөв хэлэлцэх процесс орж ирэхэд бид дахиж ийм хэмжээний алдаа гаргахгүй, гишүүд маань оролцоогоо бүрэн хангачихсан сууж байх нөхцөлийг хангахын тулд төсвийн тухай хууль, Дэгийн тухай хууль, төсвийн хүрээтэй холбоотой асуудлууд, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт гээд энэ олон зүйлүүдийг л бид нэг мөр эцэслэн шийдвэрлэе хоорондоо зөрчилгүй байя гэсэн ийм асуудлыг хөндөж байгаа.

Тэгэхээр Булгантуяа дарга ирэх долоо хоногт энэ 25 гишүүний бүрэлдэхүүнтэй том ажлын хэсгээ хэд хэдэн удаа хуралдуулаад ирэх 7 хоногийн 5 дахь өдөр гэхэд даргын дэргэдэх зөвлөл дээр танилцуулах хэрэгтэй. Тэгээд тэрний дараагийн 7 хоногоос намын бүлгүүд дээр энэ асуудал танилцуулагдаад гишүүд маань энэ асуудлаар оролцоогоо бүрэн хангаад явах хэрэгтэй гэж ингэж хэлмээр байна аа.

Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

**Х.Ганхуяг:** Энэ дэг бол ер нь хэрэггүй байсан юм. Бид нар Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авснаар шууд Засгийн газарт буцаах ёстой байсан юм. Одоо энэ өнөөдрийн хуулиар буцаахгүйгээр бид нар ингээд хэлэлцээд явахаар энэ Их Хурлын бүрэн эрхийн асуудал болчхож байгаа юм. Тэгээд нэг ёсондоо Улсын Их Хурлын гишүүд дураараа төсөв дээр саналаа оруулж болно гэсэн үг. Ийм нөхцөл байдал үүсгэгдэж байгаа.

Тэгэхээр яах вэ одоо ажлын хэсэг нь Засгийн газрын өмнөөс дараа жил хариуцлага хүлээх юм уу гэдэг асуудал үүснэ гэсэн үг. Ажлын хэсгийн дарга нь бол Ерөнхий сайдын хариуцлагыг хүлээх юм уу гэдэг асуудал үүснэ л гэсэн үг. Энэ чинь одоо Засгийн газар, Их Хурлын дунд энэ асар том зөрчлийг бий болгоно гэсэн үг. Тэгэхээрээ бид нар бол энэ төсвийг шууд Засгийн газарт нь буцаагаад Засгийн газар хасах ёстой юмаа хасаад тэгээд буцаагаад л өргөн барих ёстой байсан. Ерөөсөө л бид нар тэр хоригийг хүлээж авахдаа бас Улсын Их Хурлын тогтоол гаргаад тэгээд улсын төсвийг Засгийн газарт буцаах л ийм л асуудал байсан. Яг төсвийг баталдаг өглөө ч гэсэн би Байнгын хороон дээр хэлээд тэгээд дэмжигдээгүй.

Тэгээд өнөөдөр яг ийм нөхцөл байдал үүсчхэж байгаа юм л даа.

Хоёрдугаарт өмнөх 76 байхад бол бид нар төсөв хэлэлцэж байхад бол бүх гишүүдийг гадаад томилолтыг нь болиулдаг байсан юм. Өнөөдөр ингээд 30 гишүүн нь гадаад томилолттой явж байна. Тэгээд төсвөө хэлэлцээд явдаг. Бид нар чинь 12 сарын 6-ны дотор төсвөө батлах ёстой. 12 сарын 6-ны дотор. Одоо энэ чинь хэдхэн хоног үлдэж байгаа байхгүй юу. Тэгээд ирэнгүүтээ энэ чинь тийм байна тэр чинь ийм байна гээд л дахиад л энд хэвлэлийн бага хурал хийгээд л ингээд л явна.

Гуравдугаар асуудал хариуцлагын асуудал ерөөсөө яригдахаа больчихлоо дарга аа. Ажлын хэсэгт орж ажилласан гишүүд нь гараад л хэвлэлийн бага хурал хийгээд л тэгээд л, самарч хаялаа шүү дээ үндсэндээ. Тэгээд тэр нь ажлын хэсэг дээр яагаад юмаа ярьдаггүй юм? Энэ дээр бас нэг 2, 3 асуудал байгаа. Хуучин бас хуучин саад байх ч юу байх вэ. Ер нь болж өгвөл энэ Төсвийн байнгын хороо мэргэжлийн Байнгын хороон дээр асуудлуудыг нь нэлээн сайн ярьдаг баймаар байна. Ажлын хэсэг дээрээ тэндээсээ дийлэнх олонхыг нь оруулдаг баймаар байна. Тэгээд энд тэндээс баахан хүмүүс оруулж ирээд ингээд ажиллуулчихдаг. Тэгээд Төсвийн байнгын хорооны гишүүдийн гаргасан санал нь ч дэмжигддэггүй. Тэгээд л ингээд л баталсан шүү дээ. Өнөөдөр бид нар Дэгийн тухай хуулийг ярьж байна. Бас Төсвийн байнгын хороо оролцоогүй ийм л дэгийн хуулийг ярьж байна.

Тэгэхээр энийгээ бид нар ийм ингээд нэг ийм юм ярьж байхаар цөмөөрөө өнөөдөр шууд Засгийн газарт буцаах асуудлыг л ярих ёстой байсан. Тэгэнгүүтээ орон нутгийн төсвүүдийг яах вэ гэдэг асуудлыг Улсын Их Хурал тогтоол дээрээ оруулчих ёстой байсан. Тэгэхгүй бол одоо бид нар энэ сая сарын өмнө хөгжлийн төлөвлөгөөгөө хамт баталсан шүү дээ. Тэр хоёр долоо хоногийн өмнө байна уу тиймээ? Хөгжлийн төлөвлөгөөтэйгөө төсөв нь яаж уялдах юм. Тэгээд ирэх жил ер нь бид нар яг юу хийх юм бэ гэдэг чинь асуултын тэмдгийн цаана үлдчихлээ шүү дээ дарга? Хэн хариуцлага хүлээх юм ажлын хэсэг хариуцлага хүлээх юм уу? Засгийн газар хариуцлага хүлээх юм уу? Ийм л асуудлууд байна даа. Энэ дээр нэг хариу авчихмаар байна. Энэ дээр хэн хариулт өгөх вэ гэдгийг нь сайн мэдэхгүй л байна.

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн ажлын хэсгийн дарга хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Баасандорж дарга тодорхой хариулаад өгөөч.

**Д.Амарбаясгалан:** Үгүй, танайх ажлын хэсэг дээр яагаад ийм санал гаргаж оруулж ирж байгаа талаараа тайлбарлах нь зөв байх аа.

**Ч.Лодойсамбуу:** Энэ бол энэ одоо байгаа дэгийнхээ хуулиар л явж байгаа. Энэ нэг удаагийн дэг хийж байгаа нь одоо байгаа Дэгийн хуулиар л зохицуулаагүй суудлуудыг асуудлыг яаж хэлэлцэх вэ гэдэг нь Дэгийн хуулиараа манай энэ дэгийн байнгын хороо хэлэлцэх үүрэгтэй. Тэрнийхээ дагуу л нэг арга хэлбэрийг нь олоод л ингээд л оруулж ирж байгаа. Энэ нэг удаагийн хууль байх нь зөв. Яагаад гэхээр энийг Их Хурал өөрөө заавал хуулиар шийдвэр гаргах Үндсэн хуулийн 25 дугаар зүйл дээр байгаа Улсын Их Хурал бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар зохицуулна гээд заачихсан учраас л хууль гаргаж байгаа юм.



Ёстой байсан гээд яах вэ таны хэлж байгаа саналуудыг ойлгож байна л даа. Тэр нь бол өнгөрчихсөн асуудал буюу манай ажлын хэсэг бол тэр Их Хурлын гаргасан шийдвэрийн дараа хэрхэх вэ гэдэг гаргалгааг нь гаргаж байгаа л ажлын хэсэг. Манай гаргалгаагаар гаргаж байгаа гаргалгаа нь энэ байна аа. Өнгөрсөндөө тэр хүчингүйд тооцоод буцаах байсан гэдэг бол тэр байсан өнгөрсөн л асуудал. Их Хурал бөөнөөр олонхоороо л шийдсэн асуудал.

**Д.Амарбаясгалан:** Одоо Дэгийн тухай хуулиар Ганхуяг гишүүн бас мэдэж байгаа байх л гэж бодож байна л даа. Тэмүүлэн гишүүн ч уг нь мэдэж байсан.

Нэгдүгээр хэлэлцүүлгээ хийгээд хөгжлийн бодлого төлөвлөлтөд нийцэж байна уу гэдгээр санал хураагаад гишүүд нийцэж байна гэхчхэнээс хойш Засгийн газарт буцаах боломжгүй болчихсон байхгүй юу. Тэгэхээр энэ чинь өөрөө Дэгийн тухай хуулиараа ийм зохицуулалт нь байж байхад бид нар 2 дугаар хэлэлцүүлэг дуусчихсаны дараа буцаана гээд сууж байх ямар ч боломжгүй болчихсон байхгүй юу энэ чинь.

Ганхуяг гишүүн тодруулж асууя.

**Х.Ганхуяг:** Үгүй үгүй. Бид нар сая энэ улсын төсвийг Засгийн газар руу нь буцаахгүйгээр ажлын хэсэг дээр 3.6 их наяд төгрөгийг танах боломжтой гэдэг ийм юм яриад байгаа шүү дээ гишүүд. Тэгээд дараа жил төрийн ажил доголдвол яг хэн хариуцлага хүлээх вэ гэдэг л асуулт дээр би хариулт авчихмаар байна, нэгдүгээр асуудал.

Улсын төсөв бол Засгийн газрын онцгой бүрэн эрх байдаг юм. Санал оруулах нь. Одоо ямар асуудал үүсэж байна гэхээр Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал болчхож байгаа юм. Бид нар буцаахгүй бол Засгийн газраас зөвхөн санал авна. Тэгснээр дараа жилийн хөгжлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны тайлан, төсвийн гүйцэтгэл. Энэ дээр яг хэн хариуцлага хүлээх юм бэ гэдэг асуулт дээр надад хариулт өгөөдхөөч.

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Манай энэ төслийн 2.2 дээр байгаа. Засгийн газар саналаа Ерөнхийлөгчийн энэ хоригтой холбоотой саналаа Төсвийн байнгын хорооноос тогтоосон хугацаанд нь ирүүлнэ гэж. Тэр дээр нь үндэслээд хэлэлцүүлгүүд нь явна. Засгийн газар нь боловсруулах үндсэн эрхтэй, Их Хурал нь тэр хуулийг батлах төсвийг батлах онцгой бүрэн эрхтэй. Тэгээд энэ зарчмууд ерөөсөө алдагдаагүй байгаа л гэж ажлын хэсэг дээр яригдсан яригдсан энэ сэдвээр.

**Д.Амарбаясгалан:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Нэг асуулт байна. Энэ төсвийн тодотголтой холбоотойгоор зарим хуулиудад бас энэ хамт өргөн мэдүүлсэн хуулиудаас гадна өөр хуулиудад бас өөрчлөлт орох магадлалууд байгаа. Тухайлбал, төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн орлогын хэмжээ өөрчлөгдөж магадгүй, эдийн засгийн өсөлтийн хэмжээ өөрчлөгдөж магадгүй. Түрүүн бас хэлсэн бусад хуулиудтай холбогдолтой зардлуудыг хойшлуулах асуудал яригдвал тэр хуулиудад бас өөрчлөлт оруулах

асуудал үүсэж магадгүй. Тэгэхээр энэ бусад энэ өргөн мэдүүлсэн дагалдаж өргөн мэдүүлснээс бусад хуулиудыг ямар байдлаар өөрчилж энэ дэгд хэлэлцсэн юм болоо? Энэ талаар мэдээлэл авах гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсэг дээр энэ асуудлууд хамт өргөн мэдүүлсэн хуультай холбоотой асуудлууд яригдсан уу? Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн хариулья.

**Ч.Лодойсамбуу:** Энэ төсөл нь гишүүдэд тараагдаагүй юм шиг байна тийм үү? Энэ тараагдсан байгаа. Энхтүвшин гишүүн дээр байгаа юу байгаа тиймээ? Энэ дээр 6 дугаар зүйл дээр холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэн батлах гээд. 6.1 дээр төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл шаардлагатай гэж үзвэл төсөл баталсантай холбогдуулан арга хэмжээний тухай тогтоолыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хууль тогтоолын төслийг хэлэлцэх журмын дагуу хэлэлцэж баталж болно гээд л ингээд одоо байгаа мөн хуулиуд дээрээ бас аваад хэрэгжүүлэх боломжтой гэдгээр заачихсан зохицуулчихсан байгаа л даа.

**Д.Амарбаясгалан:** Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулж нэг удаагийн харилцаа зохицуулсан дэгийн нэмэлт ороод байна л даа. Тэгэхээр энэ орж ирчхээд байгаа төслийн 2, 3 дугаар зүйл хамгийн чухал асуудал байгаад байгаа юм. Хориг хүлээгээд авчихсан бол Их хурал Засгийн газарт төслийг хүргүүлээд, дахиад боловсруулалт тооцоололт авахаар томъёологдож орж ирчхээд байгаа юм. Энийгээ нэгдүгээрт тодорхой болгож өгмөөр байна, нэг. Тийм боломж байна уу гэж.

Хоёр дахь зүйл Төсвийн байнгын хороо хугацаа тогтоодог биш Засгийн газарт хориг хүлээж авсантай холбогдуулаад төсөл буцаачихсан бол хэд хоног дотор боловсруулалт хийж Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд ирүүлэх ёстой юм бэ гэдэг хугацааг нь тодорхой болгож өгмөөр байна аа. Тэгэхгүйгээр энэ асуудал зөв шийдлээ олж явна гэхэд тийм нэлээн эргэлзээтэй ийм зүйл гарч ирээд байна. Тэгэхээр ийм боломж байна уу гэж? Нэг.

Хоёр дахь зүйл дахин боловсруулалт хийгээд ороод ирчихсэн тэр төслийг аудитын байгууллага төсвийн тогтвортой байдлын зөвлөлдөө хэрхэн хүргүүлж хэд хоног дотор багтааж дүгнэлт гаргуулж авах юм бэ гэдэг асуудлыг өөрийг нь бас цаглаваржуулж өгөх шаардлага байгаад байна аа. Дараа нь Төсвийн байнгын хороо, ажлын хэсэг, энэ асуудлаа хариуцсан Засгийн газрын гишүүн 3 параллелийн Байнгын хороод, Дэд хороод, намын бүлгүүдэд асуудал танилцуулахаар ингээд орчхоод болж өгөхгүй байна л даа. Тэгэхээр зэрэг үүнийг нэг талд нь гаргаж зөв шийдэж өгөх хэрэгтэй. Төсвийн байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонуудад Засгийн газрын гишүүн асуудлаа танилцуулдаг. Бусад Байнгын хороо нам, эвслийн бүлгүүдэд ажлын хэсэг нь асуудлаа танилцуулдаг хэлбэрээр юм уу ингэж оруулж өгөхгүй бол хоёрдмол байдлаар параллелийн юм явах гээд байгаа ийм нөхцөл зохицуулалт орчхоод больж өгөхгүй байна. Үүн дээр та хэд маань одоо ямархуу бодол санаа байна вэ гэдэг ийм зүйл.

Ер нь дахин боловсруулаад тооцоолол хийгээд ороод ирчихсэн төслийг Төсвийн байнгын хороо эхэлж авч үзээд бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгүүдэд хүргүүлэх ёстой юм уу, эс үгүй бол орж ирсэн нь шууд бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгүүдтэй нь танилцагдаад тэндээс дүгнэлт нь эргээд Төсвийн байнгын хороондоо ирэх юм уу гэдэг энэ нэг процессын дарааллын их тодорхой болгож өгөхгүй бол бас нэлээн тийм задгай байдал нөхцөлийг үүсгэх гээд нэг л ийм л юм л харагдаад болж өгөхгүй байна л даа. Тэгээд энэ дээр нэг ийм хэдэн зүйл дээр их тодорхой хариулт санал авчихмаар байна.

Хоёр дахь зүйл бол яах аргагүй түрүүн Наранбаатар хөндсөн юм. Бид хууль дээдлэх ёстой. Тийм учраас Төсвийн тухай хууль бол өөрөө цаглавартай хууль байхгүй юу. Хаанаа төсвөө яаж боловсруулж, яаж өргөн мэдүүлж, яаж батлуулах вэ гэдэг дандаа хугацаатай ийм зүйл ээ. Тэгэхээр энэ орон нутгийн төсөв боловсруулж өргөн мэдүүлж батлах хугацаанууд чинь энэ жилийн хувьд эрх зүйн хувьд бол хангагдахгүй болчихоод байгаа юм аа. Энэ нь өөрөө тодорхойгүй байдлыг үүсгээд байгаа юм аа. Хэн нэгэн хүн хууль тайлбарлах боломжгүй ээ.

Тийм учраас Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын хуулийг гаргаж энэ жилийн хувьд энэ орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах тэр цаглавар цаг хугацааг бид тодорхой хугацаагаар хойшлуулж өгч байж хуулийн тодорхой байдлыг хангах ёстой, хууль дээдлэх зарчмаа хангах ёстой ингэж байж энэ Их Хурал үүргээ хэрэгжүүлэх ёстой гэж би ойлгоод байгаа. Энэ чинь өөрөө үр дагавар их өндөртэй хууль шүү. 12 сарын 5 гэдэг юм уу, 12 сарын 20-ны дотор төсвөө баталж чадаагүй хурлууд.

**Д.Амарбаясгалан:** Батжаргал гишүүн нэмж авах уу? Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн хариулт өгье.

**Ч.Лодойсамбуу:** Сүүлийн асуултаас нь эхлээд хариулъя. Энэ болохоор бид нар манай энэ ажлын хэсэг бол яг энэ хоригтой холбоотой, хоригийг Их Хурал хүлээж авсантай холбоотой энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг л зохицуулах ийм ажлын хэсэг байгаа.

Тэгэхээр энэ э орон нутгийн төсвүүдийн цаг нь тулчихсан байгаа асуудлыг бол манай ажлын хэсэг бол хариуцахгүй байгаа. Ер нь Их хуралд бүрэн эрх нь байж байгаа. Одоо санаачлаад ажлын хэсэг гаргаад ингээд явах зайлшгүй шаардлагатай. Энэ бол орон нутаг дээр яг тулчихсан асуудал гэдэгтэй санал нэг яг адилхан тийм бодолтой байна. Аль Байнгын хороо нь ерөнхийдөө танилцуулах юм бэ гэж. Энэ хуулийн төслийн 3.2, 3.3 дээр Төсвийн байнгын хороо тэгээд Засгийн газрын гишүүн гээд ер нь аль аль нь л танилцуулж болохоор ингээд оруулаад өгсөн байгаа.

2.1 дээрээ хамгийн эхний асуулт. 2.1 дээр хэн нь хариуцах юм бэ гээд байгаа. Энэ Засгийн газраас ирүүлсэн саналыг үндэслээд энд хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэнэ л гэдгийг энэ тодорхой заачихсан байгаа. Мөн одоо энэ мэргэжлийн байгууллагуудын санал, дүгнэлтийг авах хугацаа ямар байх юм бэ гэж. Энэ хуулийн төслийн 2.8 дээр төслийн талаар төрийн аудитын төв байгууллага болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг гаргуулж болно гээд заачихсан байгаа. Авна биш гаргуулж болно оо гээд ингээд тодорхой заачихсан. Энэ дээр зүгээр ажлын хэсэг дээр бол яригдсан. Яг энэ болно оо гээд заачихаар санал авъя гэж ингэж яваад тэгээд нөгөө төсөв батлах хугацаа маань

ингээд хойшлоод улам ерөнхийдөө тэгээд энийг ер нь хасъя гэдэг зарчмын зөрүүтэй санал бас Байнгын хороон дээр гарсан. Тэгээд дэмжигдээгүй байгаа. Энэний дараа санал хураах бол хэрвээ та энэнтэй санал нэгдэхгүй байгаа бол бас энийг хасах тэр дэмжигдээгүй саналыг нь дэмжихгүй байдлаар өгч болох байх саналаа.

**Д.Амарбаясгалан:** Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууя.

**Д.Ганбат:** Дарга аа тэнд тодруулах юм биш үү? Батжаргал гишүүн яах юм тодруулах юм уу?

**Д.Амарбаясгалан:** Би хурлаа удирдаж байгаа. Ганбат гишүүн таны микрофон эхэлчихсэн байна. Таны микрофон өгчихсэн хойно тодруулъя гэгчихсэн юм.

**Д.Ганбат:** Өө яах юм бэ?

**Д.Амарбаясгалан:** Тэгвэл дараачийн хүн асуух уу? Дашдондогийн Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** Баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс энэ 2025 оны төсөвт бүрэн хориг тавьсан. Тэгээд тавьсан тэр хоригийн бичиг баримтыг би нэг л удаа уншсан л даа. Уншиж байхад бол тэр нэлээн тэр ойлгож цаашаа бас нэлээн энэ төсвөө янзлахаар юмнууд байна лээ л дээ. Тэгээд энийгээ л сайн уншмаар байгаа юм аа. Нөгөө талаар тэр улсын төсөв бол алдагдалгүй байх ёстой, бид нарын хэт өөдрөг төсөөлөөд байгаа энэ юм бол энэ 2025 онд хүнд хэцүү шүү гэдэг нь бүгд ойлгомжтой байгаа шүү дээ.

Тэгэхээр ерөөсөө энэ төсвийг эхнээс нь хэлэлцье ээ. Яг төсвийн тэр дэс дараалал нь ямар байдаг вэ? Тэр дарааллаараа л хэлэлцэхгүй бол олигтой төсөв болж чадахгүй ээ. Мэдээж хэрэг нэг сар гээд энэ орон нутгийн төсөв энээ тэрээ юмнууд байгаа. Тэрийгээ ойлгож байна. Гэхдээ тэнд одоо тэр цалин өдөр тутмын үйл ажиллагаа явуулах энэ бүх юмнуудыг нь бол батлаад өгчихмөөр юм шиг байгаа юм. Зайлшгүй.

Нөгөө талаар бол уул нь яг зарчим яриад л ингэх юм бол энэ төсвийг оруулж ирж батлуулсан, эхнээс нь явсан энэ хүмүүстээ тэгээд итгэл хүлээлгэх юм уу үгүй юу энэ тэр гээд л ингээд л санал асуулга яваад л, тэрнийхээ дараа тэгээд ахиад төсвийг нь тэр Засгийн газар нь итгэлийг нь хүлээж байвал ахин боловсруулж орж ирээд л тэрийг нь эхнээс нь хэлэлцүүлээд л төсвийг алдагдалгүй болгоод л ер нь алдагдалгүй болох юм уу яах юм? Тийм алдагдалгүй төсөв батална гээд Сангийн сайд тэгээд байх шиг байсан. Тийм.

Тэгээд гадна дотнын нөхцөл байдал ч гэсэн өөр болчихлоо шүү дээ. Тэр манай нүүрс энэ тэр чинь үнэ нь нэлээн жоохон унаж байх шиг байна. Бид нарын гаргаж байгаа экспортын 90 хувь нь урд хөрш рүү явж байгаа. Урд хөршийн нөхцөл байдал ч гэсэн эдийн засгийн нөхцөл байдал өсөлт энэ тэр бол нэлээн доогуур байхаар шиг ийм шинжтэй байна аа. Бид нарын Засгийн газрын төсөөлөөд байдаг тэр 8 хувийн эдийн засгийн өсөлт бол энэ 2025 онд байхгүй байх.

Тэгээд бид нарын бас нэг юу байна л даа. Энэ Монгол Улсын төсвөөр бүх асуудлыг шийднэ гэсэн ийм бодол байж болохгүй ээ. Тэр Улсын Их Хурлын сонгуульд намын намууд мөрийн хөтөлбөрөө дэвшүүлээд явж байсан. Мөн намын мөрийн хөтөлбөрт бүгд л цомхон байна. Улсын төсвийн ДНБ-ий 25 хувиас хэтрүүлэхгүй гэсэн ийм зүйл заалтууд байгаа. Тэгээд сонгогчдоосоо тэгж санал авчхаад тэгээд тэд нарыгаа залилаад хуураад мэхлээд байж болохгүй л дээ. Яг тэр хөтөлбөртөө нийцүүлээд энэ анхныхаа төсвийг боловсруулж оруулж ирэх нь зөв байх. Тэгэхгүй бол олон намын ийм парламенттай болсон 126 гишүүнтэй болсон энэ тэр гэж бид нар яриад байдаг боловч тэрнийх нь юм нь энэ дээр харагдаж ирэхгүй. Нэг баахан кнопчид байгаа юм шиг л ийм болчхоод байх юм. Тэгээд энэ дээрээ хэдүүлээ анхаараад яг тэр ард түмнээр нь хэлэлцүүлэх тэр энэ тэр юмыг нь хийлгүүлээд ингэж явбал нэг аятайхан төсөв болчих юм биш үү? Тэгэхгүй бол бид нар цаг хугацаа алдаад ингээд хоног хугацаа бас л эргээд л нэг тэр косметический тийм юм хийгээд л үр дүн муутай юм биш үү гэсэн иймэрхүү санал бодол байх юм аа. Тэгээд л нэг ийм түргэн түүхий юм хийгээд л яаж ийгээд л хүнийг нэг аргалах гэсэн ийм байж болохгүй гэсэн ийм бодолтой байх юм.

Тэгээд сая тэр Ганхуяг гишүүний хэлдэг үнэн л дээ. Тийм тийм л байх, ёстой шүү дээ уг нь бол. Тэгэхгүй энэ хуулийнхаа хүрээнд ингээд ярихад чинь бид нар тийм төсвийг өөрчлөхөөр тийм эрхтэй биш шүү дээ. Тэр нэг эх үүсвэрийг нөгөө эх үүсвэрийг олно барина гээд л бас манай Цогтбаатар.

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн ажлын хэсгийн дарга хариулт өгье.

**Ч.Лодойсамбуу:** Санал хэллээ шүү дээ сая.

**Д.Амарбаясгалан:** Асуулт асуусан. Төсөв алдагдалтай болох юм уу? Алдагдалгүй болно гэж Сангийн сайд мэдэгдсэн гэдэг нэг ийм алдагдалгүй болох юм уу гэдэг тодорхой асуулт асуусан. Энэнд Сангийн сайд хариулъя.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууя. Хэлэлцэж байгаа асуудлаас өөр асуулт орж ирж байгаа учраас.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхээр энэ одоогийн энэ бид нар нэг удаа хэрэглэх дэг гэж хэлэлцээд байна шүү дээ. Тэгэхээр бид нар төсөв хэлэлцэх гэж байгаа байхгүй юу. Төсөв бол өөрийн дэгтэй, тусгай дэгтэй. Төсвийн тусгай дэгтэй байсаар байтал бид нар төсвийг дэг зохиож хэлэлцэх юм бол энэ харин цэц дээр унах магадлалтай шүү. Би одоо Баасандоржид бол зөндөө л хэлсэн. Зүгээр энэ төсөв хууль батлагдаад хүчин төгөлдөр л болоогүй байхгүй юу. Эхний хэлэлцүүлгээр нь бид нар хүлээгээд авчихсан. Одоо ингээд л муу хууль гээд л ингээд л зарим хүн яриад байх юм. Үгүй тэгвэл бид нар эхний хэлэлцүүлэг дээр нь энэ Төсвийн тогтвортой байдлын хуультай нийцэхгүй байна энэ хууль болохгүй байна гээд буцаах байсан байхгүй юу. Буцаагаагүй учраас Их Хурлын асуудал болчихсон. Төсөв бол Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаардаг асуудал. Бид нар Үндсэн хуулиар зардал нэмж болохгүй, орлого зохиомлоор нэмж болохгүй. Бусад бүх зохицуулалтыг хийж болно. Тийм учраас би буцааж байгааг ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Зүгээр хууль хүчин төгөлдөр болж чадаагүй байхгүй юу. Тэгэхээр хууль яасан төсвийн төслөөрөө үлдчихсэн. Тэгэхээр төсвийн төслийг хэлэлцэх тусгай дэгтэй. Одоо Цэц дээр очихоор юу гэх вэ?

Одоо жишээлбэл ингэж тайлбарлах нь л даа. Дэгээр зохицуулдаг байсан гэж цэц юу гэх вэ дэгээр зохицуулчихсан байсан гэж хэлнэ. Наадах чинь төсвийн хэлэлцэх дэг чинь байна 4 үе шаттай байна л гэж хэлэх байхгүй юу. Зүгээр харин миний ойлгож байгаагаар нэг тодруулах юм байсан байж магадгүй.

Хэрвээ Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан бол 2 дугаар хэлэлцүүлгээс явна гэж. Нэг ийм тодруулга Дэгийн тухай хуульдаа хийчих юм бол ямар ч асуудал байхгүй. Энэ чинь төсвийн төсөл. Одоо бид нар төсөв л батална шүү дээ. Хориг тавилаа гээд энэ чинь өөр хууль болоогүй байхгүй юу. Төсвийн төсөл хэвээрээ л байгаа. Төсөв батлах гээд байгаа байхгүй юу. Төсөв яаж батлахыг дэгийн хуулиар зохицуулчихсан байгаа. Бид нар хэрвээ зохицуулаагүй гээд өөр дэгээр хэлэлцэх юм бол харин энэ асуудал болно оо. Яг асуудал болно. Тэр санал авч байгаа юм энэ тэр бол надад болохгүй л санагдаад байгаа юм. Зүгээр бид нар хэрвээ нэг бол нэг тохиолдол гарсан юм байна лээ буцаасан юм байна лээ. Тэгэхдээ буцаах гэдэг бол бас асуудалтай. Яагаад гэвэл бид нар эхний хэлэлцүүлгээрээ буцаах байснаа хэрэглээгүй байхгүй юу. Тогтвортой байдлын хуульд нийцлээ сайхан хууль байна зардал нь болж байна гээд л бид нар бүгдээрээ хүлээгээд авчихсан байхгүй юу. Одоо хэн нэгнийгээ буруутгах ямар ч эрх бидэнд байхгүй. Өөрсдөө хүлээж авчхаад.

Тийм учраас одоо бид нар энийг харин бүгдээрээ засах ёстой. Нэгэнт одоо Ерөнхийлөгч ингэчихсэн юм чинь. Тэгэхээр 2 дугаар хэлэлцүүлгээсээ эхлээд л бүх Байнгын хороод хэлэлцээд л тэгээд 3, 4 явах ёстой. Энэ дээр 3, 4-ийг байхгүй 4 дүгээр хэлэлцүүлгийг байхгүй болгочихсон байна лээ. Болохгүй бид нар яг төсөв хэлэлцдэг бүх дэгээрээ явах ёстой. Төсөв өөрийн гэсэн дэгтэй. Тэрнээс биш одоо ингээд 3 хэлэлцүүлгээр бид нар төсөв батлах л юм бол харин унана аа. Энийг ер нь анхааралтай хандахгүй бол энэ дээр арай л гоомой хандчих шиг боллоо гэж би бодоод байна. Одоо ингээд нэг юм арай гэж баталдаг очоод энэ хууль нь уначихвал яах юм. Энэ дэгийг чинь энэ нэг удаагийн хууль чинь бас хориг 50 юу? Цэцэд очиж болох байхгүй юу. Энүүгээр бүх асуудлыг шийдчихгүй.

Тийм учраас бид нар энэ бид нарын зохиосон энэ дэг төсвийн тусгай дэг байгаад байхад ийм юм зохиолоо гэдэг асуудлаар унаж магадгүй ээ. Тэгээд бид нар энийг маш сайн бодож ингэж ч хийхгүй бол бүр ийм нэг тийм сунжралдсан юм руу явчих гээд байна уу гэж би зүгээр болгоомжлоод байна. Ер нь 2 дугаар хэлэлцүүлгээсээ эхлээд л ингээд л явчих бүрэн боломжтой байсан гэж би бодож байгаа юм. Яах вэ хэрвээ тодруулах шаардлага байсан Дэгийн хууль дээрээ Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авснаас хойш 2 дугаар хэлэлцүүлгээсээ явна аа. Төсвийн хуулиа бид нар төсөв батална. Тэгэхээр төсвийнхөө дэгээр явах ёстой.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн дарга Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн хариулъя. Нэмж манай 2 Байнгын хорооны дарга бас нэмж хариулт өгөх нь зүйтэй байх гэж бодож байна. Лодойсамбуу гишүүн.

**Ч.Лодойсамбуу:** Тэгээд одоо мөрдөгдөж байгаа Дэгийн тухай хуулийнхаа 73 дээр энэ манай энэ улсын төсөв, Төсвийн тухай хууль батлагдчихсан. Одоо төсвийн төсөл биш гэж ойлгож байгаа. Одоо бол бид нарын таны 2 дугаарт хэлж байгаа энэ оруулсан дэг дээр нөгөө Төсвийн хууль дээрээ байгаа төсвийг батлах энэ дэг дээрээ байгаа 3, 4 дүгээр хэлэлцүүлэг 4 дүгээр хэлэлцүүлгийг хасчихсан байна гэнэ. Зарчмын хувьд одоо бид нар хэдийгээр 3 хэлэлцүүлэгтэй байгаа ч

гэсэн тэр 1 дүгээр хэлэлцүүлгийн зарчмын хувьд 2 дугаар хэлэлцүүлгээс эхэлж байгаа. Тэгэхээр үнэхээр үнэндээ зарчмын хувьд бол хасаагүй л гэсэн үг.

**Д.Амарбаясгалан:** Цогтбаатар дарга нэмж хариулъя.

**Д.Цогтбаатар:** Миний байр суурь би Байнгын хороон дээр ч хэлсэн сая энэ дэгийн асуудал хэлэлцэж байхад хурал дээр ч хэлсэн. Ганхуяг гишүүний адил нэг байр суурьтай байгаа. Тэгэхдээ ажлын хэсэг дээр одоо яг энэ оруулж ирж байгаа юу хувилбар мөн үү гэвэл харин мөн шүү. Их Хурал хууль батлах тэрийгээ энэ улсын 1 сая 500 квадрат километр газар нутаг дээр бүрэн хэрэгжүүлээд явах, мөн түүнчлэн хэрэгжиж байгаа хуулиа хүчингүй болгоод өөр хуулиар орлуулах тийм эрхтэй байгууллага. Өнөөдөр энэ хуулийг баталсан бол нэг асуудлаар 2 зөрчилтэй хууль дэлхийн бүх практикт эрх зүйн орчинд байдаг. Ингээд зөрчилдөж байгаа тохиолдолд аль нь нарийвчилсан хууль байна эс үгүй бол аль нь сүүлд гарсан хууль байна. Яг энэ нэг асуудлаар 2 хууль зөрчилдөөд гараад ирж байгаа бол сүүлд гарсан хуулийг нь барьж мөрдөнө.

Тийм учраас энэ дээр эрх зүйн асуудал байхгүй. Зүгээр яг жинхэнэ утгаараа бол.

**Д.Амарбаясгалан:** Баярбаатар дарга нэмж хариулъя.

**Б.Баярбаатар:** Ажлын хэсэг дээр бас яригдсан юм тээ? Буцаах үндэслэл бол айхгүй болчихсон юм байна лээ. Одоо байна шүү дээ ийм байгаа юм. Одоо энэ дэгээ бид нар батлаад явахгүй бол одоо жишээлбэл энэ хуулийг бид нар буцаах ганцхан боломж байгаа нь хуулиа хүчингүй болгох л байгаа шүү.

Ерөнхийлөгчийн хоригийг үндэслээд хууль хүчингүй болгоё. Хуулиа хүчингүй болговол бид нар ямар өнөөдөр ямар хуулиар эрх зүйн актаар явах вэ гэвэл тэр нь байхгүй. Тэгээд энэ гацаанаас гарахын тулд өнөөдөр нэг удаагийн дэг орж ирж байгаа шүү, орж ирж байгаа. Тэгээд ер нь Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсөвт хориг тавиагүй шүү. Засгийн газар алдагдалгүй төсөв оруулаад ирснийг нь Их хурал алдагдалтай болгочихсон юм шиг ийм ойлголтыг бас өгөөд байж болохгүй өгөөд байж болохгүй. Тэгэхээр бид нар энэ гацаанаас гарахын тулд энэ эрх зүйн зохицуулалтыг 2 Байнгын хороо хамтарч ажлын хэсэг гаргаад өчигдөр хамтарсан хурлаа хийгээд оруулж ирсэн. Ийм дэг шүү энэ гарц мөн. Тийм.

**Д.Амарбаясгалан:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

**Ц.Даваасүрэн:** Би ингээд эргээд хэлэлцье. Үгүй бид нар төсөв л хэлэлцэнэ шүү дээ. Өөр хууль хэлэлцэхгүй шүү дээ. Төсөв хэлэлцэх байхгүй юу. Төсөв л батална шүү дээ. Үгүй тэгэхээр төсвийг яаж хэлэлцэж батлах вэ гээд Дэгийн хууль дээр чинь байж байна шүү дээ. Тэгэхээр одоо бид нар ямар ч дэг байхгүй дэгээр зохицуулаагүй юм уу, зохицуулаагүй гэж хэлж болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Төсөв батлах гээд байгаа юм. Тийм учраас тэр 1, 2, 3, 4 үе шаттай байна гэсэн юм байхгүй болохгүй болохгүй. Тэгэхээр жишээлбэл бид нар Цэцээс ингэж хэлнэ шүү дээ. Дэгээр зохицуулаагүй байсан гэж хэлэх гээд байна шүү дээ. Гэтэл дэгээр төсвийг хэлэлцэхийг зохицуулчихсан.

**Д.Амарбаясгалан:** Баярбаатар дарга нэмж хариулах уу? Баярбаатар Улсын Их Хурлын гишүүн.

**Б.Баярбаатар:** Одоо нэгдүгээр хэлэлцүүлгээрээ бид нар бол хэлэлцээд цаашаа хэлэлцэх нь зүйтэй юм байна гээд алх тогшчихсон байхгүй юу. Даваасүрэн дарга. Тэгээд бид нар энэ Ерөнхийлөгч хориг тавьчихсаны дараа хэлэлцэх зохицуулалт нь Дэгийн хууль дээр чинь байхгүй байгаа шүү дээ. Бүхэлд нь тавьчихсан. Хэсэгчлэн тавьсан бол харин яг тэр хэсэгчилсэн заалтууд дээр нь санал хураалт явуулаад ингээд явах байсан. Одоо тэгээд хоригоо хүлээгээд авчихсан анхны тохиолдол. Өмнөх парламентад дээр ч байж байгаагүй зүйл. Бүхэлд нь бол хориг тавьж байсан. Хоригийг нь хүлээж авсан анхны тохиолдол. Тэгэхээр энэ эрх зүйн зохицуулалтаар бид нар энэ гацаагаа арилгах нь л зөв болов уу л гэсэн ийм саналтай байна.

**Д.Амарбаясгалан:** Сайнбуянгийн Амарсайхан гишүүн Шадар сайд асуулт асууя.

**С.Амарсайхан:** Би ерөнхийдөө санал хэлнэ ээ. Хууль тогтоогчид баталсан хууль, дүрэм, журмаа бас нэг сайтар харж мөрдмөөр байгаа юм. Дэгийн тухай хууль Төсвийн тухай төсвийн дэг байна. Бид нарт төсвийг батлах. Ганцхан ямар асуудал үүсчхээд байна гэхээр энэ төсвөө дэгийн төсвийн дэгийнхээ дагуу хэлэлцэж батлахдаа бид энэ хоригийг яаж хэлэлцэх вэ гэдэг процессоо л тодорхой болгох ёстой гэж бодож байгаа юм.

Үндсэн хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ дагуу хориг тавьсан. Хориг тавигдсан тохиолдолд хэрхэн зохицуулах вэ гэдэг асуудал уг нь бол Улсын Их Хурлын тухай хууль Дэгийн тухай хуульд тодорхой заасан байх ёстой. Харамсалтай нь энэ байхгүй байгаа учраас өнөөдөр ийм нөхцөл байдалд орчхоод байгаа юм. Тэгэхээр одоо бол бид нарт 2 арга бий. Дэгдээ өөрчлөлт оруулаад аль шатаас нь яаж хэлэлцээд явах юм гэдгээ тодорхой болгож дэгээ бүрэн өөрчилж явна. Эсвэл энд энэ дээр цаг хугацаа их орно. Үгүй бол одоо байгаа дэг дээрээ түр журмаар гэдэг юм уу нэг удаагийн зохицуулалтаар энэ хоригийг хэлэлцэх асуудлаараа Дэгийн тухай хуульдаа нэг үг оруулаад тусгай журмаар зохицуулж болно гэдэг нэг удаагийн даргын зөвлөлийн дэргэдэх ч гэдэг юм уу эсвэл энэ ярьж байгаа хувилбараараа явах ийм асуудал бий. Тэрнээс биш төсөв хэлэлцэх ямар ч дэггүй юм шиг эсвэл төсвийн асуудал огт зохицуулалтгүй юм шиг ийм байдал үүсгээд байж болохгүй байгаад байна нэгдүгээрт. Ер нь зүгээр цаашдаа бид нар анхаарах асуудлууд бас байна аа. Төсөв бол зөвхөн тоо биш. Энэ бол ард иргэдийн амьдрал. Нийгмийн өнөөгийн нөхцөл байдлын тусгал.

Тэгэхээр энийг урсгал зардлыг ханах танах гэдэг юм уу энэ зардлыг бууруулах гэдэг асуудлыг зөвхөн зардал бууруулах багасгах гэдэг хэмжүүрээр хармааргүй байгаа юм шүү. Энийг бол одоо энэ хөгжлийн зорилтдоо хүрэх төсөл хөтөлбөрийг дэмжих агуулгаар нь харж орлогоо нэмэгдүүлэх, төсвөө тэнцвэржүүлэх, тэгээд энэ ашиг алдагдлаа зохицуулах цогц агуулгаар нь харахгүй бол нэг их баахан зардал нэг хэсэг нь оруулж ирээд, нэг хэсэг нь нийлж байгаад хууль бусаар идэх гээд байгаа юм шиг асуудал ярьдаг. Гэтэл тэнд ажиллаж байгаа төрийн албан хаагчид, сургууль, цэцэрлэг, тэдгээрийн урсгал зардал, сандал ширээ, тог цахилгаан, цалин хөлс энэ иддэг уудаг эм тариа, хоол хүнсийг чинь шинжилдэг лабораторийн байгууллагуудын урвалж бодисын урсгал зардал гээд бидний нүдэнд үзэгдэж гарт хар баригддаггүй гэхдээ зайлшгүй гардаг асар их зардлууд явдаг.



Тэгээд энэ юуг хэлж байна гэхээр бид бол бас энэ амьдрал дунд өшөө орж тэр хөрсөн дээр нь бууж үнэхээр ямар зардал нь ямар түвшинд өсөөд байгаа юм тэр нь бодитой юм уу үгүй юу, эс үгүй бол бодитой биш юм бол тэр бүтэц зохицуулалтыг нь хийж яаж зардлыг бууруулах юм гэдэг нарийн тооцоо судалгаатай хандаж асуудал дээрээ бид орж ирэхгүй бол ингэж явсаар байгаад сүүлд нь баахан зардал танадаг, ард нь амьдрал явдаггүй. Ажил өрнөдөггүй, асуудал шийдэгддэггүй ийм нөхцөл байдал руу улс орны амьдрал орно шүү. Энийгээ манай зарим энэ зардалтай холбоотой асуудал яриад байгаа хүмүүс гишүүд бас нэг амьдралын бодит нөхцөл байдал талаас нь харж бас нэг нухацтай хандахгүй бол хэт их явцуу байдлаар асуудалд хандах нь өөрөө.

**Д.Амарбаясгалан:** Санал хэллээ. Дамбын Батлут гишүүн асуулт асууна.

**Д.Батлут:** Өдрийн мэнд хүргэе. 2025 оны төсөвт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсантай холбоотой асуудлыг хэлэлцэх дэгийг тал талаас нь бас шүүн ярьж байгаа нь зүйтэй. Тэгэхдээ бас бүхэлд нь авч үзмээр санагдаад байгаа юм. 2025 оны төсөв батлагдсан. Тэгэхдээ Ерөнхийлөгч хориг тавьсан. Хориг тавьснаараа төсөвт нэлээн өөрчлөлтүүд орох байх. Бүтээн байгуулалтын ажлууд урсгал зардал энэ тэр гээд. Хэрвээ ингээд өөрчлөлт ороод батлагдах юм бол орон нутгийн төсөв маань яах вэ гэдэг асуудал үүсэж байгаа юм. Одоо бол яах вэ төсөв батлагдсантай холбоотой хуулийн хүрээнд хуулийн хугацаанд нь аймаг, нийслэл, 11 сарын 20 гээд Иргэдийн хуралдаа 2025 гээд Иргэдийн хуралдаа өргөн барьчихсан. 12 сарын 5-нд батлах ёстой хуулиараа. Тэгээд бид нар төсвийн хоригийг хэлэлцээд эцэслэн батлах процесс бол ирэх 7 хоногт үргэлжлээд аягүй бол 5, 6 гэж батлах нь л дээ. Гэтэл ингээд төсөв батлагдсан гээд өргөн барьчихаад байдаг. Эргээд төсөвт өөрчлөлт орохоор орон нутгийн төсөв өөрчлөгдөх үү?

Хэрвээ өөрчлөгдсөн нөхцөлд эргэж өргө. боловсруулалт хийж өргөн барих процесс явагдах нь ээ. Энийг тэгвэл яаж зохицуулах ёстой юм бэ?

Хэрвээ хуулийн хугацаандаа өргөн бариагүй нөхцөл байдалд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн, түүний удирдлагын тухай хуулиар 36.1.2-оор ИТХ-ын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох зохицуулалттай байгаа. Ийм нөхцөл байдал руу бас очно. Тэгэхээр энийг бид бүхэн хэрхэн зохицуулах ёстой юм бэ? Зөвхөн улсын төсөв ярих биш орон нутгийн төсөвтэй уялдаа холбоотой асуудлуудаа ч гэсэн тодорхой болгохгүй бол яг өнөөдөр аймаг НИТХ-д тухайн шатын Засаг дарга нь төсвөө өргөн мэдүүлчихсэн байна. Өөрчлөлт орох эсэх цаашлаад өөрчлөлт орох юм бол эргэн мэдүүлэх хугацааг яах эрх яах юм? Яаж зохицуулах юм бэ? Магадгүй тэгээд л орон нутагт чинь баахан улс төржсөн нөхцөл байдлууд үүсээд үүнээс улбаалаад иргэдийн хурал эрх зүйн чадамжтай байх уу, бүрэн эрх нь дуусгавар болох уу? Засаг дарга яах вэ гээд л бөөн асуудлууд үүснэ шүү дээ. Энэ тал дээр ажлын хэсгийнхэн юу гэж бодож ойлгож байгаа юм болоо гэдэг дээр надад хариулт өгөөч гэж хүсэж байна аа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Манай ажлын хэсэг бол нөгөө Ерөнхийлөгчийн хоригийг Их Хурал хүлээж авсантай холбоотой. Тэрийг хэрхэх вэ гэдгийг л шийдэх энэ ажлын хэсэг. Одоо энэ дараа дараагийн энэ орон нутгийн төсөв дээр яах вэ гэдэг энэ цаглавартай холбоотой хугацаатай холбоотой асуудал бол манай ажлын хэсгийн хариуцах ажил биш. Тэгэхээр Их Хурал дээр энэ бүрэн эрх боломж нь

байгаа. Тэгэхээр Их Хурал бас энэ дээр онцгой анхаарах шаардлагатай байх аа. Энэ цагийн хувьд, цаг хугацааны хувьд бол яг үүсчхээд байгаа асуудал мөн. Тийм Батлут гишүүнтэй санал нэг байна.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Би түрүүн хариулсан. Дахиад хариулъя. Энэ удаа хариулахдаа энэ нэг удаагийн энэ хуулийн төсөлтэй холбогдуулж зүгээр өөрийнхөө ойлгож байгаа хэмжээнд хариулъя. Энэ 2.1 дээр ингэж байгаа юм шүү. Засгийн газрын боловсруулсан санал тооцооллын үндэслэл гэж байгаа юм. Энэ үндэслэл гэдэг чинь бас л нэг жоохон даруу л үг байгаа юм даа. Энэ Их Хурал дээрээс уг нь чиглэл өгч байвал зүгээр юм байгаа юм. Ингээд энэнийх нь үргэлжлэл нь гэж байгаа юм. Монгол Улсын 25 оны төсвийн тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өөрөөр хэлбэл 2025 оны төсвийн тухай хууль гээд бүүр хууль ингээд батлагдсанаар оруулчихсан ийм ойлголтоор оруулчихсан байгаа шүү дээ. Тэгэхээр өөрөөр хэлбэл хууль хориг хүлээж авснаар хууль түдгэлзсэн ч гэдэг юм уу хүчингүй болсон ч гэдэг юм уу ийм ойлголт байхгүй нь байна шүү дээ. 2025 оны Төсвийн хуульд гэж байгаа байхгүй юу. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг. Тэгэхээр хууль нь хүчин төгөлдөр болохыг.

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайдын микрофоныг нэмж өгье.

**Б.Жавхлан:** Батлут гишүүн тийм байгаа биз. Төсвийн тухай хуульд гэгчхээр 2025 оны төсөв хүчин төгөлдөр батлагдчихсан юм байна.

Тийм учраас орон нутгууд бол 12 сарын 5-нд цаглаврынхаа дагуу хэлэлцээд батлаад явах нь ээ. Дараа нь шаардлага үүсвэл тодотгол хийгдээд явах байх.

**Д.Амарбаясгалан:** Дамбын Батлут гишүүн тодруулж асууя.

**Д.Батлут:** Улсын төсөв батлагдсан тэгэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгч бүхэлд нь хориг тавьсныг Улсын Их Хурал хүлээж авчхаж байгаа. Ингээд логикоор ойлгох юм бол энэ өөрөө төсөв батлагдаагүй гэж ойлгохоор байгаа. Тэгээд дээрээс нь энэ чинь урсгал зардал, бусад бүхий л асуудлууд өөрчлөгдөнө. Хөрөнгө оруулалтын асуудлууд өөрчлөгдөнө. Тэгэхээр энийг чинь одоо тэгээд ойлгоход аягүй хүнд болчхоод байгаа байхгүй юу. Энэ дээр нэг гаргалгаа гаргаач л гэсэн санаа. Тэгэхгүй бол одоо энэ урьдын Улсын Их Хурлаар баталсан төсвийг бид нар өргөн барьчихдаг орон нутагт.

Гэтэл дүн тооцоо нь өөрчлөгдөөд ороод ирэхэд яах юм бэ. Тэгээд батлаад явчих юм уу хамаагүй. Тэгээд дараа нь тодотгох юм уу? Энэ чинь болохоор болохгүй байгаа зүйл байгаа байхгүй юу. Зөрчилдөөд байгаа зүйл байна шүү дээ. Тэгэхээр ажлын хэсэг ч гэсэн энийг бүхэлд нь авч үзмээр байгаа юм. Хоригтой холбоотой бас орон нутаг дээр нэг л төсвөөр Төсвийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа учраас энийг анхаарч үзэж асуудлыг нь шийдэхгүй бол орон нутаг дээр баахан.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн дарга Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн гүйцээж хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Түрүүн Сангийн сайд яг тодорхой хэллээ. Энэ төсөв, энэ хууль батлагдчихсан, энэ хууль яг хүчингүй болчихсон тийм зохицуулалт байхгүй. Дэгийн тухай хуулийн 90.8 дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан бол хууль тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй болгох шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоолын төслийг хэлэлцэн баталж болно л гэж байгаа юм.

Тэгэхээр энэ замаараа дэгийнхээ хуулийн заасан замаараа л энэ ажил явж байна аа. Тэгэхээр бид нарын Их Хурлын баталчихсан энэ хууль бол төсөл биш төсвийн төсөл биш энэ хууль батлагдчихсан гэсэн тэр батлагдсанаараа л байгаа. Тэгэхээр орон нутаг маань бол төсвөө боловсруулахдаа энэ хуулиа дагаад өөрчлөлт орохоор бол дараа нь тодотгол маягаар явна гэж түрүүн Сангийн сайд хэлсэн.

**Д.Амарбаясгалан:** Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууя.

**3.Мэндсайхан:** Энэ тогтоол Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах энэ асуудлыг бол оруулж ирэх шаардлагагүй байсан гэж үзэж байгаа. Төсвийн тухай хуулиар хэлэлцээд явах боломж нь байгаа. Яагаад гэхээр Улсын Их Хурлын баталсан Засгийн газраас өргөн барьсан төсвийн төслийг Улсын Их Хурал баталсан баталсан шийдвэрт нь Ерөнхийлөгч хориг тавьсан гээд байгаа юм. Тэгээд ингээд ойлгохоор Засгийн газрын өргөн барьсан төсөл маань хэвээрээ үлдчихсэн. Ерөнхийдөө Төсвийн хууль маань хүчингүй болчихсон байгаа. Энэ дэгээр чинь ингээд явах юм бол Их Хурал Засгийн газрын өргөн барьсан төсөл хэвээрээ байгаа учраас Сангийн яамнаас санал аваад танайд механик тандалт хийгээд явна л гэсэн үг. Их Хурал өөрөө хууль зөрчих гэж байгаа юм. Засгийн газрын энэ өргөн барьсан төсөв гэдэг бол Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй хөгжлийн хөтөлбөртэй уялдсан тооцоо судалгаанууд байгаа юм.

Тэгэхээр Засгийн газарт буцаах ёстой гэж үзэж байгаа юм. Засгийн газар буцаад энэ өөрийнхөө мөрийн хөтөлбөртэй уялдуулаад Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн хүрээнд асуудлаа боловсруулж оруулж ирэх ёстой. Хэрвээ Их Хурал энэ дээр таналт хийгээд явах юм бол Засгийн газрын хөтөлбөрийг тэр тооцоо судалгаан дээр биш Их Хурлын одоо тэр зардал нэмж орлого нэмж болохгүй. Мөн урсгал зардлыг танана гэсэн Ерөнхийлөгчийн хоригийн хүрээнд механик хасалт хийгээд явна. Ирэх жил бид нар хөгжлийн ямар нэгэн хөтөлбөр Засгийн газраас үр дүн хүлээх ийм боломжгүй болно.

Тийм учраас байгаа тэр Төсвийн хуулийнхаа хүрээнд зохицуулаад явах ёстой энэ дэг оруулж ирэх шаардлагагүй гэж үзэж байгаа юм.

Хоёрдугаарт, Төсвийн хуулийн 58.1 дээр орон нутгийн төсвийн суурь зардлуудын эх үүсвэрийг тодорхой заагаад өгчихсөн байгаа юм. Энэ дээр төсвөөс шилжих орлогын асуудал байгаа аймгийн. Энэ дээр үндэслэж аймаг төсвөө батлах ёстой. Тэгэхээр одоо хүчингүй болчихсон Засгийн газрын өргөн барьсан төсөл дээр орон нутгууд төслөө батлаад явах юм бол дахиад тодотгол хийх ийм л асуудал үүсэх байхгүй юу. Тэгэхээр энэ цаглавар дээр нь заавал өөрчлөлт хийх ёстой. Энэ дээр ажлын хэсэг яагаад Их Хуралд ийм эрх нь байгаа гээд өөрсдөөсөө холдуулаад байгаа юм. Энэ чинь нэг зохицуулах гэж байгаа та бүхэн энэ цаглаварын гол асуудал чинь энд яваад байгаа шүү дээ.

Тийм учраас ийм дэг оруулж ирэх шаардлага байхгүй байгаа. Төсвийн тухай хуулийг өмнөх дэгээрээ хэлэлцээд явах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Хэрвээ бид нар одоо байгаагаар нь явах юм бол Засгийн газрын өргөн барьсан төсөл дээр биш Их Хурал өөрөө төсөл төсвийн төслийг өөрсдөө хийж баталж байгаатай ялгаа байхгүй байхгүй юу.

Сангийн яамнаас Төсвийн байнгын хороо хугацаа тавиад санал аваад явчихна гэж байгаа юм. Тэр санал гэдэг чинь өөрөө өргөн барьсан төсөл биш байхгүй юу. Санал байхгүй юу. Та нарын энэ төсөл дээр чинь байгаад байна шүү дээ. Засгийн газраас Сангийн яамнаас санал авна гээд байгаа байхгүй юу. Сангийн яам төсөл өргөн барих юм уу Засгийн газар барих ёстой байхгүй юу. Төсвийн тухай харилцаагаар энэ чинь зохицуулагдаад явах ёстой. Тийм учраас энэ дэгийг оруулж ирэх шаардлага байхгүй гэж үзэж байна.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн дарга Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Энэ бол тэр хоригийг хүлээж авч байгаа дээр энэ эцсийн хамгийн эцсийн цэг нь энэ биш л дээ. Их Хурал хүчингүй болгох эрх нь Их Хуралд одоо хүртэл хадгалаатай байгаа. Байнгын хороо нь оруулж ирээд тэрийг хүчингүй болгож болно. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авахдаа. Ерөнхийлөгчийн хоригийг Их Хурал хүлээж авахдаа 2 зүйлээр л хүлээж авна. Нэг хүчингүй болгоно, нэг бол шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг тухайн хуульдаа оруулна гэж.

Хоёр дахь замаар нь л бид нар явъя гэдэг байдлаар цаг хугацаандаа шахагдаад л ингээд явж байгаа. Одоо байгаа Дэгийн хуулиар төсвийн төслийг хэлэлцдэг. Одоо бол энэ төсвийн төсөл биш хууль болчхоод байгаад л асуудал байгаад байгаа юм л даа. Хууль болчхоод байгаа. Тэгэхээр энэ хэрвээ энэ ажлын хэсгийн боловсруулсан энэ дэгээр явахгүй гэж үзэж байгаа бол Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг нь хүлээн авахдаа дараагийн шийдвэр нь тэр хориг тавьсан хуулийг хүчингүй болгох энэ боломж нь Их Хуралд бас байгаа.

**Д.Амарбаясгалан:** Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя. Загджавын Мэндсайхан гишүүн тодруулж асууя.

**3.Мэндсайхан:** Сангийн сайд аа тэр орон нутгийн төсөвтэй холбоотой асуудал дээр миний тодруулаад байгаа юм. Орон нутгийн төсвийн суурь зарлага чинь тодорхой заагдаад өгчихсөн байгаа шүү дээ. Төсвийн тухай хууль дээр 58.1 дээр. Улсын төсвөөс шилжиж ирэх орлого дээр үндэслэж зарлага байгаад байгаа юм. Тэгэхээр одоо тэр үндсэн суурь ойлголт чинь хүчингүй болчхоод байна.

Хоёрдугаарт ажлын хэсгийн даргаас асуухад энэ дэгийн тухай хууль чинь та өөрөө ярихдаа нэг удаагийнх гэж яриад байна. Энэ дэг дотор чинь нэг удаагийн гэсэн ойлголт ерөөсөө алга байна. Би олж харахгүй байгаа юм уу?

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн дарга Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн нэмж хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Энэ нэг удаагийн гэдэг нь 7 дугаар зүйл дээр хууль хүчин төгөлдөр болно. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн төслийг эцэслэн баталж

дуустал хугацаанд дагаж мөрдөнө өө гэвэл эцэслэн батлаад дуусчихаар хүчингүй болчихно. Энэ 7.1 дээрээ байж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя дараа нь санал хураалттай.

**М.Бадамсүрэн:** Нэг зарчмын санал хэлэх гэсэн юм. Түрүүн Ганхуяг гишүүн хэлсэн би санал нэг байгаа. Ер нь бол Засгийн газар гол саналаа ирүүлэх ёстой л гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал Засгийн газрын өргөн мэдүүлсэн байгаа энэ төсөл дээр тийм олон өөрчлөлт хийнэ гэхээс илүүтэй Засгийн газар өөрөө энэ төсвийг, алдагдлыг бууруулах мөн алдагдалгүй төсөв батлах, сонгуулийн амлалтаа биелүүлэх зэрэг Ерөнхийлөгчийн хоригт тусгагдсан энэ зүйлийг Засгийн газар өөрөө сайн боловсруулаад тэгээд Улсын Их Хурал дээрээ батлах нь зөв байх гэж үзэж байгаа. Яагаад гэвэл Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсан учраас тэр тавьж байгаа шаардлагуудыг нь зөвшөөрч байна гэж ойлгож болно.

Хоёрдугаарт нь орон нутгийн төсөвтэй холбоотой зарчмын санал байгаа нь орон нутгийн төсөвт улсын төсөв дээр энэ үзүүлж байгаа нөлөөлөл нь маш их бага юм байна лээ шүү дээ. Тийм учраас заавал энэ орлого, зарлага тэр төвлөрүүлэх орлого татаасны хэмжээг өөрчлөх шаардлага байна уу зүгээр энийг өмнө нь ингээд орон нутагт өгсөн байгаа энэ тоо чиглэлээрээ хэвээр нь энийг хөдөлгөхгүй явах энэ зарчмыг баримталбал яасан юм бэ? Тэгвэл ямар нэгэн хүндрэл гарахгүй. Угаасаа энэ чинь улсын төсөв яг ёсчилж батлаагүй байхад л бараг жил болгон шахуу л орон нутагт төсвийн дүнг өгөөд л орлого, зарлага төвлөрүүлэх орлого. Тэгээд энийг чинь одоо иргэдийн хуралдаа өргөн мэдүүлээд л батлаад л явдаг шүү дээ. Тэгээд энэ бол нөгөө шинэ нөхцөл байдал хориг тавьсантай холбоотой үүсэж байгаа учраас энэ дээр заавал энэ дээр энэнд зориулсан зүйл гаргана гэхээс илүүтэй энэ зарчим дээрээ тохироод шаардлагатай бол Улсын Их Хурал тогтоол дээрээ энэ нөхцөл байдал үүссэнийг тодорхойлоод томъёолоод явбал яасан юм бэ гэдэг ийм санал байна.

Тэгээд гуравт нь бол энэ Ерөнхийлөгчийн хоригт байгаа энэ сонгуулийн амлалтаа биелүүлэх гэдэг энэ зүйл дээр нэлээн том ач холбогдол өгөх ёстой гэж үзэж байгаа юм. Ер нь энийг бас умартсан байна гэдэг зүйлийг бас нэлээд гишүүд хэлж байгаа учраас энийг бас анхааралдаа аваач ээ. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал нэгэнт хоригийг хүлээж авсан учраас энэ зүйлтэйгээ холбоотой засан сайжруулах зүйл дээрээ нэлээн ач холбогдол өгөөч гээд.

Дөрөвдүгээрт нь зөвхөн Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэхээсээ гадна яах вэ энэ нэг удаагийн дэг дээр байна. Гэхдээ мэргэжлийн Байнгын хороодын саналыг Засгийн газрын холбогдох гишүүдийг байлгаж байгаад нэлээн сайн авч тэгээд Төсвийн байнгын хорооныхоо шийдвэртэй энийгээ нэлээн сайн уялдуулж яваач гэдэг саналыг л гаргаж байгаа юм. Яагаад гэвэл энэ сая улсын төсөв батлах хэлэлцүүлгийн явцад анзаарагдсан зүйл бол энэ мэргэжлийн Байнгын хороодын саналыг Төсвийн байнгын хороон дээрээ маш сайн нягталж авч үзэх шаардлага бол зайлшгүй байна гэж үзэж байгаа юм. Тэгэхгүй болохоор зарим мэдээлэл дутуу Төсвийн байнгын хороонд чинь ингээд бас бүх зүйлээрээ мэдээлэлтэй байна гэж бол байхгүй шүү дээ.

Тийм учраас энэ өмнө улсын төсвийг батлахад ямар зүйл дээр ер нь алдаа дутагдал гаргасан гэж үзэж байгаа юм бэ. Тэгээд энэ зүйл дээрээ яг бодит дүгнэлт хийж тэгээд энэ зүйл дээрээ илүү сайжруулж тэгээд нэгэнт л хоригийг хүлээж авсан юм чинь ямар нэгэн асуудал шүүмжлэл дагуулахгүй ямар нэгэн цоорхой байхгүй ямар нэгэн тийм шүүмжлэл байхгүй ийм төсвийг л батлах хариуцлагатай үүрэг л оногдож байна шүү дээ. Тэгэхгүй бол зүгээр ингээд хоригийг хүлээж авсан гээд энэ дээрээ тийм сайн зөв шийдвэр гаргаж чадахгүй бол нийгэмд ямар зүйл энэ Улсын Их Хурлын нэр хүндтэй холбоотой зүйл үүсэх вэ гэдэг. Би үүнд маш их санаа зовж байгаа учраас энийг маш сайн нухацтай авч хэлэлцэж, тэгээд энэ зүйл дээрээ энэ гишүүдийн хэлж байгаа саналыг сайн тусгаж аваач.

Улсын Их Хурлын гишүүд энэ ажлыг сайжруулахын төлөө л саналаа хэлж байгаа гэж ойлгож байгаа. Тийм учраас энэ зүйлийг тодорхой зүйл дээр нь бас боломжтой бас хариулт авъя гэж бодож байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Санал хэллээ. Гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа.

Байнгын хороодын саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль хууль тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулахаар байгаа.

Эхлээд ирцийн бүртгэлийн санал хураалт явуулъя. Танхимд хэдэн гишүүн байна вэ бүртгээдэхье. Бүртгэлийн санал хураалт.

Санал хураалтад орж амжаагүй гишүүн байна уу? 5 гишүүн.

Тэгэхээр танхимд 65 гишүүн байна. Эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

55 гишүүн санал өгсөн байна. Нийт гишүүдийн олонхоор батлах ёстой байсан хуулийн төсөл батлагдсангүй.

Хуулийн төсөл дэмжигдээгүйтэй холбоотойгоор Дэгийн тухай хуулийн 90.8, 90.9-ийг үндэслээд Төсвийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо хамтарсан хурлаа одоо шууд Их эзэн Чингис хааны танхимд хуралдаад үдээс хойших хуралдаан дээр саналаа дахин боловсруулж оруулж ирнэ.

Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо хамтарсан. Холбогдох Байнгын хороо учраас. Ингээд үдээс өмнөх хуралдааныг завсарлуулж байна. 14 цагаас үдээс хойших хуралдаан үргэлжлэн хуралдана.

*11.46 цаг*

**Д.Амарбаясгалан:** Үдээс хойших Улсын Их Хурлын хуралдааныг үргэлжлүүлье.

Хэлэлцэх асуудал 7.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төсвийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Да.Цогтбаатар:** Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай 38 дугаар тогтоол, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 39 дүгээр тогтоол, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт оруулах тухай 40 дүгээр тогтоол, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 41 дүгээр тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан дээрх хууль Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.8 дахь хэсэгт заасныг баримтлан Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа хэлэлцлээ.

Хамтарсан хуралдааны үеэр Монгол Улсын Их Хурлын гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлсэн бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хууль, тогтоолыг хүчингүй болсонд тооцохыг дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасныг баримтлан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт боловсруулсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай 38 дугаар тогтоол, Засгийн газарт чиглэл өгөх тухай 39 дүгээр тогтоол, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 40 дүгээр тогтоол, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зариг зарим арга хэмжээний тухай 41 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

3 гишүүнээр тасаллаа. Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн асуулт асууна.

**Ч.Лодойсамбуу:** Сая түрүүн уг нь бид нарын боловсруулсан тэр дэгээр л явчихсан бол уг нь их амар байх байсан. Тэгээд манай сайд нар өөрсдөө эсрэг санал өгөөд ингээд унагаачихсан. Ингээд эргээд энэ хүчингүй болохыг хэдүүлээ дэмжээд явлаа гэхэд дахиад засгийн газраа өргөн барина. Тэгэхээр энэ дээр түрүүний хэлэлцүүлэг дээр бас буруу, зөрүү юм нь ойлголтууд гараад байгаа.

Ер нь Засгийн газар нь өөрөө алдагдалгүй сайн төсөв оруулж ирээд Их Хурал нь алдагдалтай болгоод муухай болгочихсон юм шиг ийм ойлголт олон нийт рүү түгээд байгаа. Тийм юм бол байхгүй. Тэгэхээр энэ Засгийн газар Сангийн яам, Сангийн сайд руу, Сангийн сайд өөрөө энэ алдагдалгүй төсөв оруулж ирэх энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагатай, энийгээ сайжруулж орж ирэх шаардлагатай. Тэгэхээр эхнээсээ хэлэлцэх юм байна. Тэгээд энэ хугацаа хэлэлцэх, хугацаа энэ ард нь хүлээгдэж байгаа том том ажлууд байгаа, төрийн бүх нийтийн ажил зогсох дээрээ тулж байна л даа. Тэгэхээр энэ хэлэлцэх хугацаагаа яаж тогтоох юм гэдгээ бас ингээд дэг дээрээ бид нар бас нарийн дагаад хэлэлцэх шаардлагатай байх гэж ийм л үг хэлэх гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Х.Булгантуяа:** Үүнтэй холбоотой сая би бас Лодойсамбуу гишүүнтэй санал нэг байна. Сая хэрвээ Улсын Их Хурлын хоригийг хүлээж аваад эндээ ажиллаад явна гэх юм бол сая дэгийн тухай хуулийг хүлээж авах ёстой байсан. Харамсалтай



нь Улсын Их Хурлын үүнийг дэмжихгүй гэж байгаа бол одоо тэгээд л бид нар Засгийн газар руу буцаагаад л ажиллуулахаас өөр арга байхгүй.

Сая бид нар бас Төсвийн байнгын хороон дээр цаг хугацааны хувьд ер нь жоохон шахаж ажиллахгүй бол аймаг, орон нутаг маань, аймгууд, дээрээс нь энэ Нийслэл, тэгээд сум, дүүргүүд гээд төсвөө хэлэлцэж баталж бас амжихгүй болчихоод ийм цаг хугацааны бас хайчинд орчихоод байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын хувьд бол бид Засгийн газраас аль болохоор яаралтай өргөн барих юм бол Улсын Их Хурлын бид нар яаралтай хэлэлцээд явахад бүрэн боломжтой. Тэгээд ийм сэтгэл нь ханахгүй байгаа юм шиг бас хандмааргүй байна. Тэгвэл бид нар аваад энд хэлэлцье гэхээр дэгээ дэмжихгүй. Тэгвэл Засгийн газар өөрснөө оруулаад ир гэхээр бас дэмжихгүй, тэгээд яг яаа гээд байгаа юм бэ энэ чинь? Хамаг юм нуман тулгуурт ороод таг зогсож байж энэ улс орон чинь хэдхэн сарын, хоногийн дараа он гарах гэж байна. Таг зогсож байж болохгүй ээ.

Тэгэхээр Засгийн газар дахин боловсруулаад л өргөж, буцаж оруулж ирэхээс өөр аргагүй нөхцөл байдалд хүрлээ. Тэгээд уг нь бас Лодойсамбуу гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг их аятайхан ингээд л дэгийг нь оруулж ирсэн. Тэгээд их олон гишүүд энэ бол болохгүй л гэж л өөрснөө үзлээ шүү дээ. Тэгвэл одоо өөр бид нарт ямар ч боломж байхгүй л болж байна гэсэн үг.

**Д.Амарбаясгалан:** Булгантуяа гишүүний хэлж байгаа үнэн л дээ. Лодойсамбуу гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг 2 өдрийн дотор бас нэлээн сунаж ажилласан. Өдөр шөнөгүй л ажиллаад бас маш боломжийн санал хуульд нийцүүлээд гаргаж ирсэн. Тэгээд яах вэ гишүүдийн олонх нь дэмжээгүй учраас ингээд өөр гарц боломж байхгүй. Хууль зүйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо хоёр хамтарч хурлаа хийгээд батлагдсан төсвийн хуулийг хүчингүй болсонд тооцож байгаа ийм л шийдвэр гарч байна. Тэгээд маш их урт процесс ахиад эхэлж байна гэсэн үг. Энэ Улсын Их Хурлын сонгогдоод үйл үйл ажиллагаагаа эхлээд 5 сар болж байна. Ингээд 5 дахь төсвөө хэлэлцэх гэж байна л гэсэн үг рүү орж байна шүү дээ хэдүүлээ бол.

Тэгэхээр гишүүд маань дараа дараачийн асуудал дээр их олон талаас нь бодож, бас хуулийнхаа талын ойлголт мэдээллүүдийг нэг мөр авч дараа дараачийн асуудалдаа бас хандах нь зүйтэй гэдгийг хаа хаанаа их сайн ойлгож авах хэрэгтэй болж байна.

Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Баярбаатар:** Өдрийн мэнд хүргэе.

Одоо саяын унасан дэгээр ч юу ярих вэ дээ. Нэгэнт уначихсан юм чинь. Ер нь Их Хурал бол хуулиар олгогдсон 2 эрхээ хоёуланг нь л эдэлж байна энэ удаад. Эхнийх нь бол нэмэлт, өөрчлөлтийн хэлбэрээр дэг оруулж ирж батлуулаад түүгээрээ хэлэлцээд явах байсан. Түрүүн ингээд дэмжигдсэнгүй. Одоо ингээд үлдсэнийг нь бид нар ингээд удахгүй эдлэх гэж байна. Энэ бол хуулийг хүчингүй болгох. Тэгээд өнгөрсөн хугацаанд 10 удаа хуульд хориг тавьж байсан юм байна лээ Төсвийн хуульд. 6-д нь бүхэлд нь тавьснаас ингээд 1 нь ингээд 1-ийг нь хүлээж авсан анхны тохиолдол.

Тэгээд өнгөрсөн хугацаанд ч гэсэн ер нь оруулж ирж байгаа төсөв алдагдал, төрийг батлагдаж байгаа хэлбэр эд нар, зүйлүүд энэ 126 гишүүнтэй парламент арай няхуур ажиллаж эхэлж байгаа юм байна гэдэг энэ дохио шүү энэ. Засгийн газраас энэ дээр анхаарах ёстой гэж бодож байгаа. Тэгээд 1 юм оруулж ирээд батлуулаад л, тэгээд явчихдаг гэж бодож байгаа бол цаашдаа үгүй юм байна, явж явж энэ нь ингээд ийм хямралын байдал руу хөтөлдөг юм байна гэдэг асуудал.

Жишээлбэл, бид нар ингээд тодорхой болгох зайлшгүй шаардлагатай зүйлүүд байна л даа. Түрүүний хэлэлцүүлэг дээр явж байна. Ерөнхийлөгчийн хориг тавьснаар хууль яг яаж байгаа юм хүчингүй болж байгаа юм уу? Хүчин төгөлдөр бол болоогүй, тэгсэн мөртөө хүчингүй бол бас болоогүй байхгүй юу. Их Хурал өөрөө энийгээ хүчингүй болгодог ийм л эрх зүйн орчин байж байгаа. Тэгэхээр иймэрхүү зүйлүүд эд нараа илүү тодорхой болгож цаашаагаа эрх зүйн зохицуулалтыг нь нээж өгөх ёстой. Тэгээд энэ орон нутгийн төсөвтэй холбоотой асуудал бол нэлээн анхаарал татаж байна. Ер нь олон ч аймгуудаас утсаар холбогдож ярьж байна. Одоо яг ямар механизмаар яаж явах вэ? Түрүүн Жавхлан сайд арай өөрөөр тайлбарлаж байсан. Одоо тэр нөхцөл байдал ингээд өөрчлөгдөж байх шиг байна. Тэгэхээр одоо дараа дараагийнхаа асуудлууддаа их яаралтай хандаад хурдан, түргэн хэлэлцэх ёстой.

Тэгэхдээ хурдан түргэн хэлэлцэж байна гээд дахиад бид нар алдаа гаргах эрх байхгүй. Засгийн газар нь өргөн мэдүүлэхдээ ч гэсэн энэ дээрээ илүү сайн анхаараарай, Байнгын хорооны түвшинд, ажлын хэсгийн түвшинд, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэхдээ ч гэсэн эд нар энэ дээрээ бид нар бас их онцгой анхааралтай ажиллаж аль болох шүүмжлэл бага дагуулах хэмжээнд асуудлыг хэлэлцэж батлах нь зөв болов уу гэсэн ийм боломж гэж харж байна. Ер нь энэ нэг талаараа бид нь бид энэ төсвөө Их Хурал хуулийн хугацаанд нь батлаад явуулсан, Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан, одоо буцаад дахиад хэлэлцэх гэж байна. Тэгээд энийг бид нар алдаа гэхээсээ илүүтэйгээр сургамж гэж хараад мэдээж 26 оны төсөв батлахад ийм зүйлүүд гарахааргүй тийм эрх зүйн орчныг бүрдүүлэх ийм зайлшгүй үүрэг энэ манай парламент хүлээж байна л гэдгийг ойлгох хэрэгтэй. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Төсвийн байнгын хороон дарга Даваасүрэн гишүүн тайлбар хэлье.

**Ц.Даваасүрэн:** Тийм, Баярбаатар гишүүний хэлээд байгаа үнэн. Бид хэрвээ өргөн баригдсан Төсвийн тухай хууль маань тааруухан хууль байсан бол бид нар эхний хэлэлцүүлгээрээ л буцаах ёстой байсан л даа. Нэгэнт хүлээгээд авчихаар яах вэ Их Хурлын асуудал, Их Хурлын бүрэн эрхийн асуудал болчхож байгаа байхгүй юу.

Тийм учраас өнөөдөр бид нар ийм нөхцөл байдал руу орчхоод ингээд хэлэлцээд байгаа юм. Тэгэхдээ би одоогийн энэ гаргаж байгаа шийдвэрийг бол бас зөв юм болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан тохиолдолд хоёрхон зохицуулалт байгаа. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан бол хууль, тогтоолыг бүхэлд нь буюу, зарим хэсгийг хүчингүй болгоно. Одоо бид хүчингүй болгох гэж байна нэгдүгээр арга нь. Хоригийг хүлээж авсан бол тухайн хуулийг хүчингүй болгоно. Эсвэл шаардлагатай гэж үзвэл зохих

нэмэлт, өөрчлөлтийг л төслийг боловсруулж хэлэлцэж болно гээд. Нэмэлт, өөрчлөлт гэж байгаа юм.

Тэгэхээр төсөвт нэмэлт, өөрчлөлт гэдэг бол тодотгол байдаг. Төсвийн ерөөсөө тодотгол байдаг. Тодотгол болчхож байгаа учраас бид нар яах ёстой гэвэл тодотголыг дангаараа шийдэж болохгүй. Тодотголын төслийг Засгийн газар боловсруулж Их Хуралд өргөн мэдүүлэх ёстой. Тийм учраас Засгийн газарт буцаагаад өргөхөөс аргагүй нөхцөл байдал үүссэн гээд манай зарим хуульч гишүүд хэлээд байгаа нь бол яг энэ 90.8-аар зохицуулагдаж байгаа учраас энэнээс өөр арга байхгүй.

Энэ нэмэлт, өөрчлөлт гэдэг чинь тухайн хориг тавьсан хуулийнхыг хэлж байгаа юм шүү. Төсвийн тухай хууль, Төсвийн тухай хуульд хориг тавьсан. Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг бол тодотгол. Тэгээд тодотголыг Их Хурал дангаараа хийж болохгүй л гэж ингэж л ойлгож байгаа.

**Д.Амарбаясгалан:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна. Ирцэд бүртгэлтэй гишүүдийг танхимд орж ирэхийг хүсье. 64 гишүүнээр энэ тогтоол батлагдах учиртай.

Хэрвээ тогтоолоо баталж чадахгүй бол тэгээд үндсэндээ цаашаа гарц байхгүй хэлбэр рүүгээ шилжинэ. 2025 онд төсөвгүй байх нөхцөл рүү явна л гэсэн үг.

Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Одоо ингээд бүүр хууль зүйн хувьд ч ийм холион бантан болоод бид нар ерөөсөө ингээд асуудлаа шийдэх биш нэг л их процесс ярьсан хүмүүс болчихлоо. Тэгээд асуудал нь бол бид нар он гарахаас өмнө төсвөө л батлах ёстой шүү дээ. Тэгээд энэ орон нутгийн төсөв чинь, төрийн байгууллагууд чинь төлөвлөлтөө хийх ёстой. Тэгээд өчигдөр энэ оруулж ирж байсан, Байнгын хороонд танилцуулагдсан дэг бол боломжийн л дэг байсан.

Тэгээд одоо болохоор ингээд хүчингүй болгож байгаа тогтоол Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо хамтарч гаргаж байгаа мөртөө одоо тодотгол гэсэн юм яриад байх юм. Хүчингүй болж байгаа бол тодотгол гэсэн ойлголт байхгүй шүү дээ.

Энэ дэгээр чинь Засгийн газар өөрөө саналаа ороод ирье, тэгээд Улсын Их Хурлын энэ дээрээ ажилла гээд боломжийн юм гарч ирж байхад нэг л ингээд л хариуцлагаас зугтсан байртай Улсын Их Хурлын гишүүд. Бид нар өөрсдөө ажиллах л ёстой шүү дээ. Тэгээд Байнгын хороо нь юм уу, эсвэл ахлах гэж байгаа ажлын хэсгийн ахлагч нь дараа нь асуудал болно гэж хариуцлагаас зугтаад байгаа юм уу нэг тийм бэргэсэн байдалтай, бие бие рүүгээ шидсэн байдалтай л болчихоод тэрнээсээ болоод цаг хугацаа алдаад байна шүү дээ.

Сүүлд нь энэ чинь юмаа төлөвлөж чадахгүй он гарахад төсвөө хийж чадахгүй байх юм, хэн хохирох юм? Улс орон даяараа л сонин байдалд хүрнэ биз дээ. Тэгээд одоо ингээд тэр өдрийн юу батлагдаагүй, хүчингүй болгоод шинээр өргөн бариад бүүр 9 сарын 1-нд өргөн барьж байгаа юм шиг ийм процессоор явна гэсэн шийдэл рүү хүрч байх шиг байна, хугацаа өгөх юм шиг байна.

Тэгээд ингээд өгөхөөр чинь одоо нөгөө Аудитын дүгнэлт, Төсвийн тогтвортой байдлын дүгнэлт, 4 удаа хэлэлцүүлэх гэхээр 12 сардаа ондоо багтах юм уу нэгдүгээрт.

Хориг бол ерөөсөө жоохон үр ашигтай, зардлаа хэмнэсэн байдлаар л байгаач л гэсэн хориг байсан юм шүү дээ. Тэгээд энэ дээр Сангийн яам угаасаа л 12 сард тодотгол хийнэ, зардлаа хэмнэнэ гээд тодотгол би бэлдэж байсан. Тэгээд их аймаар цоо шинэ, шив шив шинэ төсөв хийгээд орж ирэхгүй нь лавтай л байлгүй дээ. Тэгээд тэрнийх нь тооцооллыг нь аваад яагаад Байнгын хорооноосоо хэлчхэж болохгүй юм бэ? Би энийг ерөөсөө л гишүүд зүгээр ингээд галаа авахгүй, бэргэсэн, дараагийн асуудлуудаас, хариуцлагаас зугтсан л ийм л юм болж байна. Тэр нь эцэс эцэстээ ингээд 7 хоногоор ч юм уу, бид нар дахиад Засгийн газраас төсөв орж иртэл хэдэн хоног ч болох юм? Хугацаа л алдаж байна гэж бодож байна.

Тэгээд ийм л байсан юм бол Байнгын хороодын дарга нарын даргын дэргэдэх зөвлөл дээр энийгээ түрүү долоо хоногт ярихдаа яг аль нь зөв юм гэдгээ сайн хэлэлцээд шийдэхгүй яасан юм. 7 хоног алдчихлаа шүү дээ. Одоо асуулт нь дахиад Засгийн газарт хугацаа өгөөд, дахиад 4 хэлэлцүүлгээр орж ирээд, Аудитын дүгнэлт, Төсвийн тогтвортой байдлын дүгнэлтээ авна гэх юм бол бодитоор хэдэн өдөр болно гэж бодож байгаа юм? Ондоо багтааж бид нар төсөв баталж чадах юм уу? Бид нарын гол зорилго чинь он гарахад бид нар төсөвтэй байж байх л асуудал шүү дээ. Энэ дээр би хариулт авмаар байна.

**Д.Амарбаясгалан:** Даваасүрэн гишүүн хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Тэгээд Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Дэгийн тухай хуулийн 90.8 дээр Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан бол хоёрхон тохиолдол байгаа байхгүй юу. Эсвэл хүлээж авсан бол тухайн хуулийг хүчингүй болгоно гэж байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт, шаардлагатай гэж үзвэл тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гэж байгаа юм. Тэгэхээр төсвийн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг чинь тодотгол байхгүй юу. Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг чинь тодотгол. Яг энэ хууль дээр бичсэнээр л явж байна шүү дээ. Тэрнээс биш энэ дээр их айж зугтаад байгаа хүмүүс би байхгүй байх л гэж бодож байна. Ер нь бол эхний хэлэлцүүлгээр нь бид нар буцаачихсан байсан бол бас л өргөн барих асуудал цаглаврын асуудал яригдана шүү дээ. Яг ижилхэн нөхцөл байдал үүсэх л байсан байхгүй юу. Тэгээд тэгж бодоод л бид нар өргөн бариулаад л, тэгээд л 4 хэлэлцүүлгээрээ яваад л ингээд л батална зүгээр. Энэ дээр харин нэг зүйлийг манай Тамгын газрынхан их анхаарах хэрэгтэй.

Одоо ингээд буцаавал, буцаачихлаа шүү дээ. Тэгээд ингэсэн тохиолдолд аудитын дүгнэлт гэдэг асуудлыг яаж зохицуулах вэ гэдэг асуудал бол харин байгаа байх. Тийм учраас энэ бүгдийгээ Тамгын газрынхан бас анхаараад, ингээд буцаад өргөн баригдахаар ямар хугацаанд аудитын дүгнэлт хийх вэ гэсэн энэ зүйлүүдээ бас нэлээн нарийвчлах ийм шаардлагууд байгаа. Бид нар яг Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх тухай Дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлээр л бүх асуудлыг шийдэж байна. Энэ нь зөв.

**Д.Амарбаясгалан:** Номинчимэг гишүүн тодруулж асууя.

**О.Номинчимэг:** Даваасүрэн даргын хариулт ерөөсөө логикийн, хууль зүйн ч гэсэн алдаатай байгаад байгаа байхгүй юу. 90.8-ыг бид нар ч гэсэн уншиж чадаж байгаа. Шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулна гэж бодож байгаа бол тэр үндсэн төсөв чинь хүчин төгөлдөр төсөв, тэрэнд нэмэлт, өөрчлөлт буюу тодотгол явдаг. Тэгтэл одоо сая Байнгын хорооныхоо дүгнэлтээр та энэ төсвийг хүчингүй болгоод буцаая, шинээр Засгийн газар оруулж ир гэдэг юм байна шүү дээ. Хүчингүй байж байгаа, хүчин төгөлдөр биш, хүчингүй болгочихсон төсөв дээр нэмэлт, өөрчлөлт буюу тодотгол гэсэн асуудал яригдахгүй.

Тэгэхээр угаасаа л энэ чинь бол их тийм. Заавал ингэж явах биш Улсын Их Хурлын өөрөө Засгийн газраас саналыг нь аваад, тооцооллуудыг нь аваад, өөрсдийнх нь тэр саналуудыг нь аваад тэн дээр нь л ажиллалцахад болох л асуудал байсан юм шүү дээ. Тэгээд энэ хуулийг бас ингэж гуйвуулж яриад өөрийнхөө юунд тааруулж ярина гэж бас байхгүй. Тэгээд аудит юуны дүгнэлт гээд ярьсан. Тэр бүгдийг чинь уг нь Тамгын газар тооцоол тийм дэг хийсэн шүү дээ. Тэгээд ямар ч дэг байхгүй. Дахиж дэг хэлэлцэнэ гэж юм байхгүй. Буцаагаад энд байгаа хуулийнхаа дагуу бол чуулганы дэгийн хуулиараа явъя гэж байгаа бол тэр.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Үгүй үгүй. Төсвийн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг чинь тодотгол байдаг л гэж би хэлээд байна шүү дээ. Тийм учраас бид нар тодотголыг нэмэлт, өөрчлөлт хийнэ гээд их хурал дээрээ хэлчхэж болохгүй байсан гэж. Яагаад гэвэл тодотголын төслийг хуулиараа Засгийн газар боловсруулж өргөн барина гээд байж байгаа юм Номинчимэг гишүүнээ, мэдэхгүй бол зүгээр л ингээд олон нийтэд өөрийнхөө мэддэггүйг ингэж зарлах хэрэггүй шүү дээ. Хууль дээрээ яг тийм байгаа. Тийм учраас тодотголын нэмэлт өөрч.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан үг хэлье.

**Б.Жавхлан:** Би санал хэлэх гэсэн юм, үг хэлнэ. Сая Номинчимэг гишүүний ярьж байгаа өнцөгтэй ер нь давхцах нь. Тэгэхээр одоо бид нар хэдүүлээ гарц л ярих хэрэгтэй болж байна. Одоо ингээд Засгийн газар шинээр өргөн барих тохиолдол үүслээ гэхэд бидэнд энийг зохицуулдаг дэг бас байхгүй. Дэгийн тухай хуулиар 9 сарын 1-нд Засгийн газар төсөв өргөн барина, эсвэл тодотгол өргөн барьдаг л шинээр өргөн барих ийм л 2 тохиолдол байгаа. Өргөн барьснаас хойш хэлэлцээд хэлэлцээд явсны дараа хориг тавиад ингээд тэрнээс болж дахиж өргөн барих бидэнд дэгийн зохицуулалт байхгүй учраас энэ дээр ийм сонин цонх үүсчхэж байгаа юм. Хэрвээ саяын Байнгын хороон дээр ярьсан шиг 12 сарын 10-ны өдөр гээд хугацаа заачих юм бол бид нар бүүр амжихгүй. Төсөв өөрөө өргөн баригдах маш нарийн дэгтэй. Бид нар бараг 6 шат, 6 сар шахуу бэлддэг. Төсвийн ерөнхийлөн захирагч нар маань төсвийн анхан шатын шууд захирагч нараасаа саналаа хурааж аваад буюу сайд нар маань ингэж хурааж аваад энийгээ Сангийн яаманд хүргүүлдэг. Эдийн засаг, хөгжлийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл макро тоонуудаа гаргадаг. Ингээд эцэст нь Сангийн яам энэ бүгдийг нь нэгтгээд ямар боломж дотроо бид багтаах нь вэ? Ингэж боловсруулаад Засгийн газар дээрээ хэлэлцээд, Засгийн газар дэмжвэл ингээд өргөн барьдаг 9 сарын 1-нд. Ийм дэгтэй, ийм процесстой, энэ бүүр хуульчлагдчихсан.

Тэгэхээр энэ бүх процесс ингээд 12 сарын 10-нд юм уу, 11-нд ч юм уу яагаад ч багтахгүй. Төсөв өргөн барихад өөрөө бас хуулийн ийм бүрдүүлэлттэй, энэ процесс, энэ дэгээрээ явж байгаад 22 төрлийн жагсаалт бүхий бүрдүүлэлттэй төсвийг өргөн барих ийм хуультай юм байгаа юм. Тэрнээс нэг л дутуу байх юм бол Улсын Их Хурлын хүлээж авахгүй. Иймэрхүү зовлонтой процессууд руу яваад орчхож байгаа юм. Тэгэхээр одоо ер нь хэдүүлээ ингээд эергээр харъя л даа. Лодойсамбуу гишүүний ахалсан ажлын хэсгийн гаргасан юм уг нь тэгээд их зүгээр болчихсон байсан юм. Яах вэ муу л хувилбарууд л даа. Тэгэхдээ муу бас хамгийн сайн дүнгээр нь тэр хувилбар л байсан. Тэрүүгээр очих зам шинээр өргөн барих, явах хоёрын төсвийн эцсийн гарах төсөв нь яг ижилхэн гарна. Яг ижилхэн гарна.

Тэгэхээр Их Хуралдаа ч амар. Уг нь Засгийн газартаа ч амар тэр Дэгийн хуульдаа өөрчлөлт оруулаад саяын уг нь тэр Даваасүрэн даргын яриад байгааг саяын тэр төслөөр уг нь тэр дэг баталчихсан бол тэгээд л зохицуулаад явчих байхгүй юу. Тэгээд хэдүүлээ ингээд 12 сардаа төсвөө яаж ийж байгаад баталчихвал уг нь хэрэгтэй байгаа юм. Тэгээд Байнгын хороон дээр бүүр хүнд хувилбарууд ярьж байгаа байхгүй юу. Одоо тэгээд хэрвээ төсвөө батлахгүй бол бас 25 онд үргэлжлээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг чинь 680 мянган төгрөгөөр 220 мянган төрийн албан хаагч цалин аваад явах нь байна шүү дээ. Тэгээд хэдүүлээ тэр ипотекийг нь яаж өгөх юм? Маш их олон асуудлууд үүснэ.

Тэгэхээр уг нь одоо гарц Их Хурлын дарга ер үдээс өмнө тэр хүчин, юугаа дэмжээгүй юугаа дахиад бид нар хэлэлцэж болно шүү дээ. Бидэнд гарц байгаа шүү дээ. Байнгын хороон дээрээ дахиж яриад л, энийгээ дэмжээд, энүүгээрээ явчихвал тэгээд л тэр дээр чинь бүүр яг Засгийн газрын санал дээр үндэслэн Их Хурал хэлэлцэнэ гээд бүүр аягүй тодорхой Засгийн газар руугаа үүрэг өгчихсөн байна лээ шүү дээ. Одоо хэрвээ тэр танаж хасах, хэмнэхээсээ айгаад бүгдээрээ ингээд яая шийдвэр гаргаж чадахгүй байгаа тул тэгээд л Засгийн газар тэрийгээ саналаа бэлдээд л гаргаж ирээд л, оруулаад л, тэгээд л тэрийг нь Их Хурал дээрээ Байнгын хороо дамжаад л оруулаад л хэлэлцээд л явчихъя л даа. Засгийн газар тэр галаа аваад л явъя, бид нар хариуцлагаа хүлээе. Үгүй, өглөө бол миний хуруу, миний энэ юу ерөөсөө ажиллахгүй байсан шүү дээ. Тэгээд сүүлийнх дээр тэгээд л дарга цохиод л явчихсан. Тийм минийх ч эсрэг гарсан. Уг нь би дэмжсэн. Маш олон хүмүүс дэмжсэн. 55 дээр тэр 9 хүн бол тэр дарагдаагүй 9 хүн бол байсан шүү нөөц.

**Д.Амарбаясгалан:** Ер нь Улсын Их Хурлын Жавхлан сайдаа бас өргөн барьсан асуудлуудыг ажил хэрэгчээр хандаж, дэмжиж өнөөдрийн ийм нөхцөлд оруулахгүй гэж бүх л гарц боломжийг хайж ажиллаж. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавьсантай холбогдуулаад Номинчимэг гишүүн ч гэсэн бас түрүүн дутуу мэдээлэлтэй байх шиг байна. Даргын дэргэдэх зөвлөл дээр яриагүй биш ярьсан. Даргын дэргэдэх зөвлөл дээр энэ 7 хоногийн хуралдааны тов дараалал дээр Ёс зүй, дэгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо хамтарч хуралдах, хамтарсан ажлын хэсэг гаргах хамгийн боломжит хувилбараар гарц гаргаж оруулж ирэх энэ үүрэг чиглэлийг аваад өнөөдөр орж ирж хэлэлцэгдсэн.

Өнөөдөр өглөөний санал хураалтад нийт 69 гишүүн оролцсоноос 55 гишүүн дэмжсэн. 26 гишүүн танхимд байгаагүй гишүүдтэй нийлээд 26 гишүүн дэмжээгүй. Тэр дэмжээгүй гишүүд дотор жишээлбэл, Жавхлан сайд 7 сайд байна, 7 сайд шүү,

тэгээд энэ чинь Засгийн газрын гишүүд чинь өөрсдөө тийм дэгээр явуулахгүй ийм нөхцөл рүү оруулъя гэж хүсэж байна гэж ойлгож байна шүү дээ бид.

Тэгээд л Улсын Их Хурлын нэр нүүрээ бараад л энэ асуудлыг хэчнээн удаан хэлэлцэж байна. 6 дугаар сард байгуулагдсан Улсын Их Хурлын 5 сар үйл ажиллагаа явуулахдаа 4 удаа төсөв хэлэлцлээ шүү дээ. Төсвийн тодотгол хэлэлцлээ, 2023 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцлээ, Төсвийн хүрээ ахиж хэлэлцлээ, 25 оны төсвийг хэлэлцэж баталсан. Батлах нөхцөл дээр бас энэ Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэг, Байнгын хороо бүрэн ажиллаагүй, гишүүдийн саналыг тусгаагүй гэдэг асуудал хөндсөн учраас.

Тэгвэл тодотгол хийх боломжийг нь урьд нь авч хэрэгжүүлж байсан жишгийн дагуу гаргаж өгсөн шүү дээ. Бүх л нөхцөл боломжийг нь нээгээд л Улсын Их Хурлын энэ асуудлыг шийдчихье л гээд л яваад байдаг. Эргээд эс үйлдэхүй хийчхээд араас нь ахиад л ийм Улсын Их Хурлаа эвгүй байдалд оруулах, одоо энэ чинь нөхцөл чинь бүүр хэрээсээ хэтрээд паус/pause/ хэлбэр рүү орох нь байна шүү. Асуудлаа шийдэж чадахгүй хэлбэр рүү явж байна шүү. Бүх талдаа хариуцлагатай байх ёстой. Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино гэж, 1, 2 гишүүний хариуцлагагүй юм уу 1, 2 сайдын хариуцлагагүй нөхцөлөөс болж энэ Монголын төр ийм байдалд ороод сууж байх ёсгүй. Одоо юм бол хэрээсээ хэтэрч байна. Одоо жоохон зарчимтай, хэмжээ хазааргатай байх хэрэгтэй. Энэ төсөв батлуулах ганц Амарбаясгалангийн юм уу, энэ Улсын Их Хурлын 2 Байнгын хорооны юм уу, ажлын хэсгийн үүрэг ерөөсөө биш. Бид хамтдаа хэлэлцэж энэ асуудлыг нэг мөр шийдэх ёстой. Тэгээд одоо өнгөрсөн борооны хойноос цув нөмөрнө гэгчээр асуудал болоод өнгөрчихсөний дараа өнөөдөр ийм байдал яриад сууж байж болохгүй шүү дээ.

Хэрвээ ийм саналтай байсан бол өглөө санал хураалт болж байхад горимын санал гаргаад учир байдлаа тайлбарлаад явж яагаад болоогүй юм? Тэгээд ийм байдалд оруулчихаад та бүхэн маань араас нь ийм шаардлага маягийн зүйл яриад сууж байх нь зохимжгүй байна. Энэ Улсын Их Хурлын гишүүд, энэ Улсын Их Хурал, энэ Улсын Их Хурлын мэргэжлийн Байнгын хороод чинь бас өөрийн гэсэн хариуцсан чиг үүрэгтэй, мэргэжлийн туршлагатай гишүүд, Байнгын хорооны референтүүд, зөвлөхүүд гээд албан тушаалтнууд байдаг юм. Бүх л гарц, боломжийг нь хайж гаргаж өгч байна шүү дээ.

Энэ шинээр батлагдсан дэг хангалттай бүрэн биш байна. Өнөөдөр бид энэ дутуу талыг олон талаас харж байна. Төсөвт хориг тавигдахад яах вэ гэдэг асуудлыг хүртэл зохицуулж чадаагүй өнөөдөр бидний проблем асуудал болгочихсон сууж байна. Тэгээд л аль болох л энэ бүгдийг шийдье, зохицуулъя, хууль зөрчихгүй байя, 126 гишүүнтэй болсон парламент илүү мэргэжлийн байя гэдэг энэ чиг хандлага руугаа л бид ажиллаж байна шүү дээ. Тэгээд одоо нөхцөл байдал ийм байдалд хүрлээ.

Даваасүрэн дарга энэ дээр тайлбар хийгээч.

**Ц.Даваасүрэн:** Гишүүд бид нар Дэгийн тухай хуулиа л дагах ёстой. Тэгэхэд ямар ч алдаа гарахгүй. Дэгийн тухай хууль 90.8 дээр бичсэн байна шүү дээ. Хэрвээ Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан бол тухайн хуулийг хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүй болгоно нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хэлэлцэж болно гэж байгаа байхгүй юу. Тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж. Ийм л 2 юм байна шүү дээ. Тэрнээс биш өөр дэг зохиогоод л дахиад ингээд хэлэлцэнэ гэвэл энэ чинь өөрөө асуудал үүсэх байхгүй юу. Бид өөрсдөө маш тэнэг байдалд орох байсан байхгүй юу. Тэгэхээр ийм л зохицуулалттай учраас Их Хуралд ямар ч аргагүй байдалд яг Дэгийн тухай хуулийн энэ 2 юугаар явахаас өөр аргагүй л болчихоод байгаа юм л даа.

Нөгөө талаараа эхний хэлэлцүүлэг дээр жишээлбэл, Жавхлан сайд аа ингээд бид нар буцаачихсан бол яах байсан юм гэдэг асуудал байхгүй юу. Хэрвээ бид жишээлбэл Тогтвортой байдлын хуульд нийцэхгүй байна, бусад хуулиудтай төсвийн хүрээний мэдэгдлээ хангахгүй байна гээд ингээд буцаачихсан бол тэгвэл тэрийг зохицуулсан дэг бас байхгүй шүү дээ. Ижилхэн байхгүй юу? Дахиад л өргөнө шүү дээ. Үгүй тэрэнтэй л ижилхэн л одоо ч гэсэн тэгээд л явах байхгүй юу. Ахиад л ингээд л явах ёстой байхгүй юу. Үгүй үгүй тэр төсвийн дэг байгаад байхад дэг байхгүй гээд ахиж дэг зохиож болохгүй байхгүй юу даа.

**Д.Амарбаясгалан:** Мөнхсоёл гишүүний үг хэлэхээс өмнө ирц бүртгэлийг нь нэг санал хураалт явуулаадахъя даа. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Танхимд байхгүй байгаа гишүүдийг дуудъя. Ирц бүртгэлийн санал хураалт.

57, миний бүртгэл ороогүй байна. 58, Далайн Батбаяр гишүүн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн, Болдын Жавхлан сайд, 3 гэдэг чинь 60 гишүүн байгаа юм байна тээ? Энэ бүртгэлтэй мөртөө танхимд байхгүй байгаа гишүүдийг дуудъя. Норовын Алтанхуяг гишүүн, Алтаншагай гишүүн, Ж.Батсуурь сайд, Б.Батцэцэг сайд, Ж.Баясгалан гишүүн, А.Ганбаатар гишүүн, Д.Ганбат гишүүн, П.Ганзориг гишүүн, Т.Доржханд сайд, Б.Дэлгэрсайхан сайд, С.Зулпхар гишүүн, П.Мөнхтулга гишүүн, Ц.Мөнхтуяа гишүүн, Б.Найдлаа гишүүн, Б.Түвшин гишүүн, Х.Тэмүүжин гишүүн, А.Ундраа, Н.Учрал сайд Б.Хэрлэн гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Ж.Чинбүрэн гишүүн, Б.Чойжилсүрэн сайд, Р.Эрдэнэбүрэн сайд танхимд орж ирье. Санал хураалт явагдана.

Баатаржавын Мөнхсоёл гишүүн үг хэлье.

**Б.Мөнхсоёл:** Тэгэхээр энэ төсвийн асуудал бол маш чухал асуудал учраас нэг бодлын энэ бодлого хэрэгжүүлэх гол зэвсэг болсон энэ асуудал дээрээ удаан хугацаанд зараад байгаа нь зөв юм шиг. Нөгөө талдаа Даваасүрэн Төсвийн байнгын хорооны даргын хэлж байгаа болон зарим гишүүдийн хэлж байгаа зүйл дээр эргэлзээд байна л даа. Хэрэвзээ ийм дэг хэрэггүй байсан юм бол өмнөх чуулганы хуралдаанаар дэгийн асуудал яригдана, тусдаа дэг гарна, Ёс зүйн хороо, Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо нийлж байгаад ажлын хэсэг гаргаад дэг боловсруулъя гэдэг дээр яагаад явчихсан юм бэ? Тэр үед яагаад горимын санал гараагүй гэдэг, гараагүй вэ гэдэг дээр гайхаад байна. Хайран хугацаа хайран хугацаа.

Тэгээд яагаад дэг гарах болсон бэ гэхээр Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 90.8, 90.9, тэгээд энийгээ харсан чинь буцаад Төсвийн тухай хууль чинь онцгой хууль юм чинь гээд 36.1.2 гээд Улсын Их Хурлын тухай хуулийн тэр заалтаас шалтгаалаад буцаад Улсын Их Хурлын дэгийн 16 дугаар зүйлээс болоод дэг боловсруулагдсан гэж бодоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ яагаад ийм болчихов?



Хоёрдугаарт нь би бол түвшин түвшний хариуцлагын асуудал яригдаж байна гэж бусад гишүүдийн хэлж байгаа, энэ Их Хурлын даргын хэлж байгаатай санал нэг байна. Ирц дээр хариуцлагагүй байна.

Хоёрдугаарт, тухайн Байнгын хороод дээр оролцоо хариуцлагагүй байна байна. Өглөө Мөнхбаясгалан гишүүний хэлсэнчлэн ажлын хэсгүүд дээр хариуцлагагүй хандаад байгаатай өнөөдрийн энэ байдал үр дүн шууд холбоотой гэж харж байна. Ингээд нэгэнт ийм юм болсон юм чинь гээд сая Хууль зүйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо хоёр хамтдаа хуралдлаа. Олон зүйл яригдлаа. Тэгээд хугацаан дээр бид нар ярьсан. Бид нар төсөв бол чухал асуудал, амьдрал, энэ төрийн үйлчилгээг явуулах, ер нь энэ улс эх орны өдөр тутмын амьдралыг залгуулах эдийн засгийн гол суурь юу чинь мөн шүү дээ зэвсэг. Тэгэхээр батлах ёстой. Одоо ингээд бүх юмыг ухрааж бодохгүйгээр яаралтайгаар Засгаас оруулж ирье гэдэг дээрээ тохироод, Жавхлан сайдаас бид нар хугацааны асуудал дээр саналыг нь бас сонссон. Энэ олон баримт бичгүүд цугтаа явах ёстой учраас хугацаа хэрэгтэй гэсэн.

Гэхдээ нөгөө талдаа Ерөнхийлөгчийн тавих гэж байгаа хоригийг бид мэдэнгүүт бас ер нь нийгэм даяараа шуугиан тэгсэн шүү дээ. Төсөв хэт тэлчихлээ, өндөр алдагдалтай байна, танаач ээ, энэ энэ энэ асуудлаа эргэж хараач гэсэн. Тэр үеэс эхлээд тодорхой хэмжээний бас саналууд явагдаад танагдах хэсгүүд дээр ажиллаж эхэлсэн байх гэсэн ийм төсөөлөл байгаад байна л даа. Чухам бодит байдал дээр ямар байгаа юм мэдэхгүй. Тэгэхээр аль болохоор богино хугацаанд буюу 10 хоногийн дотор энэ асуудлыг шийдэхийг хичээе гэж түрүүн Байнгын хороон дээр ийм санал гаргасан шүү Булгантуяа гишүүн, бусад, гишүүд маань.

Нэмээд хэлэхэд тэр Дэгийн тухай хууль дээр энэ Лодойсамбуу гишүүн маань ахалсан энэ ажлын хэсгийн гаргасан дэгийн тухай хууль дээр яг тухайн үед түрүүн.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Мөнхсоёл гишүүнд 1 минут нэмж өгье.

**Б.Мөнхсоёл:** Тэр дэг дээр орсон байсан шүү дээ Үндэсний аудитын газар болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн саналыг яаж анализ хийлгэж болно гээд зайлшгүй байдлаар ороогүй байсан байхгүй юу. Тэгэхэд би бодож байсан юм. Тэгэхээр хугацаандаа давчдаад болно, болохгүй гэдэг шийдлээр бас болно гэсэн ийм магадлалтай заалт оруулсан юм болов уу гэж бодож байна. \

Үдээс, өмнөх хэлэлцүүлэг дээр бас Жавхлан сайдаа та Засгийн газрын оруулж ирэх санал, тооцоон дээр үндэслэн гээд биччихсэн байх юм гээд та хэлсэн үү? Өөр хүн хэлсэн үү? Тэр заалтыг буруушаах шиг болсон шүү дээ. Энэ асуултыг тодруулъя. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Мөнхсоёл гишүүн ийм байхгүй юу. Асуудал ингээд ирэхээр бид бэлтгэл ажил хангалгүй яах вэ, яаж зүгээр суух вэ, тооцооллуудаа хийлгүй яах вэ. Гэхдээ хоригийн хүрээнд засвар хийх бид нар бэлтгэл ажил тооцоолол юмнуудаа хийж байсан. Шинээр өргөн барих процесс энэ хоёр чинь өдөр, шөнө шиг ялгаатай шүү.

Шинээр өргөн барина гэдэг маань төсвийн шууд захирагч буюу төсвийн анхан шатнаас эхэлдэг. Тэндээс санал боловсрогдоно, сайд дээрээ очно, сайд нар саналуудаа Сангийн яаманд ирнэ, нэгтгэнэ, Эдийн засаг, хөгжлийн яам макро тоогоо гаргана, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл макро тоогоо гаргана. Ингээд эцсийн хүрээндээ төсвийн хүрээндээ багтаагаад Засгийн газар дээрээ хэлэлцээд тэгээд өргөн барьдаг ийм дэгтэй, хуультай байхгүй юу. Тэгээд тэр нь 9 сарын 1 гээд хугацаа заачихсан ийм дэгтэй.

Улсын төсвийг өргөн барих ерөөсөө хоёрхон л дэг байдаг. 9 сарын 1-нд, эсвэл тодотгол. Энэ удаа тодотгол биш, 9 сарын 1 ч биш. Шинээр өргөн барих биш цоо цоо шинэ нөхцөл байдал үүсэж байгаа. Өөрөөр энэ нь дэгээр зохицуулагдаагүй ийм л шинэ нөхцөл байдал үүсчхээд байгааг би хэлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм мухардмал байдалд орж байхаар өдрийн Лодойсамбуу гишүүний танилцуулсан хувилбар хамаагүй дээр хувилбар, хамаагүй дээр хувилбар, хамаагүй амар, тодорхой.

Гэхдээ эцсийн дүнд батлах тоо тэр төсөв энэ 2 дээр яг ижилхэн. Нэг нь зохицуулагдаагүй маш адармаатай замаар явах гээд байна. Нэг нь маш тодорхой дэг дээрээ хуулийн өөрчлөлт хийгээд түүгээрээ явчих гээд байна. Эцсийн дүндээ төсөв танах, хэмнэх, алдагдалгүй төсөв байх тэр тоо нь яг ижилхэн байхгүй юу.

**Д.Амарбаясгалан:** За болсон. Ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя даа. Санал хураалт.

Саналт хураалтад орж чадаагүй гишүүд байна уу?

1, 2, 3, 4, 5, надтай нийлээд 6 гишүүн. Дашдондогийн Ганбат гишүүн горимын санал.

**Д.Ганбат:** Энэ төхөөрөмж чинь бас их сайн ажиллахгүй байна уу, яасан юм өнөөдөр? Тэгэхээр санал өглөөнөөс хойш ингээд будилаад байна л даа. Дараа нь ингээд баахан гишүүд гараа өргөж ирээд. Ерөөсөө юу яая, дарга аа гар санал хураалтаар явчихъя. Ийм хариуцлагатай асуудал байгаа юм чинь. Тэгээд шууд тоолоод явчихъя. Сая гэхэд л 5, 6 гишүүн ороогүй, та хүртэл ороогүй байна шүү дээ. Нэгдүгээрт тэр.

Хоёрдугаарт, энэ Даваасүрэн сайд бас Төсвийн байнгын хорооны дарга бас олон жил хийж байсан хүний хувьд хуулиа маш сайн тайлбарлаад байна шүү дээ. Ойлгуулаад. Хуулийн зүйл, заалтууд бүгд байна. Амарбаясгалан даргад ч гэсэн би талархал илэрхийлмээр байна. Та ер нь их дажгүй их сайн дарга болох төлөвтэй шүү Их Хурлын. Тийм, ер яах вэ, Занданшатар даргын үеэс эхлээд микрофон энэ тэр хаагаад байдаггүй, хүмүүсийг яриулаад, үгийг нь сонсоод ингээд яваад байгаа байхгүй юу. Тийм соёл бас энэ манай энэ танхимд бүрдэж байгаад би бас их баяртай байна.

Ингээд гараар хураалгая гэсэн ийм санал гаргаж байна би.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан горимын санал уу?

**Б.Жавхлан:** Ийм санал байна Их Хурлын дарга аа Байнгын хороонд тачиглэл өгч өгөөч болдог юм уу, болдоггүй юм болов уу? Одоо хэрвээ ингээд энийг дэмжье дэмжье. Өглөө тэр шинэ дэг нь батлагдаагүй юм чинь 12 сарын хэдэн ч гэдэг юм уу хугацаа зааж байгаа тохиолдолд одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаад дэгээр явахгүй ч гэдэг юм уу, эсвэл түргэвчилсэн дэгээр, түргэвчилсэн горимоор ч гэдэг юм уу нөгөө олон процессуудаа үүгээрээ дамжихгүй тэр анхан шатнаасаа саналаа хураахгүй, тэгээд энэ чинь бүүр олон нийтийн хэлэлцүүлэг хийх ёстой шүү бүүр. Тэгээд ийм процессууд ийм дэгүүд бол энд хамаарахгүй гэдэг 1 удаагийн тийм дэгийн зохицуулалт ч юм уу, энийгээ гаргаж ир, хийе гэсэн тийм чиглэл Байнгын хороонд өгч болох уу? Тэгэхгүй үнэхээр энэ яг ингээд дэгийн зохицуулалтгүй болчихоор бүүр яг таг гацчих гээд байна.

**Д.Амарбаясгалан:** Жудгийн Баярмаа гишүүн горимын санал.

**Ж.Баярмаа:** Горимын санал гаргаж байна. Ерөнхийдөө Жавхлан гишүүнтэй ойролцоо мөртөө Даваасүрэн гишүүн зөв л хэлээд байгаа юм л даа. Угаасаа анхнаасаа л хэлж байсан шүү дээ. 90.9-өө баримтлаад яваач гээд би одоо бүүр Баасандорж даргад зөндөө хэлсэн. Ерөөсөө энийг тоогоогүй. 73.4 дээр болохоор энэ бүлгээр зохицуулаагүй зүйл байх аваас энэ хуулийн хүрээнд бусад заалтыг баримтал гээд биччихсэн байгаа байхгүй юу 73.4-өөр. Та тэрийг битгий худлаа яриад бай. Тэгэнгүүт 90.9-ийг баримтлах ёстой. Одоо би 90.8-ыг яриад байгааг гайхаад байгаа байхгүй юу. 90.9 дээр чинь ингэж байгаа шүү дээ хоригийг хүлээж авсантай холбогдуулан тухайн шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж оруулж ир гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр шийдвэрийн төслийг оруулж ир гэдэг чинь холбогдох Байнгын хороо нь өөрөө Төсвийн байнгын хороо. Тэгэхээр Төсвийн байнгын хороо руу буцна. Тэгээд ямар шийдвэр гаргаад явах ёстой вэ гэхээр одоо буцаад нөгөө нэгдүгээр хэлэлцүүлгийн дараагийн үе дээрээ оччихож байгаа байхгүй юу. Тэгээд шийдвэрээ яаж гаргах вэ гэхээр нөгөө зарчмын зөрүүтэй санал энэ тэрээ аваад

**Д.Амарбаясгалан:** Баярмаа гишүүн ямар горимын санал гаргах гэж байгаа билээ?

**Ж.Баярмаа:** Ингээд явна шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Горимынхоо саналыг нь?

**Ж.Баярмаа:** Тэгэхээр одоо энэ зүйл, заалтаа өөрчилж оруулж ир гэдэг юм уу, та дахиад тийм юу өгч явуулахгүй.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Ганбат гишүүний гаргасан горимын саналаар гараар санал хураалтаар асуудлыг шийдье гэж байна. Энэ ер нь яах вэ чухал асуудал байгаа. Төхөөрөмж дээр 5, 6 гишүүн саналаа өгч чадахгүй өнөөдөр бас будилаад байгаа тал бас байна. Тэгээд 64 гишүүн дэмжихгүй бол энэ асуудал ер нь тэгээд төсвийн асуудал паус/pause/ хэлбэр рүү орно л гэсэн үг. Цаашаа гарц боломж байхгүй болно о л гэсэн үг.

Өнөөдөр бол ний нуугүй хэлэхэд хориг тавигдсантай холбоотой дэгээр төсвийг зохицуулж байгаа зохицуулалт маш бага. Даваасүрэн гишүүний хэлж байгаа тайлбар нэг талын тайлбар. Хуульд хориг тавих, төсөвт хориг тавих гэдэг хоёр том ойлголт байгаа.

Хуульд хориг тавингуут хүлээгээд авчихвал хууль хүчингүй болоод явчихдаг. Төсөвт тавьсан хоригийг хүлээж авсан тохиолдолд саяын Баярмаа гишүүний хэлж байгаагаар хоёрдугаар шатны хэлэлцүүлгээс эхлээд үргэлжлүүлээд явахад ерөөсөө болохгүй зүйл байхгүй байсан.

Лодойсамбуу гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг яг энэ дээр 2 өдөр өдөр, шөнөгүй ажиллаж байж, ирц нь бараг 100 хувийн ирцтэйгээр ажиллаж байж энэ саналыг өнөөдөр гаргаж ирсэн. Харамсалтай нь чуулган дээр дэмжигдээгүй унасан.

Тэгэхээр одоо нэгэнт бид ийм нөхцөл байдалд хүрсэн учраас саналаа хураагаад дараачийнхаа асуудлыг шийдээд явах нь зөв байх гэж бодож байна. Хэрвээ өнөөдөр юмаа, асуудлаа шийдэж чадахгүй бол ахиад 7 хоногоор хойшилно. Бүүр ондоо багтах эсэх асуудал бүүр хүнд болж эхэлнэ гэсэн үг.

Харин Жавхлан сайдын саяын хэлж байгаа саналын дагуу түргэвчилсэн горимоор хэлэлцэх тэр боломж нөхцөл нь юу байх юм? Энэ дээр хариуцаж байгаа Байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, Ёс зүй, дэгийн байнгын хороод нэ дээр ажиллах ёстой.

Энэ хэн нэг хүний асуудал огтоос биш шүү. Энэ бол Улсын Их Хурлын дээр энэ төсөв хэлэлцэж байгаатай холбоотой асуудал байгаа гэдгийг бүх талаас нь хариуцлагатай ойлгох нь зүйтэй гэж бодож байна.

Мөнхбаясгалан гишүүн горимын санал гаргая гэнэ.

**Л.Мөнхбаясгалан:** Жавхлан сайдын хэлснийг найруулаад түргэвчилсэн горимоор, Лодойсамбыг гишүүний өглөөний барьж орсон 1 удаагийн дэгийг дахиж жоохон найруулаад буцаад хэлэлцчихье л даа.

**Д.Амарбаясгалан:** Баасандорж дарга энэ Жавхлан сайдын гаргасан саналаар ажлын хэсгээс орж ирсэн дэгээр санал хураагаад шийдчихсэн байхад ахиж эргэж тэр асуудлыг хөндөх боломж гарах юм уу? Энэ дээр тайлбар өгөөдөх өө.

**Б.Баасандорж:** Баасандорж Улсын Их Хурлын Тамгын газар.

Сая Жавхлан гишүүний гаргасан горимын саналын дагуу дахиж ярина гэдэг асуудал дэгээрээ байхгүй Жавхлан гишүүн ээ. Яг энэ асуудлыг Улсын Их Хурлын гишүүд хэлэлцээд олонхоороо дэмжээгүй тул энэ асуудал одоо хаагдсан. Тэгэхээр одоо бол бид нөгөө хууль хүчингүй болгох тухай буюу Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны оруулж ирсэн асуудлыг хэлэлцэж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Тэгвэл Дашдондогийн Ганбат гишүүний гаргасан горимын саналаар илээр санал хураалтыг гар өргөж болон төхөөрөмжөөр өгнө гэсэн дэгийн заалт байдаг. Тэгэхээр гараа өргөж санал өгье гэж дэмжиж байгаа гишүүд гараа өргөж саналаа өгчихье эхлээд. Дашдондогийн Ганбат гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн гишүүдийг гараа өргөхийг хүсье. Гишүүд гараа өргөнө шүү, өргөөд байж байгаарай зураг дарна шүү. Араас нь Жаргалан гишүүн бичиг ирүүлнэ. Тоолоорой хурал зохион байгуулах хэлтэс.

Тэгэхээр хэдэн гишүүн болов? 70 гишүүн, Тэмүүжин гишүүн өргөсөн юм уу? Өргөөгүй шүү дээ тэр. 70 гишүүн санал хураалтад оролцсон байна. Нийт 85 гишүүн өнөөдөр ирцэд бүртгэлтэй байгаа. 69 гишүүн дэмжсэн байна.

Тэгвэл санал хураалтыг гараар, гар өргөж явуулахаар боллоо.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гар өргөж явагдах нь ээ.

Гишүүд гараа өргөж байгаарай. Дэмжиж байгаа гишүүд нь гараа өргөж байгаарай. Тамгын газрын Хурал зохион байгуулах хэлтсээс тоолж байгаа, маргаангүй байсан дээр. Номин сайд, Жавхлан сайд, Баатархүү сайд, Баатархүү дэмжсэн байна. Мөнхсайхан сайд 3 дэмжээгүй байна тээ? Өөр дэмжээгүй хүн байна уу гараа, хэлээрэй. Танхимд байгаа гишүүдээс 3 сайд дэмжээгүй, бусад нь дэмжлээ.

68 хүний дэмж дэмжлэгээр. Айн Одонтуяа сайд дэмжээгүй юм уу? 4 сайд дэмжээгүй юм байна. Одонтуяа сайд дэмжсэн юм байна. Тэгвэл 68 гишүүний саналаар хоёр Байнгын хорооноос орж ирсэн тогтоол дэмжигдлээ.

Ингээд Байнгын хороодын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд оръё.

*15.23 цаг*

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д долоо хоногийн баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.**

Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг Байнгын хороод бэлтгэж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслүүдийг эцэслэн батлах санал санал хураалтыг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа.

Санал хураалт эхэлнэ. Санал хураалт чинь дандаа гараар явахаар болчихсон тийм ээ?

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Батлут дэмжиж байна шүү дээ. Гишүүд ээ, маргаан гаргахгүйн тулд дэмжиж байгаа гишүүд гараа өргөөд сууж байхыг хүсье. Ганзориг гишүүн яаж байгаа юм байр суурь нь? Хэдүүлээ анхаарлаа хэдхэн минут төвлөрүүлчихье тэгэх үү? 7 настай хүүхэд 5 минут төвлөрдөг юм гэсэн шүү.

3, 4 хүн дэмжээгүй байна тийм ээ? Мөнхсайхан, Бадамсүрэн, Жавхлан, Одонтуяа гэсэн 4 гишүүн дэмжээгүй байна танхимд байгаа гишүүдээс.

Тэгээд дэмжээгүй гишүүд нэр дурдагдахгүй бол бас хэлээрэй. Энэ протоколд тэмдэглэж байгаа, энэ хурал Зохион байгуулах хэлтсээс тоолж байгаа учраас.

2. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Салдангийн Одонтуяа, Болдын Жавхлан, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Тогтмолын Мөнхсайхан, Чинбатын Номин, Сүрэнжавын Лүндэг. Лүндэг гишүүн дэмжиж байгаа юм байна тээ? Хэрлэн гишүүн яах юм? Дэмжиж байгаа юм уу, дэмжихгүй байгаа юм уу? 5-хан минут анхаарлаа төвлөрүүлчих хэдүүлээ хариуцлагатай ажил хийж байгаа. Тулга сайд дэмжээгүй байна. Ингээд 6 сайд дэмжээгүй байна.

66 гишүүн, танхимд байгаа гишүүдээс 66 гишүүн дэмжсэн байна.

3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

4 гишүүн дэмжээгүй байна. 68 гишүүнээр дэмжигдлээ.

Далайн Батбаяр гишүүн дэмжиж байгаа юм уу? Та хэд маань анхаарлаа 5-хан минут төвлөрүүлээд гараа өргөчих. Энэ протоколд үлддэг учраас эргээд манай Б.Энхбаяр, Б.Жаргалан зэрэг гишүүд чинь араас протоколоо өг гээд бичиг ирүүлдэг юм. Бас протокол өгөх учраас энэ дээр та хэд маань бас анхааралтай хандчих.

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

4 сайд дэмжээгүй байна. Бусад нь дэмжсэн байна. 68 гишүүний саналаар дэмжигдлээ.

5.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

4 сайд дэмжээгүй байна. Бусад нь дэмжсэн байна.

5.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль,

6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явна.

Өмнөх 5 дахь санал хураалт 64 гишүүнээр дэмжигдсэн байна тийм ээ? Энэ гишүүд гарч яваад байгаа юм уу танхимаас? 4 сайд дэмжээгүй байна тийм ээ? Өөр дэмжээгүй гишүүн байна уу?

Алга байна.

66 гишүүн дэмжсэн байна.

7.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

4 сайд дэмжээгүй байна.

66 гишүүн дэмжсэн байна. Баатархүү сайд дэмжсэн үү, дэмжээгүй юу? За дэмжсэнд орсон.

Ингээд хууль тогтоолын төслүүд батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд талархал дэвшүүлье.

7 л байна даа. 6 хууль, 1 тогтоол байна. Орж ирж байна.

Хууль тогтоолын төслүүд батлагдсан.

*15.31 цаг*

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурлын энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.**

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцно.

2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3.Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

5.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

7.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудал. “Хууль хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төсвийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Индэрт урьж байна.

**Х.Ганхуяг:** Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,



Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хүлээн авсан.

Төсвийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурлын хүлээж авсантай холбогдуулан 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр баталсан холбогдох хууль, тогтоолыг хүчингүй болгох тухай асуудлыг хэлэлцсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгч бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хуралд хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан “Хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл санаачлан боловсруулж хэлэлцэн батлах шаардлагатай гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул уг тогтоолын төслийг боловсрууллаа.

Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хамтарсан Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгч бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурлын хүлээн авч, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан боловсруулсан “Хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ганхуяг гишүүнд баярлалаа.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

3 гишүүнээр тасаллаа, 4 гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэболд:** Бид нар ер нь бол намаржингаа л ингээд төсөв ярилаа. Ингээд төсөв маань бол хориг хүлээж авлаа, одоо үргэлжлээд олон олон гаргалгаануудыг л ярьж байна л даа. Яах вэ би бол чимээгүй суугаад байсан түрүүн Лодойсамбуу гишүүний гаргасан саналыг дэмжээд суугаад байсан. Ер нь бол Их Хурлын гишүүд маань бас яг энэ төсвийн асуудал дээр хаа хаанаа хариуцлагатай хандмаар байна. Жоохон популизмаа ч юм уу ингээд олон нийтэд таалагдах гэсэн хэлбэрдэлтээ жоохон больчихмоор санагдаад байх юм. Энэ чинь бас тоглоом биш.

Яагаад ингэж хэлж байгаа вэ гэхлээр энэ парламентын засаглалын бас тэр чадавх, мөн чанараа бас жоохон хүндэлчихсэн үйлдлүүд гаргамаар байгаа юм. Парламентын гишүүн нь өөрөө парламентаа муухай харагдуулах гэсэн, парламентаа хүчгүй харагдуулах гэсэн энэ хуулийн засаглалынхаа гол чадавхыг сулруулах гэсэн үйлдлийг хиймээргүй байгаа юм.

Тэгээд иргэдэд юу гэж ойлгогдох вэ гэхлээр өө нөгөө 76 байснаа 126 болоод нэмэр байхгүй, 126 ч гэсэн бүтэхгүй юм байна, ер нь цаашдаа бол энэ парламент бол тийм найдваргүй юм байна гэсэн мессеж өгөхүйц тийм зүйл болж байгаа. Энэ нь санаатай болон санамсаргүй байдлаар энэ парламентыг чадавхгүй болгох гэсэн ийм зүйлүүд байгаад байна. Энэ нь өөрөө хариуцлагагүй үйлдэл. Мэдэж байгаа хэр нь мэдэн будилж байгаа, эс үгүй бол мэдэхгүй байгаа, эс үгүй бол сайн судлаагүй байгаа ийм зүйлүүд холилдож, сульдаад байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ уриалъя. Одоо утас шөрмөсөө тавьж байгаад энэ төсвийн асуудал дээр ирцээ бүрэн оруулаад ингээд хариуцлагатай хандмаар байна. Өглөөний мэдээгээр 30 гишүүн гадаад томилолттой байгаа гэсэн. 1 гишүүн орон нутагт томилолттой байгаа гэсэн 126-аас. Тэр үлдсэн хүмүүс нь энэ парламентынхаа үйл ажиллагаа, үндсэн ажилдаа идэвхтэй оролцоод хариуцлагатай хандахыг уриалж байна. Аливаа асуудалд субъектив биш, аливаа асуудалд өргөсөн тангаргийнхаа төлөө жоохон хариуцлагатай хандаач гэдэг уриалгыг тавьж байна. Парламентын гишүүд өөрсдөө парламентын үнэт зүйлийг сахиач, үнэт зүйлийг хамгаалаач гэдэг уриалгыг дэвшүүлье.

**Д.Амарбаясгалан:** Жудгийн Баярмаа гишүүн. Асуулт асууж, үг хэлнэ.

**Ж.Баярмаа:** Хоёр талтай. Сая яг Эрдэнэболд гишүүний хэлсэн дээр бол нэг талаасаа парламентыг чадамжгүй мэт харагдуулах ийм санаатай, санаагүй үйлдэл байна гэж шүүмжилж байгаа хэсэг бүлэг хүмүүс байхыг үгүйсгэхгүй.

Гэхдээ нөгөө талдаа энэ чинь харин амьд парламент юм биш үү гэдэг ийм бас үзэл санааг илэрхийлж байгаа иргэд зөндөө байгаа. Яагаад гэвэл улс төр бол угаасаа мэтгэлцээн. Тэгээд мэтгэлцээнийх нь талбар нь юу вэ гэхээр парламент. Тэгээд бид нар юмаа зөв зохистой л хийж байна. Дундуур нь харин тэр хуулийн гаргалгааг гаргах, олох энэ тэр дээрээ харин Их Хурлын гишүүд маань өөрснөө маш хариуцлагатай, бүүр өөрснөө уншиж судалж бас оролцмоор санагдаад байгаа юм. Зөвхөн Тамгын газарт бас найдах бус би бол Тамгын газарт маш

шүүмжлэлтэй хандаж байгаа. Би олон олон дахин хэлж байгаа Баасандорж даргад.

Хоёрдугаарт, энэ авах арга хэмжээтэй холбоотой асуудал дээр ийм санал байгаа юм. Асуулт юм уу санал. Орон нутгийн төсвөө яах гэж байгаа вэ гэдэг асуулт үүсэж байна. Түрүүн зөндөө гишүүд ярьсан. Тэгэхээр тогтоолын авах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурлын хүлээн авсантай холбоотойгоор авах арга хэмжээний, авах арга хэмжээ дотроо энэ нөгөө цаглаврыг түдгэлзүүлэх ийм нэг тийм арга хэмжээ авахгүй юм уу? Болно шүү дээ. Төсвийн тухай хууль бол ердөө бүүр онцгой тустай хууль. Элээ минь ерөөсөө бараг л гар хүрч болохгүй гэж ингэж номлоод байгааг би ерөөсөө хүлээн зөвшөөрмөөргүй байгаа юм. Аяндаа тэр чинь заасан юмыг нь дагаад хэрэглэнэ, заагаагүй юмыг нь яах вэ гэдгийг чинь дахиад энэ хууль дотор чинь тэр 73.4-өөр заачихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо тэр цаглаврыг нь түдгэлзүүлэх ийм тогтоолын төсөл гаргаасай гэж хүсэж байна. Тэгвэл тэр 12 сарын 5-нд хавчигдаж, баригдаж орон нутаг маань сандрах хэрэггүй.

Яагаад гэвэл нэгэнт хавчигдаад, баригдаад, сандраад баталчихвал дахиад одоо бид нарын хийсэн төсөвтөө үндэслээд дахиад тэд нар чинь ингээд өөрчлөх хэрэг гарах юм шиг байна. Тэгэхээр ийм зарчмын саналыг хүлээж аваад энэ дээр жинхэнэ ямар хуулийн зүйл, заалтыг баримталж энэ цаглаврыг түдгэлзүүлэх ёстой юм болоо? Тэрийг авч үзэж тодорхой шийдвэрийг гаргаж өгөөсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сайнбуйангийн Амарсайхан Шадар сайд асуулт асууя.

**С.Амарсайхан:** Энэ төсвийн асуудал дээр маш нухацтай хандаж хурдан шийдэхгүй бол төрийн санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө. Цаашлаад нийгэм, эдийн засгийн асар олон сөрөг үр дагавруудыг бий болгоно. Одоо ингээд хараад байхаар нөгөө улсаар, төрөөрөө тогловол улсгүй болно, эхээрээ тоолбол элэггүй болно гэдэг шиг төсвөөрөө хэт их цэцэрхэж, хийрхэж тоглосон энэ тоглоом, төр цаашлаад ард түмний амьдралаар тоглох ийм тал руугаа орж байна шүү. Энэ бол тоглоом биш. Энэний ард төрийн албан хаагчдын цалин, төсөвт байгууллагуудын урсгал зардал, сургууль, цэцэрлэгийн санхүүжилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүүхэд багачуудын сургууль, цэцэрлэгийн асуудал, төрөөс санхүүждэг дэд бүтэц, энэ тог цахилгаан, эрчим хүч, харилцаа холбоо гээд энэ өвлийн хатуу, ширүүн улиралтай давхацсан асар олон асуудлууд бий. Үүний цаана аймаг орон нутгийн амьдрал гэж бий. Төвөөс алслагдсан, амьдралаас бас алслагдсан хэр нь улс төрч та бидэнд хувь заяагаа даатгачихсан нүдээ хөхөртөл хараад сууж байгаа ард түмний амьдрал бий. Тэгэхээр энэ тоглоом тоотойн дээр гэдэг шиг юм жоохон хэмжээтэй байгаач л гээд л би бас цөөнгүй удаа хэлж байгаа юм.

Тэгээд өнөөдөр би энэ тогтоолтой холбоотой ганц, хоёр асуудлыг хэлье гэж бодож байгаа юм Засгийн газарт буцаагаад дахин шинээр өргөн барихдаа хялбаршуулсан горимоор явахгүй бол болохгүй учраас, цаг хугацаа байхгүй учраас энэ дээр тогтоол дээрээ бид тэр үг, үсгийг оруулах хэрэгтэй байна. Тэртээ тэргүй бид энэ төсвөө өргөн барьсан, хэлэлцүүлсэн, баталсан, хориг тавьсан. Ямар нэгэн төсвийн зарцал, зарлага, зарцуулалт явагдаагүй.

Гэхдээ хуулийн хүрээнд төсвийн төсөл, төсөөллөө бид нар хэлэлцүүлгээ хийгээд үе шаттай нь ороод ирчихсэн. Одоо дахиад эхнээс нь, анхан шатаас нь явна гэх юм бол нэгдүгээрт тийм цаг хугацаа байхгүй, хоёрдугаарт тийм шаардлага байхгүй. Дахиад энэ дундуур бөөн хийрхэл, явцуурал орж ирээд тэгээд төсвөө баталж чадахгүй явах юм бол цаана нь энэ улс орон ямар байдалд орох вэ гэдгээ эргэж бүгдээрээ нухацтай харж, бас анхааралтай энэ асуудлаа түргэн, шуурхай цэгцлэх хэрэгтэй байна.

Тийм учраас Улсын Их Хурлын дарга наад энэ тогтоол дээр хялбаршуулсан маягаар түргэн шуурхай Сангийн яам дээр тодотгол гэдэг юм уу, өөрчлөлтөө хийгээд шууд буцаж өргөн барих энэ хэмжээнд оруулахгүй бол болохгүй асуудлуудыг редакцын гэдэг юм уу, үг, үсгийн найруулгаар оруулж, тогтоолоо албажуулах хэрэгтэй байна гэдгийг хэлж байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**М.Бадамсүрэн:** Эрхэм гишүүд ээ, одоо энэ асуудал дээр ийм сэтгэлийн хөөрлөөр биш, бодитой хандах хэрэгтэй байна. Тэгээд өнгөрсөн хойно нь ярилаа гээд бас олон хүн бодож магадгүй. Гэхдээ ухаантай хүн бусдын алдаанд суралцаж, арай бага ухаантай нь өөрийнхөө алдаанд суралцдаг гэж. Тэгэхээр энэ жил анх удаа энэ 9 сарын 1-ний өдрийн дотор төсвийн төслийг өргөн барьдаг болсон юм байна лээ. Энэ жил яах вэ улс төрийн бас сонгуультай жил байсан, олон том мега төсөл хэрэгжүүлэхийг зорьсон, хамтарсан Засгийн газар байгуулагдсан гээд хүчин зүйлүүд бас байгаа.

Гэхдээ бушуу туулай борвиндоо баастай гэдэг шиг энийг яарч сандармааргүй байна. Яагаад гэвэл энэ чинь бүтэн 1 жилийн 365 хоногийн асуудал бид нар олон ард иргэдийн өрх айлын амьдрал ахуйд нөлөөлөх, хувийн хэвшилд нөлөөлөх асуудлыг шийдэх гэж байгаа учраас энийг их гэнэт л учиргүй хугацаан дээр яараад л, одоо ер нь болохоо болилоо, ингэлээ тэглээ гээд ингэх шаардлагагүй гэж бодож байна.

Яагаад гэвэл Улсын Их Хурлын энэ төсвийг батлахдаа ер нь жоохон бас асуудал байна, тийм учраас энэ ондоо багтаж төсвийн тодотголыг хийе гэдэг тогтоолыг тэртээ тэргүй гаргачихсан шүү дээ. Тэгээд одоо ингээд л зарим нь их цэцэрхээд л, ингээд л хугацаа ном болохоо болилоо гээд л. Тэгээд тийм учраас энэ зүйл дээр сэтгэлийн хөөрлөөр биш бодитой хандаарай нэг.

Хоёрдугаарт нь энэ зарим дарга нар энэ субъектив байдлаар ханддагаа болих хэрэгтэй. Одоо цаг үе өөр болсон. Тэгээд нэг юм ярингуут л тийм хувь хүн рүү нь чиглэсэн юм яриад л. Тэр цаг, тэр улс төр чинь одоо дууссан. Одоо бол илүү бодитоор уурласан болгон дайсан биш, инээсэн болгон нөхөр биш гэдэг шиг тэр бодитой санал хэлж байгаа хүмүүсийн гишүүдийн үгийг хүлээж авдаг байх хэрэгтэй. Том алдаа гарахаас энэ чинь сэргийлнэ шүү дээ. Түүнээс энэ ингэж хэлээд байгаа юм гээд л энэ эсрэг, тэсрэг байгаа юм гээд ийм байдлаар хандах юм бол цаашдаа бид нар олон хуулийг батлахад энэ байтугай хүндрэл учирна.

Тийм учраас энэ зүйлийг цаашид хэлэлцэхийн тулд бид нар юун дээр анхаарах вэ гэхээр намын бүлгүүд маш сайн хэлэлцэх ёстой энийг. Тэгээд бүлэг дээрээ хэлэлцээд санал нэгдээд, олон улсын парламентад энэ ёсны дагуу тэгээд

бүлгээ төлөөлөөд энэ зүйл дээрээ нэгдмэл байр суурьтай байх хэрэгтэй шүү дээ. Сонгуульд амласан мөрийн хөтөлбөр, сонгуулийн амлалт гээд зүйлүүд байна. Тэгэхгүй ингээд өөр өөр юм яриад л ингээд л, энэ л тийм ийм парламент чинь, парламент ёс чинь өөрөө дотроо бүлэг дээр тулгуурлаж байгаа улс төрийн намууд. Бүлэг дээрээ санал, шүүмжлэлээ сайн нэгтгээд, нэгдсэн байр суурьтайгаар энэ дээр ажиллах хэрэгтэй байна. Энэ дээр би бүлгийн дарга нар нэлээн сайн анхаарч ажиллаасай гэж албан ёсоор хүсэж байна.

Дараагийнх нь энэ ажлын хэсэг байгуулагдах байх. Тэгээд ажлын хэсэг дээр одоо ёстой жинхэнэ санал хураалтыг явуулж, шүүсийг нь шахаж энэ дээр болох, болохгүй талаас нь бүгдээс нь сайн анзаарч ажиллаасай гэж хүсэж байна. Ер нь ингээд ажил нурахад л хамгийн их маргаан үүсдэг шүү дээ. Тэгээд л буруутан хайгаад л энэ тийм болсон гээд л. Тэгэхдээ яг энэ дээр ямар алдаанууд гарсан юм гэдгийг бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Тэгээд ингээд бие биеэ жоохон хаацайлсан байдалтай энэ тэр яваад байгаа зүйл байгаа. Энийг бүгдээрээ мэдэж байгаа.

Тийм учраас энэ зүйл дээрээ бас арай өөрөөр хандаж яваасай гэж бодож байна. Дээр нь энэ тогтоолын төсөл дээр орвол санал байна. Тэр бол орон нутгийн төсвийн орлого, зарлагыг баталсан зүйлээ энэ дүнг өөрчлөхгүй байх гэдэг энэ зүйлийг, чиглэлийг оруулмаар байна. Тэгэхгүй бол яг энд үүсэж байгаа нөхцөл байдал чинь 21 аймаг, нийслэл дээр дахиад үүснэ. Энд болсон энэ асуудлыг тэр орон нутаг дээр битгий аваачиж энэ дээр нялзаагаасай гэж хүсэж байна. Тийм учраас энэ тогтоол дээр их дүн эзлэхгүй юм байна лээ. Энэ тийм учраас энэ дээр орон нутгийн төсөвтэй холбоотой тэр сая бид нарын баталсан орон нутагт өгчихсөн байгаа тэр дүнгүүд дээр ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй байх нь зүйтэй гэсэн. Энийг тогтоолын төсөл дээр оруулах саналтай байна.

Нөгөө талдаа Ерөнхийлөгчийн тавьсан хоригт байгаа сонгуулийн амлалтаа биелүүлэх, хоёрдугаарт нь төсвийг алдагдалгүй, чиг үүргийг нь давхардалгүй байлгах гэдэг зүйлийг энэ дээрээ хоригийг нэгэнт бид хүлээгээд авчихсан учраас, зөвшөөрчихсөн учраас энэ үзэл санаа агуулгыг нь энэ тогтоол.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан үг хэлье.

**Б.Жавхлан:** Сая миний өмнөх 2 гишүүний санаатай бараг давхацлаа даа. Амарсайхан Шадар сайдын хэлж байгаа тэр түргэвчилсэн горим гэдэг санааг оруулж өгөөч.

Хоёрдугаарт, Бадамсүрэн гишүүний хэлж байгаа сая, одоо энэ болж байгаа процессууд 12 сарын 5, 6-нд батлагдах, дараа нь 12 сарын 20-нд батлагдах шат шатын орон нутгийн төсвийн батлах тэр процесст саад болохгүй гэдгийг бас энэ талаар нь тодруулж оруулж өгөөч гэдэг ийм саналтай байна.

**Д.Амарбаясгалан:** Баасандорж дарга энэ түргэвчилсэн горимтой холбоотой асуудал дээр тайлбар өгөөч. Ер нь бол одоо бид угаасаа цаг хугацаа, нөхцөл байдалд ингэж шахагдаж байгаа юм чинь. Өдөр болгон хуралдсан ч хамаагүй асуудалд бол ажил хэрэгчээр хандаад явж болно. Нээлттэй.

Харин төсөв эргэж өргөн барихтай холбоотой Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Аудит зэрэг байгууллагуудаас авах, гарах дүгнэлтийн асуудлууд,

зөвлөмжийн асуудлууд, бусад иргэд, олон нийтээр хэлэлцүүлэг хийх нөхцөлтэй холбоотой асуудал гээд эдгээр зүйлийн зохицуулалт чухам яаж явах вэ Баасандорж дарга энэ дээр тайлбар хийгээд өгөх үү. Зөвлөгөө өгөөдөх үү? Тайлбар биш зөвлөгөө.

**Б.Баасандорж:** Баасандорж, Тамгын газар.

Их Хурал бол яг өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын, энэ хэрвээ энэ тогтоол батлагдаад Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл ороод ирэх юм бол дэгтээ ахиад Ёс зүй, дэгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо хуралдаад дэгтээ ямар хэлбэрээр яаж хурдан явах вэ гэдэг асуудал нь нээлттэй.

Засгийн газар бол өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд одоо бид нар 2013 оны төсвийн тухай хууль, Төсвийн ерөнхий хууль гэж байгаа тээ? Энэ төсвийн хуульдаа одоо ингээд нөхцөл байдал ингэж 11 сарын 15 Ерөнхийлөгчийн хориг хүлээж авсантай холбоотойгоор энэ Аудит, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, олон нийтийн хэлэлцүүлэг гэдэг юм уу энэ байдлууд энэндээ хамаарахгүй гэсэн Төсвийн хуульдаа өөрчлөлт оруулах нь Засгийн газарт өөрт нь бүрэн эрх нь байгаа шүү дээ. Бид нар жил болгоны төсөв оруулж ирэхэд дандаа хуулийн төслүүд өөрчлөлттэй орж ирдэг юм шүү дээ. Ийм ийм хуулиудад энэ ийм ийм өөрчлөлтүүдийг ороод ирье гээд.

Тэгэхээр Засгийн газар энэ хуулиа санаачлахдаа холбогдох ямар ямар хуулиуддаа өөрчилж оруулах юм бэ гэдгийгээ санаачлах юм бол Их Хурал харин орж ирсний дараа, одоо бол асуудал орж ирээгүй учраас бид бүхэн Их Хурал өөрөө түргэвчилсэн горим, ийм горим гэж ярих нь өөрөө цаг нь болоогүй. Яагаад гэвэл асуудал орж ирээгүй гэж үзэж байна.

Өргөн барьсан тохиолдолд Их Хуралд бүрэн эрх нь байгаа. Ёс зүй, дэгийн байнгын хороонд байгаа.

**Д.Амарбаясгалан:** Нэрээ аваад дуусчихсан байгаа. Тодруулах боломжгүй. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Гишүүд маань энэ зарим гишүүдээс гарч байгаа саналд хүндэтгэлтэй хандаарай. Бид их олон асуудал дээр олон сар өдрөөр хуралдаад ямар ч завгүй яваад байдаг зүйл бол байхгүй. Төсөв хэлэлцэж байгаа нөхцөл байдал дээр өөрсдөөс шалтгаалах асуудлаар шалтаг гаргахгүйгээр, хариуцлага алдахгүйгээр байхгүй бол өнөөдөр эцэст нь ямар үр дүнд хүрч байгааг та бүхэн бүгдээрээ харж байгаа.

Лодойсамбуу гишүүн хэвлэлд бас мэдээлэл хийж байсан. Энэ төсөв батлагдаж байх үед. Өнгөрсөн борооны хойноос цув нөмөрч байна. Хуулиа мэдсээр байж байж 2 дугаар, 2 дахь хэлэлцүүлгээ хийгээд төсөв боочихсоны араас урсгал зардал багасгах асуудлыг хөндсөн. Хөндсөн зарчим нь буруу биш, зөв. Ганцхан хөндсөн цаг үе, процесс нь буруу байгаа гэдэг дээр санал хэлж байсан. Тэгээд энэ олон гишүүдийнхээ гаргаж байгаа саналыг Улсын Их Хурлын Даргын дэргэдэх зөвлөлийн хүрээнд ярилцаад бас хүндэтгэлтэй хандах үүднээс хуульд байгаа гарц боломжийн дагуу төсвийн тодотгол хийх тогтоолын төслийг авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд баталж өгсөн. Гарцыг нь л гаргаж өгсөн.

Түүнээс Улсын Их Хурлын энэ асуудлыг хүндрүүлэх гээд байсан зүйл ерөөсөө биш. Гишүүдийн тавьсан санал зарчмын хувьд зөв, арга хэмжээ ав гэдэг асуудлыг хөндөж тавьсан. Төсвийн тодотголыг ирэх оны 1 дүгээр улиралдаа багтааж хий гэдэг тогтоолын төсөл Төсвийн байнгын хороонд бэлтгэгдээд орсон боловч ондоо багтааж төсвийн тодотгол хий гэж Байнгын хороон дээр гишүүдийн саналаар өөрчлөгдсөн. Эргээд Ерөнхийлөгчийн хориг тавигдсан. Бидэнд ирсэн мэдээллээр тодотгол хийхээс хориг тавиулаад хийх нь илүү хялбар гэж үзсэн байр суурь илэрхийлсэн зарим хүмүүс байгаа.

Тэгээд эргээд хориг тавьсан. Хоригийг хэрхэн хүлээж авч, яаж хэлэлцэх вэ гэдгийг бид 1 удаагийн хууль баталж хийхээр ажлын хэсэг, Байнгын хороод санал, дүгнэлт гаргаад өнөөдөр оруулж ирж хэлэлцүүлээ. Тэр аль нэг хүний чиглэлээр биш, Даргын дэргэдэх зөвлөлийн чиглэлээр биш Байнгын хороод хуралдаад, ажлын хэсгээ байгуулаад ажлын хэсгийн гишүүд ийм санал гаргаад орж ирсэн. Бидэнд хамгийн зөв гарц, боломж тэр л байсан.

Харамсалтай нь өглөө санал хураалтад 69 гишүүн оролцсоноос 55 гишүүн дэмжсэн.

Дэмжээгүй 26 гишүүн бүртгэлтэй байсан гишүүд дотор 8 нь Засгийн газрын гишүүн ирцэд бүртгүүлчхээд саналаа өгөөгүй. Ахиад асуудал ийм түвшин рүү орж ирлээ. Монгол Улсын парламентын түүхэнд анх удаагаа төсөв, баталсан төсвөө хүчингүй болгох шийдвэрийг өнөөдөр ингээд албан ёсоор гаргаад сууж байна. Би Баярмаа гишүүнтэй санал нэг байна. Парламентын гишүүдийн тоо нэмэгдсэнээр мэтгэлцээн улам бүүр өргөжиж байгаа. Тэр маш сайн үзүүлэлт.

Гэхдээ хэзээ, хаана, ямар цаг хугацаанд вэ, бид ямар хуульд зохицуулагдаж ажиллаж байгаа вэ гэдгээ бодож, тооцож асуудалд хандах ёстой. Асуудлыг хэлэлцэж байхад байхгүй байсан мөртөө би байхгүй байсан гэж ирээд араас нь санал гаргаж, хэвлэлийн хурал хийж улс төр хийж явдаг байр суурь байж болохгүй. Та бүхэн чинь энэ ард түмний итгэлийг аваад сонгогдоод гараад ирчихсэн хариуцлагатай байх ёстой албан тушаалтнууд.

Гэтэл олуулаа сууж байгаад асуудал хэлэлцсэний ард дээр би байгаагүй юм гэдэг байдлаар асуудалд хандаж бүх зүйлийг хүндэрсэн хэлбэр рүү оруулж байгаа байдал бол цаашдаа бусад асуудал дээр байж болохгүй ээ. Бид энэ бүгд дээр маш хариуцлагатай хандах ёстой гэдгийг гишүүддээ бас зориуд анхааруулж хэлэхийг хүсэж байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Түрүүчийн санал хураалттай холбоотойгоор нэмэлт мэдээлэл өгье. Санал хураалтыг бас тодруулж хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Гараар санал хураачихсан бас буруу, зөрүү байх зүйл яригдахыг бас үгүйсгэхгүй. 7 санал хураалт явсан. Эхний санал хураалт 68 гишүүнээр, 2 дахь санал хураалт 68 гишүүнээр, 3 дахь санал хураалт 68 гишүүнээр, 4 дэх санал хураалт 68 гишүүнээр, 5 дахь санал хураалт 64 гишүүнээр дэмжигдсэн байна.

Одоо Байнгын хороодын саналаар “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг

баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Гишүүдийн олонх дэмжлээ. Ердийн олонхоор, танхимд байгаа гишүүдийн олонхоор асуудал шийдэгдэнэ.

Баатархүү сайд дэмжээгүй байна. Дэмжсэн юм уу? санал хураалт бол 10-хан секунд болж байгаа.

Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Хууль тогтоолын, Монгол Улсын Их Хурлын тогтоол, “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай”,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурлын хүлээн авч, хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Саяын санал хураалтын нийт 67 гишүүн дэмжсэн байна.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Жавхлан сайд энэ дээр санал хэлээд байсан уу, тогтоол дээр? Энэ тогтоолоор 12 сарын 10-ны дотор өргөн барь гэсэн үүрэг, чиглэл өгч байна шүү дээ. Тэгэхээр эцсийн найруулга дээр санал байна уу?

Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Түрүүн хоёр ч гишүүн ижилхэн санал гаргасан тэр түргэвчилсэн горимоор гэдэг нэгд, хоёрт энэ зохицуулалт гэх үү, юу гэх вэ, шинэ нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулж, шинээр өргөн барихтай холбогдуулж эдгээртэй холбогдоод 12 сарын 5-нд, 12 сарын 20-нд яг залгаад батлагддаг орон нутгийн шат шатын төсвүүд хэлэлцэж батлах энэ процесс явдгаараа явна гэдэг тийм зохицуулалт, тийм заалт оруулж өгөөч л гэдэг ийм горимын саналтай байна.

**Д.Амарбаясгалан:** Жигжидийн Батжаргал гишүүн эцсийн найруулга дээр санал хэлье.

**Ж.Батжаргал:** Үгүй үгүй. Энэ тогтоол дээр их тодорхой ормоор байгаа юм. Тэр нь юу байна вэ гэхээр зэрэг энэ бол дахин өргөн барьж байгаа асуудал байхгүй юу нэг төсвийг.



Тийм учраас тэр Засгийн газар өргөн барих аргыг нь тэр шуурхай журмаар гэдэг юм уу\* хялбаршуулсан горимоор явдаг асуудлыг нь зохицуулж өгөөд,

Хоёрдугаарт, ер нь бид энэ өөрийнхөө байнгын хороонд чиглэл өгөх ёстой болов уу гэж бодоод байгаа юм. Төсвийн байнгын хороо тэр Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг боловсруулж оруулж ирж, тэр цаглаварт өөрчлөлт оруулах юмыг шийдэхгүйгээр бид болохгүй. Сая сайд ярьж байна лээ орон нутгуудын тэр төсвийн зарлага юмыг өөрчлөхгүй байх асуудал тогтоолд оруулаач гэж, тийм юм байхгүй шүү дээ хууль нь хүчингүй болчихсон юм чинь тэнд ямар тоо байгаа гэж бид мэдэх юм? Мэдэхгүй юм чинь.

Тийм учраас ганцхан цаглавараа л өөрчилж, Их Хурал ямар хугацаанд энэ хуулийг батална гэж бодох юм, аймаг, сумууд ямар хугацаанд төсвөө боловсруулж батална гэж бодох юм. Энийгээ харгалзаж 1 удаагийн үйлчлэлтэй журмын тухай хууль гаргахаас өөр арга байхгүй.

Тийм учраас Төсвийн байнгын хороо тэр Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг боловсруулж Их Хурлаар батлуулах ёстой.

**Д.Амарбаясгалан:** Баасандорж дарга тайлбар өгье.

**Б.Баасандорж:** Гишүүдийн саяын ярьсан санал дээр зөвлөгөө өгье.

Гишүүд ээ, одоо бол ингээд яг өнөөдөр энэ хуулиуд батлагдсанаар Ерөнхийлөгчийн хоригийн асуудал 100 хувь процесс дуусаж байгаа шүү. Одоо бол дахин тодотголын асуудал байхгүй. Зарим гишүүдээс тодотголын асуудал яриад байна. Дахиж Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг шинээр өргөн мэдүүлэх процесс явна.

Гэхдээ саяын Жавхлан гишүүн, Батжаргал гишүүний хэлж байгаа орон нутгийн төсөвтэй холбоотой асуудлыг хуулиар зохицуулах асуудал учраас энэ тогтоол дээр оруулж болохгүй хоёр гишүүн ээ. Энэ бол тогтоолын асуудал байгаа. Харин төсвөө өргөн мэдүүлэхдээ Засгийн газар хууль санаачилж байхынхаа хувьд нэн яаралтай асуудлаар, ганцхан Засгийн газарт нэн яаралтай асуудлыг оруулж ирдэг эрх нь байдаг юм шүү дээ Хууль тогтоомжийн хууль дээр.

Тэгэхээр тэр хуулийн төслөө боловсруулахдаа төсвийн тухай хуульдаа ямар өөрчлөлт оруулах юм, холбогдох ямар хуулиудад өөрчлөлт оруулах юм гэдгээ оруулж ирэх нь Жавхлан гишүүн нээлттэй Засгийн газарт нээлттэй байгаа.

**Д.Амарбаясгалан:** Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн эцсийн найруулга дээр санал хэлье.

**М.Бадамсүрэн:** Би тодорхой санал хэлээд байгаа юм л даа. Ингээд энд үүссэн энэ нөхцөл байдлыг орон нутагт аваачиж нялзааж яах гээд байгаа юм бэ л гээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ 11 сарын 19-ний өдөр Ерөнхийлөгч гэж хориг тавьсан, 11 сарын 8-ны өдөр Их Хурал баталсан. Энэ 8-наас 11-ний хооронд чинь ингээд яах вэ ёсчлох, баталгаажуулах гээд хугацаа байгаа.

Гэхдээ энэ тоо чинь орлого, зарлага, орон нутгийн төсөвтэй холбоотой тоо чинь аль эртээд аймгууддаа оччихсон байхгүй юу.

**Д.Амарбаясгалан:** Бадамсүрэн гишүүн ээ, та Бадамсүрэн гишүүн ээ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчингүй боллоо. Төсвийн тухай хууль байхгүй гэсэн үг. Тийм. Эцсийн найруулга дээр гишүүд санал хэллээ.

Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн эцсийн найруулга дээр санал хэлье.

**М.Нарантуяа-Нара:** Тэгэхээр цаг хугацаа тулсан байгаа, маш яаралтай ажиллах хэрэгцээ шаардлага Засгийн газар болоод Улсын Их Хурлын аль алинд нь үүсэж байгаа.

Гэхдээ Засгийн газар шинээр ооруулж ирэх төсөвтөө хэрвээ аливаа нэгэн тойргийн зардал ч юм уу тийм юм нэмэгдсэн зүйл байгаа бол тэрийгээ бас мэдэгдэх хэрэгтэй байх. Ялангуяа тэрийг бүүр хэлмээр байгаа юм.

Яагаад гэвэл энэ дотор төсөв нэмэгдсэн, төсөв шинээр хэлэлцэхтэй холбоотой магадгүй тойргийн асуудлууд, тойрог дээр зардал, төсөв нэмэх ийм юмнууд бас орж ирэх вий. Гагцхүү энэ хориг бол ерөнхийдөө төсвөө танах, төсвөө хэмнэх зорилгоор бий болсон хориг учраас энэ дээр нэмэлтээр зүйл оруулж ирэх гэж байгаа бол тэрийгээ заавал бас шинээр бид нарт мэдэгдэх хэрэгтэй байх гэсэн саналтай байна.

**Д.Амарбаясгалан:** Гишүүд санал хэллээ.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дараагийн асуудалд оръё.

16.02 цаг

**Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гадаадад айлчлалттай байгаа учраас өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаарх мэдээллийг Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийн цаг дээр Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна.** Индэрт урьж байна.

**С.Амарсайхан:** Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг улс орны хэмжээнд зохион байгуулж, мал аж ахуй, эрчим хүч, зам тээвэр, барилга, нийтийн аж ахуй зэрэг салбарын нэгдсэн зохицуулалтыг аймаг, нийслэл, орон нутаг, малчид, иргэд, аж ахуйн нэгжүүдийн оролцоо харилцан хамтын ажиллагааны хүрээнд зохих түвшинд ханган ажиллаж байна.

Цаг уурын байгууллагын мэдээллээр төв, зүүн аймгуудын ихэнх нутагт агаарын температур өмнөх жилүүдээс хүйтэн цас их орж, 2024-25 оны өвөл, хавар хүндэрч болзошгүй төлөвтэй байна.

Монгол Улсын Засгийн газраас өвөлжилтийн бэлтгэлийг бүх шатад эрчимжүүлэн нөөц бололцоогоо бүрэн дайчлан, орон нутаг, салбар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлж буй ажлууд үргэлжилж байна. Салбар тус бүрийн бэлтгэл ажлын явц, бодит нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд болон цаашид

авч хэрэгжүүлэх шаардлагатай ажил, асуудлуудыг тоймлон та бүхэндээ танилцуулъя. Үүнд:

1.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 2024 онд улсын хэмжээнд 14.5 сая толгой төл хүлээн авч бойжуулсан байна. Энэ өвөл нийт 189.2 мянган малчин өрхөд 60.2 сая мал өвөлжихөөс 17.7 мянган малчин өрхийн 7.3 сая мал отроор өвөлжиж, хаваржих зохицуулалт бас хийгдэж байна.

Оторлох малыг байршлаар нь авч үзвэл 36 хувь нь улсын тусгай хамгаалалтын газарт, 22 хувь нь өөрийн аймгийн бусад сумын нутагт, 14.4 хувь нь хилийн зурвас газарт, 8.7 хувь нь өөр аймагт, 16.2 хувь нь аймаг дундын отрын бүс нутагт, 1.8 хувь нь сум дундын отрын бүс нутагт өвөлжих зохион байгуулалт хийгдсэн нь өмнөх оны үеэс 0.6 сая толгойгоор буурчээ.

2024-25 онд өвөл, хаврын улирлын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 47 хувьд бэлчээр хүрэлцээтэй байгаа бол 21 хувьд 1-3 дахин, 4 орчим хувьд 3-5 дахин, 13.8 хувьд бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна. Аймгийн дүнгээр авч үзвэл Баянхонгор, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай, Завхан, Увс, Хөвсгөл аймгуудын ихэнх сум, багийн нутгаар даац олон дахин хэтэрсэн дүн гарч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 284 дүгээр тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан ган, зудын эрсдэлийн үнэлгээ хийх зааврын дагуу боловсруулсан аргачлалын дагуу холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийхэд Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Сүхбаатар, Төв зэрэг аймгийн хэмжээнд эрсдэлийн түвшин маш их, Говьсүмбэр, Өвөрхангай аймгийн хэмжээнд их буюу дунджаас дээш, улсын хэмжээнд зудын нөхцөл байдал дунд буюу түүнээс дээш түвшинд гэж үнэлэгджээ.

Газар тариалангийн салбарт 2024 онд улсын хэмжээнд 94.9 мянган га-д малын тэжээл тариалж, 246.9 мянган тонн малын тэжээлийн ургамал хураан авсан байна.

Үр тарианаас 50 мянган тонн улаан буудай, тэжээлийн буудай руу шилжиж 2024-25 онд өвөл, хавар мал аж ахуйн салбарт 289.8 мянган тонн тэжээл нийлүүлэгдэж байна. Мөн тэжээлийн импортын хэвийн буюу 2024 он гарснаар 71.2 мянган тонн орж ирснээс 6 дугаар сарын 1-ээс хойш 35.9 мянган тонн орж ирсэн нь өвөлжилтийн бэлтгэлд бас хэрэглэгдэж байна.

Улсын хэмжээнд нийт 16 сая толгой малыг хэрэгцээлэх буюу эдийн засгийн эргэлтэд оруулах судалгаа гарч зохион байгуулалтын ажил бас хийгдэж байна. Зуншлага гандуу байсан Говьсүмбэр, Дархан-Уул, Хөвсгөл, Увс, Төв зэрэг аймгуудад нийт малынхаа 30-аас дээш хувийг эдийн засгийн эргэлтэд оруулахаар төлөвлөлт зохион байгуулалт хийн бас ажиллаж байна.

Улсын хэмжээнд мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг малчдын өвс, тэжээл бэлтгэл, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэлт, ус, хашааны хүрэлцээ хангамж, малчин өрхийн бэлтгэл зэрэг үндсэн үзүүлэлтээр дүгнэхэд улсын хэмжээнд 86.7 хувьтай хангагдсан гэж дүгнэгдэж байна.

Гэвч энэ нь эрсдэлгүй бөгөөд хангалттай гэсэн асуудал биш юм. Учир нь цас, зудын нөхцөл байдал хэрхэн хүндэрч, ямар хугацаанд үргэлжлэхээс ихээхэн шалтгаалдаг нь өөрөө өвөл хүйтэн улирлын нөхцөл байдалтай шууд уялдсан асуудал.

## 2.Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд

Монгол Улсын эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөсөн хугацаанд хийж дуусгах, ажлын явцад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд гарсан хүндрэлийг шуурхай зохицуулах, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох албаныхан тасралтгүй зохион байгуулалтад орон ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар ДЦС-уудын үндсэн тоноглол болох 65 зуух, 45 труба генератор ажиллаж системийн горим ажиллагаа хэвийн байна.

2023-24 оны өвлийн их ачааллын горимын ажиллагаанд сонгино 80мвт-ын хүчин чадалтай батарей хуримтлуурыг 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдөр, Амгалан дулааны станцын 116мвт-ын хүчин чадалтай 1 зуух шинээр суурилуулах төсөл, арга хэмжээг 24 оны 3 дугаар сарын 29-ний өдөр тус тус ашиглалтад оруулсан бол 24-25 оны өвлийн их ачааллын горим ажиллагаанд Чойбалсангийн ДЦС-ыг 50мвт-аар өргөтгөх төслийн ажил 2024 оны 10 дугаар сарын 4-ний өдөр Улсын комисст ажиллаж, ашиглалтад оруулсан байдалтай байна.

Цаашид Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 150мвт-ын хүчин чадалтай эхний ээлжийн блок, Багануурын 50мвт-ын хүчин чадалтай батарей хуримтлуурыг тус тус ашиглалтад оруулахаар холбогдох зохион байгуулалтын ажлуудыг авч хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголоор эрчим хүчний салбарт шаардлагатай нийт 131 тэрбум төгрөгийн татаасыг шийдвэрлүүлсэн бөгөөд санхүүгийн дэмжлэгийг өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө, биелэлтийг бүрэн хангах, нүүрс түлшний аюулгүй нөөц бүрдүүлэх, импортын эрчим хүч худалдан авах, тарифын алдагдлыг бууруулах, бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх төлбөр, татвар, НДШ болон бусад хуримтлагдсан өр төлбөрийг үе шаттай барагдуулах, компанийн санхүү, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, үндсэн ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулахаар шийдвэрлэсэн болно.

Ингэснээр өвөлжилтийн бэлтгэл хангах, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлтэй холбоотой бэлтгэн нийлүүлэгчдэд үүссэн өр, төлбөрийг барагдуулахад 58.3 тэрбум төгрөгийг төлөвлөж зарцуулж байна.

Нүүрсний аюулгүй нөөц бүрдүүлэх, эрчим хүчний компаниудаас нүүрсний уурхайд төлөх хугацаа хэтэрсэн өр, төлбөр болон нүүрс олборлолтын бодит өртгөөс бага тогтоосон үнийн зөрүүгээс 9, 10 дугаар сард үүсэх алдагдлыг арилгахад нийт 32 тэрбум төгрөгийг төлөвлөсөн.

Импортын эрчим хүчний татвар тарифын зөрүүгээс үүсэх алдагдал, өр төлбөрийг барагдуулахад 16.5 тэрбум төгрөг, зарим компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй НДШ болон татварын өглөгийг барагдуулахад 3.9 тэрбум

төгрөг. Эрчим хүчний салбарт 2025 оноос төсвөөс татаасгүй ажиллах зорилтыг хангах бэлтгэл ажлын хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем, ТӨХК болон Алтай, Улиастайн эрчим хүчний систем, ТӨХК-удын богино хугацаат өр, төлбөрийг арилгаж дуусгаж, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэхтэй холбоотойгоор 4.5 тэрбум төгрөг, компани бүрийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад бусад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд 14 тэрбум төгрөг тус тус хуваарилагдан шийдвэрлэгдлээ.

Дээрх тушаал шийдвэрийн дагуу өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдал хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг болгон 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 27 төрийн өмчит үйлдвэр, компаниудад 125.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шилжүүлээд байна.

2024-25 оны өвлийн оргил ачаалал, урьдчилсан байдлаар өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 10 хувиар нэмэгдэж байна. Нийтдээ 1824мвт хүрэх тооцоололтой байна. Өвлийн их ачааллын горим ажиллагааны үед ДЦС-ууд ямар нэгэн бэлтгэл тоноглолгүйгээр бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгаа бөгөөд үндсэн тоноглолын болзошгүй бөгөөд гэнэтийн зогсолт, тасралт, саатлын үед тухайн нэгж тоноглолын хүчин чадлаар хэрэглэгчдийг хязгаарлах төлөв байдалтай байна.

Улсын хэмжээнд 2024 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 9 тэрбум 254.2 сая квт цаг цахилгаан эрчим хүч боловсруулж, 8 тэрбум 464.1 сая квт цаг цахилгаан эрчим хүчийг түгээсэн байна. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад боловсруулалт 5.7 хувь буюу 494.9 сая квт.ц-аар, түгээлт 6 хувь буюу 476.8 сая квт.ц-аар тус тус өссөн байна.

Эрчим хүчний салбарын үйлдвэр, компанийн хэмжээнд өнөөдрийн байдлаар өвөлжилтийн бэлтгэл хангах засвар үйлчилгээ, шинэчлэлийн ажил дунджаар 94 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь мөн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хувиар илүү байна гэж.

Тавантолгой түлш ХХК 2024-25 оны өвлийн бэлтгэл ажлын хүрээнд 93 мянган тонн шахмал түлшний нөөцийг бүрдүүлж, өнөөдрийн байдлаар нийслэлийн 7 дүүргийн 38 агуулахад болон үйлдвэрлэлийн нөөцийн талбайд 82 мянган тонн шахмал түлшний нөөцтэй, үндсэн түүхий эд болох нийтлэг нь 198.2 мянган тонн, барьцалдуулагч 9.4 мянган тонн, шуудай 20 сая ширхэг нөөцтэй үйлдвэрлэл хэвийн явагдаж байна гэсэн мэдээлэл байна.

Шахмал түлшний үйлдвэрлэлд 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 1945 ажилтан ажиллаж байна. 376.9 мянган тонн шахмал түлш өнөөдрийн байдлаар энэ онд үйлдвэрлэжээ.

Салбарын хэмжээнд хөрөнгө оруулалт, их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээнд 2024 онд нийт 62 ажил төлөвлөснөөс бүрэн дууссан 57 ажил, хэрэгжих шатад байгаа 5 ажил, дунджаар 97.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд.

Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 2024/02 дугаартай орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай албан даалгаврын хүрээнд 44821 ажилд 40.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Салбарын өвөлжилтийн бэлтгэл 93.3 хувийн биелэлттэй байна. Орон нутгийн орон сууц нийтийн аж ахуйн 34 байгууллага, өвөлжилтийн бэлтгэл ажилд 24 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар 19.6 тэрбум төгрөг зарцуулан төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна.

Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн 66 байгууллага байгаагаас 4 орон нутгийн өмчит, хувийн орон сууцын ашиглалтын 62 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

2024 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар 22.7 тэрбум төгрөг зарцуулан 43638 нэр төрлийн ажилд биелэлт хангагдсан. Улаанбаатар хотын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт 96 хувьтай байна гэсэн дүгнэлттэй байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дахь цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл таныг индэрт урьж байна.

**О.Цогтгэрэл:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлж, уул уурхайн бус салбарын хөгжилд анхаарч, өрөөсөн хөлөөс өрсөлдөх чадвараа тэмүүлэхээр Алсын хараа-2050, Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд бас тусгасан.

Үүний томоохон хэсгийг хөдөө аж ахуй болон эрчим хүчний салбарын зорилтууд эзэлж байгаа. Бид уламжлалт ахуй урд, хойд хөршийн нөхцөл байдлыг тооцож үзэхэд эдийн засгийг төрөлжүүлж чадах стратегийн ач холбогдолтой салбар яах аргагүй хөдөө аж ахуй, эрчим хүчний салбар мөн.

Гэвч Монгол Улсын Ерөнхий сайдын Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хийсэн уг мэдээлэлд эдгээр салбарын бодлого, зорилтот хөтөлбөрийн хүрээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрсдэл багатай даван туулах урт хугацааны бодлого хөтөлбөрийн талаар мэдээлэл тусгагдаагүй байгаа нь тун харамсалтай.

Энэ мэдээлэл, тайлан нь бүхэлдээ аймаг, сумын Засаг даргын хэмжээний ажил статистикийн байгууллагуудын тоон үзүүлэлт, салбарын яамны хэлтэс, газрын мэргэжилтний улирлын тайлан төдий 1 удаагийн гал намжаах агуулгатай байгаа нь тун хангалтгүй гэж Ардчилсан намын бүлгийн зүгээс үзэж байна.

Өмнөх жилүүдийн уг салбарын мэдээллийн адил газар тариаланд гарах дэвшил, усалгаатай талбайн хэмжээ, нэгж талбайгаас авах ургацын хэмжээ, малын тэжээл, тариалан, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар малын чанарыг дээшлүүлж, нэгж малаас авах ашиг шимийг өсгөн хөдөө аж ахуйн салбарын

өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, дотоодын нийт валют бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг дээшлүүлэх, эрчим хүчний үнэ чөлөөлөлт либералчлал, эх үүсвэрийн тэлэлт, сүлжээний бодлого зэрэг бодлогын томоохон ажлууд хийгдээгүй, ахиц гараагүй нь байгаа нь мэдээллээс бас харагдаж, 2 жилийн өмнө бид бид бүлгийн дүгнэлтээрээ жинхэнэ зуд малчны хотонд биш Хөдөө аж ахуйн яаманд байна. Жинхэнэ ган тариан талбайд биш Засгийн газрын хөдөөгийн хөгжлийн бодлогод байна гэж дүгнэлт бас танилцуулж байж. Бүтэн 2 жил өнгөрөхөд яг л бахь байдгаараа хүнээ мартаж, мал, буудайг чухалчилсан алдаатай бодлогоо хэрэгжүүлж, татаас, урамшууллын ана л нэг амь зогоосоор байна.

Ардчилсан намын байр суурь, экспортын зорилго, амбицын талаар олон бүтээлч шийдлүүд дийг бид бас санал болгодог. Аль ч салбарт бодлогод суусангүй, ажил хэрэг болж чадсангүй ээ. Улам бүүр өтгөрч буй хотын утаа шиг хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан, эрчим хүчний салбарын асуудлууд улам бүүр ужгирсаар байна. Өвөлжилтийн бэлтгэл нэрийн доор малчид, аймаг, сумд болон улсын өвс тэжээлийн нөөцөд бэлтгэсэн нийт тоо хэмжээг дурдаж байгаа хэдий ч бэлтгэхээр тавьсан тоо хэмжээ нь өвлийг давах хэмжээнд хүрэлцэхүйц байхаар биш. Зөвхөн мал хөлдөж хорогдохын өмнө үргүй зардал нэмж гарах хэмжээнд байгаа нь бүхэл бүтэн улсын Засгийн газрын мэдээлэл, салбарын яамны үйл ажиллагааны тооцоолол гэхэд харамсалтай.

Засгийн газраас бэлтгэхээр тогтоолоор заасан болон өнөөдрийн байдлаар бэлтгэсэн өвс, тэжээлийн хэмжээнд манай улсын нийт малд шаардлагатай хоногийн өвс тэжээлийн хагас өдрийн ч хэрэгцээг хангахааргүй хэмжээний тоо тавиад өвөл, хаврын бэлтгэл хангагдсан гэж ярих нь нэн хариуцлагагүй асуудал. Социалист маягийн ийм төлөвлөгөө, тоо нэгтгэдэг ажлаа орхиж, бодлого зохицуулалтын ажил руугаа орохыг ахин бас сануулъя.

Хөдөө аж ахуйн яам гэдэг бас трактор, техник, үрийн буудай худалдаа хийдэг арилжааны яам биш, бодлого гаргадаг, инновац руу хөтөлдөг, зохицуулалт хийдэг ийм газар.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны хавар Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн өмнө төсвийн мөнгө зарлагадан төрийн албан хаагчдыг дайчлан байж, татаас дэмжлэгтэй хямд эх үүсвэрээр малчдын хоршоодод олгосон шинэ хоршоо хөтөлбөрийн үр дүн, олгосон зээл, зээл авсан малчид хоршооны талаар мэдээлэл огт дурдагдаагүй байгаа нь уг хөтөлбөрөөс үр дүн гарсангүй гэж үзсэнийх үү гэж эргэлзэхэд хүрч байна.

Уг хөтөлбөр хэрэгжсэн олон аймагт зуншлага тааруу байснаас өвлийг өнтэй давахгүй нөхцөл байдал өссөн тул аймгуудын нийт малын 30-аас дээш хувийг нядлах байдлаар хохирлыг бууруулахаар Засгийн газрын хэмжээнд яригдаж байгаа нь мал аж ахуйн салбарт ямар ч бодлого, үр дүн байхгүй байгааг шууд бас илтгэж илтгэн харуулж байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль 2011 онд батлагдаж, Хөдөө аж ахуйн бирж 2013 онд байгуулагдсанаас хойш 10 гаруй жилийн хугацаанд уг салбарт нэмүү өртгийн дотоодын сүлжээ, худалдаа ложистикийн тогтолцоо үүсэж бэхжээгүй, биржээр дамжих худалдаа өсөн нэмэгдээгүй нэр төдий байгаа нь 2024 онд хөдөө аж ахуйн биржээр 1 сумын, 1

багийн хэмжээний малчдын мал нэгхэн мах боловсруулах үйлдвэрийн бэлтгэх хэмжээний махны худалдаа хийгдсэн байгаагаас бас харагдаж байна.

Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй Хүнсний хувьсгалын талаар ч дурдаагүй байгаа нь төрийн байгууллагууд, институт хоорондын уялдаа ямар байгааг бас эргэлзэхэд хүргэж байгааг мөн дуулгая.

2024-25 оны өвлийн оргил ачаалалд цахилгаан эрчим хүчний хэрэглээ 1824мвт-д хүрэх бөгөөд цахилгаан эрчим хүчний доголдолд орж ноцтой эрсдэл үүсэхээр байгаа тухай мэдээлэлд дурджээ. Энэ бол орон нутгийн сонгуулийн өмнө тууз хэвлэлээр илээр болон нээлттэй хийсэн зарим цахилгаан станцад гарсан үл тохирол, ослын завсарлахгүй бол 21 дүгээр зуунд хотоороо лаа барьж, идэр 9 эсийн хүйтнийг давна гэсэн үг ээ. Юу нь сансрын хиймэл дагуул вэ?

Эрчим хүчний салбарын реформ гэх сүржин нэртэй даржин ажиллагаа мухардчих уу? Монопол салбарт хүн чөлөөлөх нэрээр жижиглэнгийн үнийг нэмж, нийлүүлэх зарим станцдаа хэт өндөр үнэ, хэтэрхий урт хугацааны гэрээг байгуулж байгаа нь уг салбарыг улам бүр чөтгөрийн тойруул тойрогт оруулж байгааг Ардчилсан намын бүлгийн зүгээс бид бас удаа дараа сануулдаг.

Уг салбарыг либералчилж, хаана нь хувийн хэвшлийг оруулж, төр юугаар нь дэмжин туслахаа ил тодоор тунхагласан бодлогын баримт бичгээ нэн даруй Улсын Их Хуралд танилцуулах замаар гадна, дотнын хөрөнгө оруулагчдад ил тод болох учиртайг бас сануулъя.

Засгийн газраас жил бүр давтагддаг асуудлыг нь эх үүсвэр, шалтгааныг арилгахад анхаарах бус өвлийг л давчихвал гэдэг ийм хандлагаар аргацаасан байдлаар хандаж ирсэн нь хөдөө аж ахуйн бодлогын цаана эрчим хүчний салбарыг ийм эрсдэлийн хэмжээнд хүргэж, асуудлыг улам хуримтлуулаад байна.

Иймд хууль тогтоогчдыг болон ард иргэддээ салбартаа буг болсон дарга нарын статистик тоогоор хуурах бус, бодит нөхцөлд үнэлгээ хийж, хавтсанд шургуулж, тоосонд дарагдан хэвтэх урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилттэй жил жилээр ханган ахиулж, ахиц дэвшил гарган ажиллахыг бас шаардаж байна. Эдгээр салбаруудын талаар 2 жилийн өмнө Ардчилсан намын бүлгийн өгсөн санал, дүгнэлтүүдийг эргүүлэн харж бид бас энэ үгийг хэлэхээс өөр аргагүй болж байна.

Монгол Улсын хөдөлмөрийн насны нийт хүн амын дөрөвний нэгийг эзлэх малчдадаа анхаарах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх, зудын гамшиг, эрсдэлийн хэмжээнд тохиолдох үед хүнээ бодсон авах арга хэмжээний төлөвлөгөөг бэлтгэн ажиллах бас шаардлагатай байна. Уул уурхайн бус салбарын хөгжилд 200 орчим мянган малчин өрхөд аж амьдралаа залгуулан буй 300 орчим мянган малчдын аж амьдралын эх үүсвэр болох мал аж ахуйн салбарын бодлогод анхаарал хандуулж олон сая мал, олон 100 мянган ажиллах хүч өргөн уудам бэлчээрийн давуу талдаа тулгуурласан бэлчээрийн мал аж ахуйд сэргэлт хийх замаар эдийн засгийн өсөлт хийх, экспортын боломжийг эрэлхийлэхэд нүдээ нээж, бодлогоо чиглүүлэн ажиллахыг бас сануулъя.

Эрх баригчид хэт олуулаа засагласан олон жилийн эцэст эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарт эдийн засгийг төрөлжүүлэх, та биднийг балчиг намгаас суга



татах учиртай тэргүүлэх салбарууд гэж үздэгээ Ардчилсан намын бүлэг ахин бас тодотгож байна.

Засгийн газарт хүч биш ончтой бодлого юу юунаас илүүтэй дутагдаж буйг ахин бас сануулъя.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэллээ.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Агваанлуvsсангийн Ундраа таныг индэрт урьж байна.

**А.Ундраа:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

2024-25 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаарх Ерөнхий сайдын мэдээллийг сонсож дараах байр суурийг илэрхийлж байна.

Ерөнхий сайдын мэдээллээс харахад улсын хэмжээнд хөдөө аж ахуйн салбар 86.7, эрчим хүчний салбар 94, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагууд 93 хувийн гүйцэтгэлтэйгээр өвөлжилтийн бэлтгэлийг тус тус хангаснаар улсын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажил дунджаар 91.2 хувийн гүйцэтгэлтэй байна гэж дүгнэж болохоор байна. Гэвч энэхүү тоон үзүүлэлт эргэлзээ төрүүлж байна.

Учир нь хөдөө аж ахуйн салбар, эрчим хүчний салбар, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлаар 24-25 оны өвөлжилт, хаваржилтыг ерөнхийд нь дүгнэсэн, хэт ерөнхий дүгнэсэн нь учир дутагдалтай байна.

Өөрөөр хэлбэл, материаллаг талаас нь илүү дурдаж, улмаар хүн ардын, хүүхдүүдийн, эмэгтэйчүүдийн малчин өрхүүдийн, иргэдийн эрүүл мэндийн болон сэтгэл санааны учирч болзошгүй хохирол, амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх түүнийг даван туулах арга хэмжээний талаар салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хэрхэн хийгдэх талаар дурдсангүй.

Тухайлбал, нэгдүгээрт цаг агаарын хүндрэлтэй үед нийтийн тээврийн хүртээмж, авто замын аюулгүй байдлыг хэрхэн хангах, зорчих хөдөлгөөн саадгүй байх, аврах болон тусламжийн үйл явцын төлөвлөгөө зэрэг бэлтгэл ажлын талаар дурдаагүй байна. Нэг жишээ дурдахад улсын хэмжээнд хадлан бэлтгэх ажилд нийт дугуйт 4280 трактор ажилласан гэх хэдий ч үүнийг 330 сумд хувааж тооцвол 1 сумд ойролцоогоор 10 гаруй трактор оногдож байна.

Гэтэл өнгөрсөн өвлийн зуд нар олон сумд малын бэлчээр зам гаргах трактор байхгүй гэж иргэд олноор гомдол гаргасан тохиолдол бүртгэгджээ. Үүний улмаас дээрх хөдөө аж ахуйн салбарын тоо баримтад эргэлзэж байна. Хянан баталгаажуулах шаардлагатай гэж үзэж байна.

Хоёрдугаарт, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг дурдахдаа иргэд рүүгээ чиглэсэн бэлтгэл ажлын талаар дутмаг байна. Ялангуяа малчид,

малчдын хүүхдүүдэд цаг агаарын эрс хүйтрэлийн нөлөө нь урт хугацаанд үргэлжилдэг, малаа алдсан малчид сэтгэлээр унах, стрессээс үүдэлтэй сэтгэл зүйн гэмтлүүд илрэх, мөн хүүхдүүдийн хувьд сургууль, цэцэрлэгээсээ завсардах, хоол тэжээлийн хомсдолд орох, тээвэрлэлтийн хүрэлцээгүйн улмаас шим тэжээлийн дутагдал, эрүүл ахуйн асуудал, эх, нярайн эндэгдэл зэрэг эрүүл мэнд, боловсролын шинэ, нэн шаардлагатай үйлчилгээг тэд авч чадахгүйд хүрдэг. Байгалийн давтагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах, эдгээр эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх бэлтгэл ажлын явцын талаар мөн дур тодорхой дурдсангүй.

Иймд хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг 86.7 хувь гэж үнэлж байгаа нь эргэлзээ төрүүлж буй юм.

Гуравдугаарт, утаа хийгээд, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл байсангүй.

2023 онд улсын хэмжээнд угаарын хийн хордлогын улмаас 3000 гаруй хүн эмнэлгийн тусламж авч, 61 хүн нас барсан. 2024 оны эхний 4 сарын байдлаар 1000 орчим хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авч, 20 хүн нас барсан тоон мэдээ байна. Энэ бол “i Toim”-ын эх сурвалжаас харахад.

Эх нярайн эндэгдлийн хувьд 2023 онд 63915 эх амаржсанаас төрөлхийн гажигтай төрсөн 456, 2500гр-аас доош жинтэй төрсөн 4804, амьгүй төрсөн ураг 344 байна гэх мэдээ сэтгэл түгшээж байна.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс агаарын бохирдлын хөрөнгө оруулалтын жишиг судалгааны дүнгээс үзэхэд Монгол Улсад жил бүр гадаад орчны агаарын бохирдлын нөлөөгөөр, Монгол Улс нийт гадаад орчны агаарын бохирдлын нөлөөгөөр 2839, дотоод орчны агаарын бохирдлын нөлөөгөөр 4300 хүн нас барсан гэсэн мэдээ байна. Мөн гадаад орчны бохирдлоос үүдэлтэй цаг бус эндэгдэл 881 тэрбум төгрөг, дотоод орчны агаарын бохирдлоос үүдэлтэй цаг бус эндэгдэл 3.5 их наяд төгрөгөөр хэмжигдэх эдийн засгийн алдагдал хүргэж байгаа зэргийг анхаарч үзэх нь зүйтэй.

Дөрөвдүгээрт, зам тээврийн халтиргаа гулгааны улмаас сэргийлэх бэлтгэл хэрхэн хангагдсан, эдгээрийн улмаас эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн бэлтгэл ажлын талаар тодорхой мэдээлэл дурдагдаагүй байна.

Жишээлбэл, 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 20-ны өдрийн хооронд Гэмтэл согогийн үндэсний төвд халтиргаа гулгаанаас үүдэлтэй бэртэл авсан 665 хүн үйлчлүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан ба түүнчлэн осголт, хөлдөлтийн 67 тохиолдол бүртгэгдсэн байна

Тавдугаарт, өвлийн хүйтэнд гадаа ажилладаг тохижилт үйлчилгээний ажилтнууд болон онцгой байдлын ажилтнууд, цагдаа, цэрэг хүчин, эрүүл мэндийн шуурхай байгууллагын албан хаагчдын аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн хүртээмж хэрхэн хангагдсан, үндсэн ажлаа явуулах нөхцөл бүрэн хангагдсан эсэх нь тодорхойгүй байна.

Цаашлаад онцгой үед ажиллах мэдээлэл шуурхай дамжуулах зохион байгуулалт, техник технологийн бэлэн байдал хангагдсан эсэхийг тодруулах шаардлагатай байна.

Зургаадугаарт, түлээ, нүүрс, түлш, шатахууны бэлтгэл ажил хэрхэн хангагдсан талаар дэлгэрэнгүй дурдах хэрэгтэй байна. Улаанбаатар хотын гэр хорооллын 200 мянга орчим өрх сайжруулсан шахмал түлшээр халаалтаа шийддэг. 1 өрх ойролцоогоор 2.8 тонн шахмал түлшээр өвлийг давдаг. Монгол Улс 2024 оны байдлаар 1 жилд ойролцоогоор 2 сая тонн шатахуун хэрэглэдэг зэрэг статистик байна. Иймд түлш шатахуунаар тасралтгүй хангах бэлтгэл ажил бүрэн хангагдсан эсэх нь эргэлзээтэй.

Долоодугаарт, мөн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн дутагдал үүсэх үед хөнгөлөлт болон хязгаарлалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч байгааг дурджээ. Бодит байдлаас харахад цахилгааны хязгаарлалтын мэдээлэл түүний төлөвлөгөөг эрд иргэдэд урьдчилан хангалттай мэдээлдэггүй, мэдээлсэн ч төлөвлөгөөнийхөө дагуу байдаггүй зэрэг нь олон нийтийг бухимдуулах олон тохиолдол гарч байсныг дурдах нь зүйтэй.

Наймдугаарт, цаг агаарын цочир хүйтрэл, зудын эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, түүнийг хэрхэн даван туулах талаар төлөвлөгөө нь шинжлэх ухаанч бус байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангахдаа холбогдох ямар мэргэжлийн байгууллага, олон улсын ямар ямар байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг тусгасан талаар дурдаагүй, мөн шинжлэх ухааны үндэслэлтэй бус, бодлогын шийдэл болохуйц бус дутмаг төлөвлөгөө байна гэж дүгнэхэд хүрч байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Одоо Улсын Их Хурлын гишүүн Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үг хэлнэ. Таныг индэрт урьж байна.

**М.Нарантуяа-Нара:** Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.2-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж буй 2024-2025 оны өвөлжилт, хавар хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаарх Ерөнхий сайдын мэдээлэлд сөрөг хүчний хувьд Иргэний зориг ногоон намууд төлөөлөн байр сууриа илэрхийлье.

2024-2025 оны өвөлжилт, хаваржилтыг үнэтэй давах нь Улсын Их Хурал, Засгийн газрын, Засгийн газар макро, микро эдийн засгийн шокоос урьдчилан сэргийлж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хөдөө аж ахуй, эрчим хүч, хот суурин газрын орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг ханган өвөл хаврын улирлын эрсдэлтэй нөхцөл байдлыг даван туулах талаар бодлогын оновчтой шийдэл гаргаж богино хугацааны зөв менежменттэйгээр ажиллахаас их зүйл хамаарна гэж Иргэний зориг ногоон нам үзэж байна.

Аливаа ажил асуудалд бүх цаг үеийн бэлтгэлийг бодолцож ажиллах нь тухайн цаг үеийн шийдлийг агуулж байдаг. Иймээс өвөлжилт, хаваржилтын бэлтгэл цаашлаад хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарын талаар төрөөс баримталбал зохих бодлогод Иргэний зориг ногоон нам дараах 3 саналыг дэвшүүлж байна.

1.Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын талаар.

Хөдөө аж ахуй гэдэг мал амьтан өсгөн үржүүлэхээс гадна тэдгээрээс авч болох түүхий эдийг боловсруулах, мөн хүнс тэжээл, цардуул үйлдвэрлэх бүхий л үйл ажиллагааг хамруулан ойлгодог билээ. Тухайлбал, энэ салбарыг нийгэм, эдийн засгийн агуулгаар нь харвал Монгол Улсын ДНБ-ий 20.6 хувь бөгөөд ажиллах хүчний 42 хувийг эзэлдэг.

Тиймээс уг асуудлыг, мөн шийдлийг зөвхөн зуншлага, бэлчээрийн даац, хадлан тэжээлийн бэлтгэл зэрэг талаар мэдээлж ярихаас гадна ДНБ-д эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх ажиллах хүчний баталгаат ажлын байр бий болгох талаар бодлого боловсруулж энэ салбарын эрсдэл, менежментийг сайжруулах, ашигт ажиллагааг дээшлүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн үр нөлөө, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч бүх цаг үеийн бэлтгэл ажил болгож, бодлого болгож, судлах мөн зорилго болгох, хэлэлцэх, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж Иргэний зориг ногоон гам үзэж байна.

Хоёрдугаар асуудал. Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар.

Эрчим хүчний салбар бол улс орны тулгуур хөгжлийн хөгжлийн тулгуур түрүүлж хөгжих шаардлагатай суурь салбар байдаг билээ. Ерөнхий сайдын мэдээллээс үзэхэд манай улс 2024 оны эхний 10 дугаар сарын байдлаар нийт хэрэглээний 75.6 хувь цахилгаан эрчим хүчийг дотоодын эх үүсвэрээс, 24.4 хувь цахилгаан эрчим хүчийг импортоор хангасан юм байна.

Энэ өвөл 2024-2025 оны өвлийн оргил ачаалалд урьдчилсан байдлаар өмнөх оны үеийн гүйцэтгэлээс 12 хувиар нэмэгдэх тооцоололтой. Мөн эх үүсвэрийн хүчин чадлын дутагдал үүсэх үед хөнгөлөлт, хязгаарлалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм байна.

Хязгаарлалтын хөтөлбөрийг Улаанбаатар хотод 11 орон нутагт 3 нийт 14 багцад хуваан хэрэгжүүлэхээр төлөвлөж эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж байна. Гэвч өнөөдөр 2024 онд бид тог цахилгааны асуудлаа бүрэн шийдвэрлэж чадаагүй. Тог цахилгаанаар тасалдуулдаг эрс тэс уур амьсгалтай манай улсын хувьд хэзээ мөдгүй тог цахилгаангүй болох эрсдэлтэй өвөлжихөөр байгаа нь мөн өмнөх өмнөх жилүүдэд ч гэсэн ийм байсаар ирсэн нь бас эмгэнэлтэй зүйл билээ.

Цахилгаан дулааны эрчим хүчний хэрэглээ жилээс жилд тогтмол өсөж байгаа, цаашид ч өссөөр байх болохыг, мөн түүнчлэн эрчим хүчний асуудал зөвхөн өвөл бий болдог цаг үеийн шинжтэй асуудал биш болохыг бид бүхэн маш сайн мэдэж байгаа.

Иймд богино хугацаандаа олборлодог эрчим хүчнээс цэвэр ногоон сэргээгдэх эрчим хүч рүү шилжих нь дээрх хүндрэлээс гарах зам гэж манай нам үзэж байна. Иймд дэлхийн улс орнууд ч гэсэн эрчим хүч гаргаж авдаг түүхий эд, эх үүсвэрийнхээ тоог нэмэгдүүлэхэд анхаарч, нар, салхины эрчим хүчний үйлдвэрлэлээ нэмэгдүүлж байгаа билээ.

Тиймээс бид энэ салбарт шинэчлэлийг яаралтай анхааралтай хийх шаардлагатай. Гэвч энэ шинэчлэлийг монопол нөхцөлд хийж болохгүй бөгөөд харин эхлээд энэ тогтоодог тусгай зөвшөөрлийг цуцлах хэрэгтэй, чөлөөт өрсөлдөөнийг бий болгох хэрэгтэй. Хийж чаддаг нь хийгээд, бүтээгээд, оролцоод явах энэ нөхцөл боломжоор хангах хэрэгтэй гэж бид үзэж байна.

Дараа нь шинэчлэлээ шинэчлэл хийх замаар явбал бид хэрэглэгчээ ч бодсон, үнийн өсөлтөө ч бодсон энэ хамгийн оновчтой бэлтгэл ажил байна гэж бодож байна. Өөрөөр хэлбэл, эрчим хүч бол цэвэр хувийн хөрөнгө оруулалтаар хөгжиж явах боломжтой зүйл бөгөөд зах зээлийн харилцаанд бүрэн шилжих юм бол төр оролцоо багатайгаар хөгжих боломжтой салбар юм. Энэ тухай бас маш олон шинжилгээ, судалгаанууд ч гэсэн гарсан байгаа.

Цаашлаад дунд, урт хугацаандаа Монгол Улс эрчим хүч экспортлогч орон болох зорилгоор сэргээгдэх эрчим хүчний мега төслийг эхлүүлж байгалийн сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашигласан цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, цаашид экспортлох боломжийг бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллах нь өвөлжилтийн бас чухал ажил бэлтгэл болно гэж үзэж байна.

Гуравдугаарт, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар.

Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн 66 нийт байгууллага байгаагаас орон нутгийн өмчит 4, хувийн орон сууцын ашиглалтын 62 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Өвөлжилтийн бэлтгэл ажилд 28.9 тэрбум төгрөгийг санхүүжилт төсөөлснөөс 22.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улаанбаатар хотын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг ажлын төлөвлөгөөний биелэлт 96 хувьтай байна гэж мэдээлсэн байна. Гэвч энэ их мөнгө том дүн ч гэлээ өнөөдөр Улаанбаатар хотын өвөлжилт бодит байдалд зөв дүгнэлт, үнэлгээ өгч ажиллах шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл, өвөлжилтийн бэлтгэл ажилд зайлшгүй байх анхаарах асуудлууд байна. Иймд 4 асуудлуудыг бид бүхэн дэвшүүлж байна.

Утааны асуудлын хувьд шахмал түлшний түлшний бодит хор хөнөөлийг тогтоох, чанар стандартыг нягтлах, бодит байдалд зөв үнэлэлт, дүгнэлт дүгнэлт өгөх хэрэгцээ цаг нь болсон байна.

Мөн 2 дугаарт, цаг агаарын аюултай үзэгдлийн үед хүн ам, эд хөрөнгийн эрсдэлээс хамгаалах учирсан хохирлыг цаг алдалгүй түргэн шуурхай үнэлэх, хариу арга хэмжээ авах төлөвлөлт, бэлтгэлд урьдчилан онцгойрч анхаарч ажилламаар байна.

Гуравдугаарт, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлөөс шалтгаалж зам даваа хаагдах, халтиргаа гулгаа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, автомашин, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах ажил бас чухал байна.

Дөрөвдүгээрт, халтиргаа гулгаа, цас мөсний асуудалтай шинэчлэлт, шийдэл хийсэн байгаа юу, давс бодисын нөөц хэр байгаа вэ? Түүнийгээ цацах техник хэрэгсэл гээд хүрэлцээ хангагдсан эсэх талаар бид бүхэн бас анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Энэ мэтчилэн хот тойрсон жил бүрийн өвөл тулгардаг олон олон асуудал, шийдэл, бэлтгэлийг нарийн бэлтгэх, одоо цаг нь болсон. Эдгээрийн бэлтгэл болон нийт өвлийн бэлтгэл бүрэн хангагдсан уу гэх мэт асуудалд бодитоор хандаж бэлтгэх цаг болсон. Эдгээр асуудал нь зөвхөн хотын асуудал биш бөгөөд Монгол Улсын хүн амын тал хувь нь амьдарч байгаа нийслэлийн өвөлжилтийн асуудалд бас мөн анхаарах хэрэгтэй байна.

Энэ бүгдийг төр засгаас анхаарч оновчтой бодлого хэрэгжүүлэх ёстой гэж бид бүхэн үзэж байна. Тийм учраас Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ та 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажилдаа сөрөг хүчин болох Иргэний зориг ногоон намын байр суурийг хүлээн авч ажиллахыг хүсэж байна.

**Х.Булгантуяа:** Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүндээ баярлалаа.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу Ерөнхий сайдын мэдээлэл хийж, цөөнхийн төлөөлөл үг хэлэхээр байгаа. Цөөнхийн төлөөлөл тус бүр мэдээллийн дагуу асуулт асууж, үг хэлэх хугацаа бол 3 минутаас хэтрэхгүй, хариулт өгөх хугацаа 5 минутаас хэтрэхгүй байгаа.

Энд цөөнхийн төлөөлөл 6, 8, 12 хүн байна. Манай эндээс олонхын төлөөллөөс бас 10 гаруй хүмүүс бас байх шиг байна. Би та бүхэнд ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Амарсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр. Шадар сайдаа Энхбаяр сайд хааччихав? Энэ чинь мэдээллийн бараг 50, 60 хувь нь хөдөө аж ахуйн чиглэлээр мэдээлэл хийлээ. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Батсуурь? Батсуурь сайд бас байхгүй байна. Зам, тээврийн сайд Дэлгэрсайхан, Эрчим хүчний сайд Чойжилсүрэн, эрчим хүчний асуудал сая цөөнхийн мэдээллээс нэлээдгүй олон гишүүдээс бас хэллээ. Тэгэхээр Эрчим хүчний сайд баймаар байна. Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан? Мөнхсайхан сайд байхгүй байна. Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, хоёр Төрийн нарийн бичгийн дарга ирсэн байна уу? Байхгүй байна шүү дээ. Одоо тэгэхээр энэ салбарын яамнуудаас чинь асуулт асуугаад хэн хариулах вэ? Улсын онцгой комисс бүгдээрэнг нь хариулах юм уу? Онцгой байдлынхаа бүх асуултад хариулж чадахгүй байлгүй дээ. Бэгзсүрэнгийн Мөнх-Оргил Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Түвшинсайханы Баярхүү Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа, Цогтбаатарын Ганзориг Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хурандаа, Ёндонгийн Азжаргал Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны ажлын албаны дарга, Отгоны Мөнхбаяр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуй, бодлого зохицуулалтын

газрын дарга, Мандширийн Энхболд Зам, тээврийн яамны салбарын хяналтын газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жанцандоржийн Цогтбаатар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Малын генетик нөөцийн хэлтсийн дарга, Батмөнхийн Насантогтох Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Пүрэвийн Оюунцэцэг Бодлого төлөвлөлтийн ямар яамныхан эрчим хүчнийхэн болов уу? Бодлого төлөвлөлтийн газрын дарга. Ичинхорлоогийн Лувсанцэрэн Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Аюушжавын Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Түмэндалайн Даваадалай Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Засан даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Моломжамцын Балдандорж Улаанбаатар хотын захирагчийн албаны Хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга, Даваасамбуугийн Мөнхбаатар Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын дарга, Пүрэвдоржийн Эрхэмбулган Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга. Эрхэмбулган дарга ирээгүй байна тээ? Чимэдийн Буянжаргал Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын Сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн дарга, Буянжаргал дарга ирсэн үү? Төрбатын Мөнхболд Улаанбаатар ЦТС ТӨК-ийн ерөнхий инженер, Аварзэдийн Батзориг “Тавантолгой түлш” компанийн Санхүү, эдийн засгийн газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна. Сайд нар, Төрийн нарийн бичгийн дарга нар ирээгүй шүү Шадар сайдаа.

Хийсэн мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж үг хэлэх цөөнхийн т төлөөллийн нэрсийг авъя

Ээнэ Жаргалсайхан гишүүнээр тасалъя. Мэдээлэлд үг хэлэхээр ХҮН намаас нэр өгөөгүй байгаа юм байна шүү. Золжаргал гишүүнийх орсон байна. Сая цөөнхийн бүх намуудаас мэдээлэл хийхэд ХҮН намаас мэдээлэл хийхээр нэрээ өгөөгүй шүү. Ганбаатар гишүүнийхийг Г. Ганбаатар гишүүнийхийг сая 2 дараад гарчихлаа гэж байна. Ганбаатар гишүүнийхийг нэмээд оруулчихаарай. Тэгвэл Ганбаатар гишүүнээр тасалъя.

Хамгийн сүүлд ирцээрээ гэхээр Жаргалсайхан гишүүнийх хамгийн сүүлд байна шүү. Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан.

**Л.Мөнхбаясгалан:** Намайг жоохон байхад л ийм мэдээлэл радиогоор явдаг байсан. Тэдэн трактор, тэдэн өвс бэлдлээ, тийм ургац хураалт хийлээ гэсэн тэр уламжлал ёсоороо дахиад орж ирлээ. Хөдөөгүүр ялангуяа уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа малчдын асуудал үнэхээр хүнд байгаа. Жишээ нь, амьдарч байсан, хэдэн үе дамжиж амьдарч байсан газар нь гэнэтхэн лиценз хэлбэрээр олгогдчихсон байдаг. Тэндээсээ нүүх болдог, нөлөөллийн бус та нүү гэдэг, нөхөн олговор нь болохоор өвөлжөө, хаваржааны мөнгө л өгдөг. Бэлчээрийг нь яах юм малчдынхаа? Бэлчээрийн нөхөн олговор гэж ойлголт байгаа юу? Малчин хүний бизнес бол мал нь. Тэр малыг бэлчээрт тариулдаг. Гэтэл өнөөдөр хүнийг зүгээр амбаар пингийнх нь мөнгийг өгөөд хөөж нүүлгээд байгаа юм, шилжүүлж суурьшуулаад байгаа юм.

Гэтэл тэр малчинд бизнесээ хийх боломж, бэлчээрийн нөхөн олговор байдаггүй. Энэ тал дээр ямар бодлого боловсруулж ажиллаж байгаа вэ?

Зуд өнгөрсөн жил болсон, Шинэ хөдөө бодлого гаргасан. Малчдын зээлийг тэглэнэ л гээд яриад байдаг. Зуд тэртээ тэргүй байнга л болдог, цаашдаа ч болно. Зудаас яаж гаргах вэ гэхээр малчдыг орлоготой болгох байхгүй юу. Өнөөдөр малчид амьдрах орчингүй болоод, малаа бэлчээх газаргүй болоод хот суурин барааддаг тэгээд шууд ажилгүйчүүдийн тоо ядуурлын тоог нэмдэг. Монгол Ардын намын зүгээс малчид руу чиглэсэн Шинэ хөдөө мундаг бодлого явууллаа. Бид нар Цагаан алт хөтөлбөр эд нар гээд л яриад байдаг. Гэтэл саяхан авсан тоогоор 30 гаруй малчин өрхийн хүүхдүүдээс ямар мэргэжилтэй болох вэ гэж асуухад бүгд хот руу орж их, дээд сургуульд орно гэж байгаа юм. Нөгөө уламжлалт малчин гэдэг чинь байхгүй болж байгаа байхгүй юу. Хэрвээ энэ бодлого чинь нүдээ олоод, яг цагаа олоод малчдадаа очиж байгаа юм бол яагаад малчин удам тасрах гээд байгаа юм? Яагаад малчид ядуурлаас гарч чадахгүй байгаа юм бэ? Энэ дээр ямар бодлого боловсруулж байгаа вэ?

Дээрээс нь эрчимжсэн мал аж ахуй гэж бид нар ярьдаг тийм үү? Бид нар өнөөдөр малаа олон болгохоор л мянгат малчин гэдгээр шагнадаг. Тэрний ач тус гэж юу ч байдаггүй. Тэрэнд орвол цөөн тооны чанартай мал байх ёстой, малынхаа ашиг шимийг бид нар борлуулж мөнгө олох ёстой гэдэг дээр ямар соён гэгээрүүлэх ажил хийсэн бэ? Яг тодорхой хариулт авъя.

**Х.Булгантуяа:** Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хариулах уу? Болорчулуун дарга хариулах уу? Болорчулуун дахиад микрофоныг нь өгчхөөрэй. Протоколд нэрээ хэлээд.

**Ц.Болорчулуун:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариульъя.

Тэгэхээр ер нь бас хөдөө аж ахуйн салбарын бодлого байгаа. Тариалангийн бүс нутгийг түшиглэж, эрчимжсэн мал аж ахуйгаа хөгжүүлэх, эрчимжсэн мал аж ахуй маань яагаад тариалангийн бүс нутгаа түшиглэж байна гэхээр тариалан тэжээлийн бааз суурийг бий болгоход энэ тариалангийн бүс нутгаа түшиглэхээс өөр гарц байхгүй байгаа.

Тийм учраас бид нар эрчимжсэн мал аж ахуйгаа дэмжих бодлогоо, тариалангийн бүс нутагтаа хөгжүүлж тэндээ малын өндөр ашиг шимтэй мал үржүүлэх, 1 малаас авах ашиг нэмэгдүүлэх, олон улсын түвшинд тухайлах юм бол 1 үхрээс өгч байгаа сүүний хэмжээ 9-10 тонн байхад манай Монголын дотоодын сүүний чиглэлийн үхрүүд 2 мянган тонн сүү өгч байх жишээний. Тэгэхээр энэ жишиг рүү дөхүүлэх чиглэлээр бид нар эрчимжсэн мал аж ахуйгаа тариалангийн бүс нутгаа түшиглэн хөгжүүлэх бодлогыг баримтлаад энэ томоохон аж ахуйн нэгжүүд бас тодорхой үр дүнгээ өгсөн аж ахуйг бий болгоод ингээд явж байгаа.

Малчдын, ер нь малчдад нийт малчид руу чиглэсэн явж байгаа ажил гэх юм бол бид нар энэ малчдын бэлтгэж байгаа арьс шир, ноосонд тодорхой хэмжээний мөнгөн урамшууллыг олгож байгаа. Тэгээд мэдээж энэ нь бол нэг талаасаа малчдын орлогыг нэмэгдүүлэх, нөгөө талдаа бол үндэсний үйлдвэрийг түүхий эдээр хангах гэсэн энэ 2 бодлогыг ингэж хоршиж хэрэгжүүлэх үүднээс энэ мөнгөн урамшууллын хэмжээ голгож явж байгаа.



Цагаан алт хөтөлбөр бол ерөнхийдөө боловсруулах үйлдвэрүүд 3 салбарт чиглэсэн ноос, ноолуур, арьс ширний салбарт чиглэсэн ийм боловсруулах үйлдвэрлэлийнхээ түвшнийг нэмэгдүүлье гэсэн ийм хөтөлбөр явж байгаа.

Шинэ хоршоо хөдөлгөөнөөр бол малчдаа хоршиж, нэгдэж ажиллах. Одоо бид нар малчин тус бүрд хүрсэн бодлого хэрэгжүүлэхээс илүү хоршоод явбал малын гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ цэн нэмэгдэх, анхан шатын тордолтыг хийх ийм боломж, нөхцөлийг нь бүрдүүлэх зорилгоор энэ зорилгоор малчдын Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлээд ингээд хэрэгжилтийг нь бол хангаад ажиллаж байгаа гээд.

**Х.Булгантуяа:** Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

**Л.Мөнхбаясгалан:** Бэлчээрийн нөхөн олговрын талаар асуусан. Уул уурхайн бүсэд байж байгаад нүүг гээд төрөөс нөхөн олговор авч байгаа энэ дээр нь тэр малд нь, бэлчээрт нь ямар нөхөн олговор өгч байгаа юм бэ? Энэ талын бодлого байгаа юу гэсэн.

Дээрээс нь хүн болгон, малчин болгон мянгат малчин болоод малаа л олон болгоод байх биш, чанартай цөөн тооны малыг яаж адгуулах юм бэ, яаж өрх бүр юм уу, эсвэл хоршоолол нийлээд орлоготой байх вэ гэдэг дээр соён гэгээрүүлэх ажил юу хийж байгаа вэ гэсэн. Та бүхний энэ авч хэрэгжүүлээд байгаа ажил чинь байгаа онож байгаа юм уу? Хэрвээ онож байгаа бол өдийд яагаад залуу малчдын халаад тасраад байгаа юм бэ? Яагаад малчид малаа маллаж хэдэн мянган жилээр амьдарч ирсэн энэ амьдралаасаа залхаад орхиод байгаа юм бэ л гэж байгаа шүү дээ 3 асуулт. Шадар сайд.

**Х.Булгантуяа:** Шадар сайд Амарсайхан сайд хариулах уу?

**С.Амарсайхан:** Би юун түрүүн энэ өвөлжилтийн бэлтгэл ажил ямар байна вэ гэдэг асуулт орж ирсэн учраас холбогдох байгууллагууд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажилтай холбоотой танилцуулгыг хийж байгаа. Хэрвээ ямар бодлого, ямар стратеги, ямар төсөл, хөтөлбөрийг ямар хугацаанд хэрэгжүүлсэн юм тэрний үр дүнг тодорхой тайлагнана гэдэг ийм асуудал орж ирсэн бол бид бүх бодлого, хөтөлбөрийг дэлгэрэнгүй танилцуулахад бэлэн байгаа.

Асуудлын агуулга, сэдэв өөрөө энэ өвөл, хаврыг хэрхэн давах юм бэ гэдэг л ийм асуулт байгаа. Тэгэхээр бид цаг үетэйгээ нийцсэн энэ улирлын шинж чанартай бэлтгэл ажлын мэдээллийг та бүхэнд өгч байгаа.

Гэхдээ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны бодлого бол өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлыг даван туулж, эсвэл аргацаах маягаар биш дасан зохицож.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Амарсайхан Шадар сайдад нэмэлт минут өгье.

**С.Амарсайхан:** Тэгээд даван туулж дасан зохицох урт хугацааны стратегийг олон төсөл, хөтөлбөр, бодлоготойгоо уялдуулж байгаа.

Нэгдүгээрт нь бүсчилсэн хөгжлийн бодлогыг бүгдээрээ хамтдаа ба Улсын Их Хурлаараа баталсан. Энэ үзэл баримтлал бол яаж энэ улирлын шинж чанартай,

зуд турхан, ган гамшиг, аюулт үзэгдэл, гал түймэр, зовлон бэрхшээлээс үндэстнээрээ салах вэ гэдэг бодлогын хамгийн чухал хэсэг бол энэ бүсчилсэн хөгжил. Тийм ч учраас хангайн бүсээ эрчимжсэн мал аж ахуй болгоё, хөдөө аж ахуйн дэд бүс, болгоё, газар тариалангийн бүс, болгоё гээд 6 дэд бүсийн ажил бүсчилсэн хөгжлийн хүрээнд явж байна.

Хоёрдугаарт нь Шинэ хоршоо хөтөлбөр. Энэ бол хөдөө аж ахуй тэр дундаа үндэсний үржих баялаг болсон мал аж ахуйн салбар таван хошуу малыг өсгөж үржүүлэх, үржил шимийг нь нэмэгдүүлэх, эдийн засгийн өгөөжийг нь дээшлүүлэх, малчдын амьжир.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Пүрэвийн Батчимэг гишүүн.

**П.Батчимэг:** Өвөлжилтийн тухай асуудлыг өнөөдөр Улсын Их Хурлаар Ерөнхий сайд мэдээлэл хийнэ гэсэн энэ асуудлын дагуу гишүүдэд бас асуулт тавьж байна.

**Өвөлжилтийн тухай асуудлыг ярина гэвэл ийм дагавар байдлаар өнөөдөр энэ асуудалд хандах юм уу, эсвэл бүүр ингээд даацтай ярилцах юм уу гэдэг асуудал маш их зөрүүтэй асуудал.**

Эрчим хүчний салбарын өнөөгийн энэ хүндрэлтэй асуудал, үнэ тарифын нэмэгдэлтэй холбоотой яаж энэ өвлийг энэ Улаанбаатарчууд давж гарах вэ гэдэг нэн тэргүүний асуудал тулгамдсан асуудал болоод байгаа юм. Цахилгааны хязгаарлалтыг хийнэ гээд бүүр төлөвлөгөө гаргачихсан байгаа. Энэ асуудлаа яаж шийдэж давж гарах юм бэ? Дараагийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай холбоотой энэ мал аж ахуйн салбар тэр дундаа энэ ургамал, газар тариалан энэ жил энэ гантай байсан энэ аймгуудад тариалалт маш муу, ургац алдсан. Үүнтэй холбоотойгоор энэ улаан буудайн нөөц, энэ хадгалалт энэ ямар байгаа вэ? Малын гоц халдварт өвчин 5, 6, 7, 8 энэ төрлийн өвчнүүд гараад л байдаг. Вакцинжуулалтын асуудал удаа дараа яригддаг. Тэр вакцины нөөц, түрүүчийн Байнгын хороон дээр ярихад 70 сая малтай харьцуулахад вакцины тунгийн асуудал тэр вакцинжуулалт 70-н хэдхэн хувьтай байсан шүү дээ. 73 билүү, хэдэн хувьтай байсан.

Тэгэхээр энэ асуудлуудыг ер нь манай мэргэжлийн энэ байгууллагууд юу гэж хүлээж авах вэ? Гурилын импортын татварыг тэглэсэнтэй холбоотой дотоодын гурил үйлдвэрлэгчид тэдний бизнесийг шахсан энэ байдалд хэрхэн дүгнэлтээ хийж байгаа юм? Өнөөдөр бид нар импортоор орж ирж байгаа маш олон төрлийн ямар чанартай гурил өнөөдөр энэ ард иргэд хэрэглэж байгаа вэ? Хүнсний ногооны хадгалалт байна. Улаанбаатар хотод өнөөдөр хүнсний ногооны зоорь нэмэгдсэн үү? Хот тойрсон энэ хүнсний ногоо, хувиараа эрхэлж байгаа хүмүүсийн тэр борлуулалт, түгээлт, хадгалалт, энэ хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа, бизнес эрхэлж байгаа хүнсний ногоо чадан ядан тарьж тоос шороонд дарагдсан энэ иргэдийн тэр эрхэлж байгаа бизнесийг хэр.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Эхлээд Эрчим хүчний яам хариулъя. Эрчим хүчний яамнаас 2 номерын индэр дээрээс хариулъя. Дараа нь Хүнс, хөдөө аж ахуйн яам бас индэр дээр гарч хариулахад бэлдэж байгаарай.

**Б.Насантогтох:** Эрчим хүчний яамны Хэрэгжилтийн газрын дарга Насантогтох. Батчимэг гишүүний асуултад хариулья.

2024-25 оны эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажил 94 хувьтай явж байгаа. Нийтдээ улсын хэмжээнд 45 эрчим хүчний үйлдвэр, систем, түгээх компаниудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.

Өвлийн горимын хувьд бид хэд хэдэн хүчин зүйлийг тооцоолсон. Өнөөдрийн байдлаар манай системийн хувьд 5 бүсэд хуваагдаж байна. Алтай, Улиастай, баруун бүс, зүүн бүс, өмнөд бүсийн энэ 4 системд ямар нэгэн чадлын дутагдал, хязгаарлалтын горим хийгдэхгүй. Төвийн бүсэд үндсэн өсөлтөөс хамаарсан төлөвлөгөө гаргасан. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний хувьд өнгөрсөн оны мөн үеэс 12 хувь буюу 196мвт-аар өснө гэж тооцоолсон. Төвийн бүсэд хэрэгжиж байгаа эх үүсвэрийн ажлын явцыг бас товчхон хэлэхийг хүсэж байна. Үндсэндээ зүүн бүсэд 50мвт-ын шинэ эх үүсвэр орсон нь төвийн бүсийг 30мвт-аар дэмжиж ажиллах юм.

Дээр нь Эрдэнийн батарей хуримтлуур, Багануурын батарей хуримтлуур буюу эдгээр хуримтлуур нь орой оргил ачаалалд 50, 20 буюу 70мвт-аар дэмжиж ажиллана.

Мөн Тосонцэнгэлийн цахилгаан станц, Бөөрөлжүүтийн цахилгаан станц нийтдээ 168мвт. Эдгээр 5 төслүүд 2024 оны 12 сарын 1, 12 сарын 15, сүүлийн Бөөрөлжүүтийн станцыг бид саяын гарсан гэмтэлтэй холбоотой 12 сарын 30-нд төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд залгахаар төлөвлөсөн.

25 оны 1 дүгээр сард мөн бидний тооцоож төлөвлөснөөр Өвөр Монголын эрчим хүчний системээс 60мвт-ын импортын эрчим хүчний дэмжлэг авах юм. Ингээд Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд саяын 6 төсөл нь 328мвт-ын нөөц чадлыг бий болгох юм.

Тэгэхээр хязгаарлалтын төлөвлөгөө ямар тохиолдолд хэрэгжүүлэх вэ гэхээр 2 үндсэн шалтгаантай. Одоо ажиллаж байгаа манай 7 ДЦС-ууд бүх тоноглол ажиллагаанд байгаа, бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна. Эдгээр станцуудад, тоноглолд гэмтэл гарах юм бол хязгаарлалтын нөхцөл үүснэ.

Хоёрдугаарт саяын миний хэлсэн 6 төсөл цаг хугацааны хувьд тодорхой хэмжээгээр өөрчлөлт орох юм бол хязгаарлалтын нөхцөл үүсэх юм. Тэгээд энэ энэ 2 хүчин зүйлээс хамаараад бидний хувьд нарийвчилсан төлөвлөгөө гаргасан юм. Гэхдээ сүүлийн байдлаар өнөөдрийн байдлаар бид төсөл дээрээ манай Эрчим хүчний яам холбогдох төрийн өмчийн компаниудын нарийн мэргэжлийн хүмүүс хотын болоод хувийн хэвшлийн эдгээр эх үүсвэрийн төслүүд дээр хамтран ажиллаж байна. Сүүлийн төлөвлөсөн тооцооллоор саяын миний хэлсэн 12 сарын 1-ээс, 12 сарын 30-ны дотор эдгээр эх үүсвэрүүд төвийн бүсэд холбогдоно гэж тооцоолж ажлаа зохион байгуулан ажиллаж байна.

**Х.Булгантуяа:** Хүнс, хөдөө аж ахуйн яам бас хариулт өгье.

**Ц.Болорчулуун:** Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Батчимэг гишүүний асуултад хариулт өгье.

Тэгэхээр 2024 оны ерөнхий ургацын байдалд бол бид нар төлөвлөж байсан хэмжээнээс 56 орчим мянган га-гаар хаврын тариалалт буурсан. Тэгэхдээ энэ жилийн ургацын чанар харьцангуй гарсан ургац бол чанартай байсан.

Тариалангийн гол бүс нутгуудаар 7 дугаар сараас, 7 дугаар сарын наадмаас хойшоо 20 хоногийн үргэлжилсэн нартай байсны улмаас чанарт бас тодорхой хэмжээний асуудлууд бага зэргээр гарсан хэдий боловч ерөнхий хураалтаа бид нар төлөвлөж байсан ургацаасаа ийм гарсан ургацаа бол хурааж авч ургацынхаа дүнг сая өнгөрсөн 7 хоногт Засгийн газарт танилцуулсан байгаа.

Тэгэхээр улсын хэмжээнд нийтдээ 430 мянган тонн үр тариа хурааж авсан. Үүнээс 368 мянган тонн хүнсний улаан буудай, 250.8 мянган тонн төмс, 267.3 мянган тонн хүнсний ногоо хурааж авсан байгаа. Улаан буудайгаа, хурааж авсан улаан буудайн хуваарилалтууд ерөнхийдөө борлуулалтад гараад явж байна. Тэгэхээр хөдөө аж ахуйн корпорац ТӨК-д 46 мянган тонн хүнсний улаан буудайг авлаа тариаланчдаас. Гурил үйлдвэрлэлд 160 гаруй, 160.4 мянган тонн нийтдээ ингээд гурил үйлдвэрлэлд аваад үзвэл 2005 мянган тонн буудай нийлүүлэгдсэн. Одоо борлуулалтын шатдаа зарим аж ахуйн нэгжүүд борлуулалтаа хийж амжаагүй байгаа, хадгалчихсан өөрийнхөө саваа нөхцөлийг, агуулах киловатт-аас хамаараад хадгалчихсан аж ахуйн нэгжүүд бас тодорхой хэмжээнд байна. Ингээд 40 гаруй мянган тонн буудай бол аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын шатад байна. Тэгэхээр цаана нь бид нарын ер нь хэрэгцээ жилдээ 305 мянган тонн хүнсний улаан буудайн хэрэгцээтэй. Тэгээд ингээд гурил үйлдвэрлэлд борлуулалтын шаттайгаа аваад үзэх юм бол цаана нь 60 орчим мянган тонн буудай дутахаар байгаа.

Нөгөө талдаа бол 2024 оны 4 сарын 19-нд батлагдсан хуулийн хүрээнд импортоор тодорхой хэмжээний гурилууд орж ирсэн. Он гарсаар нийтдээ улсын хэмжээнд 57.4 мянган тонн гурил импортоор орж ирсэн байна.

Орж ирж байгаа гурил бол ОХУ-ын энэ “ГОСТ” гээд стандартын чанарыг хангасан, шаардлагыг хангасан ийм гурилууд орж ирж бас үйлдвэрүүдэд нийлүүлэгдэж байгаа. Нөгөө талдаа бас “ТУ” гэж стандарт байгаа. Тэгээд эхний хэсгийн ...-ын. Тэгээд энэ хангасан гурил гээд ингээд 2 янзын үндсэндээ чанартай гурил бас орж ирж хэрэглэгчдэд хүрч явж байгаа гэдгийг бас хэлье.

Хүнсний ногооны зоорины тал дээр бол бид нар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан энэ хүнсний хувьсгал хөдөлгөөний хүрээнд Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолд хүнсний ногооны зоорь агуулахын хэмжээг 55 мянган тонноор нэмэгдүүлж байж бид нар дотооддоо хадгалах боломж нь үүснэ гэдэг ийм зорилтыг дэвшүүлсэн.

Тэгэхээр бид нар үүнтэй холбоотойгоор энэ 36 дугаар тогтоолын хүрээнд тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгож байгаа. Тэгэхээр аж ахуйн нэгжүүд энэ банкны Засгийн газрын хүүгийн татаастай энэ зээлийн эх үүсвэрийг түшиглээд 2023 онд 29.4 мянган тонноор, одоо ингээд 2024 он гараад 7.7 мянган тонн зоорийг өөрсдийнхөө боломжийн хүчээр нэмэгдүүлж байгаа. Тэгэхээр энэ дээр бид нарын тавьсан зорилт бас 50 орчим хувьтай ингээд биелээд явж байгаа гэж ойлгож болно.

Ер нь бол хүнсний ногооны хамгийн чухал асуудал бол хадгалалтын асуудал. Тэгэхээр энэ дээр бол мэдээж сүүлийн энэ 2 жилийн хугацаанд энэ зээлийг түшиглээд аж ахуйн нэгжүүд яг энэ зоорины агуулахын бизнесийн чиглэлээр бас томоохон аж ахуйн нэгжүүд орж ирж байгаа. Дээрээс нь манай масс үйлдвэрлэл хийж байгаа томоохон аж ахуйн нэгжүүд өөрсдөө энэ зоорь агуулахынхаа хэмжээг нэмэгдүүлж байгаа ийм байдал байна гэдгийг бас танд хэлье.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар. Нэмж хариулах гэж байна.

**А.Нарантуяа:** Батчимэг гишүүний асуултад Мал эмнэлгийн ерөнхий газраас мэдээлэл өгье.

Ингээд Монгол Улсад худалдааны хорио цээрт гоц халдварт гол өвчнүүд ялангуяа энэ Монгол Улсад эрсдэл бүхий тийм 4 өвчин байдаг. Тэгээд та бүхэн бас мэднэ үхрийн арьс товруутах өвчин Дорнод аймгаас гарч байсан, бог малын мялзан гээд өвчин байна. Шүлхий өвчин байна, хонины цэцэг өвчин. Сая нэмээд 72 жилийн дараа ямааны годрон гээд өвчин хилийн бүсээр ингээд орж ирсэн.

Тэгээд үүнтэй холбогдуулан мал эмнэлэг эрсдэлд суурилсан тархвар зүйн шинжлэх ухаан дээр тулгуурлаж тодорхой бүс нутагт бүх малд биш, тодорхой хувьд вакцинжуулалтыг, дархлаажуулалтыг явуулдаг. Тэгээд өнөөдрийн байдлаар нэгдсэн дархлаажуулалт бол цэцэг өвчний дархлаажуулалт 97.4 хувьтай, бог малын мялзан өвчний дархлаажуулалт 95 хувьтай, шүлхий өвчнийг 2 удаа дархлаажуулдаг. Хаврын дархлаажуулалт, намрын дархлаажуулалт гээд. Хаврын дархлаажуулалт болохоор 93 хувьтай, яг намрын дархлаажуулалт 24 оны 11 сарын 14-өөс эхлээд 35 хувийн дархлаажуулалт явагдаж байна эд.

Нөөцийн хувьд арьс товруутах өвчний вакцин 2.2 сая тун, бог малын мялзан өвчний вакцин 13 сая тун, шүлхий өвчний вакцин 9.8 сая тун, цэцэг өвчний вакциныг 1 сая тунгийн нөөцтэй. Энэ вакциныг манай био үйлдвэр өөрөө үйлдвэрлэдэг. Бусад 3 төрлийн вакциныг бид нар импортоор авдаг. Уул нь сая годрон өвчин гараагүй бол сүүлийн 2 жил Монгол Улс гоц халдварт өвчингүй тайван байна. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад шүлхий өвчинтэй тэмцэх хяналтын хөтөлбөрөө илгээсэн байж байгаа. Ийм нөхцөл байдалтай байна.

**Х.Булгантуяа:** Батчимэг гишүүн тодруулъя. Батчимэг гишүүний микрофон.

**П.Батчимэг:** Сүүлийн үед яг гараад байгаа тэр ямааны годрон тэгээд тэр хонины цэцэг өвчин бүр их түгээмэл болоод байна л даа тээ? Тэгэхээр энэ тэр шинэ төрлийн энэ гараад байгаа тэр малын гоц халдварт өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх, яг тэр юунд тохирсон тэр вакциныг нийлүүлэх тэр гадаадаас импортоороо аваад байгаа гэж байгаа яг ямар орноос авч байгаа юм, тэгээд жилдээ ер нь хэчнээн сая тун, хэд, ямар хэмжээний, хэдий хэрийн төсөвтэй тэр вакцинд юуг төсөв зарцуулж байгаа вэ гэдгийг.

**Х.Булгантуяа:** 2 номерын индрийн микрофон өгье.

**А.Нарантуяа:** Саяын асуултад хариулъя. Нийтдээ Мал эмнэлгийн ерөнхий газар 36 дугаар тогтоолын хүрээнд ялангуяа гоц халдварт өвчинтэй тэмцэх, яг энэ дархлаажуулалт, вакцинжуулалттай холбоотойгоор төсөв нэмэгдүүлсэн. Тэгээд нийт төсвийн 20 тэрбумаар нь гаднын 3 вакциныг авдаг. 43 орчим нь тарилгын үйлчилгээний хөлсөнд явдаг. Энэ 4 гол өвчний 3 вакциныг Дэлхийн мал амьтны байгууллагын ялангуяа вакцин болгон дээр нь, өвчин болгонд нь чиглэсэн олон улсын лавлагаа, лабораториор баталгаажсан олон улсад, гадаадад эрх бүхий тийм вакцин үйлдвэрлэгч орноос авч байгаа.

Тэгээд энэ жилийн тухайд Худалдан авах ажиллагааны хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан энэ гоц халдварт өвчинтэй тэмцэх 3 вакциныг бид нар дундын зуучлагчгүйгээр улсын яг өөрсдийнх нь үйлдвэрлэгчээр арай өөр байдлаар олон улсын тендерээр явуулсан. Тэгээд үүний үр дүнд нийлүүлэгдэх вакцины хэмжээ нэмэгдсэн учраас.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Ганбаатар гишүүний нэр түрүүн асуугаагүй байж байхад нь алга болчихсон байна шүү Тамгын газрынхан. Одоо бүүр бүүр хойшоогоо явчихлаа. Гомбын Ганбаатар гишүүн.

**Г.Ганбаатар:** Хэл ам хийж байж микрофонтойгоо. Тэгээд Их Хурлын сонсгол ер нь ингэж явдаг юм уу, эсвэл Ерөнхий сайдын сонсгол ингэж явдаг юм уу 2 дахь удаагийн Ерөнхий сайдын сонсгол тийм нөгөө юу хэллэгээр жаргон хэллэгээр гурилдсан юм шиг л юм болоод байгаа юм.

Яагаад тэгж байна вэ гэхлээр нөгөө хилийн боомттой холбоотой өөрөө орж ирээгүй, ахиад энэ хөдөө аж ахуйн энэ өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой яах вэ Ерөнхий сайдыг өөрөө ажил ихтэй байгааг нь ойлгож байна. Тэгээд энэ холбогдох улсууд нь байж байгаа царай нь, тэр Төрийн нарийнууд нь мэдэх хүмүүс ер нь байгаа юм уу? Тэгээд 2 асуулт. Энэ тараасан мэдээлэлтэй нь холбоотой 2 асуулт байна. Тэр хөдөө аж ахуйн юутай холбоотой, яах вэ яг өвөлжилтийн бэлтгэлтэй гэхээсээ илүү танай оруулж ирж байгаа материалтай холбоотой, тэр малжуулах хөтөлбөртэй холбоотой, даатгалтай холбоотой.

Өнгөрсөн жил үнэхээрийн хүнд өвөл болсон. Хүнд өвөл ч гэж бүүр зүүн аймгууд бол гамшиг болсон шүү дээ. Тэгээд энэ малжуулсан арга хэмжээ гээд тэгсэн нийтдээ 21 аймгаас 3419 өрхийн 27 тэрбум төгрөг зарцуулсан гээд тэгж байна. Үүнийг нь 100 хонин толгойд нь хуваагаад үзэхэд айлд 30 толгой, 30 бог мал ноогдож байгаа юм байна л даа. Гэтэл өнгөрсөн жил бид нар чинь 8.1 сая толгой малаа алдчихсан. Хонин толгойд шилжүүлэх юм бол энэ чинь бүүр 12 сая 700 мянган мал хоргодсон юм байна лээ шүү дээ. Эдийн засгийн хохирол нь бүүр 2.4 их наядар хэмжигдэхээр. Энэ чиглэлээр төсөв мөнгө хэцүү байж болно, олон улсын төсөл, хөтөлбөрт хандаж энэ малгүй болсон малчдаа малжуулах чиглэлээр хийж байгаа ажил байна уу Хөдөө аж ахуй яам? Би уг нь үүнийг байнга л асуугаад байгаа. Дээр бас Хөдөө аж ахуйн байнгын хорооны хурал дээр асуусан. Одоо яг үнэндээ ингээд зээлийнх нь үндсэн төлөлтийг хойшлуулсан ч гэсэн хөдөө манай энэ Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговийн зүүн тал ерөөсөө хуучин портер, Хятад мотоцикл хоёроос өөр төлөх юмгүй болсон шүү малчид чинь. Тэгэхлээр малжуулах, цаашид нь энэ тэр банкных нь үндсэн зээлийн төлөлттэй холбоотой ямар бодлого энэ Засгийн газраас баримталж байгаа юм бэ гэж.

Хоёр дахь нь тэр даатгалтай холбоотой. Бас 21 аймгийн 21.4 мянган малчин 3.7 тэрбум төгрөгөөр малаа даатгуулсан юм байна. Нөхөн олговорт нь бас 4.1 тэрбум төгрөгийг 2382 малчинд олгосон гэж байна. 1 малчин өрхөд ноогдож байгаа нь дунджаар 1.7 сая төгрөг л юм байна л даа. 10 хонь л юм байна 170 мянгаар бодох юм бол.

Тэгэхлээр зуд бол үеийн үед энэ байгаль цаг уур ямар болж байгаа билээ болно. Нөгөө талдаа угаасаа энэ хүн төрөлхтөн эрсдэлээс хамгаалах ганцхан арга энэ түүхийг энэ олон жилийнхээ хугацаанд бодож олсон нь ерөөсөө л даатгал шүү дээ. Эрсдэлээс урьдчилан сэргийлдэг арга бол. Энэ мал аж ахуйн салбарт энэ эрсдэлээс сэргийлдэг, өөрөөр хэлбэл, дараа нь төрд ачаалал болохгүйгээр, дараа нь малжуулах гээд ярихгүйгээр энэ даатгалын системийг нэвтрүүлэх тал дээр яг ямар бодлого явж байгаа юм?

**Х.Булгантуяа:** Эхлээд Шадар сайд Амарсайхан хариулъя.

**С.Амарсайхан:** Засгийн газрын тухай хуулиар бол Ерөнхий сайдыг Шадар сайд орлодог. Өвөлжилт, хаваржилт гээд энэ хариуцсан асуудлаар Шадар сайд шууд мэдээлэл хийх хуулиар хүлээсэн эрх, үүрэгтэй. Ерөнхий сайд байхаар асуудал өөр хариулагддаг, эсвэл үгүй гэдэг ойлголт байж болохгүй л дээ нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ өвөлжилт, хаваржилтын асуудлыг бид хэд хэдэн чиглэлээр түрүүн ярьсан. Бүсчилсэн хөгжил, Шинэ хоршоо хөдөлгөөн, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох, байгалийн таашгүй гамшиг, эрсдэлийг даван туулах гэдэг бол зөвхөн нэг салбарын асуудал биш, нэг аймаг орон нутгийн ч асуудал биш. Энэ өөрөө байгаль орчин, эдийн засаг, дэд бүтэц, нийгмийн хэрэгцээ шаардлага, эрүүл мэнд, боловсрол гээд бүх салбарын оролцоог шаардсан цогц асуудал. Мэдээж өвлийг ингээд өнөөдөр яриад маргааш хавар нь мартдаг намар нь санадаг тийм байж болохгүй. Тэгж явсан ирсэн гашуун туршлагууд бий.

Тэгэхдээ Засгийн газар бол энэ Алсын хараа-2050 хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлого гээд энэ бодлогуудынхаа хүрээнд ер нь урт хугацаанд тогтвортой орчин, нөхцөлийг бүрдүүлэх. Ялангуяа энэ үндэсний үржих баялаг болсон мал сүргийг өсгөж үржүүлэх, түрүүн Мөнхбаясгалан гишүүний яриад байдаг тэр бэлчээрийн доройтол, бэлчээрийн зохицуулалт, бэлчээр ашиглалт, нөхөн сэргээлт гээд олон асуудлуудтайгаа уялдуулж шийдэх ёстой асуудал.

Тэгэхдээ энэ уур амьсгалын өөрчлөлт цаг уурын нөхцөл байдалтай холбоотой үүсэж байгаа хүндрэл, бэрхшээлийг бид өмнө нь зөвхөн өвс тэжээл өгснөө тоолдог, авснаа ярьдаг, ард нь тэр айлын амьдрал, эдийн засгийн чадавх, өрхийн орлого, хүүхдийн эрүүл мэнд, боловсрол гээд олон нийгмийн сөрөг үр дагавруудыг ерөөсөө орхичихсон явж ирсэн ийм гашуун туршлагууд бий.

Харин сүүлийн жилүүдэд бол бид нийгмийн сөрөг үр дагаврыг нь тухайн цаг үеийн хохиролтой нь эргээд ирээдүйд гарах эерэг, сөрөг үр дагавартай нь хамтад нь тооцдог ийм эрсдэлийн үнэлгээг хийдэг болсон. Урьдчилж зудын эмнэлгээ үнэлгээгээ хийдэг болсон, урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ авдаг болсон. Сая Ганбаатар гишүүний асуусан асуулт жишээ нь малжуулах хөтөлбөр. Өнгөрсөн жил

бид малжуулах хөтөлбөрийг эрчимтэй хэрэгжүүлэх, гэхдээ энийг аймаг, орон нутгийн түвшинд малчид орон нутгийн дундын зохицуулалтаар малын тарга тэжээлийн шим, үржил шимийг дээшлүүлэх, тарга тэвээрэг нэмэгдүүлэх, нөгөө хашаа хороогоо сайжруулах, стандарттай нийцсэн саравч, хашаа барих, өвс тэжээлээ бэлдэж авах гээд маш олон ажлууд дээр анхаарч зохион байгуулалтыг хийх бодлогын хүрээнд энэ Шинэ хоршоо хөдөлгөөн өрнөсөн. Өнөөдөр 66000 гишүүнтэй байна, 6500 гаруй хоршоод байгуулагдсан байна, 3400 гаруйд нь хоршооны 14000 гаруй гишүүд нийтдээ 517 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт авч эхнээсээ тэр өвс тэжээлээ базаагаад авчихсан. Дээрээс нь хашаа хороогоо янзлаад эхэлчихсэн.

Малынхаа үржил, селекцийг сайжруулах замаар хийж байгаа энэ өөрчлөлтүүд нь ерөөсөө энэ хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах, эрсдэлийг бууруулах, эдийн засгийн өгөөжийг нь нэмэгдүүлэх эцэст нь хөдөө орон нутгийн айл өрхийн орлого нэмэгдэж, нөгөө үндэсний баялгаасаа өөрсдөө өгөөжөө хүртдэг байх ийм тогтолцоо руу оруулах гэж байгаа.

Гэтэл нөгөө талдаа асар хүндрэлтэй нөхцөл байдлууд байна. Ажиллах хүчин дутагдаж байна. Дээрээс нь цаг уурын өөрчлөлт өөрөө асар таашгүй нөхцөл байдлыг бий болгож байгаа. Манай малчид бол хөдөө орон нутагт, алс хязгаар нутагтаа эзэн нь болж эх орон, ард түмэн энэ одоогийнхоо өмнөөс газар нутгаа харж байгаа, өөрийгөө ажлын байраар хангаж байгаа, дээрээс нь бусдыг ажлын байраар хангаж байгаа, нийт хүн амын улс орны хүнсний хэрэгцээний бараг 80 хувийг хангаж байгаа ийм хүмүүс.

Тэгэхээр эргээд энэ хүмүүсийн бэлчээрийн асуудлыг яах юм, нийгмийн асуудлыг яах юм гэдэг цогц бодлогыг л энэ салбар бүрийн оролцоотой сая Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан стратегид үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг дээшлүүлэх стратеги гэдгээ хэрэгжүүлж, бүх шатад дорвитой өөрчлөлт хийе гэж байгаа. Бүх зүйл сайхан болчихсон зүйл байхгүй. Манай гишүүдийн хэлж байгаа тэр анхаарах асуудлууд их бий. Ингээд өнгөцхөн харахад өвс тэжээл яриад байгаа юм шиг мөртөө яг цагаа тулахад л ярихаас өөр аргагүй ийм нөхцөлд манай малчид, иргэд маань өв соёлоо тээж, үнэт зүйлээ тээж тэнд өвлийн хүйтэн, хөр цас, хаврын шуурга, намрын.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Даатгалын тогтолцоо холбоотойгоор бас асуулт асуусан даа тээ? Шадар сайд нэмж хариулья.

**С.Амарсайхан:** Энэ даатгалын, эрсдэлийн даатгалын сан гэж бий. Дээрээс нь энэ даатгалын тогтолцоогоо бид нар сайжруулахгүйгээр цаашаа энэ хохирлыг барагдуулах, эрсдэлийг бууруулах гэдэг асуудал байхгүй. Тэгэхээр энэ даатгалын тогтолцоонд өөрчлөлт оруулах. Ялангуяа тэр индексжүүлсэн даатгал гэж хөдөө орон нутагт, малчид, ялангуяа энэ банк, санхүүгийн байгууллагаас зээл авахдаа хүртэл нэг хэсэг нь хамрагддаг, нэг хэсэг нь хамрагддаггүй.

Тэгэхээр энэ Шинэ хоршоо гэж бид хэрэгжүүлээд байгаа чинь нэгдүгээрт энэ даатгалын тогтолцоо руугаа хүн бүр оръё гэж. Дээрээс нь хөдөө аж ахуй, мал аж ахуй бизнес аж ахуйн үйл ажиллагаагаа даатгадаг больё. Аль аль нь эцэстээ төр нь ч эрсдэлгүй, аж ахуйн нэгж нь ч эрсдэлгүй, малчин ч хохиролгүй байх ийм боломж нөхцөлийг бүрдүүлэх тогтолцоог хийхээр энэ даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах судалгаанууд хийгдээд явж байгаа. Энэ талаар бол бас удахгүй



Засгийн газрын хуралдаанаар танилцуулж бас гишүүдэд мэдээлэл хууль өргөн баригдах байх. Та бүхэн маань энэ дээр бас.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн.

**С.Цэнгүүн:** Оройн мэнд хүргэе. Энэ Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл дунд эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажил 94 хувьтай гээд сая бүх гишүүдийн өмнө, тэгээд ард түмний өмнө бид нар ингээд уншаад танилцуулж байна шүү дээ. Яг үндсэндээ Эрчим хүчний үндэсний хороон дээр танилцуулагдаж байгаа мэдээлэл дээр ч тэр үндсэн байгаа бодит байдлаа хараад үзэхээр 94 хувийн бэлтгэл ажил хангаж чадаагүй шүү дээ. Яагаад ингэж 94 хувьтай байна, ямар ч асуудал байхгүй, эрчим хүчний салбарт байхгүй юм шигээр ийм тоо тавьж байгаа юм бэ? Ер нь энэ танилцуулгад яамнууд тоонуудаа танилцуулахдаа Монгол Улсад ямар ч асуудал байхгүй юм шигээр ингэж танилцуулдаг. Яамнууд бүх бүх ажлаа хийж чадаж байгаа юм шиг.

Гэхдээ бодит нөхцөл байдал дээр нь тэндээ хүний амь нас эрсдэж байдаг, тог тасарч байдаг энэ асуудлууд нь байсаар л байгаа шүү дээ. Ер нь зүгээр энэ тоогоо бид нар яаж гаргаж ирж тавьж байгаа юм гэдгээ хармаар байгаа юм.

Дээрээс нь бас худлаа мэдээлэл ингэж тавьчхаад энэ дээрээ бас бид нар хариуцлага хүлээдэг байхгүй бол хариуцлагатай хандаж ажиллахгүй байхаар чинь ингээд хуурамч тоонууд сонссон болоод тэгээд 94 хувийн өвөлжилтийн бэлтгэл ажил сайн хийгдсэн байгаа юм байна, Ерөнхий сайдын мэдээлэл дунд орсон юм чинь асуудалгүй энэ өвлийг давж чадах юм байна гэсэн ойлголтыг бид нар иргэддээ өгөх гээд сууж байна шүү дээ. Бид нар бодит байдлаа мэдэж байгаа, хүн болгон мэдэж байгаа. Эрчим хүчний үндэсний хороо байгуулагдаад бид нар реформын ажил хийнэ гэж зарласан. Энэ маань бол хэдхэн долоо хоногийн дотор шийдэгдчих асуудал биш, 30 жил шийдэгдээгүй асуудал учраас бид нарт маш их цаг хугацаа орно.

Дээрээс нь бодитойгоор бид нар асуудлаа гаргаж ирж тавьдаг баймаар байна. Эрчим хүчний яамны энэ мэргэжилтнүүд, энэ ажилтнууд бүгдээрээ салбарынхаа асуудлуудыг бодитоор нь харуулж, ярьж, дээрээс нь энэ Ерөнхий сайдад бодит мэдээлэл өгмөөр байна. Яагаад ийм худлаа мэдээлэл өгч байгаа юм бэ гэдгийг асуумаар байна та бүхнээс?

**Х.Булгантуяа:** Эрчим хүчний сайд Чойжилсүрэн.

**Б.Чойжилсүрэн:** Цэнгүүн гишүүний асуултад хариулъя.

Нэг талаас шударга шүүмжлэл мөн. Гэхдээ бид нар дандаа хүнд юм яриад, хүндрэл яриад байх юм бол бүр хүнд байдалд орох юм. Тийм учраас 2024 оны зорилтот түвшнийг бид нар батлахдаа тодорхой байгаа орлогынхоо хэмжээнд ийм ийм ажлуудыг хийнэ гэдгээ эрэмбэлээд, түүнийхээ гүйцэтгэлийг шалгаад үзэхээр ийм 94 хувьтай гарч ирж байгаа юм ер нь бол. Түүнээс биш яг том утгаараа бол таны яриад байгаа эрчим хүчний салбарт бол асуудал их байна, зовлон их байна. Энийг бүгдийг нь яриад байх юм бол зөвхөн энэ энэ хүндрэлээр юу ч хийхгүй байлтай биш. Бид нар ямар ч байсан эрчим хүчний салбарын 20-иод мянган албан хаагчид бол байгаа боломждоо бол бүх боломжоо шавхаад хадгалж байгаа юм.

Жишээлбэл, та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдэд нэг зүйлд бас талархал илэрхийлье. 2024 оны улсын төсвийн тодотголоор 131 тэрбум төгрөгийн татаасыг эрчим хүчний сайдын багц дээр нэмэгдүүлж баталж өгсөн. Үүний хүчинд үнэнийг хэлэхэд энэ өвөл хуучирсан тоноглолуудаа ямар ч байсан аргалаад зогсоочихгүй аваад гарах ийм л бэлтгэл хангасан гэж ойлгож болно. Ингэхгүйгээр огт юу шалгуур үзүүлэлтгүй болчих юм бол бүүр хүндэрчих учраас бид нар байгаа боломждоо тохируулаад өвөлжилтийн бэлтгэл ажил 2024 оны зорилтот түвшнээ батлаад, үүнийхээ биелэлтийг хянаад, гүйцэтгэх захирлууд ТУЗ-уудтай нь бол үүгээр нь үр дүнг нь тооцоод явж байгаа.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд.

**С.Эрдэнэболд:** Өвөлжилтийн, хаваржилтын бэлтгэл гэдэг бол энг талаасаа бол өвөл хот дулаахан байх, нөгөө талаасаа малчид маань өнтэй өвөлжих, өвлийг эсэн мэнд авах гэдгээсээ гадна цаана нь үндэсний аюулгүй байдлын бас том шалгуур байгаа.

Өчигдөр Шадар сайдтай хамт бас Хөдөө аж ахуйн яаман дээр Дархан-Уул аймагт бас бүсийн чуулганы үеэр очсон. Тэнд авч байгаа мэдээллээр бол өнгөрсөн жил 8.1 сая мал хорогдсон. Энэ нь эдийн засгийн үнэлгээгээр ойролцоогоор 1 тэрбум доллар буюу 3.4-5 их наяд төгрөгийн хохирол Монгол Улсад учирсан гэж байгаа.

Гэхдээ энэ нөгөө иргэдийн хөрөнгө гэсэн үг л дээ. Тэгээд тэнд нэг зүйл ажиглагдсан нь бол ноднин, уржнан бол энэ Туваан сайдтай хамт Төв аймгийн энэ төвийн бүсийн сумдаар яг зудын үеэр маш их явсан. Тэгэхэд шатахуун тасалчихсан. Ингээд том том чиргүүлтэй өвс ачсан машинууд шатахуунгүй хаа сайгүй, шатахуун тасарчихсан учраас өвөлжилтийн бэлтгэл чинь тэр чигтээ тасарчихгүй юу. Өвс, тосоо базааж чадаагүй.

Тэгээд энэ нь бол энэ зудын хохирол авах бэлэн байдал хангагдахгүй байхад бараг ноцтой цохилт өгсөн гэж үзэж болно. Тэр 8.1 сая малын үлэмж хувьд нь энэ шатахууны тасалдал нөлөөлсөн гэж ойлгож байгаа. Тэгэхээр иргэдийн хувьд бол хамгийн их асуухыг хүсэж байгаа зүйл бол мэдээж энэ өвөл дахиад ноднингийнх шиг энэ бензин, шатахуун, түлш тасарчихгүй биз дээ? Энэ дээр Засгийн газар нөөцийн ямар бодлого барьж байна вэ? Өнөөдрийн байдлаар нөөц ямар байна вэ? Өвөл хүндрээд цагийн байдал хатуурахад энэ асуудал дээр Засгийн газар найдвартай байдлыг авч гарч чадах уу? Өчигдрийн байдлаар мэдээлэл авахад энэ өвөл дахиад хүйтэн болно гэсэн ийм судалгаа байна гэж үзэж байгаа.

Тэгэхээр уржнан жилийн өвөл чанга байсан, ноднин жилийн өвөл эхлээгүй бүүр 11 сард манай Төв аймгийн Эрдэнэсант сумд 6 хүн, 7 хүн амь нас алдсан шүү дээ шуурганд уруудаад. Тэгээд иргэдийн амь нас ноднин жил бас ингээд алдсан. Тэгэхээр энэ жил бол бид нар бол яг энэ дээр шатахуунтай холбоотой асуудлууд дээр та бүхэн иргэдэд мэдээлэл хийж өгөөч.

Хоёрдугаарт нь бол тэр ноднингийн 8.1 сая мал тэрбум долларын үнэлгээтэй энэ хохирлыг бид нар авчихсан байна. Энэ жил ер нь цагийн байдал хүндэрлээ гэхэд энийг бодитоороо бууруулах ямар эрсдэлийн менежментийг Засгийн газраас барьж байгаа вэ гэсэн 2 асуултыг асууя.

## **Х.Булгантуяа:** Шадар сайд Амарсайхан хариулах уу?

**С.Амарсайхан:** Тэгье. Өнгөрсөн жил бас бензин шатахуунтай холбоотой асуудал бүх салбарт байсан бүгдээрээ мэдэж байгаа. Үүнээс шалтгаалж бас тодорхой ажил, амьдралд учирсан хохирол, эрсдэлүүд байсан гэдгийг үгүйсгэхгүй.

Гэхдээ өнгөрсөн жилийн өвөл өөрөө сүүлийн 40, 50 жилд тохиолдоогүй энэ салбарын мэргэжилтэн, боловсон хүчнүүдийн хэлж байгаа судалгаагаар гарсан ийм дүгнэлт.

Ер нь бол эрсдэлийн үнэлгээг хийдэг болсон гэж би түрүүн хэлсэн. 21 оноос хойш Шадар сайдын тушаалаар өвлийн зудын эрсдэлийн үнэлгээг хийдэг болсноос хойш жил бүхэн энэ эрсдэлийн үнэлгээ дээр тулгуурлаж урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд авч хэрэгжүүлдэг. Өнгөрсөн жилийн эрсдэлийн үнэлгээ, зудын үнэлгээ эрсдэлээр нийтдээ 26 сая толгой мал хоргодох ийм эрсдэлтэй байна. Өвлийн хүндрэлээс болж гэж 10 дугаар сарын сүүлээр хийсэн. Ийм судалгаагаар гарч ирсэн.

Үүний мөрөөр бид урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, малчид, иргэддээ уриалж нэгдүгээрт махыг хэрэгцээлэх буюу зах зээлийн эргэлтэд оруулах.

Хоёрдугаарт, өвс тэжээл бэлтгэл ажлаа сайтар хангах.

Гуравдугаарт, аливаа гарч болзошгүй эрсдэлээс амь нас, эрүүл мэндээ хамгаалж явах гэдэг олон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж олон улсын байгууллагууд ч, Засгийн газар ч бас үе шаттай арга хэмжээ авч, түүний нэг нь өөрөө энэ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хохирлыг багасгах хууль тогтоомжийг хүртэл гаргаад ингэж ажилласны үр дүнд 8 аварны энэ хохирол 2 дахин, 3 дахин буурч чадсан.

Гэхдээ 8.4 сая толгой мал сүрэг гэдэг бол асар өндөр тоо. Тэгэхээр энийг дахиж давтаж гаргахгүй байх боломж нөхцөлийг иргэн, аж ахуйн нэгжүүд, малчид, орон нутгийн удирдлагууд, Засгийн газрын харьяа байгууллагууд бүгдээрээ хамтарч ажиллаж байж энийг бууруулна. Ингэхийн тулд өнөөдөр хүртэл Шадар сайдын удирдамж, зааврын дагуу аймаг, орон нутагт шуурхай бүлгүүд гарч, өвөлжилтийн нөхцөл байдлыг газар дээр нь дүгнэх, малчид, иргэдэд зөвлөн зөвлөгөө өгөх, урьдчилан сэргийлэх, бодлого, санаагаа хуваалцах, тэгээд анхаарах асуудлууд байвал газар дээр нь шийдвэрлэх, нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд бол бас асуудлыг нэгтгэж, Улсын Их Хурал, Засгийн газраар хэлэлцүүлэх хүртэл ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Ер нь энэ салбарт бол бензин шатахуунаас эхлээд нүүрс, түлээ түлш, энэ дулаан цахилгааны станцуудыг хэвийн ажиллуулахтай холбоотой, зам тээврийн салбар, дэд бүтцийн бусад салбарын үйл ажиллагаанууд гээд орхигдож, хаягдах ийм зүйл байдаггүй учраас бүх салбарын оролцоо энэ дээр чухал.

Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яамныхантай бид ярьж энэ аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтарч бензин шатахууныхаа нөөцийг урьдчилж сайтар бүрдүүлэх, аймаг орон нутаг, сум багийн түвшинд хомсдол үүсгэхгүй байхтай холбоотой зохицуулалт зохион байгуулалтын ажлууд Улсын онцгой комиссын шуурхай штаб

дээр бас яамдын холбогдох албан тушаалтнуудтай хийгдээд явж байгаа. Бид бас тодорхой шаардлагуудыг тавьж байгаа. Аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтарч энэ нөөцийг сайтар бүрдүүл гэдэг. Зам хаагддаг автомашин явдаггүй, очих гэж байна гэсээр байтал нөөц нь дуусдаг. Ингээд энэ хооронд амь нас эрүүл мэндээрээ хохирох асуудал гардан учраас үүнийг анхаарч ажиллахаас аргагүй ийм зүйлүүд байгаа.

Тэгээд ер нь бол энэ өвлийн нөхцөл байдал цаашаа зөвхөн өвөл, хавар гэлтгүйгээр цаг уурын өөрчлөлт асар хурдацтай явагдаж байгаа нь өдөр тутам бидний амьдрал дээр бодитойгоор нүүрлэж байгаа энэ эрсдэлүүдээс харагдаж байгаа. 30 он гэхэд 40 хувиар нэмэгдэнэ гэж байгаа өнөөдрийн нөхцөл байдал. Дахиад цаг уурын аюулт үзэгдлүүд 3 дахин нэмэгдэнэ гэж байгаа. Тэгэхээр цорын ганц арга бол бэлэн байдлыг хангах, бэлтгэл ажлыг сайтар хийх.

Ер нь бол өвөлжилтийн бэлтгэл ажил гэдэг бол бид түрүүн эрчим хүчний салбар дээр ярьсан асуудал, одоо байгаа эх үүсвэр, тэгээд тоног төхөөрөмж, шугам сүлжээний найдвартай байдлыг хангахтай холбоотой бэлтгэл ажлын тухай ярьж байгаа.

Нөгөө талдаа мэдээж хүрэлцээ шаардлага хангахгүй байгаа эрэлт, хангалт нийлүүлэлттэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн орчны өөрчлөлт шинэчлэлт, үнэ тарифын асуудал, зах зээлийн зарчмаар нь явуулах, тасалдалгүй, тогтвортой, найдвартай эх үүсвэрийг бий болгож салбарын хөгжлийг дэмжих эрчим хүчний, эдийн засгийн хөгжил, эрчим хүчний салбарын шинэчлэлтэй холбоотой олон асуудлууд байгаа. Тэгэхдээ өнөөдрийн асуудал бол яг байгаа нөөц бололцоо дээрээ гал алдахгүй, тасалдуулахгүй, дээрээс нь салбарын онцлогт тохир.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл.

**О.Цогтгэрэл:** Өвөлжилтийн бэлтгэл гээд нэг сонсохоор их лаг ажил хэрэгч ч юм шиг. Нөгөө талаасаа бол үнэхээр энэ бас тийм өрөвдөлтэй л үг байх байх л даа. Монгол нутаг дээр мянга мянган жил жилийн дөрвөн улиралтай л байсан. Өвөл болохлоор хүйтэн болдог гэдэг шиг байдаг л зүйл байх нөгөө талаас.

Тэгээд өвөлжилтийн бэлтгэлийн тухай ярихлаар бид нар тийм өвс тэжээл, баахан баахан статистик тоонууд. Яг үнэндээ энэ өвөлжилтийн бэлтгэл гэдэг зүйл тухайн салбарын дотоод чадвар, чадавх, дархлааг нь хэр бэхжүүлсэн бэ, дархлаа нь ямар түвшинд очив оо гэдэг зүйлийн тухай уг нь яриа байвал хамгийн зүй зохистой байх. Бид нарын ярьж байгаа сэдэв, тэр танилцуулагдаж байгаа зүйлс бол үнэхээр бас нөгөө талаасаа үнэхээр бас ийм өрөвдөлтэй. Хүнээр бол бодит биеийн дархлаа нь ер нь ямар байгаа юм, ханиад томуу авахад эрдэс витаминаа авч байгаа юм уу, агаар салхиндаа гарч байгаа юм уу тэр хүүхэд гэдэгтэй адилхан.

Тэгэхээр бид нарын хувьд бол ийм хүүхэд нь шалдан, нүцгэн гүйчихсэн, эрдэс витаминаа авдаггүй, тэгээд их нэг л баахан өвчин зовлон ярьсан ийм айл шиг л зүйл жил жилд л яг энийг ингээд л ярьж байдаг.

Тэгэхлээр яг хөдөө аж ахуй дээр ярихад бид нарын тэр хөдөө аж ахуйн салбарын дархлаа өнөөдөр ямар байна вэ гэвэл энэ дээр хэцүүхэн л тоо гарна. Хөдөө аж ахуй маань улсын дунджаас хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа

хүний олж байгаа орлого 2-3 дахин бага, орлоготой салбаруудынхаас 5 дахин бага орлоготой тэр хөдөө аж ахуйн салбар нь олж байгаа зүйл, үнэндээ ахуй амьдрал, олж байгаа зүйл, орлого, ашиг, найдвартай өрсөлдөх чадвар гээд гоё гоё зүйл, технологи энэ тэр гээд ярих юм бол үнэхээр ямар ч өөрчлөлт, хөгжил дэвшил байхгүй ийм улс төрчдийн ийм бодлогын зүгээр улс төрийн арга хэрэгсэл шахуу болоод хоршоо есөн жорын тэр дотор ямар нэгэн тийм бодлогын өөрчлөлт, зүгээр л ийм арга, хэрэгсэл болоод ингээд л өөрчилсөн ийм л зүйл яг өнөөдөр манай хөдөө аж ахуйн салбарт л байна л даа.

Уг нь бол энэ эрсдэл гэдэг зүйл өвөлжилтийн цаана эрсдэл яриад байх шиг байгаа юм. Эрсдэл гэдэг зүйл чинь уг нь зүй зохистой улс орондоо энэ чинь өөрөө бизнес юм гэнэ лээ. Эрсдэл байна. Эрсдэлийг шийддэг арга замыг нь даатгалын тогтолцоо гэдэг. Үүгээрээ бизнес хийгээд харилцан ашигтай ажиллачихдаг тэр эдийн засгийн тэр механизмууд нь, эд эрхтнүүд нь энд бүрэн дүүрэн байх тухай л яриа энэний цаана байдаг байх.

Тэгэхлээр яг энэ зүй зохистой дархлааны системийг, энэ эрсдэлийн системүүдийг ажиллахад бид нар өнгөрсөн хугацаанд юу хийсэн бэ, юу хийх гэж байгаа вэ гэдэг энэ бодлогын энэ том шилжилт рүү орж байж энэ өвөлжилт гэдэг энэ ийм бүтээл ч юм шиг мөртөө өрөвдөлтэй энэ ярианаас хэдүүлээ гарцгаах ёстой байх. Яг одоо энэ тайлан дээр байгаагаар мал аж ахуйн салбарт сая өнгөрсөн хавар.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Уг нь Хөдөө аж ахуйн сайдаас л. Болорчулуун дарга хариулах уу? Тодруулъя. Шадар сайд хариулъя.

**С.Амарсайхан:** Цогтгэрэл гишүүний бас тайлбарт тодорхой хариулт өгье.

Өвөлжилтийн асуудлыг яриа, танилцуул гэсэн учраас ярьж байгаа. Тэгээд ярихаар ярилаа. Ярихгүй болохоор ярьсангүй гэдэг асуудал бас байж болохгүй л дээ. Тэгээд өвөлжилтийн асуудал бидний амьдралаас хэзээ ч салахгүй байсаар байна. Өвөл хэзээ алга болно тэр цагт ярихгүй байж магадгүй байх.

Тэгэхээр энэ цаг уурын нөхцөл байдал, бид нарын амьдралын хувь заяаны эрхээр учирсан энэ дөрвөн улиралтайгаа бид зохицож амьдрах, дасан зохицох, дээрээс нь даван туулах нөгөө ард иргэд, өвөг дээдсийн хэлдэг шиг урьдчилж мэдээд, тосож бэлдээд, тэсэж гаргадаг ийм цаг үед бас нөхцөл байдлуудаа сайн тооцохоос өөр аргагүй ийм бидний хүчин зүйл, өөрөөр хэлэх юм бол хүний хүчин зүйлээс үл хамаарсан байгалийн давагдашгүй хүчин зүйлүүд өөрсдөө биднийг бас сорьж байна. Тэгээд энэ сорилтод нь бид нар унаж болохгүй.

Таны хэлж байгаа бас зүйлүүдийг маш сайн ойлгож байна. Мэдээж анхаарах асуудлууд бий, салбарын хэмжээнд унхиа дорой байгаа зүйлүүд бий, өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлага бий. Энд сууж байгаа манай салбарынхан хүртэл яг одоо энэ бодлого шийдвэрийг гаргах процессыг гүйцэтгэдэг, хянадаг, зохион байгуулдаг нөхдүүд хүртэл анхаарах асуудлууд бий. Уламжлалт сэтгэлгээнээсээ салах ёстой.

Гэхдээ уламжлалт үүх түүх, үнэт зүйл энэ оршин тогтнохуйн суурь болсон мал аж ахуйн салбараа бид үгүйсгэж болохгүй. Энэний цаана малчид гэдэг асар том амьд өв сан, үнэт зүйл, үнэ цэн бий Монголын.

Тийм учраас хүссэн, хүсээгүй хүндрэлтэй үед нь Засгийн газар, Монгол төр тусламжийн гараа сунгаж хамтарч ажиллаж байгаа. Тэгээд энд бид нар нэг юмыг тодруулмаар байгаа юм. Жил бүрийн өвөлжилтийн бэлтгэл ажилд бол ярьдаг шалтгаан бүүр л тухай тухайн салбартай наад захын засвар, шинэчлэл, нөөц бүрдүүлэлтийг ингэж анхаарах асуудлууд байдаг юм.

Засгийн газар өвөлжилт, хаваржилтын асуудлыг урьдчилан сэргийлэх стратеги болгон цогцоор нь шийдвэрлэж хөгжүүлэх тал дээр нь шийдвэрлэх тал дээр нь анхаарч ажиллаж байгаа энэ олон бодлогыг бид нар бүгдээрээ л гаргаад явж байгаа. Тэгээд өчигдөр би Дарханд очихдоо тэр Шинэ хоршоо хөдөлгөөний 1 8гишүүнтэй уулзахад бүгдээрээ зээл, тусламжаа авчихсан, өвс тэжээлээ базаачихсан, энэ өвлийг өнтэй давна гээд жишээ нь Дархан-Уул аймгийн 18 хоршоологчид өөрсдийнх нь асуудлын шийдсэн ажил хэрэгч, бүтээлч байх боломжийг бүрдүүлсэн ийм хөтөлбөр болж байгаа гэдгээ хэлээд байж байхад бид тэрийг үгүйсгэх тийм боломж байхгүй. Үр дүнгээ өгч байна гэж үзэж байгаа. Гэхдээ энэ үр дүнг тодорхойлоход бас эрт байгаа.

Өвөлжилтийн бэлтгэл, санхүүжилтийн асуудлууд гээд бас Улсын Их Хурал, Засгийн газраас бидний өнөөдрийн төсөв, хөтөлбөртэй холбоотой асуудлууд ч хүртэл байж байгаа. Цаашдаа ер нь зүгээр бид энэ урт хугацааны стратеги бодлого төлөвлөлт жишээ нь, энэ малын асуудлууд, мал, хөдөө аж ахуй газар тариалангийн асуудлуудаа яах юм, үр дүнг нь яаж тооцох юм? Энэ малчдынхаа амьдрал ахуйтай холбоотой асуудал ялангуяа энэ эдийн засгийн гол тулгуур салбар болсон хөдөө аж ахуйн салбарын бодлого шийдвэрээ цогцоор нь ямар хэмжээнд цааш нь илүү оновчтой бөгөөд зүй зохистой төлөвлөж авч явах юм бэ гэдэг талаар Улсын Их Хурлын дээр бас дахиж нээлттэй ярилцах, хэлэлцэх асуудлууд нээлттэй гэж бодож байгаа.

**Х.Булгантуяа:** Цогтгэрэл гишүүн тодруулъя.

**О.Цогтгэрэл:** Тийм ээ би бараг 5 дахь жилдээ ч байна уу яг өвөлжилтийн бэлтгэл гээд бараг нэг форматын цаасыг 5 дахь жилдээ л уншиж байна л даа энэ чинь. Харин хамгийн гол нь тэр эрсдэлээс нь хамгаалах шалгарсан арга, механизмуудыг оруулах, энийг яаж өөрөө төр хамгаална гэхээсээ урьдаар өөрөө өөрснөө систем чинь өөрийгөө хамгаалдаг болгох тэр бодлогын өөрчлөлтүүд гэдэг юм чинь алга л даа. Яг л ийм хэдэн хуудас цаас орж ирнэ. Тэр сумд хэдэн тонн тэжээл бэлдчихсэн, тэгсэн чинь тэгсэн гэдэг ерөөсөө ийм эндээс ингэвэл бид нар яг л тэр нөгөө өвөл болохоор хүйтэн болдог гэдэг шиг бид нар угаасаа л энэ байгаа байгалийн нөхцөл байдал, энэ байгаа зүйлээ, нэгэнт ирэх цаг хугацааны энэ зүйлийг бид нар энийг чинь шийдэх гэж харин байгаа юм биш үү? Энд яагаад гол нь энэ олон жилд өөрчлөлт гардаггүй юм бэ гэдэг л. Ингээд л байвал бид нар ер нь ингээд 10 жил, 100 жилээр энийгээ л яриад сууж байх нь зөв гэж үзэв үү? Би энийг буруу л гэж бодож байна.

**Х.Булгантуяа:** Өвөлжилтийг бид нар ярихгүй бол болохгүй л дээ. Үнэхээр хүнд өвөлтэй нь үнэн. Өвөлжилтийн бэлтгэл, өнөөдрийн мэдээллээс хэд хэдэн хүмүүсийн яриад байгаа нь 80 хэдэн хувь, 90 хэдэн хувийн бэлтгэл хангасан гэж байгаа нь өнтэй сайхан өвөл ер нь бүх салбарт болох юм биш үү гэдэг мэдээлэл хийгээд байгаа юм биш үү л гэж л шүүмжлээд байх шиг байна зарим гишүүдээс.

Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

**М.Нарантуяа-Нара:** Тэгэхээр өвөл угаасаа манай Монгол Улс бас нэг талаараа дарван улиралтай байна гэдэг бас бурхны бэлэг юм уу. Өвөл угаасаа хүнд хэцүү болдог. Сүүлийн үед ялангуяа дэлхийн энэ цаг уурын өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор энэ өвөл нь яг ямар байх юм, зун нь ямар байх юм гээд ер нь тодорхойгүй байдлууд үүсдэг болсноос шалтгаалаад өвөлжилтийн бэлтгэлийг бас онцгой хангах нь зүйтэй.

Гэхдээ одоо ялангуяа Улаанбаатарын өвлийн асуудлын талаар зайлшгүй ярихгүй бол болохгүй ээ. Энэ дундаа утааны асуудал. Иргэд ингээд л өвлийн хүйтэнд жагсаад байна гээд л ингээд л шүүмжилж байгаа.

Гэвч яг үнэндээ иргэд бодит зовлон бэрхшээлтэйгээ тулаад ирэхээрээ энийг эсэргүүцэж байгаа юм. Аргагүй олон жил энэ утааны эсрэг арга хэмжээ гээд өчнөөн олон шоучдын энэ зохиомол жагсаалын золиос болсон иргэд одоо бүүр уур уцаартай болох нь аргагүй. Одоо тэр битгий хэл утааны асуудлыг бүр утааны хор хохирлыг үнэлээд, эрүүл мэндийн байгууллагууд, эмнэлгийн байгууллагууд, судалгааны байгууллагууд үнэлээд энэ хүний эрүүл мэнд, амь насанд ямар хор хөнөөлтэй болгож байна гэдгийг бүүр тодорхойлоод гаргаж ирж байна. Тухайлах юм бол энэ Нийгмийн эрүүл мэндийн судалгааны хүрээлэнгээс энэ утааны асуудал, энэ түлшний хор нь ургийн эрүүл мэндэд яаж нөлөөлж байгаагаар, ургийн жинд яаж нөлөөлж байгааг бүүр судлаад, батлаад гаргаад ирчихсэн байж байна.

Өөрөөр хэлбэл, энэ утаанаас болоод зүв зүгээр эхийн хэвлийд бойжиж байгаа энэ ураг хүртэл төрж гарч, мэндэлж ирэхдээ жингийн хомсдол ингээд орчихсон байгаа тухай мөн мэдээлж байна.

Дээрээс нь аутизм гэдэг зүйл 2014 онд 30 бүртгэл байсан бол 2023 онд 1700-г гартлаа бүртгэлтэй байгаа нь утаанаас үүдэлтэй гээд эрүүл мэндийн шат дараалсан байгууллагын судалгааны байгууллагууд бас хэлээд байна.

Тэгэхээр зэрэг энэ утаан дээр ямар асуудал, ямар ажлыг гол чиглэлээ болгох юм бэ? Түлшнийхээ чанар стандартыг үнэхээр хангаж, шалгаж, нягталж чадаж байгаа юм уу? Урд хөршөөс зарим нэгэн бодисыг илүү хямд үнээр нийлүүлж байгаа гэсэн ийм иргэдийн шум бас яваад байна. Энэ нь хэр үнэний ортой юм бэ? Бид нар үнэхээр дотооддоо үйлдвэрлэсэн, дотооддоо олборлосон, дотооддоо бий болгож байгаа энэ нүүрсээ түлж чадаад байна уу, эс үгүй бол гаднаас бас илүү хямд өртөг, үнийн дүнтэй юм худалдаж авч оруулж ирээд байгаа юм уу гэдэг юмыг яримаар байна.

Дээрээс нь бас энэ Нийслэл Улаанбаатарын хувьд халтиргаа гулгаандаа бэлдсэн юм уу? Тэгээд ажилтан, ажилчид нь улаан гараараа ингээд бээлий өмсөөд давсаа цацаад явдаг энэ байдал чинь энэ жилдээ ямар түвшинд явагдах юм бэ? Халтиргаа гулгаанаас үүдэлтэй эрүүл мэнд, амь насны хохирол, эд хогшлын хохирлыг бас барагдуулах ийм юм гэж ер нь байдаг уу? Тэгээд хүүхдийн өвчлөл хэрээс хэтэрнэ. Энэ хүүхдийн өвчлөл дээр ер нь яаж бэлтгэсэн эрүүл мэндийн салбар энэ одоо.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Нэлээн олон дарга нар хариулах нь байна шүү. Эхлээд Эрчим хүчний яамнаас хариулах уу Нийслэлээс хариулах уу? Нийслэл, Засаг

даргын орлогч Даваадалай Түлшний чанар, гулгаа, халтиргаа гээд хэд хэдэн асуудал Нийслэлээс, дараа нь Эрүүл мэндийн яам хариулахад бас бэлдэж байгаарай.

**Т.Даваадалай:** Нара гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Даваадалай.

Утааны асуудал дээр асуулт асуулаа. Ер нь утааны асуудлыг яах вэ сууриар нь шийдээд утааны асуудлыг сууриар нь шийдэх олон улсын жишиг нь орон сууцжуулалт гээд. Тэгээд бид нар эдгээр асуудлууд дээр бол та бүхний мэдэж байгаа Сэлбэ, 20 минутын хотыг байгуулахаар орон сууцжуулах хөтөлбөрүүдийг яаралтай холбогдох материалуудыг бэлдээд энэ өвөлдөө 12 мянган айлын орон сууц дээр төсөл, хөтөлбөрөө зарлаад явахаар байж байгаа.

Мөн орон сууцжуулалттай холбогдолтойгоор суурь дэд бүтцүүд болох дулаан, цахилгааны эс эх үүсвэрүүдийг шинээр хийх дээр Эрчим хүчний яам болон бусад яамнуудтай хамтраад судалгаа хийгээд явж байна.

Тэгэхээр утаан дээр бид нар ер нь уг үндсээр нь шийдэхийн тулд Улаанбаатар хотыг орон сууцжуулъя, суурь дэд бүтцүүд, инженерийн хангамжуудаа сайжруулъя гэдэг ийм үндсэн шийдэл рүү бодлогоо барьж явж байгаа. Мөн бас богино болон дунд хугацаандаа түлшийг хийн түлшээр орлуулах агаарын бохирдлыг дунд, богино хугацаанд бууруулах суурь судалгаануудыг одоо хийж байна.

Харин. Тавантолгой түлшний хувьд болохоор манай Тавантолгой түлшний газрын дарга удирдлагууд түлшний найрлага, чанар дээр тодорхой мэдээлэл өгөх байх. Ер нь бид нар Тавантолгой түлш дээр урт хугацаандаа бид нар сууриараа Улаанбаатар хотынхоо асуудлыг шийдэж байгаа учраас Тавантолгой түлшний үйлдвэрлэлийг цаашид жил бүр дараалаад бууруулах. Бид нар ер нь агаарын бохирдолгүй болъё, Улаанбаатар хотынхоо энэ агаарын бохирдлыг суурь дэд бүтцээр үндсээр нь шийдье гэдэг энэ цогц бодлого руу Нийслэлийн удирдлагууд бол чиглэл бариад явж байна.

Энэ дээр Тавантолгой түлшний удирдлагаас чанар, түвшин дээр нь мэдээлэл өгье. Мөн гулгаа болон энэ өвлийн бэлтгэл ажлын талаар Нийслэлийн Засаг даргын Захирагчийн алба, хотын инженерийн дэд бүтцийн албаны дарга Балдандорж даргаас тодорхой хариулт өгье.

**Х.Булгантуяа:** Хэд, аль бэ?

**А.Батзориг:** Сайн байцгаана уу? Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Таван толгой түлш компанийн Санхүү, эдийн Засгийн газрын дарга Батзориг байна.

Сайжруулсан шахмал түлш хэрэглээд бид нар 6 жил болж байна. Манай түлш бол ер нь яг нүүрсэн шахмал түлш байгаа. Тэгэхээр нүүрсийг Тавантолгойн ордын баяжуулсан нүүрсээр шахмал түлшний үндсэн түүхий эд хийгдээд явж байгаа.



Тэгэхээр ер нь түүхий нүүрс ч бай, Багануурын нүүрс ч бай Тавантолгойн нүүрсийг бид нар үндсэн түүхий эд болгож хэрэглэж байгаа гэсэн үг.

Тийм учраас нүүрсэнд агуулагдаж байгаа угаарын хий болон бусад нүүрсэнд агуулагддаг элементүүд, мөн энэ Тавантолгойгоос бид нарын татаж авчирч ирж байгаа мидлинг-д байгаа. Тийм учраас бид нар 6 жилийн хугацаанд угаарын хийг мэдрэгчийг айл бүрд тавьж байна, мэдээлэл судалгаа нэлээн түгээж байна айл өрхүүдэд, бүүр янданг хүртэл хөөлөх ийм ийм арга хэлбэрүүдийг бас хэрэгжүүлээд явж байгаа.

Ингээд ер нь бол чанарын тухайд бол яг стандартын түвшинд үйл ажиллагаагаа явуулж байгаа. Барьцуулагч гэж нийт бүтээгдэхүүний 5 хувьд нь барьцуулагч ордог. Барьцуулагч маань ямар бүтээгдэхүүн гэхээр 50-60 хувийн байгалийн буюу ургамлын цардуул байгаа, эрдэнэ шишийн. Үлдсэн 40 хувьд нь байгалийн бентонит, шохойн чулуу, доломит болон каулин гэсэн ийм шаварлаг бодисууд, байгалийн бүтээгдэхүүнүүд байдаг. Ингээд энэ барьцалдуулагчийн орц нь ийм найрлагатай байгаа.

Энэ бол яг стандартаар энэ дагуу түлшээ үйлдвэрлээд явж байгаа. Манай түлшний стандарт 5679 MNS 2022 гэсэн стандартын дагуу үйлдвэрлээд явж байгаа. 2019 онд ямар стандарттай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан яг өнөөдөр мөн яг энэ стандартынхаа дагуу үйлдвэрлээд явж байгаа.

Манай түлшний хяналтад их олон байгууллага, газрууд хяналт тавьж байдаг. Олон улсын болон дотоодын аж ахуйн лабораториуд байнгын хяналт тавиад явж байдаг ийм үед байдаг юм.

**Х.Булгантуяа:** Халтиргаа гулгаатай холбоотой асуулт. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албан инженерийн дэд бүтцийн газрын дарга Балдандорж. Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулт хийе.

**М.Балдандорж:** Ер нь энэ хот нийтийн аж ахуй, ялангуяа энэ цэвэрлэгээ, үйлчилгээ, нийтийн эзэмшлийн зам талбайн энэ халтиргаа, гулгаатай холбоотой асуудал нэлээн бас олон нийтийн бухимдал дагуулж байгаа. Бас дан ганц цэвэрлэгээ, үйлчилгээ дээрээ бид нар бас анхаарахаас гадна энэ салбарын тогтолцоо, салбарын чадавх гэдэг юман дээр бас нэлээд түлхүү анхаарахгүй бол бас болохгүй байгаа. Ер нь Улаанбаатар хотын хэмжээнд бол 16.70 сая м2 ер нь зам талбай, 1000 гаран километр явган замыг ер нь хот нийтийн аж ахуйн болон энэ хувийн хэвшлийн байгууллагууд цэвэрлэгээ, үйлчилгээг нь хариуцаж байж байгаа. Энэ нийтдээ 35 байгууллага, 2000 орчим зам талбай үйлчлэгч нар ажиллаж байгаа.

Гэхдээ өнөөдрийн тулгамдаад байгаа асуудал юу хийж байна вэ гэхээр бид нар энэ яг үндсэн зам талбайдаа хүрч байна уу, хүртээмжийн асуудал нь яг болж байна уу гэдэг ганц давс бодисын нөөцийг бэлдсэнээрээ бас энэ шийдэгдэж байна уу гэдэг асуудлыг сая нэлээн сүүлийн олон жилийн хугацаанд бас энд үр дүнтэй ажил бас биш юм. Бид нар ер нь салбарын хэмжээнд энэ үндсэн энэ 2000 хүний ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, дээр нь энэ тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх хүрээнд бол энэ 2024 онд 110 орчим техник хэрэгсэл, 80 орчим энэ гар багаж үлээдэг энэ зам талбайн, явган зам дээр ажилладаг багаж тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн.

Дээр нь энэ Засгийн газрын 340 дүгээр тогтоолоор энэ Улаанбаатарт бол гол болон төв зам дээр 60 орчим хувийг нь орон нутгийн өмчит, нийслэлийн өмчит байгууллага хийдэг байсан бол энийг хувийн хэвшлийн байгууллагуудаар нь хийлгэх, 80 орчим хувийг нь шилжүүлэх, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ийм ажлыг зохион байгуулаад ажиллаж байна.

Энэ дээр хамгийн гол цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах энэ ажил ер нь олон салбар дээр бас тулгарч байгаа. Үйлчилгээний, нэг давхрын үйлчилгээ буюу энэ аж ахуйн нэгж байгууллагуудын 50 метр орчмын талбайг цэвэрлүүлэх, дээр нь СӨХ орчмын байрны гаднах зам талбайг нь цэвэршүүлж хэвшүүлэх. Ингээд хариуцлагын асуудлууд бас нэлээн байгаад байгаа болохоор энэ дээр бол зохион байгуулалтын арга хэмжээ авч байна.

Ер нь саяын энэ жилийн давс, бодисын нөөц бодисын хувьд бол одоо 6572 тонн давс, 5117 тонн бодис нөөцөлчихсөн байна. Энэ нь бол өнгөрсөн оныхоос 2 дахин илүү хэмжээгээр нөөцлөгдсөн байна. Дээр нь дахиад 1500 тонн бодисыг бол нэмэгдүүлж байна 10 сарын 12 сарын 10-нд татан авалт хийж нийлүүлэгдэхээр төлөвлөж байна. Энэ нь бодисыг бол Иргэний нисэхийн энэ илүү их чанартай, өндөр ач холбогдолтой энэ бодисоор нэмэгдүүлэх ийм хэмжээнд бас ажиллаж байгаа.

Эрүүл мэндийн яамнаас хариулах уу өвчлөлтэй холбоотой? 1 дүгээр номерын микрофон дээрээс.

**П.Оюунцэцэг:** Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн салбарын хүрээнд бол яг энэ ял өвөлжилтийн хүрээнд хамгийн их тархдаг өвчин бол амьсгалын тогтолцооны өвчин. Тэр дундаа бол томуу, томуу төст өвчин тохиолдлын тоо байгаа.

Тэгэхээр хүүхдүүдийн дунд бол томуу, томуу төст өвчин хүндрэл бол нэлээн гардаг, эмнэлгийн орны ачаалал бас нэлээн өндөр байдаг олон жилийн бас ийм туршлага сургамжууд байгаа. Энэ жилийн хугацаанд бол бид нар энэ эмнэлгийн орны ачааллыг бодит цагийн, ачааллын мэдээллийг бол бодит цагийн горимоор Эрүүл мэндийн яаман дээрээ бол бас өдөр болгон авдаг болсон. Аль дүүрэг дээр, аль аймагт орны ачаалал хэтрэхээр байгааг бол бодит цагийн горимоор хянаад явж байна. Энэнтэйгээ холбоотойгоор эмнэлгүүдийн орны ачаалал одоохондоо бол бас орны ачаалал хэтэрсэн ийм статистик тооцоо байхгүй. Тэгэхдээ энэнтэйгээ холбоотойгоор ор нэмэгдүүлэх төлөвлөгөө, түүнийг дагаж гарах эмнэлгийн ажилчдын нөөц төлөвлөлтүүдийг бол хийгээд ажиллаж байна.

Мөн түүнчлэн энэ эмнэлэгт хэвтэх шаардлагагүйгээр томуу, томуу төст өвчний учраас ӨЭМТ-дөө хандаж хөнгөн хэлбэрийн томуу, томуу төст өвчин үед бол бас ӨЭМТ-үүдээс гэрээрээ эмчлэгдэх боломж бүхий энэ эмийн багцуудыг бол бас олгох үйл ажиллагаа бол эхлээд явж байна.

Энэ жилийн хувьд бол бид нар бас томуугийн вакцины асуудлыг бол маш эрт эхлүүлсэн байгаа. Өнөөдөр бол вакцинжуулалтын хамрагдалт ерөнхийдөө 90 гаруй хувьтай бол явж байгаа гэсэн ийм юм мэдээд байна. Одоогоор яг амбулаторийн түвшинд бол амбулаторийн үзлэгт томуу, томуу төст өвчин маань бол 7.8 хувийг эзэлж байна. Тэгэхээр бол яг амбулатори болон стесо нарын

түвшинд бол ба яг өвөлжилтийн бэлтгэлд хамгийн их нөлөөлөл үзүүлдэг энэ томуу, томуу төст өвчин өвчлөл бол бас яг хяналтын түвшинд байна гэж үзэж болно.

Эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээллийг бас бид нар эрүүл мэндийн байгууллагуудаасаа бас бодит цагийн горимоор цахимаар бол бас хянаад явж байна. Эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хувьд бол ихэнх эмүүд 26 хоногийн нөөцтэй эмч байна цөөхөн эм дээр байна. Дийлэнх эмүүд бол 3 сараас дээш хоногийн нөөцтэйгөөр байгаа гэсэн ийм мэдээлэлтэй байна.

**Х.Булгантуяа:** Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

**М.Нарантуяа-Нара:** Тэгэхээр утааг сууриар нь шийдэхийг бол ойлгож байна. Угаасаа ингэж байж л бүрэн шийднэ.

Гэхдээ энэ жилийн хувьд 12 мянган өрхийг орон сууцжуулна, нийт Нийслэл Улаанбаатарын хэмжээнд хэдэн айл өрх орон сууцгүй гэр хорооллын бүсэд амьдарч байгаа юм бэ? Энэ утааг сууриар нь шийдэх хүртэл хэд хэдэн жил бид нар энэ утаатай байх юм бэ?

Хоёрдугаарт, одоо энэ ба барьцалдуулагч 50 хувь, 5 хувийн барьцалдуулагчийг оруулдаг гээд ингэж байна. Энэ Тавантолгой түлш энэ Монголын Улаанбаатарын ард иргэдэд нийлүүлж байгаа энэ шахмал түлшинд гадаадаас ямар нэгэн бодис худалдан авч ирээд нийлүүлж байгаа ийм зүйл байна уу гэдгийг асуусан. Энэ дээр би тодорхой хариулт авмаар байна.

Тэгээд энэ Нийслэл дээр болохоор энэ халтиргаа гулгааг нь аж ахуйн нэгжээр талбай, өөрсдийнхөө харах хүрээнд 50-100 м орчимд газар, талбайгаа цэвэрлэдэг, үйлчлүүлэгчдээ бодоод нийгмийн хариуцлагын хүрээнд цэвэрлэж, бэлтгүүлдэг ийм байдлыг Нийслэлээс давхар арга хэмжээ авах хэрэгтэй.

**Х.Булгантуяа:** Санал хэллээ тээ Нара гишүүн? Утаатай холбоотой тодруулах асуулт Нийслэлээс хэн хариулах вэ? Гараа өргөчхөөрэй микрофоныг чинь нээх. Албан тушаалаа протокол дээр үйлдэх учраас хэлэх ёстой шүү. Тэгээд албан тушаалаа хэлээрэй.

**А.Батзориг:** Барьцалдуулагчтай холбоотой асуулт асуулаа.

“Тавантолгой түлш” компанийн Санхүү эдийн Засгийн газрын дарга Батзориг. Нарантуяа гишүүний асуултад хариулъя.

Барьцалдуулагч 2019-өөс, байгуулагдсан цагаасаа 2022 он хүртэл бид нар дандаа импортоор буюу Хятад Ард Улсаас барьцалдуулагч бид хэрэглэж байсан. 2022 оноос дотоодын барьцалдуулагчийг 40 хувь, 50 хувьтай болгоод явж байгаа. Ер нь цаашдаа бид нар дотоодоосоо барьцалдуулагчаа аваад үйл ажиллагаандаа хэрэгжүүлээд явна гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа.

**Х.Булгантуяа:** Даваадалай дарга.

**Т.Даваадалай:** Нара гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Даваадалай байна.

Нийслэлийн Засаг даргын 2024-28 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр бас батлагдсан. Үүнтэй холбогдолтойгоор энд ирэх 4 жил Сэлбэ, Шар хадны төвүүд дээр ойролцоогоор 20 мянган айлын орон сууцжих хөтөлбөр хийнэ гээд бас тодорхой тусгасан байж байгаа. Одоогийн байдлаар Улаанбаатар хотод 200-аад мянган гэр хороолол дээр өрх, яндан байж байгаа. Тэгэхээр үүнийг ерөнхийдөө 4 жилийн хугацаанд бид нар яг тодорхой 20 мянган айлын орон сууцыг барьж байгуулаад орон сууц хөтөлбөр рүү явна гэж ингээд мөрийн хөтөлбөртөө тусгаад, төлөвлөлтүүдийг, холбогдох бичиг баримтуудыг цэгцлээд, хөрөнгө оруулалтыг шийдээд явж байгаа гэж ойлгож болно.

**Х.Булгантуяа:** Хариулт болсон уу? Тэгээрэй нэмэлт тодруулга байхгүй юм байна шүү. Манай энэ гишүүдээс гарч байгаа асуултуудыг та бүхэн сайн бичиж авч байгаад аягүй тоймтой хариулмаар байх юм. Аягүй тоймтой уг нь их олон асуулт асуусан шүү дээ.

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Бүгдэд нь оройн мэнд.

Энэ өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотойгоор энэ өвсний нөөцийн талаар бас жоохон тодруулга мэдээлэл авах гэсэн юм. Өвсний нөөцийг улсын нөөц, эсвэл аймгийн нөөц, сумын нөөц гээд бэлддэг байх. Гэхдээ сумаасаа цааш нь эрсдэлтэй бүлгүүдэд хүргэх шинэ арга, технологи гэдэг юм уу өнгөрсөн өвлийн энэ хүндрэл, бэрхшээл дээр үндэслээд авч байгаа шинээр хэрэгжүүлэх бодлого арга, төлөвлөгөө гэж байна уу? Жишээлэх юм бол, энэ өнгөрсөн жил Архангай аймгийн Эрдэнэмандал суманд яг урд талд нь 14-хөн километрийн цаана сум харагдаад байдаг малчин цасанд боогдоод явж чадахгүй байж байгаад 500 гаруй хоньтой айл хот нь харлаад хоцорсон ийм жишээ байгаа юм. Сумаасаа ч хойшоо айл нь харагдана, урагшаа айлаасаа сум нь харагдана. Өвс тэжээл хүргэж чадахгүй байж байгаад ингээд ийм эрсдэл үүсчихсэн. Энэ дээр шинэ гаргаж байгаа бодлого, төлөвлөгөө байгаа юу гэж.

Хоёрдугаарт уг нь бол энэ улс төржилт биш. Гэхдээ яг бодит байдал нь орон нутгийн сонгууль болоод дуусаад сар гаруй хугацаа өнгөрчихсэн. Жишээлэхэд Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга томилогдоогүй, өнгөрсөн жил өвсний нөөцийн нөөц бүрдүүлэлттэй холбоотой 80 гаран сая төгрөг тавьсан. Энэ онд 9 сарын 20-д гэхэд Баянхонгор аймгийн Галуут суманд цас ороод 20, 30см цас ороод эхэлсэн. Сүүлд дахиад нэмээд цас орчихсон, энэ оторт гараад эхэлчихсэн байгаа. Тэгээд энэ сумын Засаг даргаас нь энэ өвөлжилттэй холбоотой өвс тэжээл бэлдсэнтэй холбоотой асуудал байна уу гэхээр байдаггүй. Очсон жоохон өвсийг нь хувьдаа дарж хэвтсээр байгаад гаргаад ирсэн чинь өвс нь бүр мод болчихсон хэн ч хэрэглэхээргүй болчихсон байгаа юм. Тэгээд энэ асуудал дээр ямар арга хэмжээ авах вэ? Өнөөдрийн байдлаар Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга томилогдоогүй, өвөлжилт нь тэнчээ хүндэрчихсэн зудын хэмжээнд оччихсон байгаа. Энэ дээр бас тодорхой хариулт байна уу гэж байгаа юм.

Гуравдугаарт нь энэ Нийслэлийн утаатай холбоотой. Энэ даамжраад бүүр аймгууд руугаа орж байгаа. Бага насны хүүхдүүдтэй залуу гэр бүлүүдэд жил болгон нэг асуудал тулгардаг нь өвөл болохоор ханиадны асуудал тулгардаг. Манай хүүхдүүд бүүр амьдаараа туршилт болж дууслаа. Эрүүл мэндийн яаман

дээр жишээлэхэд энэ хүүхдүүд ханиад хүрэхгүйгээр яаж өвлийг давах тийм төлөвлөгөө ч юм уу, тийм боломж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар бодлого, арга тактик байдаг уу гээд ийм 3 асуулт байна.

**Х.Булгантуяа:** Эхлээд Шадар сайд хариулах уу? Тэгчхээд Баярхүү дарга тэгээд Эрүүл мэндийн яам.

**С.Амарсайхан:** Одоо аймаг орон нутагт улс орон даяар сонгууль, улс төрийн ажил хууль журмын хүрээнд яваад дууссан. Тэгэхээр ямар нэгэн байдлаар хууль зөрчиж томилгоо хийхгүй байх, тэгээд аймаг орон нутгийн засаг захиргааг удирдлагагүй байх эрх асуудал хэнд ч байхгүй.

Тийм учраас энэ асуудал дээр хаана хаанаа анхаарч бас ажиллах ёстой. Аймгийн Засаг дарга холбогдох хүмүүсээс нь бид тодруулж бас зохих арга хэмжээнүүдийг авах тал дээр анхааръя нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол мэдээж энэ зам харгуйтай холбоотой хүндрэлтэй нөхцөл байдлууд үүсдэг. Тэгээд тэр бүхэнд аймаг, орон нутаг өөрөө хүч нөөц бололцоо нь бас хүрдэггүй учраас өнгөрсөн жил бид улсын хэмжээнд бүх машин техник, механизмыг тэр битгий хэл төрийн цэргийн байгууллага зэвсэгт хүчний алба хаагчдаа, онцгойгийнхоо алба хаагч дээр хүртэл, нэмж хилийн цэргийнхэн гээд асар олон чиглэлд зам гаргасан. Нийтдээ 200 гаруй мянган км зам гаргасан гэж та бүхэн тухайн үед сонсож байсан байх. Энэ бас бага тоо биш. Тэгээд сая Цогтбаатар гишүүний хэлдэг бол бас үнэн. Тэгээд зам хаагдаж, өвс тэжээлээ авч чадахгүй байсаар байгаад мал нь хорогддог, тэр битгий хэл эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ ч авдаггүй ийм асуудал байгаа.

Тэгэхээр сая түрүүн би хэлсэнчлэн аймаг, орон нутагт шуурхай бүлгүүд гараад ажиллаж байгаа. Энэ бол тэр саяын ярьсан бүх асуудлуудад газар дээр нь үнэлэлт, дүгнэлт хийж дахиж зохион байгуулалтыг хангах тал дээр анхаарах асуудлууд байвал бид шуурхайд арга хэмжээ авч ажиллана. Улсын онцгой комиссын дэргэдэх шуурхай штаб 24 цагаар аймаг, орон нутгийн штабууд ажиллаж байгаа. Тэгээд эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудал бусад энэ асуулт дээр Баярхүү дарга Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн яамныхан нь хариулаад явчих нь зөв байх.

**Х.Булгантуяа:** Баярхүү дарга Улсын онцгой комисс.

**Т.Бархүү:** Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Баярхүү. Цогтбаатар гишүүний асуултад хариульъя.

Ер нь бол энэ өвс тэжээлийн нөөцтэй холбогдуулж сумдын аюулгүй нөөц, аймгийн аюулгүй нөөцийн өвс тэжээлийн хэмжээ, хадгалах тухай, түүнтэй холбоотой тересс-үүдийг тухайн аймаг, орон нутгийн удирдлагууд шийдвэрлээд явдаг. Мөн улсын нөөцийн цэгүүд дээр бол энэ өвс тэжээлтэй холбоотой бас хадгалах агуулахуудад ингээд хадгалдаг байгаа.

Ер нь улсын нөөц дээр бол энэ өвс тэжээлийг эрсдэлтэй, ялангуяа энэ зам даваа хаагддаг, хүрч очиход бэрхшээлтэй ийм цэгүүдэд аль болох байршуулж, төвлөрүүлж хадгалахыг зорьж ажиллаж байгаа. Ер нь бол энэ өнгөрсөн жилийн өвөл, энэ сүүлийн жилүүдэд гарч байгаа энэ хүндрэл бэрхшээлтэй холбоотойгоор

сүүлийн жилүүдэд сумын фонд буюу сумын төв дээр энэ өвс тэжээлийн нөөцийг бэлтгэж хадгалдаг байсан сумууд тараан байршуулах замаар буюу багийн төвүүд дээр эрсдэлтэй, өндөр даваа гүвээтэй ийм эрсдэлтэй цэгүүд дээр хадгалж ингэж эхэлж байгаа ер нь хадгалаад явж байгаа.

Гол асуудал нь бол яг энэ өвс тэжээлтэй холбоотой агуулах, хадгалалтын асуудлууд байдаг учраас энэ дээр бол сум, орон нутаг дээр нэлээн хүндрэлтэй асуудлууд үүсэж байгаа гэдгийг хэлье.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн биш, Эрүүл мэндийн яамнаас нэмж хариулна. 1 номерын микрофон.

**П.Оюунцэцэг:** Баярлалаа. Ерөнхийдөө энэ ханиад томуунаас сэргийлэх өвөрмөц болон өвөрмөц бус урьдчилан сэргийлэх арга гэж байна. Би энэ түрүүн ярьсан өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн арга дээр бол вакцины урьдчилан сэргийлэх арга байна. Түрүүн би томуугийн вакцины хамралтын талаар бас ярьсан.

Өвөрмөц бус, урьдчилан сэргийлэлтээр, харьцангуй бага зардлаар хамгийн энгийн арга амны хаалт зүүх асуудал. Тэгэхээр бид нар бол бас энэ энэ чиглэлээр иргэдэд бас нэлээн их эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийж явдаг. Одоо бид нар ч гэсэндээ энэ томуу, томуу төст өвчин энэ дэгдэлтийн урьдал үе, дэгдэлтийн үед бол энэ амны хаалт зүүх асуудлаар бол бас эрүүл мэндийн байгууллагууд болон бусад аж ахуйн нэгжүүд дээр уриалга, дээрээс нь хяналтуудыг хийгээд явж байна.

Тэгэхээр өөрсдөөсөө эрүүл мэндийн салбараасаа эхлээд үлгэрлэж энэ амны хаалтыг хэрвээ өвдсөн л бол заавал хэрэглэдэг байхаар, өвдөхөөсөө урьдчилан сэргийлээд хэрэглэдэг байх энэ арга бол хамгийн чухал.

Түүнээс гадна мэдээж бас биеийн бие махбодынхоо дархлааг сайжруулах асуудал. Гэхдээ энэ агаарын бохирдлын энэ хэмжээ, энэ агаарын бохирдлоос үүдэлтэйгээр бол бас өвлийн улирал дээр хүн болгоны дархлаа сулрах энэ асуудал нэлээн өргөн тархацтай, өргөн байдаг. Тэгэхээр энэ чиглэлээрээ бол бас хувь хүн өөрөө бол бас энэ биеийн дархлаагаа сайжруулах, шим тэжээлтэй хоол унд идэх асуудал бас мэдээж яригдана. Тэгэхээр өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн ийм аргууд бол дэлхий нийтэд шалгарсан ийм аргууд байгаа.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал.

**Ж.Золжаргал:** Түрүүн нөгөө өвлийн шатахууны нөөцийн талаар Эрдэнэболд гишүүн асууна лээ. Тэгээд хариулт өгчихсөн учраас би энэ дээр зүгээр санал хэлье гэж бодож байна.

Мэдэж шатахуун хангамжийн эх үүсвэр, байнгын эх үүсвэр олшруулах нэг тусдаа асуудал байгаа.

Хоёрдугаарт нь яг тухайн үед, богино хугацаанд илүү өндөр үнээр ч хамаагүй нийлүүлэх тийм нөөц хувилбарууд гэж юм байх ёстой. Онцгой байдал, манай мэргэжлийн байгууллагууд мэдээж янз бүрийн сценариуд боддог л байх. Тэгэхээр тэр хувилбарууд дээрээ тийм гэнэтийн тохиолдолд яаралтай нийлүүлэх

эх үүсвэрүүд тусгасан байдаг юм болов уу? Хэрвээ яагаагүй бол тэр хувилбаруудыг тооцоосой гэж ингэж хэлмээр байгаа юм.

Өнгөрсөн жилийн зуднаар уул уурхайн компаниуд их сайн ажилласан. Хөдөө гадаа явж байхад зам мам боогдчихдог, тэгээд л хэдийгээр тэд нар чинь үүрэг хүлээгээгүй ч гэсэн Монгол хүн байна бас зуд турхнаар яана, зам нээнэ, малчдадаа тусална. Тэгэхээр тэр үйл ажиллагааг бас хувилбарт сценариудаа оруулаад ямар хэмжээнд, яаж ажиллаж болох вэ? Магадгүй дараа нь нөхөн тооцоотой түүгээрээ татвартай холбодог ч юм уу иймэрхүү механизм байх ёстой юм болов уу гэсэн ийм санал байна.

Тэгээд 2 асуулт байна. Энэ танилцуулга дээр байгаа өвс тэжээлийн бэлтгэл гээд. Тэгээд өвс тэжээлийн бэлтгэл дээр зарим аймаг 20 гаруй хувьтай, зарим нь 50 хувьтай байгаа, нөгөө аюулгүй нөөц. Баян-Өлгий, Завхан, магадгүй энэ баруун тийшээ ган гачиг энэ тэр гээд 20 гаруй хувьтай байдаг биз. Одоо энэ дээр Хөвсгөл аймаг, Хэнтий аймаг гээд 50 хэдэн хувьтай байгаа байхгүй юу. Төв аймаг.

Тэгэхээр чинь энэ чинь бас өвс тэжээлтэй газар шүү дээ. Яагаад ийм бага байгаа юм бол асуулт? Энэ бодвол байгалийн бус шалтгаанаас болсон бол хариуцлага тооцдог л байлгүй. Энэ дээр хариуцлага тооцсон юм байна уу гэж?

Хоёрт нь Эрчим хүчний сайд 131 тэрбум төгрөгийн татаасыг ингээд тушаалаар батлаад, санхүүгийн дэмжлэг олгосон гээд байгаа юм. Нүүрсний аюулгүй нөөц гэх мэтчилэн. Тэгээд энэ дотор тарифын алдагдал бууруулах гэж нэг хэсэг байгаа. Тарифын алдагдал бууруулах дээр хэчнээн төгрөг зарцуулагдаж байгаа юм? Тэгээд тариф нь сая нөгөө үнэ тариф өөрчлөгдөхийн өмнөх тарифаар тооцогдчихов уу, дараагаар нь нэгдчих үү? Тэгэхээр дараагаар нь нэгдэхэд энэ чинь дахиад өөрчлөгдөх юм болох нь уу, үгүй юү? Нөгөө өвлийн халаалтын хөнгөлөлтөө хамарч чадаж байгаа юм болов уу ийм 2 асуулт байна.

**Х.Булгантуяа:** Эхлээд Чойжилсүрэн сайд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Сая улсын төсвийн 2024 оны тодотголоор 131 тэрбум төгрөгөөр эрчим хүчний сайдын урсгал зардал дээр 131 тэрбум төгрөг нэмэгдүүлж Улсын Их Хурлын баталж өгсөн. Энэ хөрөнгийн эх үүсвэрийг бид нар эрчим хүчний сайдаар зорилтот түвшин батлуулдаг, бизнес төлөвлөгөө батлуулдаг 27 аж ахуйн нэгжүүд дээр сая таны уншсан зориулалтын дагуу хуваарилсан байгаа. Сайдын тушаал гаргаж хуваарилж байгаа юм. Энэ бол 2024 онд дагаад дуусна гэсэн үг. 25 ондоо бол дараагийн төсөв эцэслэн батлагдахаар яригдана нэг.

Тарифын өөрчлөлт бол 2024 оны 11 сарын 15-аас цахилгааны эрчим хүчний үнийг Эрчим хүчний зохицуулах хорооноос өөрчилсөн. Улаанбаатар хотын дулааны тухайд бол 2025 оны 5 сарын 16-аас эхэлж мөрдөгдөхөөр ийм шийдвэрүүд гарчхаж байгаа юм.

Тэгэхлээр бид нар бол энэ тарифын алдаа, таны асуултыг бас бүрэн ойлгосонгүй. Бид нар эрчим хүчний салбар маань 2024, 23 гээд бусад урьд жилүүд дээр алдагдалтай ажилласаар байгаад, алдагдалтай ажилласан энэ алдагдал маань өр төлбөр болоод хувирчихсан 379 орчим тэрбум төгрөгийн өр төлбөртэй

23 оны төгсгөлөөр. 24 ондоо 218 тэрбум төгрөг гээд. Эдгээр алдагдлын нэг хэсгийг нь бид нар багасгаж энэ өвлийг даван туулахад өвөлжилтийн бэлтгэлд зориулж 131 тэрбум төгрөгийг холбогдох төрийн өмчит компаниудад шилжүүлсэн байгаа.

**Х.Булгантуяа:** Шадар сайд Амарсайхан нэмж хариулах уу? Түлштэй холбоотой бас асуусан.

**С.Амарсайхан:** Түлш бол түрүүн хэлсэн Уул уурхай, эрдэс баялаг, аж үйлдвэрийн яаман дээр импортлогч ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн нөөц бүрдүүлдэг, улсын хэмжээнд бас улсын нөөц бий. Шаардлагатай үед зохицуулалтыг хийдэг. Жишээ нь, өнгөрсөн өвөл энэ Багануурын уурхайгаас эхлээд түлш, бензин шатахуун тасарсан, аймаг орон нутгуудад хүртэл хүндрэлтэй байхад улсын нөөцөөс бид тодорхой зохицуулалтыг гаргаж бас зохицуулалт хийж байсан ийм тохиолдлууд бий. Энэ жил ч гэсэн бас энэ чиглэлээрээ холбогдох байгууллагууд уялдаа холбоогоо хангах зохион байгуулалтаа хийж ажиллаж байгаа.

Гэхдээ хэчнээн нөөц бүрдүүлээд хэрэгцээ шаардлага бас цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалаад хаанаа ч хүрэхгүй байх ийм эрсдэлүүд өндөр бий. Тийм учраас улсын хэмжээнд нөөцийн савыг бүрдүүлэх, ялангуяа аж ахуйн нэгжүүдтэй хамтарч төр, хувийн хэвшлийн чиглэлээр улсын хэмжээний шатах, тослох материалын нөөцийг бүрдүүлэх зайлшгүй шаардлага байгаа учраас бас энэ ажлууд яаман дээр зохион байгуулагдаж бас хариуцаад явж байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол сая энэ өвс тэжээлийн хангалт, нийлүүлэлттэй холбоотой асуудал ярилаа. Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоол бий. Энэ тогтоолын дагуу аймаг, орон нутгийн удирдлагууд сум, орон нутагтаа аюулгүй нөөцөө бүрдүүлэх ёстой.

Тэгвэл өнөөдрийн байдлаар нийт аюулгүй нөөцийн бүрдүүлэлт 75.4 хувьтай байна. Гэхдээ сая Золжаргал гишүүний хэлдэг шиг зарим нэг бүрдүүлэлт нь дутуу байгаа аймаг орон нутаг бий. Тэгээд энэ бас яагаад ингэдэг вэ гэхээр энэ хөдөө аж ахуйн салбарт ялангуяа энэ өвс тэжээл ханган нийлүүлэлттэй холбоотой асуудал, өвсний гарц бага, ургамлын гарц муу байсан, гантай байсан газруудад нөхөн бүрдүүлэлтийг хийхдээ тендер сонгон шалгаруулалт, тээвэрлэлт, худалдан авалт гэх мэт шалтгаануудаар удааширдаг зүйлүүд байгаа. Мөн энэ алслагдсан аймгуудад тээвэр төрийн асуудал байдаг. Тэгэхээр нөгөө татан авах хугацаа бас тодорхой хугацаагаар хойшилдог, бүрдүүлэлт дутуу байдаг ийм асуудал байгаа. Энэ асуудал дээр анхаарч цаг алдалгүй аюулгүй нөөцөө бүрдүүл гэдэг ийм даалгавар, чиглэлүүд нь өгөгдөөд бас тодорхой түвшинд хянагдаад явж байгаа.

Ер нь энэ оны байдлаар, 11 сарын байдлаар бол улсын хэмжээнд нийт малчид бол 1.2 сая тонны ийм хадлан бэлдэж авсан байгаа юм. Дээрээс нь 91 мянган тонн ногоон тэжээл, 59 мянган тонн үйлдвэрийн тэжээл, гар тэжээл 49 мянган тонн ч гэдэг юм уу ингээд нийтдээ бол малчид өөрсдөө бэлтгэвэл зохих ёстой өвс тэжээл, хужир шүү, тэгээд дарш ургамлууд бол нийтдээ 96 хувийн ийм гүйцэтгэлтэй байна гэсэн дүн гарсан байгаа юм.

Тэгээд орон нутагт малчид маань энэ холбогдох тогтоол, шийдвэр, дүрэм, журмын дагуу өөрсдөө хангалт нийлүүлэлтээ хийж, татан авалтуудаа хийгээд явж



байгаа. Гэхдээ сум, аймгийн нөөцийг бид бүрдүүлэх тал дээр хяналтууд нь цаашаа нь хийгдээд явна.

Бусад асуудал дээр Баярхүү дарга хариулаад явчихъя.

**С.Амарсайхан:** Нэмээд хаанаас хариулах вэ ажлын хэсэг? Баярхүү дарга.

**Т.Баярхүү:** Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн өвлийн тухайд бас яг шатахуунтай холбоотой нэлээн хүндрэлүүд үүссэн. Тухайн үед бид тухайн үеийн Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар болон энэ шатахуун, газрын тосны бүтээгдэхүүн экспортлогч, импортлогч компани, аж ахуйн нэгжүүдтэй хамтран тухайн үед нь бол бас зохицуулалтыг хийж ажиллаж байсан. Тухайн үед энэ нэлээн хүндрэлтэй асуудлууд яг энэ өөр шаардлагатай эх үүсвэрээс анхны авч байсан эх үүсвэрээс, өөр эх үүсвэрүүдээс авах үед энэ тээвэрлэлттэй холбоотой түүнийг дагасан дэд бүтэцтэй холбоотой нэлээн хүндрэлүүд энэ дээр хугацаа алдаж байгаа хугацаа маань энэ Улаанбаатар хот гэдэг юм уу, томоохон суурин газруудад эргээд хэрэглээг дээрээ бас нэлээн асуудал үүсэх ийм асуудлууд тухайн үед тулгамдаж байсан.

Мөн Шадар сайд түрүүн хэллээ Улсын нөөцөөс бид нар ялангуяа стратегийн ач холбогдолтой салбарууд буюу энэ уул уурхай, эрчим хүч, мөн зарим аймаг, сумдын онцгой албаны салбарууд, эрүүл мэнд, цагдаа, онцгой гэх мэтийн энэ шаардлагатай байгууллагуудад тухайн үед нь бол нөөц зохицуулалтуудыг ингээд хийгээд явсан.

Энэ жилийн тухайд мөн Улсын онцгой комиссын даргын тушаалаар холбогдох албаны төлөөлөлөөс бүрдсэн Улсын онцгой комиссын шуурхай штаб үүрэг гүйцэтгэж байгаа. Энэ чиглэлд мөн холбогдох зохицуулалтуудыг хийж ажиллана.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан.

**Д.Жаргалсайхан:** Та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе.

Энэ өвөлжилтийн бэлтгэл ажил хангана гэдэг бол Монгол Улсын хэмжээнд л том ажил. Ер нь бидний хувьд бас энэ жил юу хийсэн юм бэ гэдгээ бас үнэлдэг, цэгнэдэг жил. Тэр тусмаа орон нутагт бол энэ ажлууд бол маш том бэлтгэл ажлыг хангадаг, хоол хүнсээ авдаг, өвөлжөө бууцандаа буудаг, ингээд гэр орон гадаа давхарладаг, дулаалдаг, хүүхэд шуухдаа сургууль, цэцэрлэгт хоол хүнсийг нь хүргэж өгөх гээд л ингээд эрүүл мэнд боловсролын маш том салбар байдаг. Тэгээд энэ дээр бас манай энэ онцгойнохон, тэгээд ер нь энэ орон нутагт ажиллаж байгаа хүмүүс бол нэлээн л ажлыг бэлддэг л дээ. Тэгээд бидний нүүдэл бол эндээ ингээд яригдаж байна. Өмнө жил бид бүхэн бас онц ийм хүндрэлтэй жил байсан. Олон улсын байгууллагуудаас л тусламж, дэмжлэгүүдийг маш их үзүүлсэн. Тэгээд энэ жил сонгуулийн жил. Энэ сонгуулийн жилд ийм алдаа гардаг юм. Орон нутгийн удирдлагууд бас ингээд сумдын удирдлагууд солигддог, дээрээс нь ингээд төсөв шилжих жил ингээд хавар ингээд төсвөө ерөнхийдөө өвс, хадлан тэжээлд үрчихдэг. Одоо төсөв хэлэлцэгдээгүй, батлагдаагүй үед тэгээд дээр нь батлагдсаны дараа тендер гээд зарлагдаад он даваад явчихдаг, бэлтгэл ажлууд маш муу хийгддэг орон нутагт. Хийгддэг нэг шалтгаан нь энэ. Тэгээд энэ дээр улс

УОК түрүү жил ажиллаад явж байхад маш сайн харсан. Тэр малчин өрхүүд маань яг ямар байдалтай байгаа вэ гэдгийг, яваад ороход түлш байхгүй, хоол байхгүй, гэрт нь 1 л хүн байж байгаа. Авгай нь хүүхдүүдээ аваад сум руугаа орчихсон. Тэгээд энэ байдал дээр бол ажлын хэсгүүд сая Шадар сайд хэлж байна ажлын хэсгүүд гараад сумдад ажиллаж байгаа гэж байгаа. Би яг энэ талаар бас 3 аймагт, хангайн бүсийн Архангай, Баянхонгор, Өвөрхангайд бас өвөлжилтийн талаар бэлтгэл ажлын талаар сумуудтай, аймгийн удирдлагуудтай холбогдсон. Архангай аймагт бол 5 хэсэг ажлын хэсэг гараад ажиллаж байна. Баянхонгорт бас ажлын хэсгүүд гарч байна. Тэгээд бидний яг энэ ажил маань ямар удирдамжаар явж байгаа вэ? Надад ирж байгаа мэдээллээр бол жишээ нь сумуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх машин маань хүрэлцэхгүй байна, эвдэрчихлээ гэсэн 2 сум байна. Энэ мэдээ ирсэн үү? Мөн дээрээс нь манай 1 сум дээр дотуур байр нь актлагдчихсан, засвар хийе гэхээр засвар хийлгэдэггүй.

Тэгэхээр өнөөдөр юу яригдаж байгаа вэ гэхээр Монгол Улсын төсөв яригдаж байгаа юм. Яг одоо Шадар сайд дээрээс яг энэ актлагдсан, ашиглахыг больчихсон энэ барилгуудыг шинэчлэх дээр улсын төсөв дээр суулгах тэр санал ирдэг үү? Энэ жил ямар ч ажилд шинээр оруулахгүй гээд оруулж чадсангүй. Нэгд дотуур байрны ажлыг ингээд 2 асуудал. Мөн дээрээс нь яг тэр айл өрхөд очиход яг сая үнэхээр бэлтгэл ажлаас.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Эхлээд хариулт яачхаад тэгээд тодруулчихъя тэгэх үү Жаргалсайхан гишүүн? Хэн хариулах вэ? Нэгдүгээрт эхлээд Шадар сайд хариулаад, Эрүүл мэндийн яам тэр эрүүл мэндийн салбарын түргэн тусламжийн машины асуудлаар, дотуур байрны энэ тэр асуудлаар тэр Шадар сайд л хариулъя даа тэгэх үү?

**С.Амарсайхан:** Жаргалсайхан гишүүн маш чухал асуудлууд бас орон нутгийн зовлон, нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлийг маш сайн ойлгодог хүний хувьд тэгээд яг үнэн бодит байдлыг хэлж байна. Амаргүй байдаг. Ялангуяа энэ өвс бэлтгэл, тэжээл гэдэг юм уу улсын орон нутгийн аюулгүй нөөцийг бүрдүүлэхэд бол аймаг орон нутагт тулгамдаж байгаа асуудал сая бидний ярьдаг нөгөө төсөвтэй холбоотой асуудал. Тэгээд заримыг нь нөөцөөсөө бүрдүүлдэг, өмнөх нөөцөө ашигладаг, тэгээд он дамжихад бол төсвөө баталж ,төсвөөрөө тэр худалдан авалтаа хийдэг.

Тийм учраас түрүүн төсөв дээр бас ингээд цаана нь байгаа сөрөг үр дагавраа тооцож байж асуудалдаа хандаж энэ төсвийн батлах асуудлаа анхаараарай гэж хэлээд байгаа нь тэр юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ялт ч үгүй орон нутагт явж байхад хүндрэлүүд их байдаг. Сумын дарга, багийн дарга, тэгээд эрүүл мэнд, онцгой, цагдаа, боловсрол гээд байр сав, машин тэрэг, дулаан цахилгаан, урсгал зардал, дээвэр засвар, засвар үйлчилгээ гээд ерөөсөө маш их хүсэлтүүдийг тавьдаг. Тэгээд тэр болгоныг бас шууд шийдээд байх боломж хомс байдаг учраас ер нь энэ аймаг, орон нутагт бид энэ төрийн албыг гүйцэтгэлдүүлнэ, ард иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой төрөөс баримталдаг бодлогыг бодитой хэрэгжүүлье гэх юм бол энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний автомашинуудаа бүрэн гүйцэт стандартаа шинэчилдэг болъё, аймаг орон нутгийн энэ машин тэрэгний асуудлаа шийддэг болъё, тэр дотуур байрны сургуулийн асуудлуудаа Боловсролын яам нь, харьяа Гэр бүл, хөдөлмөрийн яам гээд энэ яамнууд нь анхаараад улсын төсвөөр л

бид шийдэхгүй бол Шадар сайд шууд сонсож авч ирээд тэгээд Засгийн газраар оруулаад шийдчихдэг асуудал ерөөсөө огт биш учраас цаашдаа ер нь энэ зайлшгүй хийх ёстой ажлуудаа ач холбогдлоор нь эрэмбэлж, дараалаад тэгээд аймаг, бүсээр нь ялгаад, эрүүл мэнд, боловсролын салбарын үйлчилгээтэй холбоотой асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэхэд онцгой анхаарч ажиллахгүй бол яг одоо ороод ирсэн төсвийг нь ингээд тэр ч аймаг болохгүй энэ ч аймаг болохгүй гээд эсвэл өөрсдийнхөө хүслийн жагсаалтаар энэ төсвийг батлах гээд, нэг бол хийрхэж явцуураад бүх юмыг нь хасаад хаячихдаг энэ хандлага бол бас орон нутагт асар их хүндрэл учруулж байгаа. Тэр энэ орон нутгийн асуудлаа бид бүсийн бодлоготойгоо уялдуулж, цэгцтэйгээр шийдвэрлэх олон асуудлын хүрээнд сая ярьсан энэ дотуур байр, машин тэрэгний асуудлыг шийдвэрлэх ёстой гэж үзэж байгаа. Цаашдаа ер нь бол энэ төсөв хөрөнгө ер нь яаж, ямар түвшинд, ямар, бүс нутагт хэрхэн хуваарилагдах вэ гэдэг орон нутгаас саналыг нь авч орон нутгийн нөөц бололцоогоороо юу шийдвэрлэх юм, улсын төсвөөрөө юугаар шийдвэрлэх юм, гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжаараа юугаар шийдвэрлэх юм гэдгээ тодорхой болгож, ангилж ялгаад, хугацааг нь тодорхой тогтоож, шийдвэрлэдэг байх ийм тогтолцоо чухал. Тийм учраас гишүүд маань ч гэсэн энэ дээр анхаарах байх гэж бодож байна.

**Х.Булгантуяа:** Эрүүл мэндийн яамнаас нэмж хариулах уу? 1 номерын индэр дээр.

**П.Оюунцэцэг:** Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө энэ ондоо бол бид нар энэ 24 ондоо Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр Ланд крузер 78 маркийн автомашин 60 ширхгийг бол бас энэ сумдын Эрүүл мэндийн төвүүдэд олгоод байна. Одоо бас Дэлхийн банкны төслийн хүрээнд нийтдээ 75 түргэний автомашиныг нийлүүлэхээр бас гэрээлсэн байгаа. Эхний ээлжид бид нар 44 түргэний автомашиныг олгоод байна. Одоо ингээд үлдсэн автомашинуудыг энэ ондоо багтаан бас сумдын Эрүүл. мэндийн төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгөхөөр бол ажиллаж байна.

Ер нь одоо, цаашдаа бол энэ бас энэ сумдын болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад энэ түргэн тусламжийн автомашин дээр туулах чадвар сайтай бас энд ийм том машинуудыг олгохоор ийм шийдвэр гаргаад хангалтаа хийгээд явж байгаа.

**Х.Булгантуяа:** Нэмж тодруулах уу? Улсын Их Хурлын гишүүдээс мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа.

Өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой ер нь жил болгон л Улсын Их Хурлаар мэдээлэл хийдэг. Өнөөдөр хэд хэдэн гишүүд асууж байгаа асуултууд дээр Засгийн газрын гишүүд анхаараарай.

Нэгдүгээрт, яг өвөл өвөлжилт хүндрэхээр гэв гэнэт өвөлжилтийн асуудал ярьдаг биш, эртнээс бэлтгэлийг хангах, хүнс тэжээлийн бэлтгэлээ хангах, түлшний бэлтгэлээ хангах, Улаанбаатар хотын түгжрэл, халтиргаа, утааны чанарын асуудал, эрүүл мэндийн салбар, хүүхдийн өвчлөл, эрүүл мэндийн салбарын тулгамдаад байгаа энэ орны асуудал гэх мэтчилэн. Мөн дээрээс нь нэмээд сая Жаргалсайхан гишүүн бас асууж байна. Эрүүл мэндийн салбар яг өвөлжилт хүндрээд л ингээд эхлэхээр яаралтай горимоор дандаа л нэг худалдан авалтуудаа

хийж ингэж явдаг биш эртнээс төлөвлөөд 330 сумынхаа яаралтай тусламжийн машины асуудлыг энэ тэр төлөвлөж байгаад жил жилээр төсөв дээрээ тодорхой хэмжээгээр тавиад ингээд шийддэг байх дээр та бүхэн маань өөрснөө анхаарах хэрэгтэй.

Ингээд Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс өнөөдөр чуулганы дэгийн тухай 112 дугаар зүйлийн 112-ын 9-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс 1 гишүүн төлөөлж, Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултуудыг бас асуусан. Ингээд ардчилсан, одоо асууна тээ? Асуухаар ирүүлсэн Эрдэнэболд гишүүн асууна тээ? Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд иргэдээс ирүүлсэн асуултыг асууна. Гишүүнд асуулт асуух 20 минутад багтаана.

**С.Эрдэнэболд:** Эндээсээ юу тээ?

**Х.Булгантуяа:** Санал дээрээс.

**С.Эрдэнэболд:** Улсын Их Хурлын энэ дэгийн тухай хуульд зааснаар сая Их Хурлын гишүүд асуулт тодруулгаа авсан бол одоо иргэдээс ирсэн асуултыг бас ингээд сөрөг хүчний зүгээс тавьж байгаа юм.

Тэгэхээр энэ асуулт маань бол нийтдээ 15 асуулт цахимаар ирсэн. Энэ асуултуудыг би тоймлоод бас зарим нь давхардсан учраас нэг дор асуугаад явчихъя. Тэгээд та бүхэн маань бас харьяалагдах зүйлүүдийг нь хариулаарай. Гэхдээ бас зарим асуултууд түрүүн Улсын Их Хурлын гишүүдийн асуулт дээр давхацсан учраас тэдгээрийг асуухгүй байя гэж бодож байгаа. Яах вэ зарим нь давхацна. Гэхдээ Их Хурлын гишүүд гэхээсээ илүүтэйгээр бас иргэдийн асуултыг ямар ямар асуулт ирж байгааг нь та бүхэнд тоймлоод уншиж өгье.

Ер нь бол ийм асуудал байгаа юм. Юу гэхлээр өмнө нь дэгээр бол 14 хоног тутам Ерөнхий сайд мэдээлэл хийдэг байсан бол өмнөх парламентын үед, энэ парламентын үед бол сард 1 удаа хийж байгаа. Тэгээд энэ асуулт маань Ерөнхий сайдын мэдээлэл маань бас олон нийтэд 7 хоногийн өмнө ч гэдэг юм уу ингээд тавигдах ёстой байтал цаг тулгаж энэ мэдээлэл цахим хуудсан дээр тавигдаад байгаа юм. Цаг тулаад тавигдчихаар иргэд маань төдийлөн бас танилцаж амжихгүй байгаад байгаа. Тэр утгаараа бол энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Тамгын газар хоёрт хандаж хэлэхэд иргэдийн мэдэх эрхийг хангах үүднээс энэ Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотой асуудал дээр бас иргэдтэй танилцах боломжийг нь түлхүү хангаж байх юм бол процессын хувьд үр дүнтэй байна гэж үзэж байгаа.

Эхний асуулт, хөдөө аж ахуйн салбарт улсын төсвөөс олгох татаас, дэмжлэгийн хэмжээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж ирсний зэрэгцээ шинэ хоршоонд багагүй хөрөнгө оруулалт оруулж байгаа. Энэ дэмжлэг, хөрөнгө нь малчдыг зудаас сэргийлэх, зудын эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах боломжтой юу? Энд тодорхой хариулж өгөөч гэж байгаа юм. Тоо баримттай байвал сайн байна.

Хоёрдугаар асуулт нь цаг уурын төлөв байдлын урьдчилсан мэдээгээр энэ өвөл ямар нөхцөл байдалтай байх вэ? Малчдын зүгээс ирж байгаа асуулт. Үүнтэй

холбоотойгоор ямар нэгэн нэмэлт арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна уу? Хэрэв цагийн байдал хүндэрч зуд боллоо гэхэд малчдад бага хэмжээний өвс тэжээл, барааны тусламж өгөх замаар зудын эрсдэлийг даван туулах гэсэн ийм уламжлалт арга барилаа яаж өөрчлөх вэ? Өвөлжилтийн байдал хүндэрч эхэлсэн аймаг, сумдын малыг эргэлтэд оруулж, мах экспортлох талаар хэрэгжүүлсэн бодитой ажил байна уу? Өнгөрсөн өвөл гэхэд өвөлжилтийн бэлтгэл хангах эд ажлын үеэр шатахууны хомсдолд орсон гээд түрүүний энэ давхацсан асуулт байгаа.

Гурав дахь асуулт нь, бүлэг асуулт нь хөдөө аж ахуйн салбарт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг нь бэхжүүлэхэд чиглэсэн шинэ технологи, инновац яагаад хангалттай түвшинд нэвтэрч чадахгүй байна вэ? Малын ашиг шим, таримал ургамлын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн дотоод, гадаад төслүүдийн үр дүн яагаад хангалттай биш байна вэ? Тооноос чанарт шилжиж байж зуд байгалийн гамшгийг үр дүнтэйгээр даван туулах, хохирол багатайгаар даван туулах ёстой. Тэгээд энэ эмзэг байдлаа бид нар бууруулах тал дээр ямар тодорхой алхмууд энэ Засгаас хийх вэ?

Дараагийнх нь асуулт нөөцийн мах бэлтгэх, үнийг тогтвортой байлгах гэж оролдох малчид тариаланчдад хавтгайруулан урамшуулал, татаас олгож, төрийн халамж нэмэгдэх, хөдөөд хоршоог компаничлан байгуулах, гурил, улаан буудайн импортын татварыг тэглэх гэх мэтээр хөдөө аж ахуйн салбар дахь төрийн оролцоо ихээхэн өсөх хандлагатай байна. Энэ бодлогыг зөв гэдэгт итгэлтэй байна уу гэсэн асуулт байна.

Дараагийнх нь асуулт түрүүн бас давхацсан. Тэгэхдээ яах вэ иргэдээс ирсэн учраас би заавал уншиж өгөх ёстой. ДЦС-уудын нүүрсний нөөц хэдэн хоногийн хэрэгцээг хангах хэмжээнд байна вэ тоо? Цахилгаан станцуудын их засвар, техникийн бэлэн байдал хэр хангагдсан бэ? Эрчим хүчний системийн ослын нөөц, аваарын нөөц, түүний бэлэн байдал ямар түвшинд байна вэ? Өмнөх жилүүдэд гарч байсан алдаа, дутагдлуудыг засаж сайжруулах чиглэлээр ямар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байна вэ гэсэн. 90 гаруй хувийн бэлтгэлтэй байгаа гэсэн. Энэ дээр бол тодорхой арга зүйн хувьд ямар бэлтгэлтэй байна вэ гэдгийг нь асууж байна.

Дараагийн асуулт. Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийн бэлэн байдал хэр хангагдсан бэ? Онцгой нөхцөл байдал үүссэн үед ашиглах нөөц сангийн хөрөнгө хэдий хэмжээнд бэлтгэгдсэн бэ гэсэн асуултууд байна.

Иргэдээс ирсэн асуултыг Ардчилсан намын бүлгийг төлөөлж асууж дууслаа.

Хүнс, хөдөө аж ахуйн яам эхлээд хариулах уу? Шинэ хоршоотой холбоотой, дараа нь цаг уурын мэдээлэлтэй зуд бол яах вэ гэдэгтэй холбоотой. Хөдөө аж ахуйн яам мөсөн Хөдөө аж ахуйн яамтай холбоотой бүх юмнуудыг нь хариулчхаарай.

**Ё.Азжаргал:** Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга Азжаргал.

Шинэ хоршоо хөдөлгөөний хөрөнгө оруулалтын зээл малчдыг зудын эрсдэлд бэлдэж чадах уу гэж асуусан. Өнгөрсөн хаврын чуулганаар уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсан. Үүний араас Засгийн газрын 166 дугаар тогтоол гарч Шинэ хоршоо хөдөлгөөн өрнөж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд нийтдээ 68500 орчим малчид хоршооны гишүүнээр элссэн ийм тоо байна. Нийтдээ 17 мянга барь орчим малчин 558 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан. Сүүлийн сар гарангын хугацаанд бид нар 8 аймгаар явж малчидтайгаа уулзаж мониторинг хийсэн. Тэгээд малчид нийт зээлийнхээ 40 гаруй хувийг өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангахад, хашаа хороогоо сайжруулахад, хадлан өвс ногоон тэжээлээ бэлтгэхэд, орлогоо нэмэгдүүлэх чиглэлд зарцуулсан байна гэдэг ийм судалгааны дүн гарсан.

Өөрөөр хэлэх юм бол, энэ 17 мянган малчин Шинэ хоршоо хөдөлгөөний зээлд ав хамрагдсан 17 мянган малчин энэ өвлийн болзошгүй эрсдэлд бэлтгэлээ хангасан гэж ийм дүгнэлт гарч байгаа. Баярлалаа.

**Х.Булгантуяа:** Баярхүү дарга Улсын онцгой комисс.

**Т.Баярхүү:** Эрдэнэболд гишүүний асуултад хариулья.

Энэ жилийн цаг уурын төлөв байдал, өвөл ямар нөхцөл байдал үүсэх төлөвтэй байгаа энэ талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна гэсэн асуултад хариулья.

Цаг уур, орчны шинжилгээний газрын өгсөн мэдээллээр 2024 оны 12 дугаар сард төв болон зүүн аймгуудын нутаг, баруун аймгуудын хойд хэсгээр олон жилийн дунджаас хүйтэн, хур тунадас зүүн аймгуудын нутгаар ахиу орно гэсэн ийм цаг агаарын прогнозтой байгаа.

Харин 2025 оны 1, 2 дугаар саруудад ихэнх нутгаар олон жилийн дунджаас хүйтэн. Ялангуяа 1 дүгээр сард нутгийн баруун хойд хэсгээр болон 2 дугаар сард зүүн аймгуудын нутгаар олон жилийн дунджаас ахиу хэмжээний цас орох төлөвтэй байна гэсэн ийм урьдчилсан мэдээ байгаа.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан журмын дагуу, мөн Монгол Улсын Шадар сайдын баталсан ган, зудын үнэлгээ хийх ерөнхий үнэлгээний дүнгээр 21 аймгийн хэмжээнд зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийхэд эрсдэлийн түвшин улсын хэмжээнд дунд байгаа. Үүнээс Баянхонгор, Говьсүмбэр, Өвөрхангай аймгуудад зудын эрсдэлийн түвшин их. Архангай, Баян-Өлгий, Завхан, Сүхбаатар, Төв аймгууд эрсдэл маш их, бусад аймгууд дунд гэсэн ийм дүн мэдээтэй.

Танилцуулга дээр бэлчээрийн даацын талаар бас тодорхой мэдээллүүд байгаа. Ер нь өвөл, хаврын улирлын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 47 хувьд хүрэлцээтэй, бусад хувьд нь бол ямар нэгэн байдлаар бэлчээрийн даац хэтэрч гарсан байна гэсэн ийм дүнтэй байгаа.

Өнгөрсөн өвлийн зудын туршлага, сургамжтай холбоотойгоор Улсын онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж, мөн Монгол Улсын Шадар сайдын тушаалаар зудын гамшгийн хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг

боловсруулж батлуулсан. Энэ жилийн тухайд бид энэхүү төлөвлөгөөг тодотгон хэрэгжилтийг хангаж ажиллана. Ер нь бол энэ өвөлжилттэй холбоотойгоор түрүүн бас мэдээлэлд дурдсан Улсын онцгой комиссын Шуурхай штабыг 6 яам, 4 агентлагийн холбогдох албаны мэргэжлийн байгууллагуудын төлөвлөлттэйгөөр бүрдүүлэн энэ салбар дундын зохицуулалтуудыг хийж шуурхай хариу арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг танилцуулъя. Илтгэгч дууслаа.

**Х.Булгантуяа:** Хөдөө аж ахуйн яамнаас хөдөө аж ахуйн салбар шинэ технологийн нэвтрэлт муу байна гэдэг асуудлаар Болорчулуун дарга.

**Ц.Болорчулуун:** Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр хөдөө аж ахуйн салбарын мал аж ахуйн салбарт малыг эдийн засгийн эргэлтэд оруулах тал дээр бас тодорхой арга хэмжээ ажлуудыг хийж ажиллаж байна. Энэ жилийн тухайд аймгуудаас ирсэн мэдээгээр нэгтгээд үзэхэд нийтдээ улсын хэмжээнд 16 орчим сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулах ийм тооцоо гарсан. Үүнээс 10 орчим сая нь бол дотоодын хэрэгцээнд, 6 сая нь бол экспортод гаргана гэсэн ийм тооцоог гаргасан байгаа. Яг өнөөдрийн байдлаар бол 51.3 мянган тонн мах экспортод гарч байгаа.

Тэгэхээр мах экспортлох, импортлох орны тоо тодорхой хэмжээнд нэмэгдэж байна. Ер нь өнгөрсөн жилийн экспортын тоо хувийг аваад үзэх юм бол нийт экспортолсон махны 80 хувь нь БНХАУ руу гарч байсан бол энэ жилийн тухайд энэ булангийн орнуудтай бас экспорт, импортын хорио цээрийн протоколууд тохироод аж ахуйн нэгжүүд гаргаад эхэлсэн байгаа тодорхой хэмжээнд. Сая өнгөрсөн долоо хоногт бас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Вьетнам Монголын Засгийн газрын комиссын хуралд очоод ирэхэд бас Вьетнамын талтай бас мах авах нэлээд хорио цээрийн протокол дээрээ бас гарын үсэг зураад ирсэн байж байгаа. Тэгэхээр бид нарын экспортлох орны тоо нэмэгдэж байгаа учраас малыг эдийн засгийн эргэлтэд оруулах энэ том боломжууд бас нээгдэж байна гэж ингэж харж байгаа.

Түүнчлэн бас 12 сард бид нар аймаг 21 аймгийн түвшинд Улаанбаатар жил болгон уламжлал болгон зохион байгуулаад идэш арга хэмжээг бас зохион байгуулахаар төлөвлөж байгаа. Үүгээр бол мэдээж малчдаас шууд хэрэглэгчдэд өвлийн идшийг нь бэлтгэж өгөх энэ арга хэмжээнд бас тодорхой хэмжээний үр дүнтэй байдаг гэдгийг бас хэлье. Аан хөдөө аж ахуйн салбар дээр төсөл, хөтөлбөрүүд бас тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа. Бид нар энэ донор байгууллагууд болох Азийн хөгжлийн банктэй тухайлах юм бол усалгаатай газар тариалан гээд төслийг хэрэгжүүлж нийтдээ 7000 га талбайгаар усалтын системийг нэмэгдүүлэх энэ төслийг хэрэгжүүлээд энэ жилийн тухайд 3, нийт 12 байршилд усалтын систем байгуулж байгаагаас 3 байршил дээр, 4 байршил нь бол ажил нь 100 хувийн гүйцэтгэлтэйгээр ингээд сая оны төгсгөл рүү орж байгаа. Ирэх жил бид нар ерөнхийдөө энэ 10 усалтын системийг хүлээгээд авах ийм боломж үүсэж байгаа гэж харж байгаа. Түүнчлэн Дэлхийн банкин дээр бас мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх гээд бас төслүүд явж байгаа. Тэгэхээр мэдээж нэг төслийн санхүүжилтээр бүх асуудал шийдэгдэхгүй хэдий боловч хэрэгжиж байгаа тухайн орон нутагтаа, тухайн салбартаа тодорхой хэмжээний үр дүнгүүд гарч байгаа гэж ингэж харж байгаа.

Дээрээс нь төсөв мөнгө бага байгаа ийм нөхцөлд энэ олон улсын зээл тусламжууд бас тодорхой хэмжээний үр дүнгээ өгч байгаа гэдгийг бас хэлье.

**Х.Булгантуяа:** Нөөцийн мах бэлтгэл хөдөө аж ахуйн салбарт төрийн бодлого хэт их болж, халамж болж байна гэдэг асуудлыг бас ярьсан.

**Ц.Болорчулуун:** Хөдөө аж ахуйн салбарт татаас урамшууллын хэмжээ нэмэгдэж байна. Халамж гэдэг асуудал яригдаж байна. Тэгэхээр энд ямар нэгэн халамжийн бодлого бид нар хэрэгжүүлээгүй. Одоо ер нь энэ хэрэгжээд байгаа Хүнсний хувьсгал, Цагаан алт хөтөлбөрүүд дандаа арилжааны банкны эх үүсвэрийг бид ашиглаж, аж ахуйн нэгжүүдэд зээл олгох Засгийн газрын оролцоо бол энэ дээр хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас дээр дэмжлэг үзүүл үзүүлэх хэлбэрээр явж байгаа. Тэгэхээр энэ дээр бол ямар нэгэн халамжийн бодлого байхгүй гэж ойлгож болохоор байгаа. Зүгээр малчид руу чиглэсэн явж байгаа татаас гэдэг дээр бол сүүний урамшуулал явж байгаа дээрээс нь ноос, арьс ширний урамшуулал явна, эдгээр урамшууллууд бол мэдээж 2 талтайгаар ингээд малчид руу чиглээд явж байгаа. Өөр халамжийн бодлого энд хэрэгжээд байгаа асуудал байхгүй гэдгийг хэлмээр байна.

**Х.Булгантуяа:** Нөөцийн мах бэлтгэл, үгүй ээ хэдэн асуултаа та хэд бичиж авч байгаад хариулчхаач. 3, 4-хөн асуултад хариулах гэж. Хаанаас хариулах юм? Нийслэлээс.

**М.Балдандорж:** Улаанбаатар хотын захирагчийн ажил алба хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга Балдандорж.

Нийслэлийн хүн амын 2024-25 оны өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд ер нь 5500-аас 6000 тонн мах бэлтгэх л тооцоо судалгаа гаргасан. Нийслэлийн төсөвт 25 оны төсөвт бол 7.9 тэрбумын хүүгийн татаасыг суулгах ажил зохион байгуулагдаж байна. Нийтдээ бол нөөцийн мах бэлтгэлтэй холбоотой 13 аж ахуйн нэгжээс материал ирснээс өнөөдрийн байдлаар 8 аж ахуйн нэгжтэй ажлын хэсэг хэлэлцээрт орсон. Одоогийн байдлаар яг 6 аж ахуйн нэгж нь бол энэ шаардлагад нийцсэн гээд энэ 5 арилжааны банканд ер нь зээлийг нь хэл гэрээ хэлэлцээрийг нь хийх, судлуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

Өнөөдрийн байдлаар ер нь 2 арилжааны банк бол “Хаан банк”, “Худалдаа хөгжлийн банк” 2 зээлийн хүүгийн хөнгөлөлтийн зардлыг санхүүжүүлэх гэрээгээ байгуулчихсан. Нөөцийн банк бэлтгэх ажил ер нь 80 хувьтай гэж явж байна.

**Х.Булгантуяа:** Нүүрсний нөөц Эрчим хүчний яамнаас 2 номерын микрофон дээрээс. Цахилгаан станцуудын бэлэн байдал, аваарын асуудал гээд.

**Б.Насантогтох:** Эрчим хүчний яамны хэрэгжилтийн газрын дарга Насантогтох. Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар ДЦС-уудын нүүрсний нөөц 15-22 хоногийн нөөц буюу өвлийн горимдоо орчихсон ажиллаж байна. ДЦС-уудын засвар, өвөлжилтийн бэлтгэл ажил би түрүүн хэлсэн 94 хувьтай. Үндсэндээ энэ хавар, зун, намар хийсэн нийтдээ их урсгал 860 төрлийн ажил, хөрөнгө оруулалтыг, 640 ажлуудыг хийж гүйцэтгэсэн. ДЦС-уудын бас онцлог өвлийн горимд горимоос өмнө энэ эдгээр засвар өвөлжилтийн бэлтгэл ажлыг хийж дуусахгүй бол тоноглолуудаа



ажиллагаанд залгаж чадахгүй. Тэгэхээр өнөөдөр бүх засварын ажлаа дуусгаад, манай 7 ДЦС-ууд бүх тоноглолууд ажиллагаанд бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна.

Улаанбаатар дулааны сүлжээний хувьд энэ жилийн өвөлжилтийн горимд нэг онцлог байгаа. Энэ юу вэ гэхээр Дэлхийн банкны төсөл, Европын сэргээн босголтын банкны нийт 5 багц Улаанбаатар хотын дулааны төв магистралыг шинэчлэн өргөтгөх ажлуудыг энэ зун, намар дуусгасан.

Улаанбаатар дулааны сүлжээний хувьд мөн ДЦС салбарын хэмжээнд аваарын нөөц бүрдүүлэлт 90 хувьтай байна. Энэ жагсаалтаар батлагдсан нөөцийг бүрдүүлж сая 10 сар, 11 сард яамны хяналтын газраас бүрэн тооллого хийж баталгаажуулсан байдаг. Улаанбаатар дулааны хувьд засварын ажлыг бүрэн дуусгасан. Энэ нь бас нөгөө онцлогтой. Улаанбаатар дулааны сүлжээг өвлийн горимоос өмнө бүрэн ажиллагаанд залгах ёстой. Тэрнээс өмнө засвар дууссан байх ёстой.

Тэгэхээр ер нь эрчим хүчний салбарын их засвар өвөлжилтийн бэлтгэл ажлын онцлог нь өвлийн горимоос өмнө бүх тоноглолуудыг ажиллагаанд залгах өвлийн горимоос өмнө бүх төлөвлөсөн засварын ажлуудаа хугацаанд нь дуусгах, цаг хугацаанд тооцоолж ажилладаг ингээд засварын ажлын чанар энэ нь өвлийн горимын ажиллагааны үед шалгагддаг ийм шалтгаантай байдаг юм. Баярлалаа.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын дахь Монгол Ардны намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр асуулт асууна.

**У.Отгонбаяр:** Оройн мэнд хүргэе.

Өнгөрсөн жил би бас ганц нэг асуулт асууя. Өнгөрсөн жил Монгол Улс 8-9 сая орчим малаа зудад алдсан. Өнгөрсөн жилийн үйл явдал зуд гэхээсээ илүүтэйгээр байгалийн гамшиг болсон, байгалийн гамшиг болсон. Сүхбаатар аймаг гэхэд 1.8 сая, Говьсүмбэр 179 мянга, Дорноговь 600, 700 орчим мянган мал, Хэнтий аймаг гэхэд 1.1 сая мал, Архангай гэхэд 1 сая мал гээд ингээд эхний хамгийн их эрсдэлд орсон, мал алдсан энэ 5 аймаг байгаа. Тэгээд үндсэндээ тэр 8, 9 сая малын 4 арваны бараг 5 сая орчим нь зөвхөн энэ 5 аймагт байгаа.

Тэгэхээр би үүгээр юу хэлэх гээд байна гэхээр өнгөрсөн жил энэ аймгуудад бол байгалийн гамшигт үзэгдэл бий болсон. Өнгөрсөн энэ байгалийн гамшгаас манай Хөдөө аж ахуйн яам ямар сургамж авч үлдэв? Энэ жилийн бэлтгэл энэ өвөлжилтийн бэлтгэл хангахад ямар ямар ажлуудыг яг тодорхой энэ төлөвлөгөөндөө оруулж чадав гэдгийг бас тодруулъя.

Мөн энэ малчдыг дагаад явж байдаг энэ даатгалын, малын индексжүүлсэн даатгал гэж энэ дан л хэл ам хэлцэл шуугиан дагуулж байдаг ийм зүйл. Үндсэндээ малчид энэ бол банкнаас зээл авахын тулд энэ малын индексжүүлсэн даатгалд хамрагддаг. Тэрнээс биш юу гэдэг юм малаа зуд турханд алдвал бид бүхэн нөхөн төлбөр авахын даатгуулж байгаа гэдэг үндсэн дээр биш, банкнаас зээл авахын тулд банкны тэр зээлийн шалгуурт даатгуулсан байх ёстой гэдэг ийм зүйл байдаг. Тийм учраас энэ Хөдөө аж ахуйн яам энэ малын индексжүүлсэн даатгал дээр ер нь цаашдаа ямар бодлого барьж ажиллах юм бэ? Энэ дээр бас дорвитой өөрчлөлт, шинэчлэлт хийж цаг үетэйгээ бас хөл нийлүүлж алхах зайлшгүй

шаардлага байгаа. Энийг орон нутгаас иргэд маш их асуудаг, мөн би бас иргэдийн төлөөлөл болж энийг албан ёсоор бас асууж байгаа юм гэдгийг бас дуулгая. Өнгөрсөн жил 35 орчим мянган өрх 4.9 тэрбум төгрөгөөр малаа даатгуулсан. Тэгээд буцаагаад энэ 22, 23 мянга орчим өрх 16.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, нөхөн олговрыг авсан байх жишээтэй.

Өнгөрсөн жилийн хувьд бол зуд турхантай, байгалийн гамшигтай байсан учраас, маш их малын хорогдолтой байсан учраас энэ нөхөн төлбөрийг нэлээдгүй гайгүй хэмжээнд малчид маань авч чадсан. Цаашдаа энэ дээр бас нарийн бодлого хэрэгтэй гэж.

Гурав дахь асуулт. Зуд турхан гэдэг зүйл болдгоороо болно. Энэ бол ойлгомжтой. Байгалийн энэ давтагдашгүй хүчин зүйлийн нөлөө улам их ихэснэ. Энэ бол шинжлэх ухаанаар нотлогдсон ийм зүйл. Өнгөрсөн жилийн өнгөрсөн жил харж байхад цасанд боогдоод сумынхаа удирдлагуудтай, онцгой байдлынхантай холбогдож чадахгүй олон сар болсон олон айлууд байсан. Тэр мал хуй нь тэгээд хоргоддог дээрээс нь бас 2 чухал асуудал эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чаддаггүй.

Дараагийнх нь энэ боловсролын асуудал. Хүүхдүүд хичээлдээ явж чаддаггүй олон сараар цасанд боогдоод. Хэрвээ энэ жил айхтар зуд турхан бол яг энэ чиглэлээр эрүүл мэнд, боловсролын чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр та бүгд маань төлөвлөж байна?

Дараагийн асуулт. Өвс тэжээл бэлтгэж, нөөц бэлтгэх асуудал нэлээдгүй яригддаг өвлийн бэлтгэл ажлын хүрээнд. Энэ дээр юу гэдэг юм 10 боодол өвс дор орчихсон малд 10 боодол өвс өгөхөөсөө илүүтэйгээр бид бүхэн энэ ногоон тэжээл, хүчит тэжээл, даршилсан тэжээл рүү түлхүү анхаарах ёстой юм билээ. Тийм учраас Хөдөө аж ахуйн яам энэ ногоон тэжээл, хүчит тэжээлийн чиглэлээр тусгайлан хөтөлбөр байна уу? Энэ чиглэлээр ер нь энэ жилийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд ямар ажлуудыг төсөв төлөвлөгөөндөө тусгасан бэ гэдгийг бас би асууж тодруулъя.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсгийнхэн эхлээд хэн хариулах вэ? Шадар сайд хариулах уу, Баярхүү дарга хариулах уу? Баярхүү дарга.

**Т.Баярхүү:** Отгонбаяр гишүүний асуултад хариулъя.

Яг энэ цас ихээр орж зам, даваа хаагдсан ийм өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн зудад нэрвэгдсэн ийм үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бол ялт ч үгүй мөн тулгамдсан асуудал болдог. Энэнтэй холбоотойгоор өнгөрсөн өвлийн зудын үеэр Улсын онцгой комиссоос бүс хариуцсан сайд нарыг томилж ажиллуулах, мөн шуурхай ажлын хэсгүүдийг орон нутагт томилон ажиллуулах үедээ Улсын 1 дүгээр эмнэлэг, Гэмтэл, 2, 3 дугаар эмнэлэг, мөн Гэмтлийн эмнэлэг гэх мэтийн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн хөдөлгөөнт багуудыг тухайн үед энэ аслагдсан зам, даваанд хаагдсан бүс нутгуудад, айл өрхүүд рүү хүргэж ажиллуулах чиглэлээр зохион байгуулалтын ажлуудыг авч хэрэгжүүлсэн. Энэ өвс тэжээлийг хүргэх, зам, давааг нээх явцдаа мөн давхар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх энэ ажлыг зохион байгуулсан.

Үүний хажуугаар энэ сумын Эрүүл мэндийн төвүүд дээр бас эмч, мэргэжилтэн дутагдалтай Эрүүл мэндийн төвүүд дээр тухайн үед нарийн мэргэжлээр сурч байгаа резидент эмч нарыг дайчлан сумын төвүүдэд ажиллуулах, мөн энэ сумын Эрүүл мэндийн, аймгийн Эрүүл мэндийн төв, сумын Эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэг үзүүлэх байдлаар тухайн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг энэ цасанд боогдсон, зудад нэрвэгдсэн, алслагдсан дүүрэг, сум, багуудад байгаа айл өрхүүдэд хүргэх чиглэлээр тухайн үед ажлуудыг зохион байгуулж ажилласан.

Үүнтэй холбоотойгоор бас энэ зөвхөн хичээл сургуульд явахаасаа гадна ер нь дотуур байрнууд дээр бас хүнсний хомсдол үүсэх, энд цахилгаан эрчим хүчний тасалдалтай холбоотой, зам даваа хаагдсантай холбоотой бас сургуулиуд дээр бас нэлээн дэд бүтцийн халуун, дулааны гэх мэтийн гэмтэл гарсан ийм асуудлууд тухайн үед нь үүсэж байсан. Энийг бол тухайн үед нь бид Боловсролын яамтай хамтран холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч, аймаг орон нутгийн байгууллагуудтайгаа нэгдсэн байдлаар удирдлага зохицуулалтуудыг хийж ажиллаж байсан.

Мөн Боловсролын сайдын тухайн үед аймаг орон нутгууд руу өгсөн үүрэг чиглэлийн дагуу тухайн сумын Засаг дарга, аймгийн Засаг дарга нар аймаг, орон нутгийнхаа нөхцөл байдлыг үнэлээд сургуулийнхаа энэ хичээл, сургалтын график хөтөлбөрт тодорхой зохицуулалтуудыг бие даан хэрэгжүүлэх ийм үүрэг чиглэлийг өгч тухайн үед нь зохицуулалтуудыг хийж ажиллаж байсан.

Тэгэхээр ер нь цаашдаа ч гэсэн яг иймэрхүү чиглэлээр холбогдох зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг тухайн нөхцөл байдалд нь үнэлэн шуурхай авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа.

**Х.Булгантуяа:** Малын индексжүүлсэн даатгалын тухай хэн хариулах вэ? Болорчулуун дарга хариулах уу?

**Ц.Болорчулуун:** Отгонбаяр гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр өнгөрсөн жилийн зудын нөхцөл байдалтай уялдуулаад ер нь бол уламжлалт мал аж ахуйн ерөнхий байдал маань ийм байдлаараа нэлээд байгаль цаг уурын хүндрэлтэй тулгарах нь тодорхой ийм асуудлууд гарч байгаа учраас Монгол Улсын Засгийн газраас энэ Шинэ хоршоо хөдөлгөөнийг санаачилж, энэнтэй холбоотой тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтын зээлийн асуудлыг шийдээд, бүүр хөрөнгө оруулалтын зээлийг шийдэхдээ ийм дараах 14 чиглэлээр хөрөнгө оруулалтынхаа зээлийг зарцуулах гээд бүх асуудлуудыг нь тодорхой болгож бид нар энэ арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа. Ингэж хорших, хоорондоо хоршиж, нэгдэж явснаар бид энэ эрсдэлийг бас даван туулах том боломж гэж ингэж харж байгаа.

Тийм учраас бол энэ дээр цаашдаа энэ Шинэ хоршоо хөдөлгөөнийг улам өргөжүүлэх, бэхжүүлэх, малчид маань хоршиж ажиллах энэ боломжоороо боломжийг нь үүсгэх тал дээр тодорхой хэмжээний арга хэмжээнүүдийг бас авч ажиллаж байна гэдгийг бас хэлье.

Эрсдэлийг даван туулах хамгийн том арга зөвхөн мал аж ахуй дээр ч биш, газар тариалан энэ хөдөө аж ахуйн салбар дээр ер нь даатгалын тогтолцооны асуудал байгаа.

Тэгэхээр одоо бол бид нарын энэ өнөөдөр яг мал аж ахуйн салбарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа малын индексжүүлсэн даатгалын асуудал бол хүчин төгөлдөр хэрэгжээд явж байгаа хэдий боловч хэд хэдэн шалтгааны улмаас бас төдийлөн малчид энд даатгалын тогтолцоонд бас бүрэн хамрагдаж чадахгүй байгаа.

Нэгдүгээрт, мэдээж төлбөр хураамжийн асуудлууд бас нэгдүгээрт яригддаг.

Хоёрдугаарт нь гэх юм бол одоо хүчин төгөлдөр хуулиараа бол энэ тухайн сумын малын хувиас дээшээ хорогдсон тохиолдолд энэ даатгалын систем үйлчилж байгаа учраас төдийлөн малчид бас энэ рүү орохгүй байгаа. Тэгэхээр одоо Сангийн яамнаас санаачлаад энэ Индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт орж байгаа. энэ хувь, хэмжээг бол тухай бүр энэ нөхцөл байдалтай уялдуулаад Засгийн газар тогтооно гэсэн ийм өөрчлөлттэйгөөр энэ хууль сая хамтарсан үзэл баримтлалын төслийг нь батлаад удахгүй Засгаар орж хэлэлцэгдэхээр явж байгаа.Тэгэхээр энэ бас тодорхой хэмжээний малчдыг даатгалд хамрагдах том хөшүүрэг нь болно гэж ингэж харж байгаа юм.

Ер нь малчид хоршоод ингээд ажиллаад, дундын техник үйлчилгээний техниктэй болоод, энэ үйлдвэрлэлийг явуулах хэмжээнд хүрээд ирэхээр хамгийн гол асуудал бол мэдээж малынхаа чанар, үйлдвэрлэдэг байдал дээр анхаарах, тооноос чанарт шилжих энэ асуудал дээр хамгийн гол асуудал бол мэдээж сайн үүлдрийн малтай, чанарлаг, таваарлаг малтай, 1 малаас гарч байгаа ашиг шим өндөртэй малтай байхын тулд хамгийн гол асуудал нь энэ тэжээлийн асуудал байгаа.

Сүүлийн жилүүдэд энэ ган, зудын нөхцөлтэй уялдуулаад ер нь таримал тэжээлийн ашигт усыг нэлээд малчид ойлгодог болсон. Тэгэхээр бол бид нийт улсын хэмжээнд дахиад энэ эрчимжсэн аж ахуйг хөгжүүлээд, ийм малын үүлдэр угсааг сайжруулаад ирэхэд ер нь бол улсын хэмжээнд 200 мянган атар газрыг бас энэ тариалангийн үйлдвэрлэл, тэр дундаа тэжээл үйлдвэрлэлд оруулах ийм зайлшгүй шаардлага байгаа. Энэ 200 мянган га газрыг эргэлтэд оруулах асуудал энэ Хүнсний 36 дугаар тогтоолд туссан. Аймгууд дээр бүх судалгааг нь гаргаад өгсөн. Энэ зуны хувьд сонгуультай холбоотойгоор аймгууд шийдвэрээ гаргаж ирээгүй. Одоо бид хөөцөлдөөд энэ 200 мянган га-гаа ирэх жилээс бас эргэлтэд оруулах юм бол, мэдээж газар байж байж бид нар энэ хүчит тэжээл, ногоон тэжээл, энэ шүүслэг тэжээлийг хийх ийм боломж нь бүрдэнэ гэж харж байгаа.

Тийм учраас бид нар энэ газрын асуудлыг шийдсэнээр цаашдаа бол энэ таримал тэжээл, тэгээд тэжээл үйлдвэрлэл дээр анхаарах том боломж үүснэ гэж харж байгаа.

**Х.Булгантуяа:** Минут нь болоогүй байгаа учраас юу нэмж асууж болно тээ дэгийн дагуу? Отгонбаяр гишүүн нэмж тодруулах уу?

**У.Отгонбаяр:** Болорчулуун дарга малчдаас төдийлөн энэ малын индексжүүлсэн даатгалд хамрагдахгүй байгаа гэж дуугарч байна. 200 гаруй мянган малчнаас яах вэ дээ бараг хүчээр шахуу 35 мянга орчим өрх энэ малын индексжүүлчихсэн даатгалд хамрагдаж байгаа юм. Хамрагдахгүй байгаагийн гол

шалтгаан нь малаа даатгуулаад нөхөн олговроо авч чадахгүй байгаа байхгүй юу. Эндээ л их учир нь байгаа юм.

Яагаад гэвэл тухайн сумд 5 хошуу мал 5 төрөлдөө хамгийн багадаа 5 хүртэлх хувийн хорогдолтой байвал, гэхдээ бүүр 5 хошуу мал гэж байгаа шүү. Хэрвээ 4 юу гэдэг юм, адуу, тэмээ, үхэр, хонь, ямаа гээд 4 төрөлд 5 хувьтай, 1 төрөлд нь 5-аас доошоо бол энэ нөхөн олговор олгогддоггүй.

Тийм учраас бид бүхэн энэ малын индексжүүлсэн даатгалын энэ хувь, хэмжээг тэр дээр нэлээн анхаарах зайлшгүй шаардлага байгаа. Энийг бол малчид байнга ярьдаг. Хэрвээ энэ нь юу гэдэг юм яг бизнесийнхээ зарчмаар мал хорогдлоо, тодорхой хэмжээнд хорогдлоо, тэгээд нөхөн олдвороо олж авдаг бол энэ малын индексжүүлсэн даатгал цаашаагаа хэвийн явах ийм боломж байгаа гэдгийг би бас дуулгая.

Тэгээд нэг юм тодруулъя. Бас тодруулж асуумаар байна. Түрүүн манай иргэдийн төлөөлөл, иргэдийн асуултад бас гарсан, мөн над дээр байгаа энэ иргэдийн асуулт дээр бас байна. Шатахууны асуудал, шатахууны хомсдол үүсгэх. Ноднин бол яг бэлтгэл хангадаг үеэр нь шатахууны хомсдол үүссэн. Тэгээд намаржаанаасаа өвөлжөөндөө очиж чадаагүй, өвс тэжээлээ татаж чадаагүй, тэгээд анхны цастай золгосон. Энэнээсээ болж маш их эрсдэлд орсон ийм асуудал үүссэн. Энэ жил харьцангуй шатахууны хомсдол харьцангуй гайгүй байх юм байна гэж би хувьдаа ойлголоо. Үнийн асуудал дээр та бүгд маань бас тодорхой мэдээлэл өгөөч. Үнэ харьцангуй тогтвортой байж чадах нь уу, эс үгүй бол дээшээ, доошоо бас савлах, сүү нь нэмэгдэх ийм хандлага байгаа юу гэдгийг бас энэ дээр бас мэдээлэл өгөөч. Тэгээд төгсгөлд нь тэр малын индексжүүлсэн даатгал дээр бас та бүгд маань, тэр дундаа Хөдөө аж ахуйн яам энэ дээр бас нэлээн дуу хоолойтой малчдынхаа эрх ашгийг хамгаалах чиглэл рүү бас нэлээн түлхүү ажиллаарай гэдгийг би бас дуулгая. Баярлалаа.

**Х.Булгантуяа:** Болорчулуун дарга хариулах уу? Эхлээд Шадар сайд Амарсайхан.

**С.Амарсайхан:** Отгонбаяр гишүүний энэ хөндөж байгаа индексжүүлсэн даатгал маш чухал асуудал. Энэ индексжүүлсэн даатгалын бодлого хууль, эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох, яаралтай шийдвэрлэх ёстой асуудал. Ер нь энэ малчдын эрх ашгийг хамгаалах хөдөө аж ахуйн салбарын бидний яриад байгаа энэ өвөл, хаврын эрсдэл, зуд турхан тэгээд энэ тогтвортой хөгжлийг хангахтай холбоотой бодлогыг дэмжих үүднээс хэрэгжүүлэх хамгийн чухал ажлуудын нэг өөрөө энэ юм байгаа юм. Тэгээд энийг 3, 4-н чиглэлээр ойрын хугацаанд бид бас хэлэлцэж, ярилцаж Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх хуулийн төсөл дээр ажиллах ёстой.

Нэгдүгээрт, энэ малын индексжүүлсэн даатгалын төлбөрийн нөхцөлийг сайжруулах хэрэгтэй байгаа юм. Одоо бас энэ анх хэрэгжиж эхэлснээсээ хойш цаг хугацаа ч өөрчлөгдсөн, нөхцөл байдал ч өөрчлөгдсөн. Тэгэхээр энэ малчдын эрсдэлд тохируулсан даатгалын нөхөн төлбөрийг оновчтой тогтоох асуудлыг шийдэхгүй бол энэ өөрөө цаашаа бас хэрэгжилт хангалтгүй байгаа юм. Тэгээд нөхөн төлбөрийн хэмжээг цаг агаарын аюулт үзэгдэлтэй нь уялдуулахаас гадна бодитой яг энэ тооцоолол хийх аргачлалуудаа шинэчлэх шаардлагатай. Тэгээд индексийн системийг илүү оновчтой болгох, нарийвчлалтай болгож малын

эрсдэлийг илүү бодитоор шуурхай тодорхойлох энэ орон нутгийн цаг агаарын нөхцөл байдалтай нь ч гэсэн уялдуулдаг байх тогтолцоо руу орох нэгдүгээр шаардлага бий.

Хоёрдугаарт нь энэ даатгалын хуулийн хүрээний асуудлуудыг боловсронгуй болгох асуудал бас энд байгаа юм. Тэр юуг хэлж байна гэхээр энэ малчдын орлогыг хамгаалахад энэ даатгал маш чухал. Тэгэхээр энэнтэй холбоотой энэ хуулийн шинэчилсэн найруулга индексжүүлсэн даатгал болон бусад төрлийн энэ даатгалын хуульд ч гэсэн давхар зохицуулалтыг хийж, илүү уян хатан ба бөгөөд ойлгомжтой болгох асуудал байгаад байгаа юм. Зарим нь ойлгомжгүй байгаа “индексжүүлсэн” гэдгээ юугаа хэлээд байгаа юм гэдгийг малчид бараг ойлгохгүй ийм хэмжээнд энэ асуудлууд бас хүндрэлтэй байгаа учраас энэ малчдын төдийгүй даатгалын компаниудын үйл ажиллагаатай уялдуулах энэ бодлого шинэчлэгдэх ёстой.

Гуравдугаарт, энэ малчид чиглэсэн бодлогын хүрээнд энэ төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, бас энэ малчдын энэ даатгалтай холбоотой эрсдэлийг хамгаалах хэрэгцээ, шаардлагыг илүү тодорхойлж, энэ мэдээ, мэдээллээ хүртэл хүртээмжтэй болгох ажлуудыг бид бас төлөвлөж хийхээр ажиллаж байна. Орон нутгийн малчдын орлого, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэн энэ шинэ даатгалын хөтөлбөрийг ойрын хугацаанд даатгалын эрсдэлийн сан, энэ индексжүүлсэн даатгал гээд бусад энэ бүтцүүдтэй уялдуулж бид сайжруулж оруулж ирэх хэрэгтэй.

Хамгийн сүүлд энэ даатгалын талаар ерөөсөө энэ малчдад илүү дэлгэрэнгүй мэдээллийг өгч, тэдний ойлголтыг дээшлүүлэх, мөн энэ талын ойлголт чадварыг нь нэмэгдүүлэх, энэ мэдлэг сургалт олгох сургалтуудыг хүртэл зохион байгуулах асуудлыг бид энэ Шинэ хоршоо үндэсний хөдөлгөөний хүрээнд бас зохион байгуулах хөтөлбөртөө оруулчихсан явж байгаа юм. Ингэж байж энэ бодлого шийдвэр малчдын өөрсдийнх нь нөхцөл байдал, эрэлт хэрэгцээтэй уялдаж хэрэгжих юм байгаа юм.

Хоёрдугаарт, тэр шатахууны асуудал байна. Шатахууны үнийн өсөлт яг өнөөдрийн байдлаар ямар нэгэн айхтар савлагаа, хөдөлгөөн байхгүй тогтвортой байгаа. Хангалт, нийлүүлэлт төлөвлөсөн ёсоор нөөц бүрдүүлэлт нь хийгдээд тэгээд Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яам, энэ импортлогч, түгээгч аж ахуйн нэгжүүд зохион байгуулалт уялдаа холбоогоо хэвийн авч явахад бол цаашаа үнэ өртөг хэлбэлзээд байх зүйл одоохондоо байхгүй гэж үзэж байна.

Цаашдаа бас нөхцөл байдал, цаг үе, хангалт, нийлүүлэлт, болзошгүй хүчин зүйлүүдээс шалтгаалаад яаж өөрчлөгдөхийг бас сайн одоогоор бол тийм гэж хэлэх тийм боломж байхгүй байна гэж үзэж байгаа.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүдээс, иргэд олон нийтээс ирсэн асуултуудыг Дэгийн тухай хуулийн 112.10-д заасан асуултыг нам, эвслийн бүлэг ангилан багцлаад, нам эвслийн бус бүлэг тус бүрээс 1 гишүүн төлөөлж асуулт асууж, 20 минутын дотор хариулт авахаар байх байгаа. Энэ хугацаандаа багтаан асуулт асууж, хариулт авлаа.

Ийнхүү өнөөдөр үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын өвөлжилттэй холбоотой мэдээллийг сонслоо.

Оролцсон гишүүддээ баярлалаа. Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал үүгээр дуусч байна.

18.59 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*